By adding the suffix *-уул[aa(н)] / -үүл[ээ(н)]* to numerals new forms are produced, which mean 'the two of them, the two of us, both', 'all three of them, three of them' etc. The final vowel is nasalised in colloquial speech [-a:ŋ, -e:ŋ], which is also indicated by writing the final nasal. These forms are used in response to the question *хэдүүл (ээ)* 'how many (people) together'.

<i>2 хоёул(aa)</i>	<i>5 тавуул(aa)</i>	<i>8 наймуул(aa)</i>
<i>3 гурвуул(aa)</i>	<i>6 зургуул(aa)</i>	<i>9 есүүл(ээ)</i>
<i>4 дөрвүүл(ээ)</i>	<i>7 долуул(aa)</i>	<i>10 арвуул(aa)</i>

Inflected forms use the stem in *-ан, -эн*, which may also be used as the basic nominative form.

Genitive: <i>хоёулангийн</i>	of both of them
Sociative: <i>хоёулантай</i>	with both of them
etc.	

5. Imperative

The verbal stem (as it is found in the Vocabulary) may also be used as an imperative:

Ор!	Come in!
Яв!	Go!
Үз!	Look!
Хий!	Do!

6. Present tense of the perfect (*presens perfecti*)

This tense is formed by adding the suffix *-лаа*¹ to the stem (or root). It indicates an action, which has taken place in recent past.

танилцлаа	we have become acquainted
баярлалаа	thank you (lit.: I have rejoiced)

7. Particle *юм* ('thing, something') in a nominal sentence

This word is used as a particle with the predicate in nominal sentences (cf. L2, Gr. 14). It is also used after the nominal verb forms as a predicate (*-сан, -даг*). The basic meaning of the utterance is not changed. The function of *юм* may be compared with the function of the definite article in English, as if it were referring to the whole sentence and implying mild emphasis. It may also indicate that the referent (action) is partly known or has been mentioned before, and thus the use of the particle is contextually conditioned. Sometimes the actualising (foregrounding) function of this particle may be expressed in translation by 'and' or 'but'. With regard to its *slightly emphatic* function, a foreigner should not use this particle indiscriminately in his speech because in some situations it may even be inappropriate (e.g. in official contacts, in contacts with a superior, teacher, etc.). In sentences about humans, *юм* may alternate with *хүн*.

Дорж сайн ярьдаг юм.	Dorji (really) speaks well.
Дорж сайн ярьдаг хүн.	Dorji speaks well (lit.: Dorji is a well speaking man).

Or better: *Дорж сайн ярьдаг хүн юм* = *Дорж сайн ярьдаг хүн байна*.

Dorji speaks *really* well (lit.: Dorji is a well speaking man + *emphasis: юм, байна*).

The particle *юм* may often be used in *questions*. In *wh-question* it usually expresses an emotion (astonishment, surprise, dislike, joy, etc.) – 'what (ever)', 'what (then)', 'and what', etc. In the general question the use of this particle is usually conditioned by the previous context (the subject was mentioned or is being discussed) and corresponds approximately to 'and', 'and so', 'and thus'.

Чи тэднийд очсон юм уу?	<u>And (so)</u> you have visited them?
Бат ямар өрөөнд суудаг юм бэ?	In which room does Bat live, <u>then</u> ?
Юуны ангийн оюутан юм бэ?	In which class do you (does he, etc.) study, <u>then</u> ?
Ямар ямар өрөөтэй юм бэ?	What (types of) rooms do you (do they, etc.) have, <u>then</u> ?

In the answer the particle *юм* may or may not be used. The reasons are stylistic, rhythmical or contextual (familiar situation, slight emphasis etc.).

... *хэдэн өрөөтэй юм бэ?* How many rooms do (you, they, etc.) have then?
... *дөрвөн өрөөтэй.* ... four rooms.

Ямар ямар өрөөтэй юм бэ? What (types of) rooms do you (do they, etc.) then have?
... *гал зуухны өрөө, халуун усны өрөөтэй юм.* We (they) have (in fact, actually) ... a kitchen and a bathroom.

By adding the present tense of the verb of existence to the verb form in *-даг + юм*, the meaning changes in the sense that the speaker has just learned about the respective fact or has just seen it, perhaps with mild astonishment.

Та сайн ярьдаг юм байна. Oh, how well you (can) speak! You do speak well!

Further, the particle *юм* is used with the future noun in answering a question related to the future:

Энэ өрөө ямар ханатай байх вэ? What (colour) will the wall of this room be?
Энэ өрөө цагаан ханатай байх юм. The wall of this room will be white.

Colloquial pronunciation: in colloquial usage the particle *юм* merges with the verbal noun suffixes:

-сан юм [-si:m]
-даг юм [-dək'i:m]

8. The particle *юм* in a nominal phrase

After adjectives, interrogative words and numerals, this word preserves the meaning 'thing, something'.

ямар юм what thing, what
нэг юм one thing, something
янз бүрийн юм various things (Pattern 12)

9. Word order

In a phrase comprising a genitive before a noun, the adjective may be placed after the genitive, unless the phrase comprising a genitive is a technical term.

номын жижиг шүүгээ a small bookshelf
оюутны хоёрдугаар байр second students' dormitory

Occasionally the adjective may appear both before the word in the genitive or after the word in the genitive.

10. Pairing words

Mongolian often uses the syntactical device of pairing words or making longer chains of words in coordinate phrases. In such cases the grammatical suffix is used only once after the last word of the enumeration (cf. L1, Gr. 3), or it may also appear after each word (cf. Pattern No. 5 below).

A particular case is pairing words (*хоршоо үг*) of similar, identical or also opposite meaning. Sometimes such pairs stand for a new semantic unit (naming unit), which also may usually be translated only by one word, whose meaning is more or less synonymous with each of the words (except in pairs of words of opposite meaning). Sometimes the pair represents an enumeration of a class of objects or phenomena. Pairing occurs with all lexical classes (cf. also L4, Gr. 16; L9, Gr. 2; L11, Gr. 1; further cf. references in Bibliography). In this lesson we encounter some pairs of nouns:

<i>орон сууц</i>	living quarters	<i>хоол унд</i>	food and drink
<i>орон</i>	dwelling, abode	<i>хоол</i>	food
<i>сууц</i>	residence, dwelling	<i>унд</i>	drink
<i>сав суулга</i>	dishes, utensils	<i>аяга халбага</i>	forks and spoons, cutlery
<i>сав</i>	vessel	<i>аяга</i>	cup
<i>суулга</i>	bucket	<i>халбага</i>	spoon
<i>гал зуух</i>	kitchen	<i>ор дэр</i>	bed clothes etc.
<i>гал</i>	fire	<i>ор</i>	bed
<i>зуух</i>	stove	<i>дэр</i>	pillow

Sometimes one word or its part is repeated to emphasise the meaning of the utterance or of the respective word.

За, ор ор. Well, (do) come in.

Тагттай юу? Have you a balcony?

Тагттай тагттай. (Of course), we have a balcony.

11. Possession

Mongolian does not have a special verb to express possession. One manner of expressing possession uses the *sociative case*; its negation is expressed by the negative particle replacing the sociative case suffix (both with real possession and with abstract nouns). The tense is expressed by adding the relevant forms of the verb of existence.

Би хичээлтэй. I have a lesson.

Би хичээлгүй. I do not have a lesson.

Би номтой. I have a book (books).

Би номгүй. I have no book(s).

Another possibility of expressing possession is to use the *dative-locative case* of the personal pronoun or noun denoting the owner together with a form of the verb 'to be' (both positive and negative; cf. L1, Gr. 3b; L2, Gr. 2a). This manner is mainly used with real possession of things (not abstracts).

<i>Надад ном бий.</i>	Надад ном байна.	I have books.
<i>Надад ном байхгүй.</i>	Надад ном байхгүй байна.	I have no books.

The difference between *бий* and *байна* is similar to what was said above (L1, Gr. 10).

12. *Verba vicaria*

Mongolian has a set of verbs, which can be used like the English verb 'to do' to represent any other verb. They have a full paradigm of grammatical forms like other verbs with full lexical meanings.

a) The verb *тэг-* 'to do so', 'to do in that manner' may replace the verb in the answer if the question was about the circumstances (place, time). If the question concerns the action of the verb itself, the original verb must be repeated (cf. Patterns Nos. 17–19).

<i>Тэгсэн үү?</i>	Did (he, they, you) do that?	<i>Тэгсэн.</i>	(He, they, I) did.
<i>Ирсэн үү?</i>	Did (he, they, you) come?	<i>Тэгсэн.</i>	(He, they, I) did.

b) The verb *яа-* 'to do (become) in which way', 'to do (become) how', 'to do (become) what', etc., also has a full paradigm of forms. In this lesson we encounter the form *яасан* 'what a ...' (lit.: 'how become').

<i>Яасан сонин (юм)!</i>	Oh, how interesting! What an interesting thing!
<i>Яасан сонин хүн (бэ)!</i>	What an interesting man!
<i>Яасан том (юм)!</i>	Oh, how big (it is)!

But the verb may be used in various other forms: *яаж*:

<i>Энийг яаж хийх вэ?</i>	How is it to be done? How can I do it?
<i>Энийг яаж мэдэх вэ? [midix ve]</i>	How can I found out? How can I know it?
	How can I learn it?

13. Future noun (*nomen futuri*)

The future noun may be used in a verbonominal phrase as a grammatical link between two nouns – one noun is the object (the preceding noun) of the future noun, while the future noun is an attribute of the last noun in the phrase. This is one of the very frequent patterns, in which Mongolian verbal nouns of all tenses can be used. In this lesson we encounter one phrase:

<i>бие засах газар</i>	'place, where body is relieved' (lit.: 'body-adjusting-place', i.e. lavatory)
------------------------	---

14. Idioms and phrases

<i>Танай сууц хэдэн давхар (юм) бэ?</i>	How many floors are there in your house (then)?
<i>Тэдний байшин таван давхар.</i> But it is also possible to say: <i>Танай сууц хэдэн давхар(тай) вэ?</i>	Their house has five floors.
<i>Яавал яа!</i>	Do as you like.

Шинэ үг

Vocabulary

ажил	work, job
аяга (н)	cup, bowl
аятайхан	agreeable, pleasant, nice
байшин (г)	building, house
баярлалаа	thank (you)!
баяртай	good-bye
бие	body; health
бие засах газар	toilet, W.C.
бичиг	writing, script
бичгийн ширээ (н)	(writing) desk
буйдан	divan
бүр (encl.)	each, every
бүтээлэг	covering; bedspread
бэх	ink
газар	place, locality; earth, land; office
гал	fire
гал зуух (ан)	stove, fireplace
[= гал тогоо (н)]	
гал зуухны өрөө (н)	kitchen
гэр	the Mongolian yurt; a dwelling place
даавуу (н)	cloth, textile
давхар	storey, floor
диван [= буйдан]	divan
дор [= доор] (G.)	below, under
дотор (G.)	inside, within
дугаар	number
дэр (эн)	pillow, pad
дэргэд (G.)	at, by, near, by the side of
дээр (G.)	on, upon, on top of
жорлон (г)	latrine, toilet
за, заа	well, all right; yes
зас- (Э2.5)	to repair, fix, improve
(засаж, засах, засна)	
зочны өрөө (н)	drawing room
зөв	correct(ly), proper(ly)
зураг	picture, painting
зурагт радио / телевиз	television
зуух (ан)	stove
зүгээр	ordinary, common; 'quite all right'; free, gratis
ийшээ	hither, in this direction

мод (он)	tree; wood, piece of wood
номер [= дугаар, тоо]	number
номын тавиур	book shelf
номын шүүтээ (н)	book-case
нөгөө	the other, that very one
ор- (Э2.4)	to enter, go or come into; to move in
(орж, орох, орно)	
ор (он)	bed
орны бүтээлэг	bedspread
орны даавуу (н)	bed sheet
орон 1.	dwelling, abode
орон сууц (ан)	dwelling, housing; living quarters, apartment
оч- (Э2.3)	to go to a place; to visit
(очиж, очих, очно)	
өрөө (н)	room, chamber
өчигдөр	yesterday
сав (ан) 3.	vessel, receptacle
сав суулга (н)	utensils
суулга (н)	bucket, pail
сууц (ан)	residence, living quarters
сэтгүүл	journal, magazine
тавиур	stand, shelf
тагт (ан)	balcony
тасаг	section, department; room
телевиз	television
тогоо (н)	kettle
тоот	number
тухай (G.)	about, regarding
тэг- (Э2.4)	to do thus, in that manner
(тэгж, тэгэх, тэгнэ)	
унтлагын өрөө (н)	bedroom
унш- (Э2.3)	to read, recite
(уншиж, унших, уншина)	
ус (ан)	water
хажууд (G.)	at the side of, around
хайрцаг [= чемодан]	case; box
халбага (н)	spoon
халуун	hot, warm
халуун ус (ан)	hot water; bath
халуун усны өрөө (н)	bathroom
хий- (Э1)	to do, make, act
(хийж, хийх, хийнэ)	
хоол унд (ан)	food and drink
хөдөө (н)	country, countryside; rural district
хөнжил	blanket; bed cover
хувцас (ан)	clothes, dress
хувцасны шүүтээ(н)	wardrobe
хүлээн авагч	(radio) receiver
хүүхэд	child
хүүхдийн өрөө (н)	kids' room
хэд (эн)	how much, how many; some, several
хэдүүл (ээ)	how many (people) together; 'with how many'
хэрэглэл	need; equipment; utensil
цаас (ан)	paper
цэцэг	flower

шүүгээ (н)	wardrobe, chest of drawers
яа- (Э1) (яаж, яах, яана)	to do how, to do what (interrogative verb)
яв- (Э2.4) (явж, явах, явна)	to go
янз	kind, sort, type
янз бүр(ийн)	diverse, all kinds of

Дуудах

Pronunciation

[i]	бичиг, жижиг, ширээ
[i:]	би, бий, чи, хий, түүний
[ɛ]	эм, бэх, зэс, дэр, хэдэн, цэвэрхэн
[ɛ:]	дээр, хээр, нээрэн, тэмээ, бүтээл
[a]	гал, бал, хана, сав, газар, засах
[a:]	та, за, заах, аав, даавуу
[ɔ]	ор, ном, долоо, олон, орон, жорлон
[u]	ус, бус, цус, гурван, булан, зураг
[u:]	дуу, сууц, бууз, зуух, тавуул, арвуул,
[ü:]	сүү, хүү, дүү, түүх, шүүх, хүүхэд
[ö]	бөх, хөх, дөнө, дөрвөн, өрөө, нөгөө
[ö:]	зөөлөн, өөрийн, өөрөө, өрөө, нөгөө
[ŋ]	булан, бүтэн, бичгийн, жорлон, олон, зөөлөн, халуун, хэдэн, хүлээн
[n]	энэ, хана, чоно, байна, очно, өгнө, олно, ухна, хэлнэ, хийнэ, ингэнэ

1. Асуулт

Та Та нар Чи Тэднүүс Тэднийх Танайх	хэдэн ямар юуны	сандалтай ~ ортой номтой ~ шүүгээтэй өрөөтэй ~ сонинтой үзэгтэй ~ сэтгүүлтэй дэвтэртэй ~ ажилтай тольтой ~ байшинтай	вэ?
--	-----------------------	---	-----

Хариу

Би Чи Та Бид Тэднүүс Доржийнх Тэднийх Манайх	нэг ~ том хоёр ~ жижиг арван ~ хүүхдийн олон ~ гал зуухны монгол ~ халуун усны англи ~ хувцасны сонин ~ монгол-чех сайхан ~ хуучин	сандалтай. ~ сонинтой. өрөөтэй . ~ ортой. сэтгүүлтэй. ~ байртай. үзэгтэй. ~ шүүгээтэй. номтой. ~ тольтой. байшинтай. ~ дэвтэртэй.
---	---	--

2. Асуулт

Та Та нар Тэд Танайх Тэднийх	олон франц том сонин шинэ хуучин	номтой өрөөтэй ортой шүүгээтэй байртай гэртэй сэтгүүлтэй	юу? юу?
Танд Чамд Бидэнд Тэдэнд Тэднийд Танайд	зочны хүүхдийн гал зуухны халуун усны	ном шүүгээ өрөө байр ор гэр	бий юу? байна уу?

Хариу

Би ~ Тэд Бид ~ Манайх Та ~ Тэднийх	олон франц том сонин шинэ хуучин	номтой. ~ оргүй. номгүй. ~ байргүй. өрөөгүй . ~ гэргүй.	
Надад ~ Тэдэнд Чамд ~ Тэднийд Танд ~ Манайд Бидэнд	зочны хүүхдийн гал зуухны халуун усны	ном өрөө ор шүүгээ байр гэр	бий. байна. байхгүй.

3. Батлах

Би ~ Тэд Бид ~ Манайх Тэр ~ Тэднийх	Монголд ~ хөдөө Прагад ~ байранд Улаанбаатарт ~ гэрт	суудаг. байдаг.
---	--	--------------------

4. Асуулт

Та ~ Тэд Та нар ~ Танайх Тэр хүн ~ Тэднийх Доржийнх	шинэ хуучин	байшинд байранд гэрт сууцанд давхарт	орсон уу? орсон бэ?
--	----------------	--	----------------------------

Хариу

Би Бид Тэр хүн Тэд Манайх Тэднийх Доржийнх	шинэ хуучин	байшинд байранд гэрт сууцанд	орсон.
	нэгдүгээр хоёрдугаар зургадугаар долдугаар есдүгээр	давхарт байшинд	

5. Асуулт

Танайх Доржийнх Тэднийх	ямар ямар юу юуны	өрөөтэй вэ?
-------------------------------	----------------------	-------------

Хариу

Манайх Тэднийх Доржийнх	унтлагын, гал тогооны хүүхдийн, унтлагын, гал тогооны зочин, гал зуух, хүүхэд, унтлагын	хоёр гурван дөрвөн	өрөөтэй.
-------------------------------	---	--------------------------	----------

6. Асуулт

Доржийн Танай Тэднүүсийн	орон сууц байр сургууль байшин	хэдэн	давхар өрөөтэй цонхтой	вэ?
--------------------------------	---	-------	------------------------------	-----

Хариу

Миний ~ Манай Тэр хүний ~ Бидний Тэднүүсийн ~ Түүний	орон сууц байр сургууль байшин	хоёр есөн олон	давхар. өрөөтэй. цонхтой.
--	---	----------------------	---------------------------------

7. Асуулт

Доржийнх ~ Дорж	гэрт	байдаг	уу?
Анандынх ~ Ананд	байранд	суудаг	
Багшийнх ~ Багш	байшинд		уу?
Танайх ~ Тэр оюутан	хотод ~ Дарханд		үү?
Та ~ Чи ~ Та нар ~ Тэд	хөдөө ~ Завханд		юу?

Хариу

Тийм ээ, Үгүй ээ,	Доржийнх ~ Дорж Анандынх ~ Ананд Багшийнх ~ Багш Тэр оюутан тэднийх ~ тэд манайх ~ би ~ бид	байранд гэрт байшинд хотод ~ Дарханд хөдөө ~ Завханд	байдаг. суудаг.
----------------------	--	--	--------------------

8. Асуулт

Та Чи Та нар Ринчен энэ тэр	хаана		суудаг байдаг	вэ? бэ?
Тэд Тэднийх Танайх Доржийнх	хэддүгээр ямар аль	давхарт байшинд өрөөнд тасагт	байсан	

Хариу

Би Бид Ринчен энэ тэр Тэднийх Манайх Доржийнх	нэгдүгээр хоёрдугаар зургадугаар долдугаар есдүгээр аравдугаар	давхарт байшинд тасагт өрөөнд	байдаг. суудаг. байсан.
--	---	--	-------------------------------

9. Асуулт

Та Чи Та нар Тэднийх Доржийнх Танайх Дорж	ямар ямар	өрөөтэй номтой ширээтэй ортой тольтой оюутантай	вэ?
---	-----------	--	-----

Хариу

Би Бид Бид нар Тэднийх Доржийнх Дорж Манайх	янз бүрийн том жижиг хэдэн урт монгол, англи, чех хятад, солонгос монгол-англи шинэ хуучин олон	өрөөтэй. номтой. ширээтэй. ортой. тольтой. оюутантай.
---	--	--

10. Асуулт

Тэр Таны Танай Доржийн Тэдний	өрөөний байшингийн байрын сууцны сургуулийн ангийн	хана шал хаалга	ямар	өнгөтэй	байсан бэ? байна вэ? байх вэ?
	өрөө байшин байр сууц сургууль анги	ханатай шалтай хаалгатай			

Хариу

Тэр Таны Танай Доржийн Тэдний	өрөөний байшингийн байрын сууцны сургуулийн ангийн	хана шал хаалга	улаан цагаан ногоон шар	(өнгөтэй)	байсан. байна. (байх юм.)
	өрөө байшин байр сууц сургууль анги	модон цаасан аятайхан цагаан	ханатай шалтай хаалгатай		

11. Асуулт

Энэ Тэр Танай Чиний	өрөөнд тасагт байранд ангид	хэдэн	ном өрөө сандал хүн ор дэр хөнжил	байсан бэ? байна вэ? байх вэ?
Энд Тэнд Танайд Доржийнд				

Хариу

Энэ Тэр Танай Чиний	өрөөнд тасагт байранд ангид	нэг хоёр гурван... арван нэгэн арван хоёр... олон	ном өрөө сандал хүн ор дэр хөнжил	байсан. байна. (байх юм.)
Энд Тэнд Танайд Доржийнд				

12. Асуулт

	Энд Тэнд Танайд Тэднийд Доржийнд		ямар юм юу		
Энэ Тэр Таны Чиний Тэдний Доржийн	сандал(ын) ширээн(ий) шүүгээн(ий) орон(ы) гавиур(ын) ханан(ы) хаалган(ы) байшин(гийн) цүнхэн(ий) гэр(ийн)	дээр дор дотор	юу юу ямар ямар юм	байсан байна байх байдаг бий	бэ? вэ?

Хариу

	Энд Тэнд Танайд Тэднийд Доржийнд		ном дэвтэр зураг бүтээлэг нэг юм	
Энэ Тэр Таны Чиний Тэдний Доржийн	сандал(ын) ширээн(ий) шүүгээн(ий) орон(ы) тавиур(ыг) ханан(ы) хаалган(ы) байшин(гийн) цүнхэн(ий) гэр(ийн)	дээр дор дотор	ном дэвтэр хоёр хоёр ном хэдэн харандаа олон зураг үзэг, бэх, харандаа янз бүрийн юм ном дэвтэр энэ тэр нэг сонин юм	байсан. байна. байх юм. байдаг. бий.

13. Асуулт

Миний Чиний Анандын Таны	дэргэд хажууд	хэн	суудаг сууж байна суух	вэ?
-----------------------------------	------------------	-----	------------------------------	-----

Хариу

Миний Чиний Анандын Таны	дэргэд хажууд	Дулмаа	суудаг. сууж байна. сууна. суух юм.
-----------------------------------	------------------	--------	--

14. Асуулт

Гал тогооны өрөөний Унтлагын өрөөний Зочны өрөөний Бие засах газрын Оюутны байрын Зочид буудлын Их сургуулийн	дэргэд хажууд дотор	юу	байдаг вэ? байна вэ? бий вэ? байсан бэ? байх вэ?
---	---------------------------	----	--

Хариу

Гал тогооны өрөөний Унтлагын өрөөний Зочны өрөөний Бие засах газрын Оюутны байрын Зочид буудлын Их сургуулийн	дэргэд хажууд дотор	гал тогооны өрөө унтлагын өрөө зочны өрөө бие засах газар жорлон оюутны байр олон өрөө зочид буудал	байдаг (юм). байна. бий. байсан юм. байх юм.
---	---------------------------	--	--

15. Асуулт

Тэднийхэн Танайхан Дорж гуайнхан Та ~ чи ~ Дулмаа ~ багш	гэртээ	хэдүүлээ	(суудаг) вэ? (байдаг) вэ?
---	--------	----------	------------------------------

Хариу

Тэднийхэн ~ би Манайхан ~ Дулмаа Дорж гуайнхан ~ багш	гэртээ	олуулаа ~ хоёулаа гурвуулаа ~ дөрвүүлээ тавуулаа ~ зургуулаа ганцаараа	(суудаг) (байдаг)	(юм).
---	--------	---	----------------------	-------

16. Батлах

а)

Энд Тэнд	номын бичгийн гал зуухны хүүхдийн хоолны	жигжиг том аятайхан	шүүгээ тавиур ширээ өрөө	байна.
-------------	--	---------------------------	-----------------------------------	--------

б)

Энд Тэнд	монгол англи хятад орос	хэлний	нэгдүгээр хоёрдугаар дөрөвдүгээр	анги байна.
-------------	----------------------------------	--------	--	-------------

17. Батлах (харьцуулал)

Доржийн Түүний	байр өрөө гэр тасаг	манай миний Батын	байрнаас өрөөнөөс гэрээс тасгаас	том. сайхан. саруул.
		минийхээс манайхаас Батынхаас		

Хажууд Лотор Дарга Дээр	нь	хоёр ор унтлагын өрөө хувцас номын шүүтээ хайрцаг	байна.
----------------------------------	----	---	--------

Харуу

Хажууд Лотор Дарга Дээр	нь	юу ямар өрөө ямар юм	байна вэ?
----------------------------------	----	----------------------------	-----------

Асуулт

Энэ манай	хүүхдийн өрөө, гал тороо, халуун усны өрөө, хувцасны шүүтээ.
-----------	---

21. Мэдээлэл

Чи юу хийж байна, МОНГОЛ АНГЛИ ЧЕХ Хятад СОЛОНГОС	хэл сурч	байна уу?	Тийм(ээ). Тэгж байна.
	ажил хийж хэл сурч		

20. Асуулт **Харуу**

Чи байранд орсон уу? Дорж тэндээс ирсэн үү? Дулмаа өчигдөр орсон уу? Дулмаа байсан уу? Батш ирсэн үү? Ананд хөдөө явсан уу? Чи орсон уу?	Орсон. Ирсэн. Очсон. Байсан. Явсан.
--	---

19. Асуулт **Харуу**

Танайх шинэ байранд өчигдөр орсон уу? Чи Америкаас ирсэн үү? Дорж өчигдөр ирсэн үү? Дулмаа танайд орсон уу? Ананд хөдөө явсан уу? Батш чамтай ирсэн үү? Амина Бээжин явсан уу?	Тэгсэн.
--	---------

18. Асуулт **Харуу**

1-р яриа

- Дорж: – Дулмаа аа, танайх ямар орон сууцтай вэ?
 Дулмаа: – Манайх байртай, танайх?
 Дорж: – Манайх гэртэй. Анандынх ямар орон сууцтай вэ?
 Дулмаа: – Тэднийх байшинтай.

2-р яриа

- Ринчен: – Доржийнх байранд орсон уу?
 Дулмаа: – Тэгсэн. Тэднийх саяхан байранд орсон.
 Ринчен: – Чи тэднийд очсон уу? Хэддүтээр (хэдэн) давхарт, хэдэн өрөөтэй байр байна?
 Дулмаа: – Очсон. Гуравдугаар (гурван) давхарт дөрвөн өрөөтэй, их аятайхан байр байсан.
 Ринчен: – Ямар ямар (юу юуны) өрөөтэй байна?
 Дулмаа: – Зочны өрөө, хүүхдийн өрөө, унтлагын өрөө, бас нэг том өрөөтэй, гал тогоо, халуун усны өрөөтэй байсан.

3-р яриа

- Доржийн зочны өрөөнд юу юу байсан бэ?
- Нэг урт буйдан (диван), хоёр том шүүтээ, нэг сайхан ширээ, зурагт радио (телевиз), хүлээн авагч байсан.
- Тэдний хүүхдийн өрөө том уу? Тэнд юу байсан бэ?
- (Тэр өрөө) тийм том биш. Хүүхдийн ор, ширээ сандал байсан.
- Би тэднийд очно оо, хаалганы нь дугаар хэд вэ?
- Тэдний хаалганы дугаар (номер) ес.

4-р яриа

- Сайн байна уу Дулмаа аа? За, ор ор. Яасан сонин хүн бэ!
- Сайн сайн, та нар сайн уу?
- Сайн, за ийшээ ор. Энэ манай зочны өрөө.
- Сайхан өрөө байна. Танайх энэ шинэ байранд хэзээ орсон бэ?
- Саяхан орсон. За, манай шинэ байрыг үз. Энэ манай хүүхдийн өрөө, хажууд нь унтлагын өрөө байна.
- Тун аятайхан (байр) байна. Танай гал зуухны өрөө том юм байна.
- Тийм. Энэ халуун усны өрөө, хажууд нь бие засах газар (жорлон) байна.
- Тагттай юу?
- Тагттай тагттай, тэр байна.
- Олон өрөөтэй, саруулхан, сайхан байр байна.

5-р яриа

- Энэ, оюутны нэгдүгээр байр уу?
- Тийм.
- Бат хэддүгээр өрөөнд байдаг вэ (юм бэ)?
- Юуны ангийн оюутан бэ (юм бэ)?
- Монгол хэлний хоёрдугаар анги...
- Дөрөвдүгээр давхрын найман тоотод байдаг.
- Баярлалаа.

6-р яриа

- За, сайн байна уу Бат аа?
- Сайн, сайн байна уу? Ор ор.
- Сайн. Хоёулаа суудаг юм уу? Хэнтэй суудаг юм бэ?
- Тийм, хоёулаа. Нэг чех оюутантай сууж байна. Монгол хэлний нэгдүгээр ангид суралцдаг. Бид хоёрын байр ямар байна?
- Зүгээр, аятайхан байна. Энэ чиний ор уу?
- Биш, миний найзынх. Миний ор энэ. Энэ миний номын шүүгээ.
- Чи одоо юу хийж байна? Ном үзэж байна уу?
- Тэгж байна.

7-р яриа

- За, миний найз Ян энэ. Та хоёр танилц!
- Миний нэр Дулмаа. Монгол хэл сайн сурч байна уу?
- Зүгээр, сайн сурч байна. Та юуны ангид суралцаж байна?
- Би япон хэлний гуравдугаар ангид суралцдаг. За, Ян аа, энэ орон дээр юу юу байна?
- Миний орон дээр бүтээлэг дэр хоёр байна. Бүтээлгийн дор хөнжил (орны) даавуу хоёр байна. Би зөв ярьсан уу?
- Зөв. Та сайн ярьдаг юм байна.
- Дулмаа аа, та одоо хичээлтэй байна уу?
- Тийм ээ, за, сайхан танилцлаа. Баяртай.

Бичвэр

Text

Манай тасаг (өрөө)

Би оюутны байранд суудаг. Манай тасаг дөрөвдүгээр (дөрвөн) давхарт байдаг. Манай тасаг жижиг. Бид хоёр(аа) суудаг. Манай тасагт хоёр ор, хоёр ширээ, хоёр шүүгээ бий. Ширээ бүр бүтээлэгтэй. Бас гурван сандал, хэдэн хайрцаг бий. Манай тасаг нэг цонхтой, нэг жижигхэн тагттай.

Манай нэг ширээн дээр бидний хичээлийн хэрэглэл: ном, толь, үзэг, харандаа, бэх ... байдаг. Нөгөө ширээн дээр бидний хоол ундны хэрэглэл: аяга, халбага, сав

суулга байдаг. Манай нэг шүүгээнд бид хоёрын ном, сонин, сэтгүүл бий. Манай тасаг цэвэрхэн, саруулхан, дулаахан.

Энэ, бид хоёрын ор. Орон дээр бидний ор дэрний хэрэглэл: орны даавуу, хөнжил, дэр, орны бүтээлэг байна.

Exercises

Дасгал

1. Цэгийн оронд тэмдэг нэрийг тавь. Fill in suitable adjectives.

1. Миний орны бүтээлэг
2. Манай ширээний бүтээлэг
3. Доржийн хүүхдийн өрөө
4. Ширээн дээр ... ном байна.
5. Багшийн цүнх ..., Доржийнх
6. Манай гэрийн цонх
7. Энэ үзэг ..., тэр дэвтэр
8. Би өчигдөр нэг ... хүнтэй танилцсан.

2. Цэгийн оронд асуулт тавь. Fill in suitable interrogative sentences.

1. ... ? – Доржийнх тун саяхан байранд орсон.
2. ... ? – Би тэднийд өчигдөр очсон.
3. ... ? – Тийм ээ, манайх тэдний дэргэд байдаг юм.
4. ... ? – Тэдний байр их аятайхан байсан.
5. ... ? – Манай тагт жижигхэн.
6. ... ? – Доржийн байр тагтгүй байсан.
7. ... ? – Энд самбар байсан юм.
8. ... ? – Тэнд нэг том шүүгээ байх юм.
9. ... ? – Дорж миний дэргэд сууж байна.
10. ... ? – Үгүй ээ, энэ шүүгээн дотор бий.
11. ... ? – Хүүхдийн өрөөний дэргэд байна.
12. ... ? – Биш, энэ зочны өрөө.
13. ... ? – Номын жижиг тавиур хананд байна.
14. ... ? – Хаалганы хажууд байна.
15. ... ? – Манайх монгол гэрт суудаг.
16. ... ? – Надад монгол-англи толь байхгүй.
17. ... ? – Миний найз тийм тольтой.
18. ... ? – Тийм ээ, олон монгол номтой.

3. Хаалтандахь үгийг гарга. Put the words in brackets into correct forms.

(Цонх) дээр нэг аяга байна. (Би) дэргэд Дулмаа суудаг. (Байшин) хажууд мод бий. (Цүнх) дотор хэдэн ном байна. (Би) дэвтрийн дор (чи) зураг бий. Тэр (шүүгээ)

дотор юу байдаг вэ? Би (Дулмаа) танилцсан. Дулмаа (би) танилцсан. Манай тасаг (нэг) цонхтой. Энэ (байшин) хана шар өнгөтэй. Бид тавдугаар (давхар) суудаг. Би тэр (хүн) таньдаг, харин тэр хүн (би) танихгүй. Би түүний (нэр) мэднэ. Ринчен өчигдөр (манай) байсан.

**4. Хаалгандахь үгийг ашиглан
үлгэрийн дагуу хариул.**

Answer according to the model while using the words in brackets.

ҮЛГЭР: Танайх хаана байдаг вэ? (ХОТ)
МАНАЙХ ХОТОД БАЙДАГ.
(УЛААНБААТАР, ДАРХАН, ЭРДЭНЭТ, ПРАГА, ПАРИС, ГЭР,
БАЙШИН, БАЙР, ХӨДӨӨ, АРХАНГАЙ, ТӨВ АЙМАГ)

5. Орчуул.

Translation.

Манай өрөө том биш, гэвч саруулхан, цэвэрхэн. Манай өрөө нэг том цонхтой. Манай өрөө сайхан цаасан ханатай. Манай өрөөнд нэг бичгийн ширээ, хэдэн сандал бий. Бас миний ор, нэг диван, нэг хувцасны шүүгээ бий. Хананд номын тавиур бий. Энэ тавиур их олон номтой. Тэр ном минийх. Манай цонхон дээр сайхан улаан цэцэг бий.

6. Үлгэрийн дагуу хариул.

Answer according to the model.

ҮЛГЭР А: Хэнийх шинэ байранд орсон бэ? (БАТ)
БАТЫНХ ШИНЭ БАЙРАНД ОРСОН.
(БИ, ЧИ, ТЭР ХҮН, ТЭД, ТА, БИД, ДУЛМАА, ДОРЛИГ)
ҮЛГЭР Б: Та нар өчигдөр хэнийд очсон бэ? (БАТ)
БИД ӨЧИГДӨР БАТЫНД ОЧСОН.
(БИ, ЧИ, ТА, ТЭР ХҮН, ТЭД, БИД, ДУЛМАА, ДОРЛИГ)
ҮЛГЭР В: Ринчен хэнийхээс (хаанаас) ирсэн бэ? (БАТ)
РИНЧЕН БАТЫНХААС ИРСЭН.
(БИ, ЧИ, БИД, ТЭД, БАГШ, ДУЛМАА, ДОРЛИГ)
ҮЛГЭР Г: Чи хаанаас ирсэн бэ? (АРХАНГАЙ)
БИ АРХАНГАЙГААС ИРСЭН.
(АМЕРИК, БЭЭЖИН, ХӨДӨӨ, ГОВЬ, ТОКИО)
ҮЛГЭР Д: Чи тэнд ямар хүнтэй (хэнтэй) ярьсан бэ? (БАТ)
БИ ТЭНД БАТТАЙ ЯРЬСАН.
(ЧИ, ТА, ТЭД, НЭГ ОРОС, НЭГ ХЯТАД, НЭГ ХҮН)

7. Асуултад хариул.

Answer the questions.

1. Танайх хаана байдаг вэ?
2. Танайх байшинтай юу, байртай юу?
3. Танайх хэдэн өрөөтэй вэ?
4. Доржийнх ямар сууцтай вэ?
5. Та оюутны байранд сууж байна уу?

6. Чи ямар ангид суралцдаг вэ?
7. Та монгол хэл сайн сурч байна уу?
8. Танайх хэдүүл суудаг вэ?
9. Гал зуухны өрөө олон юмтай юу?
10. Танай тасаг манай тасгаас том уу?
11. Доржийн орон дээр юу байсан бэ?
12. Та монгол оюутантай танилцсан уу?
13. Та монгол гэрт байсан уу?
14. Чи Доржийнд хэзээ очсон бэ?
15. Дулмаа өчигдөр хэнийд байсан бэ?
16. Дулмаа өчигдөр хэнийхээс ирсэн бэ?
17. Та хаанаас ирсэн бэ?
18. Та сургууль дээр хэнтэй ярьдаг вэ?

Homework

Даалгавар

1. Гэрийнхээ тухай ярь.
2. Доржийн байрыг ярь.
3. Яриануудыг тогтоо.
4. Орчуулах.

Speak about your home.
 Speak about the Dorj's flat.
 Learn the conversations by heart.
 Translate into Mongolian:

1. How many rooms do you have? We have three rooms.
2. On which floor do the Dorj's live? They live on the fourth floor.
3. Do you have a bathroom? Yes, we have a small bathroom.
4. How many floors are there in your house? There are five floor in our house.
5. Do the Dorj's live in a yurt? Yes, the Droj's live in a yurt.
6. How many rooms do the Dorl'igs have? The Dorl'igs have four rooms.
7. How many students are there in your class? In our class there are ten students.
8. Which is your school? Is it the new building? Yes, the big new building.
9. What (colour) are the walls in your classroom? Two walls are yellow and two walls are white.
10. How many windows are there in this house? In this house there are nine windows.
11. What is on the shelf? On the shelf there are books and copybooks.
12. Is there a picture on the wall? No, there is a shelf on the wall.
13. What (all things) are on the table? There are copybooks, pencils and pens on the table.
14. What is near (next to) the children's room? A bedroom? No, next to the children's room is a living room.
15. Where is the small bookshelf? The small bookshelf is on the wall near the door.
16. When did you move into the new flat? We moved recently.
17. What (sort of) books do you have? I have Czech and Russian books.
18. Do you also have Mongolian books? Yes, I also have many Mongolian books.

Хэлзүй

Grammar

1. The word *улс* / *улсууд* (people)

These nouns mean 'people' and in colloquial language they are used as a partial number correlation of the word *хүн*. The appropriate form of the partial number of the word *хүн* is *хүмүүс*.

Дорж залуу хүн.

Dorji is young (lit.: a young man).

*Танай аав ээж хоёр залуу улс / улсууд
(хүмүүс).*

Your parents are young (lit.: young people).

2. Collectives II

These forms are derived from the genitive of personal pronouns or proper names, and also local names and names of institutions, by adding the suffix *-хан*⁴ (cf. L2, Gr. 3; L3, Gr. 1). These forms have a slightly broader meaning than those labelled Collectives I (L3, Gr. 1).

<i>манайхан</i>	our family or our (social) surroundings
<i>танайхан</i>	your family or your (social) surroundings
<i>тэднийхэн</i>	their family or their (social) surroundings
<i>Батынхан</i>	Bat and his family (or his people – village, at work etc.)
<i>их сургуулийнхан</i>	all people connected with a university (not necessarily only students or graduates)
<i>ангийнхан</i>	pupils in the same class

3. Postpositions

The postpositions *-руу* / *-рүү* denoting direction are used in two vocalic forms (for male and female words respectively). The initial *p-* of the postposition changes into *л-* after the final *-p* of the previous word: *-луу* / *-лүү* (cf. Patterns No. 16). In orthography these four forms are summed up as *уруу*.

4. Enclitic possessive pronouns

<i>минь</i> ту	маань [ma:ŋ] our
<i>чинь</i> your	тань [taŋ/teŋ] your (pl., honor.)
<i>нь</i> [-Vŋ] his, her, its; their	

The third person form is the most frequently used (L2, Gr. 4). These pronouns are placed after the word they determine. The second person singular form is sometimes used as a mere particle adding a mild emphasis or as a mere extension (most often after the deictic pronoun: *тэр чинь*). In speech, vowel harmony also takes place with the second person plural enclitic pronoun, which is pronounced with a front vowel after female words: *ээж тань* [e:dʒ taŋ]

5. Possessive suffix -аа⁴

This suffix¹ is used after case forms or after the zero-ending accusative, but not after the nominative (exception: *өөрөө*). In other words we can say that this suffix does not appear with the subject of the sentence, but marks the object as possessed by the subject of the sentence. It is rarely used after postpositions, except after those, which are placed after the nominative case. After a final diphthong the hiatus filler -z- is inserted, -x- is inserted after the final -н of the genitive. In the last syllable an interconsonantal vowel is elided.

<i>аавынхаа</i>	of his (my, etc.) father (G.)
<i>багштайгаа</i>	with (his, your, etc.) teacher (Soc.)
<i>хүүхэдтэйгээ</i>	with (his, your, etc.) children (Soc.)
<i>гэрийнхээ өмнө</i>	in front of (his, your, etc.) yurt (G. plus postposition)

<i>Номоо унш!</i>	Read your book!
<i>Гэртээ байна.</i>	He is at (his) home.
<i>Дэвтэртээ бич!</i>	Write in (your) notebooks!
<i>Гэр дээрээ гар!</i>	Climb on (your) yurt!
<i>Даалгавраа хийсэн.</i>	(He) did (his) homework.

In some cases this particle may imply a regular activity or an activity related to a profession, hobby and the like:

<i>Би зураг зурж байна.</i>	I am painting a picture (casual).
<i>Би зургаа зурж байна.</i>	I am painting a picture. (I paint pictures) – as a painter.
<i>Би ном уншиж байна.</i>	I am reading a book.
<i>Би номоо уншиж байна.</i>	I am reading a book. (I read books.) – as a part of my profession (student, teacher).

¹ Called also reflexive possessive suffix (Poppe 1970, p. 123) or reflexive suffix (Kullmann, Tserenpil 1996, p. 108). However, it may be suspected that its status is very close to that of a particle (particularly with regard to the fact that it can follow postpositions).

6. Negative indefinite pronouns

Negative indefinite pronouns are formed from interrogative pronouns by adding the particle *ч* and negation. The negation may be expressed by a particle immediately after the pronoun, or it is linked with the verb of the sentence.

<i>Тэр юу ч биш.</i>	That is nothing.
<i>Тэр хүн юу ч мэдэхгүй.</i>	He knows nothing.
<i>Тэр хүн юу ч хийдэггүй.</i>	He does not do anything.

Similarly negation is added to other pronouns: *хэн ч биш* nobody

<i>Би хаашаа ч явахгүй.</i>	I will not go anywhere.
<i>Хэн ч мэдэхгүй.</i>	Nobody knows.

7. Numerals 10–100

10 <i>арав, арван+</i>	50 <i>тавь, тавин+</i>	80 <i>ная (н+)</i>
20 <i>хорь, хорин+</i>	60 <i>жар (ан+)</i>	90 <i>еp (эн+)</i>
30 <i>гуч (ин+)</i>	70 <i>дал (ан+)</i>	100 <i>зуу (н+)</i>
40 <i>дөч (ин+)</i>		

The forms marked by + are used in connection with another numeral or with the word they determine. The combination of simple numerals with the tens is seen in Patterns Nos. 7 and 8. The numeral *нэг* after tens has the form *нэгэн* before the words it determines.

When followed by the words *ах, эгч, дүү*, numerals are used in the basic forms if the phrase means 'older than', 'younger than'. The phrases mean 'older or younger by one, two, etc. years' (cf. Pattern No. 9).

In these phrases, the numeral in the basic form stands for a phrase *гурван жилийн, дөрвөн жилийн* etc.

Grammatically, numerals are nouns and can take case suffixes. E.g. the sociative case is used when specifying age:

<i>Та хэдтэй вэ?</i>	What is your age?
<i>Би арван естэй.</i>	I am nineteen.
<i>Би хорьтой.</i>	I am twenty.

8. Limiting the number

With numerals, limitation of number can be expressed by the particle *л*, or by the suffix *-хан*⁴; the latter has a quasi-diminutive function (cf. L1, Gr. 4) and in that sense may express the feeling of dissatisfaction and/or other shades of meaning, which are conditioned by the context.

<i>нэг л</i>	only one, just one
<i>хоёр л, хоёрхон</i>	only two, just two
<i>гурван л, гуравхан</i>	only three, just three

<i>хоёрхон ном</i>	only two books
<i>хоёулхан</i>	only the two (of them, of us etc.)
<i>Би дөрвөн л ном авсан. Би дөрөвхөн ном авсан.</i>	I bought only four books.
<i>Хоёр л хүн ирсэн. Хоёрхон хүн ирсэн.</i>	Only two people came.
<i>Хоёулаа л ярья. Хоёулханаа ярья.</i>	Let's talk just the two of us.

9. Prescriptive

The suffix *-аарай*⁴ (but: *-өөрэй*) added to the verb stem expresses a wish, a suggestion, or a mild injunction referring to the second person singular or plural. After a final *-ь* this suffix takes the form of *-иарай* / *-иорой* and *-ь* is elided. After a final long vowel or diphthong of the stem, the hiatus filler *-з-* is inserted:

<i>Яваарай</i>	Go!
<i>Аваарай</i>	Take!
<i>Ороорой</i>	Enter!
<i>Ирээрэй</i>	Come!
<i>Үзээрэй</i>	Look! Have a look!
[<i>Өгөөрэй</i>	Give! Cf. L6: <i>өг-</i>]
[<i>Туслаарай</i>	Help! Cf. L11: <i>тусал-</i>]
<i>Тавиарай</i>	Put! (< <i>тавь-</i>)
<i>Бай-г-аарай</i>	Be! Stay!

10. Negation of the imperative and prescriptive

In colloquial speech the particle *битгий* is most often used:

<i>Битгий хий, битгий хийгээрэй!</i>	Do not do!
<i>Битгий ор, битгий ороорой!</i>	Do not enter!

11. Last syllable vowel of the verbal stem

The interconsonantal vowel in the last syllable may be elided, if the following suffix begins with a vowel or if a vowel is inserted after the final consonant of the stem before a suffix beginning with a consonant:

<i>амар-, амра-</i>	<i>амарч</i> <i>амарна</i>	<i>амрах</i>
<i>авчир-, авчра-</i>	<i>авчирч</i> <i>авчирна</i>	<i>авчрах</i>
<i>амьдар-, амьдра-</i>	<i>амьдарч</i> <i>амьдарна</i>	<i>амьдрах</i>

12. Noun of the imperfect (*nomen imperfecti*)

This form takes the suffix *-aa*⁴ which is added to the verb stem. After a final long vowel or diphthong, the hiatus filler *-z-* is inserted. Final short vowels are elided (Э2.1.):

хийгээ, байгаа, суугаа, уншаа

This form denotes an action, which began in the past and still continues or will continue (as from the moment it is being referred to in speech). This noun can be used as an attribute or predicate. In this lesson we encounter the form of the verb 'to be' in connection with the imperfect gerund. The time duration of this form is more limited than that of the verbal noun indicating habitual action (*nomen usus*), but sometimes their meaning may be identical.

хийж байгаа хүн a man who does, makes

13. Negated *nomen usus*

The particle *-гүй* is added to the noun. It can be used as a predicate but also as an attribute.

...хийдэг хүн a man, who does..., a man doing ...
жолооч хийдэг хүн a man, who works as a driver
...хийдэггүй хүн a man, who does not do...

14. Verbal phrases

Mongolian often uses verbal phrases, in which two or more verbal forms are juxtaposed – only the last one takes the 'finite' form or a verbal noun form. All the non-final verbs in the chain take the forms of various converbs (or gerunds). This is the manner of describing individual successive actions, which in most European languages would be expressed by way of the conjunction 'and' (for examples see the following lessons). Some pairs of verbs in such phrases may be almost idiomatic and they are often translated by one verb into European languages. Some verbs have a more general meaning, resembling various modal or auxiliary verbs. In this lesson we encounter phrases with the verbs *бол-* 'to be possible or permitted', and *дуус-* 'to finish, to complete'.

Хийж болох уу? Is it possible to do (this, that)? (Can I do? Can you do?)
Хийж болно. It is possible to do (this, that).
Хийж болохгүй. It is not possible to do (this, that).

Хийж дууссан. He finished (lit.: having done finished).
Хийж дуусч байна. He is finishing (lit.: having done finishes).

Амар даа! Well then, have a rest (or: Why don't you have a rest.)
Би гэр бүлгүй шүү дээ. But I have no relatives at all.

20. Idioms and phrases

The interrogative *юу* can ask about people when we ask about the functional positions and not about the concrete persons (or names) in a social unit (family, department, class, and the like).

Юу юу чинь (тань) байдаг юм бэ? What all people are there with you
 (in your family)?
Миний аав, ээж хоёр, хоёр дүү маань There are my Father, Mother and two
байдаг. younder brothers (sisters).
аав нь 1. his, her father; 2. your father
Хэлц: За тийм байдаг байж. Well, that would be it. I see, that is it.

Шинэ үг

аа тийм үү?	oh, is that so?
аав (= ав)	father
ав- (Г5)	to take, to buy; to receive (from; with Abl.)
(авч, авах, авна)	
авгай	married woman; wife (coll.)
авчир- (Э2.4)	to bring
(авчирч*, авчрах, авчирна)	
ажилчин	worker
айл	family; household; group of yurts
амар- (Э2.4)	to rest, to relax
(амарч*, амрах, амарна)	
амьдар- (Э2.4)	to live
(амьдарч*, амьдрах, амьдарна)	
асуу- (Э1)	to ask
(асууж, асуух, асууна)	
ах	elder brother
ах дүү	brothers and sisters
ач	grandson, granddaughter (son's child)
ач охин	granddaughter
бага	small, little
битгий (= битий)	don't (prohibitive negative particle before imperative)
бол- (Г1)	to become, to be
(болж, болох, болно)	
бүл (гэр бүл)	family, members of a family
бүсгүй	young woman
бүстэй	man, male (used as attribute)
гадаа (adv.)	outside
ганцаараа	alone, solitarily

Vocabulary

гар- (Г2) (гарч, гарах, гарна)	to go out, to leave
гуай	Mr., Mrs. (honor.)
гэр бүл	family, family members
даа ⁴	an emphatic particle
даалгавар	task; homework
дамжаа (н) = курс	class, course
дараа нь	afterwards, then
дараагаар нь	afterwards, then
дуус- (Г3) (дуусч, дуусах, дуусна)	to finish, to stop
дүү	younger brother or sister
жолооч	driver
залуу	young; young man, youth
зээ	grandson, granddaughter (daughter's child)
инженер	engineer
коллеж	college
компани	company
курс	course, class
малчин	herdsman
минь (encl.)	my
нааш (аа)	this way, in this direction
нас (ан)	age; life (time)
нас бар- (Э2.4) (барж, барах, барна)	to die
ойрхон	near, close
олуул(аа)	many, in great number (cf. 3L, Gr. 4)
охин	daughter
өвөг	ancestor; forefather
өвөг аав	grandfather
өнөр	large (family); having many children or relatives
өнчин	orphan
өөрийн	one's own
өөрөө	self, one-self (myself, etc.)
руу / рүү ≈ луу (лүү)	to, towards
сурагч	pupil
тавь- (тави-; Э2.4) (тавьж, тавих, тавина)	to put (down); to place
такси	taxi
тань (encl.)	your
тариачин	farmer, peasant
тогло- (Э2.1) (тоглож, тоглох, тоглоно)	to play
тогтоо- (Э1) (тогтоож, тогтоох, тогтооно)	to learn by heart
тэтгэвэр	pension; financial assistance
тэтгэвэрт гар-	to retire
унт- (Э2.2) (унтаж, унтах, унтана)	to sleep, fall asleep
уучлаарай	excuse me
хааш(аа)	where (to); in which direction
хадам аав (хадам эцэг)	father-in-law
хадам ээж (хадам эх)	mother-in-law

хар- (Э2.4) (харж, харах, харна)	to look at, to see
хол	far (away)
холбоо үг	phrase
хүү	son
хэдтэй	how old
хэлц	expression, phrase
цөмөөр(өө)	all, everybody
цөөхүүл(ээ)	few, in a little number
цэцэрлэг	park, garden, flowergarden; kindergarden
чацуу	equal age, same age
шүү (дээ)	emphatic particle
эгч	elder sister
эмч	physician, (medical) doctor
эмэг	woman ancestor
эмэг ээж	grandmother
эмэгтэй	woman, female
эрэгтэй	man, male
эцэг эх	parents
эх	mother
эхнэр	wife, consort (honor.)
ээж	mother
ямар	how (asking about quality of action)

Дуудах

Pronunciation

[ɛ]	эгч, эмч, эхнэр, цэцэрлэг, тэтгэвэр
[ɛ:]	ээж, тэгээд, гэртээ, гэртэй, эмэгтэй, эрэгтэй, хэдтэй
[a]	ах, нас, засах, явах, таван, бага, гарах, газар, манайх
[æ]	тавин, тариачин, амьдрах, ажилчин
[a:]	аав, та, саах, багш аа, найз аа
[ɔ]	цонх, хонх, охин, жорлон, жолооч
[u]	ус, цус, сурагч, булан, зураг, хувцас
[u:]	дуу, уух, зуух, суух, сууц
[ü]	үс, хүн, бүл, зүрх
[ü:]	дүү, хүү, түүх, хүүхэд
[ö]	өнөр, өвөг, дөрвөн, хөдөө
[ö:]	нөгөө, хөдөө, өрөө, өөрөө, ерөөл
[ɕ]	ээж, байж, жил, ажил, жаахан, жолооч, жижиг, жаргал

1. Асуулт

Та ~ Чи Тэр хүн Дорж ~ Дулмаа	ахтай ~ дүүтэй ~ эгчтэй авгайтай ~ эхнэртэй ~ нөхөртэй аав ээжтэй ~ хүүхэдтэй	юу? юү?
-------------------------------------	---	------------

Хариу А

Би Тэр хүн Дорж Дулмаа	авгайтай. ахтай. эхнэртэй. эгчтэй. дүүтэй. аав ээжтэй. нөхөртэй.
---------------------------------	--

Хариу Б

Би Тэр хүн Дорж Дулмаа	авгайгүй. ахгүй. эхнэргүй. эгчгүй. дүүгүй. аав ээжгүй. нөхөргүй.
---------------------------------	--

2. Асуулт

Та Чи Тэр хүн	хэдэн	ахтай хүүхэдтэй дүүтэй эгчтэй	вэ?
---------------------	-------	--	-----

Хариу

Би Тэр хүн	нэг хоёр гурван дөрвөн олон	ахтай. хүүхэдтэй. дүүтэй. эгчтэй.
---------------	---	--

3. Асуулт

Та Чи Дорж	хэдэн	ах, эгч, дүү.	хэдэн	дүүтэй ахтай эгчтэй	вэ?
------------------	-------	---------------------	-------	---------------------------	-----

Хариу

Би Дорж	нэг хоёр гурван дөрвөн олон	дүү, ах, эгч,	нэг хоёр гурван дөрвөн олон	ахтай. эгчтэй. дүүтэй.
------------	---	---------------------	---	------------------------------

4. Асуулт

Чиний Таны Доржийн Дулмаагийн Манай	хоёр гурван дөрвөн таван	дүүгийн номын	хэд нь	бүстэй, эрэгтэй, монгол,	хэд нь	бүсгүй эмэгтэй англи	вэ?
---	-----------------------------------	------------------	--------	--------------------------------	--------	----------------------------	-----

Хариу

Миний Доржийн Дулмаагийн Манай	хоёр гурван дөрвөн таван	дүүгийн номын	нэг нь хоёр нь гурван нь дөрөв нь	бүстэй, эрэгтэй, монгол,	нэг нь хоёр нь гурван нь дөрөв нь	бүсгүй. эмэгтэй. англи.	
---	-----------------------------------	------------------	--	--------------------------------	--	-------------------------------	--

5. Асуулт

Чиний Таны Доржийн Энэ	хоёр дөрвөн	дүүгийн номын дэвтрийн хүний оюутны юмны	аль нь хэд нь ямар нь	бүстэй, сайн, урт, чинийх, авгай нь, Дорж,	аль нь хэд нь ямар нь	бүсгүй муу богино Доржийнх нөхөр нь Дулмаа	вэ?
---------------------------------	----------------	---	-----------------------------	---	-----------------------------	---	-----

Хариу

Миний Доржийн Энэ	хоёр дөрвөн	дүүгийн номын дэвтрийн хүний оюутны юмны	нэг нь энэ нь хоёр нь том нь залуу нь	бүстэй, сайн, урт, чинийх, авгай нь, Дорж,	нөгөө нь тэр нь хоёр нь бага нь хөгшин нь	бүсгүй. муу. богино. Доржийнх. нөхөр нь. Дулмаа.	
-------------------------	----------------	---	---	---	---	---	--

6. Асуулт

Чиний Таны Доржийн	аав ~ ах ээж ~ авгай дүү ~ нөхөр	ямар ажилтай	(хүн) (юм)	вэ? бэ?
Аав ~ ээж ~ дүү Ах ~ авгай ~ нөхөр	чинь ~ тань ~ нь	юу хийдэг		

Хариу

Миний Доржийн Манай	аав ~ ах ээж ~ авгай дүү ~ нөхөр	багшийн эмчийн жолоочийн	ажилтай	(хүн). (юм).
		багш эмч жолооч	хийдэг	
Аав ~ ээж ~ дүү Ах ~ авгай ~ нөхөр	минь ~ тань ~ нь	багш ~ эмч ~ жолооч оюутан ~ сурагч ~ малчин		

7. Асуулт

Таны Чиний	ах ~ эгч ~ дүү ~ аав ээж эхнэр ~ авгай ~ нөхөр	хэдэн настай хэдтэй	вэ?
Ах ~ эгч ~ дүү ~ аав Ээж ~ эхнэр Авгай ~ нөхөр	чинь тань нь		

Хариу

Миний	ах ~ эгч ~ дүү ~ аав ээж эхнэр ~ авгай ~ нөхөр	нэгтэй. ~ хоёртой. ~ гуравтай. дөрөвтэй. ~ тавтай. ~ зургаатай. долоотой. ~ наймтай. ~ естэй. аравтай ~ хорьтой. ~ гучтай. ~ дөчтэй.	
Ах ~ эгч ~ дүү Аав ээж Авгай ~ эхнэр Нөхөр	минь	нэг ~ хоёр ~ гурван дөрвөн... ~ хорин ~ гучин дөчин ~ тавин ~ жаран	настай.

8. Асуулт

Та ~ Чи ~ Дулмаа ~ Бат ~ Тэр багш Таны найз ~ Дорж гуай	хэдтэй хэдэн настай	вэ?
---	------------------------	-----

Хариу

Би Тэр багш Дулмаа Бат Миний найз	арван ~ хорин ~ гучин дөчин ~ тавин ~ жаран далан ~ наян ~ ерэн зуун	настай.	
		нэгэн ~ хоёр гурван ~ дөрвөн таван ~ зургаан долоон ~ найман есөн	настай.
		нэгтэй. ~ хоёртой. ~ гуравтай. дөрөвтэй. ~ тавтай. ~ зургаатай. долоотой. ~ наймтай. ~ естэй.	
аравтай. ~ хорьтой. ~ гучтай. ~ дөчтэй. ~ тавьтай. жартай. ~ далтай. ~ нятай. ~ ертэй. ~ зуутай.			

9. Асуулт

Та Чи Би	надаас ~ Доржоос танаас ~ түүнээс чамаас ~ биднээс	ах уу? дүү юу? эгч үү?	(Тийм ээ,)	ах. эгч. дүү.
----------------	--	------------------------------	------------	---------------------

Хариу

Та	Тар хүн	Та нар	Таны	аав	ээж	ах	дүү	Түүний	Тэдний	Доржийн	Эгч	Аав	Ээж	Дүү	Ах
			Чиний	аав	ээж	ах	дүү	Түүний	Тэдний	Доржийн	Эгч	Аав	Ээж	Дүү	Ах
			юу	ямар ажил		хийж		байгаа		байсан	байна				
			мар ажигтай												

11. Асуулт

Би	Бид (нар)	Тэр охин	дээд ~ орос дунд ~ монгол улсын ~ хувийн	сүрүүлд	сүрцдэг. сүрдэг. явдаг.	Таны	дүү	ах	эгч	Миний	хүүхдийн нийгэмлэгт				
						Таны	дүү	ах	эгч	Миний	ангид	дамжканд	сүрцдэг байгаа. сүрц байсан. явж байна.	ангид	дамжканд

Харуу

Та	Чи	Танар	Тэр охин	ямар	сүрүүлд	ангид	дамжканд	курст	сүрцдэг	явж	байсан	байна	Таны	дүү	ах	эгч	Чиний	Асуулт	
													Таны	дүү	ах	эгч	Чиний	Таны	дүү

10. Асуулт

Хэд	ах	дүү	эгч	Асуулт	Харуу	Би	Чи	Та	надаас	танаас	чамас	биднээс	Доржоос	Дулмаатаас	олон ~ хэд	нэг ~ хоёр	гурва ~ дөрөв	тав ~ зурга	долоо ~ найм	ес ~ арван нэг	ах.	эгч.	дүү.
-----	----	-----	-----	--------	-------	----	----	----	--------	--------	-------	---------	---------	------------	------------	------------	---------------	-------------	--------------	----------------	-----	------	------

Харуи

Би	Тэр хүн	Багш жолооч	Хийдэг.
Миний	Түүний	Багшийн	Хийдэг. Байсан. Байгаа.
Тандий	Доржийн	эмгийн жолоочийн инженрийн	
Эгч	Аав	маань	Тариагчин. ~ ажиглагч. ~ малчин. ~ оюутан. Багш. ~ сурагч. ~ инженер. ~ жолооч.
Ээж	Дүү	минь	
Ах	Дүү	нь	

12. Асуулт

Би	Бид (нар)	Тэр хүхэд	Дорж
Яэж ~ ярьж	Явж ~ хийж	Сүүж ~ уншиж	Амарь ~ тоглож
Болох уу?			

Харуи

(Та)	(Чи)	(Та нар)	(Тэр хүхэд)	(Дорж)
Яэж ~ ярьж	Сүүж ~ хийж	Явж ~ уншиж	Амарь ~ тоглож	
Болно.	Болохгүй.			

13. Асуулт

Би	Тэр оюутан	Дулмаа	Бид (нар)
Яэж ~ очиж	Орж ~ уншиж	Сүүж ~ хийж	Явж ~ тоглож
Болох уу?			

Харуи

(Та)	(Чи)	(Тэр оюутан)	(Дулмаа)	(Та нар)
Ийшээ ~ төлөвиз	Тийшээ ~ номоо	Ангидаа ~ хичээлээ	Дасталаа ~ ерөөндөө	Явж ~ тоглож
Одоо	Одоо	Дараа (нь)	Дараагаар нь	Болно.
Болохгүй.				

14. Асуулт

Та Чи Дорж Эхнэр чинь Авгай тань Чиний нөхөр	ажлаа даалгавраа номоо	хийж уншиж бичиж	дууссан уу? дуусч байна уу?
---	------------------------------	------------------------	--------------------------------

Хариу

Би Дорж Эхнэр минь Авгай маань Миний нөхөр	ажлаа даалгавраа номоо	хийж уншиж бичиж	дууссан. дууслаа. дуусч байна. дуусаагүй (байна).
--	------------------------------	------------------------	--

15. Асуулт

Та Чи Тэр оюутан	хаашаа	явж	байна байгаа юм	вэ? бэ?
------------------------	--------	-----	--------------------	------------

Хариу

(Би) (Тэр оюутан) (Чи)	гэр лүүгээ ~ цэцэрлэг рүү Монгол руу ~ манай руу сургууль руу(гаа) ~ танай руу	явж	байна. байгаа юм.
------------------------------	--	-----	----------------------

16. Асуулт

Таны Танай Чиний Тэр оюутны	гэр сургууль ажлын газар	хол ойр(хон)	уу? байна уу? байгаа юу?
Танайх Тэр оюутных Тэднийх			
Гэр Сургууль Ажлын газар	чинь тань		

Хариу

Миний Манай Тэр оюутны	гэр сургууль ажлын газар	хол ойр (хон)	(байна). (байгаа).
Манайх Тэр оюутных Тэднийх			
Гэр Сургууль Ажлын газар	маань нь		

17. Асуулт

Хариу

Танайх шинэ байранд орох уу? Чи Доржтой ирэх үү? Дулмаа манайд маргааш очих уу? Цэмбэл хөдөө явах уу? Цэрмаа Улаанбаатар орох уу? Ананд маргааш явах уу? Чи Доржийнд очих уу?	Тэгнэ.
---	--------

18. Асуулт

Хариу

Чи байранд орох уу? Дорж чамтай ирэх үү? Дулмаа маргааш очих уу? Цэмбэл явах уу? Багш ирэх үү? Чи тэнд очих уу?	Орно. Ирнэ. Очно. Явна.
--	----------------------------------

Conversations

Яриа

1-р яриа

- Танайхан гэртээ олуулаа суудаг уу?
- Манайхан олуулаа. Танайхан?
- Манайхан цөөхүүлээ. Танайхан гэртээ хэдүүлээ вэ?
- Манайхан тавуулаа.
- Юу юу чинь (тань) байдаг юм бэ?
- Миний аав (эцэг), ээж (эх) хоёр, хоёр дүү маань байдаг.
- Танайх (танай гэр) хаана байдаг вэ?
- Манайх Их сургуулийн ойр байдаг.

2-р яриа

- Таны (танай) аав юу хийдэг вэ?
- Багш хийдэг.
- Хаана багш хийдэг вэ?
- Нэг дунд сургуульд.
- Ээж чинь ямар ажилтай вэ?
- (Миний ээж) эмч.
- Хаана эмч хийдэг вэ?
- Бас дунд сургуульд эмч хийдэг.
- Хоёр дүү чинь?
- Нэг нь бага сургуульд суралцдаг, нөгөө нь жолооч.

3-р яриа

- Та хэдэн настай вэ?
- Би хорин зургаатай. Та хэдтэй вэ?
- Би дөчтэй.
- Миний (манай) ээж бас дөчтэй. Та миний ээжтэй чацуу юм байна.
- Аа тийм үү? Аав чинь хэдтэй вэ?
- Аав дөчин наймтай.
- Таны (танай) аав ээж хоёр их залуу улс байна.

4-р яриа

- Бат аа, чи эхнэртэй юу?
- Үгүй. Би эхнэргүй. Чи нөхөртэй юу?
- Би нөхөртэй.
- Хүүхэдтэй юу?
- Хүүхэдтэй. Охин хүү хоёртой.

5-р яриа

- Дорж гуайнх олуулаа юу?
- (Тэднийх) олуулаа.
- Дорж гуай юу хийдэг вэ?
- (Дорж гуай) нэг коллежид багш хийдэг.
- Авгай нь хаана, ямар ажил хийдэг вэ?
- (Авгай нь) энэ хотод эмч хийдэг.
- Тэднийх олон хүүхэдтэй юу?
- Гурван хүүхэдтэй.
- Хэд нь охин, хэд нь хүү вэ?
- Хоёр нь хүү, нэг нь охин.
- Тэд цөмөөрөө сургуульд суралцдаг уу?
- Үгүй, том хүү нь таксийн жолооч, бага хүү нь оюутан, охин нь дунд сургуулийн сурагч.

- Дорж гуайн эцэг эх хаана байдаг вэ?
- Тэр хоёр хөдөө байдаг.
- Тэд нар хөдөө юу хийдэг вэ?
- Юу ч хийдэггүй, тэтгэвэрт гарсан улс.

6-р яриа

- Монгол хэлэнд аавын аавыг юу гэдэг вэ?
- Өвөг аав (өвөг эцэг) гэдэг.
- Чиний өвөг аав одоо бий юү?
- Байхгүй, нас барсан.
- Ээжийн ээжийг юу гэдэг вэ?
- Эмэг ээж (эмэг эх) гэдэг.
- Чиний эмэг ээж одоо бий юү?
- Бий.
- Хүүгийн хүүхдийг юу гэдэг вэ?
- Ач гэдэг. Ач хүү, ач охин гэдэг.
- Охины хүүхдийг юу гэдэг вэ?
- Зээ гэдэг. Зээ хүү, зээ охин гэнэ.
- За тийм байдаг байж. Одоо нэг юм асууна. Эхнэрийн аав ээжийг юу гэдэг вэ?
- Эхнэрийн аавыг хадам аав, ээжийг хадам ээж гэдэг.
- Нөхрийн аав ээжийг?
- Бас л хадам аав, хадам ээж гэнэ.
- За, их баярлалаа.
- За.

7-р яриа

- Та ах дүү олуулаа юү?
- Би (ах дүү) олуулаа.
- Юу юу тань байна вэ?
- Нэг ах, нэг эгч, нэг бүстэй дүү, нэг бүсгүй дүү.
- Дулмаа ах дүү олуулаа юү?
- Дулмаа ах дүү цөөхүүлээ. Дулмаа нэг л дүүтэй.
- Дүү нь эрэгтэй юү, эмэгтэй юү?
- Эмэгтэй.

8-р яриа

- Бат аа, хүү минь нааш ир. Энд суу. Чи юу хийж байна? Ном үзэж байна уу, гэрийн даалгавраа хийж байна уу?
- Ном үзэж байна, аав аа. Гэрийн даалгавраа хийсэн.
- Даалгавраа хийж дууссан уу?
- Дууссан. Одоо би амрах уу аав аа?
- За миний хүү тэндээс нэг сандал авчраарай.

- Хаанаас? Ямар сандал?
- Гал зуухны өрөөнөөс нэг жижиг хуучин сандал авчир.
- За, авчирлаа. Энүүнийг хаана тавих вэ, таны дэргэд тавих уу?
- Үгүй ээ, хүү минь, миний дэргэд битгий тавь. Тэр ширээний дэргэд тавь.
- Аль ширээний дэргэд?
- Тэр бичгийн ширээний дэргэд.
- За, тавилаа.
- Одоо энэ сандлыг зочны өрөөнд тавиарай.
- За, тавилаа. Одоо яах вэ, амрах уу?
- Миний хүү одоо амар даа. Гадаа жаахан тогло.

9-р яриа

Багш: – Та гэрийн даалгавраа хийсэн үү?

Оюутан: – Хийсэн.

Багш: – Харилцаа яриаг тогтоосон уу?

Оюутан: – Тогтоосон.

Багш: – Сайн байна. Одоо та өөрийнхөө гэр бүлийг ярь.

Оюутан: – Уучлаарай багш аа, би гэр бүлгүй шүү дээ. Би өнчин хүн.

Бичвэр

Text

1. МАНАЙХАН

Манайхан олуулаа (өнөр). Би аав ээжтэй. Миний аавыг Дорлиг гэдэг. Одоо дөчин долоон настай. Дунд сургуульд багш хийдэг. Миний ээжийг Хандсүрэн гэдэг. Ээж эмч. Дөчин таван настай. Би нэг ах, нэг эгчтэй. Ах маань хорин наймтай. Нэг компанид жолооч хийдэг. Эгч маань хорин тавтай. Оюутан. Их сургуульд суралцдаг. Би бас нэг бүстэй (эрэгтэй) дүүтэй. Дүү маань дунд сургуульд суралцдаг. Миний энэ дүү арван дөрвөн настай. Эмэг эх, өвөг эцэг маань нас барсан. Манайх Улаанбаатарт гэрт сууж байна. Би оюутан. Одоо монгол хэлний ангид суралцаж байна.

2. ДОРЖ ГУАЙНХ

Дорж гуайнх өнөр айл. Тэднийх олуулаа. Дорж гуай, Улаанбаатарын нэг дунд сургуулийн багш. Авгай нь эмч. Нэр нь Дулмаа. Дорж гуай Дулмаа гуай хоёр хоёулаа тавин настай. Тэр хоёр чацуу улс. Тэднийх хоёр охин, гурван хүүтэй. Тэдний хоёр том хүү нь дээд сургуульд суралцдаг. Хоёр охин нь дунд сургуулийн сурагч. Бага хүү нь дөрвөн настай. Хүүхдийн цэцэрлэгт байдаг. Дорж гуайн эцэг эх хоёр ажил хийдэггүй. Тэтгэвэрт гарсан (улс). Тэд нар хотод байдаггүй, хөдөө байдаг. Саяхан Дорж гуайн аав хөдөөнөөс ирсэн.

1. Нөхөж ярь.

Fill in and say aloud.

Дорж ... хийдэг. Тэр хүн ... настай. Эхнэр Дулмаа нь ... хийдэг. Хоёр хүү нь ... сургуульд суралцдаг. Хоёр охин нь ... сурагч. Тэдний бага хүү ... байдаг. Өвөг аав эмэг ээж хоёр нь хөдөө ... Тэд нар ... хийдэггүй.

2. Асуултад үлгэрийн дагуу хариул. Answer according to the model.

ҮЛГЭР: Та оюутан уу? ТИЙМ, (БИ) ОЮУТАН.

ҮГҮЙ, (БИ) ОЮУТАН БИШ.

ҮГҮЙ, БАГШ.

- а) Таны ах ажилчин уу?
- б) Таны аав ээж хоёр хоёулаа багш уу?
- в) Танай авгайн нэр Долгор уу?
- г) Доржийнх хол уу?
- д) Дорлиг гуай багш уу?
- е) Дулмаа эмч үү?
- ё) Таны дүү сурагч уу?
- ж) Таны ээж жолооч уу?
- з) Дүү чинь малчин уу?
- и) Ах чинь тариачин уу?

3. Асуух үгийн оронд зохих үгийг тавь.

Use suitable words instead of the interrogatives in brackets.

Дулмаа (ямар) сургуулийн (юуны) багш. Дулмаа нөхрөөсөө (ямар). Дулмаа нөхрөөсөө (хэд) дүү. Сүрэн (ямар) сургуулийн багш. Сүрэн эхнэрээсээ (ямар). Сүрэн гуай эхнэрээсээ (хэд) ах. Дорж гуай (хаана) жолооч хийдэг. Доржийн хоёр том хүү (ямар) сургуулийн оюутан. Дорж гуайн эцэг (хаана) байдаг. Дорж гуайн аав саяхан (хаанаас) ирсэн. Хоёр охин нь (ямар) сургуулийн сурагч. Долгор (хаана) ажилчин. Дүү нь (хэзээ) ирсэн. Эгч нь (хэзээ) ирнэ. Ах нь (хэний) хуучин найз.

4. Үгсээр өгүүлбэр зохио.

Construct sentences from these words.

- а) Ринчен, гадаа, Доржийн бага хүү, тоглосон.
- б) биш, охин, Доржийн, оюутан, хоёр, сурагч.
- в) манай, байдаггүй, хөдөө, гэр, байдаг, хотод.
- г) сурч байна, одоо, ангид, их сургуулийн, монгол хэлний, би.
- д) аав, сонин, хийдэг, ажил, нэг компанид, манай.
- е) би, байдаг, эхнэр ч үгүй, ганцаараа, хүүхэд ч үгүй, гэртээ.
- ё) үзсэн, өчигдөр, би, юм, нэг, сонин.

5. Асуух үгийн оронд тоо тавь.

Use numerals instead of the interrogatives in brackets.

Дорж (хэдэн) настай. Түүний эхнэр Дулмаа (хэдэн) настай. Тэдний нэг хүү (хэдэн) настай, нэг охин нь (хэдэн) настай. Доржийн бага хүү (хэдтэй). Би (хэдэн) настай. Миний аав (хэдтэй), ээж (хэдтэй). Манайх (хэдүүл). Миний найзынх гэртээ (хэдүүл). Би байрандаа (хэдүүл) суудаг.

6. Өгүүлбэрт асуулт тавь.

Turn the sentences into questions.

- а) Доржийн нэг охин хоёрдугаар дамжаанд суралцаж байна.
- б) Өвөг аав, эмэг ээж хоёр нь хөдөө бий.
- в) Дорж багш.
- г) Дулмаа эмч.
- д) Миний аав дөчин долоотой.
- е) Ээж минь дөчин хоёртой.
- ё) Доржийнх хотод байдаг.
- ж) Дорж гуай их сургуулийн багш.
- з) Эхнэр нь бага сургуулийн багш.
- и) Сүрэн жолооч хийдэг. Хорин настай.
- й) Цэрэндорж гуай манайд байсан.

7. Уншаад асуултад хариул.

Read the sentences and answer the questions.

- А: Дорж Дулмаа хоёр – ах дүү хоёр.
Дорж нь дөчтэй. Дулмаа нь гучтай.
1. Ах нь хэн бэ, дүү нь хэн бэ?
 2. Ах нь дүүгээсээ хэд ах вэ?
 3. Дүү нь ахаасаа хэд дүү вэ?
- Б: Дулмаа Дорж хоёр – эгч дүү хоёр.
Дулмаа хорин тавтай. Дорж арван наймтай.
1. Энэ хоёрын эгч нь хэн, дүү нь хэн бэ?
 2. Эгч нь дүүгээсээ хэд эгч вэ?
 3. Дүү нь эгчээсээ хэд дүү байна вэ?
- В: Аюуш Ринчен хоёр – багш оюутан хоёр.
Аюуш гучин хоёртой. Ринчен хорьтой.
1. Энэ хоёрын хэн нь ах, хэн нь дүү вэ?
 2. Багш нь оюутнаасаа хэд ах вэ?
 3. Оюутан нь багшаасаа хэд дүү вэ?
- Г: Дорж Дулмаа хоёр – эхнэр нөхөр хоёр.
Дорж тавин настай. Дулмаа хорин настай.
1. Энэ хоёрын аль нь залуу, аль нь хөгшин байна вэ?

2. Дорж эхнэрээсээ хэд ах вэ?
3. Дулмаа нөхрөөсөө хэд дүү вэ?

8. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу холбоо үг болго.

Use the model in order to change the sentences.

ҮЛГЭР: Энэ хүн сая надтай ярилцсан.
(ЭНЭ) САЯ НАДТАЙ ЯРИЛЦСАН ХҮН.

1. Энэ оюутан даалгавраа хийсэн.
2. Тэр оюутнууд ажил хийж байгаа.
3. Чех оюутнууд монгол хэл сурч байна.
4. Энэ хүн саяхан эхнэр авсан.
5. Энэ хүн надтай танилцсан.
6. Хүүхэд нэг сандал энд авчирсан.
7. Энэ хүн нэг дээд сургуульд багш хийдэг.
8. Тэр оюутнууд их сургуульд сурдаг.
9. Тэр хүн дээд сургуульд багш хийдэг.
10. Энэ оюутан Германаас ирсэн.
11. Энэ япон эмэгтэй гэрт суудаг.

9. Цэгийн оронд асуулт тавь.

Fill in suitable interrogative sentences.

1. – ...? – Миний эхнэр биш, Батын эхнэр.
2. – ...? – Тийм ээ, манайх олуулаа байдаг.
3. – ...? – Миний дүү оюутан.
4. – ...? – (Би) ажил хийдэггүй, оюутан.
5. – ...? – Миний аав, ээж, дүү байдаг.
6. – ...? – Тийм ээ, Цэмбэл өнчин хүүхэд.
7. – ...? – Миний хоёр дүүгийн энэ нь бүстэй хүүхэд.
8. – ...? – Манай аав ээж хоёр их залуу улс.
9. – ...? – Багшийн авгай тийм ч залуу биш.
10. – ...? – Долгор гуай Доржийн ээж биш, хадам эх нь.
11. – ...? – Бат энэ хүний ач хүү биш, зээ хүү.
12. – ...? – Эмэг ээж маань хотод байдаг.
13. – ...? – Бид хоёр саяхан танилцсан юм.
14. – ...? – Болно. Та одоо явж болно.
15. – ...? – Бид хичээлээ хийж дуусч байна.

10. Асуултад хариул.

Answer the questions.

1. Та юу хийдэг вэ?
2. Та оюутан уу?
3. Та ямар сургуулийн оюутан бэ?
4. Та хорин хоёртой юу?
5. Дорж ямар ажил хийдэг вэ?

6. Ямар сургуулийн багш вэ?
7. Эхнэр нь юу хийдэг вэ, багш уу?
8. Эмч үү, багш уу?
9. Тэднийх олуулаа юу?
10. Тэднийх хэдэн хүүхэдтэй вэ?
11. Тэд юу юу хийдэг вэ?
12. Дорж Дулмаа хоёр хэдтэй вэ?
13. Тэднийх хаана байдаг вэ?
14. Аав ээж тань юу хийдэг вэ?
15. Тэд нар хэд хэдэн настай вэ?
16. Та ах эгчтэй юу?
17. Чи ямар сургуульд суралцдаг вэ?
18. Чи дээд сургуульд суралцдаг уу?
19. Чи хэдтэй вэ?
20. Танайх ямар хотод байдаг вэ?
21. Чиний өвөг аав, эмэг ээж хоёр хотод уу, хөдөө юү?
22. Танайх ойрхон уу, хол уу?
23. Та ямар сургуульд суралцаж байсан бэ?
24. Та одоо ямар сургуульд суралцаж байна вэ?
25. Чи юу юуны хичээлтэй вэ?
26. Самбарын дэргэд юу байдаг вэ?
27. Шүүгээн дотор юу юу байдаг вэ?
28. Чи ямар сурдаг вэ?
29. Чи сайн сурдаг уу?
30. Чи монгол оюутантай танилцсан уу?

Даалгавар

Homework

1. Яриаг тогтоо, цээжээр ярь.

Learn the conversations by heart.

2. Өөрийнхөө гэр бүлийг дараахь асуултын дагуу ярь:

Speak about your family using the following questions:

Танайх олуулаа юу? Хэдүүлээ вэ? Юу юу чинь байдаг вэ? Хэн хэн, хаа хаа ажил хийдэг? Та өөрөө ямар ажил хийдэг вэ? Юу сурдаг вэ?

3. Орчуул.

Translate into Mongolian:

1. What does you elder brother do? He attends secondary school.
2. Do you have a younger brother? I have two younger sisters and an elder brother.
3. What does your father do? My father is a driver (teacher).
4. What is your age? I am eighteen.
5. How many brothers and sisters do you have? I have five elder brothers and one younger sister.

6. Do you have a grandfather and a grandmother? I have a grandfather, but I have no grandmother.
7. How old is your mother? My mother is fifty-three.
8. How many brothers and sisters does your father have? My father has five younger brothers/sisters and one elder brother.
9. What does your younger brother do? He goes to school.
10. What work do you have (do)? I study Mongolian and Russian at the University.
11. What is the name of your younger sister? Her name is Dulma.
12. How old is your teacher? Our teacher is forty.
13. Does your teacher have children? Yes, our teacher has three children, two daughters and one son.
14. How many bags have you got? I have two bags, one is small and one is big.
15. Our family is large. There are eight of us.

Хэлзүй

Grammar

1. Formation of new lexical units

Mongolian often uses combinations of words to express new abstract notions. Strictly speaking this is not 'word formation' but rather formation of new 'naming units', which are to be understood grammatically as syntagmas. Some words are used very frequently in such syntagmas.

<i>сан</i> storage, treasury; (foundation of capital)	<i>үгсийн сан</i>	lexicon (vocabulary)
<i>зүй</i> principle, regulation, law	<i>хэлний зүй</i>	grammar (law of language)

2. Partial number

In this lesson we encounter the following suffixes: *-ууд* / *-гүүд* and *-д* for *-р*.

<i>оюутан</i> > <i>оюутнууд</i>	in the form	<i>оюутнуудтай</i> with the students
<i>нөхөр</i> > <i>нөхөд</i>	in the phrase	<i>найз нөхдийндөө</i> at (our, your, etc.) friends'

3. Instrumental case

The instrumental case takes the suffix *-аар*⁴. Final short vowels are elided, final *-и*, *-о* merge with the suffix into *-иаар*/*-оор*. After final long vowels or diphthongs the hiatus filler *-г-* (exceptionally *-н-*) is inserted.

<i>сүүгээр</i>	with milk
<i>яриагаар</i>	through a talk
<i>ангиар</i>	by, with the class
But: <i>цайгаар</i>	through tea, by tea, with tea
<i>цайнаар</i>	at the time of tea (break) (cf. also L13, Gr. 9. Idioms)

In this lesson the instrumental will have a temporal meaning:

<i>завсарлагаар</i>	during the break
<i>амралтаар(аа)</i>	during vacations, during leave

Instrumental of personal pronouns:

1	надаар	бид нараар
2	чамаар (танаар)	та нараар, та бүхнээр
3	энүүгээр, тэргүүгээр энэнээр, тэрнээр (үүнээр, түүнээр)	эд нараар, тэд нараар эднүүдээр, тэднүүдээр эднүүсээр, тэднүүсээр (эдгээрээр, тэдгээрээр)

4. Postpositions

<i>дараа</i>	after (temporal meaning, with genitive)
<i>хичээлийн дараа</i>	after the lesson
<i>долоо хоногийн дараа</i>	in a week
<i>жилийн дараа</i>	in a year
<i>сарын дараа</i>	in a month
<i>цагийн дараа</i>	in an hour

<i>хүртэл</i>	till, up to (this is a verbal form of <i>хүр</i> 'to reach', which follows an accusative without an ending)
<i>дөрвөн цаг хүртэл</i>	till four o'clock
<i>их сургууль хүртэл (яв)</i>	(walk) up to the University

The following postpositions indicate the meaning 'after or before a certain point in time', if used with the **ablative** (cf. 7L, Gr. 2 for *өмнө* after G.):

<i>хойш</i>	: <i>үдээс хойш</i>	in the afternoon
	<i>хоёр цагаас хойш</i>	after two o'clock
<i>өмнө</i>	: <i>хоёр цагаас өмнө</i>	before two o'clock

5. Negation of the past tense

Negation in the past is expressed by the noun of the imperfect with the negative particle (cf. L4, Gr. 12 and also L6, Gr. 8).

<i>Та хийсэн үү?</i>	Did you do (it)? Have you done (it)?
<i>Хийгээгүй.</i>	I did not do, I have not done (it yet).

<i>Чи орчуулсан уу?</i>	Did you translate (it)? Have you translated (it)?
<i>Орчуулаагүй.</i>	I did not translate (it). I have not translated (it yet).

6. Negation of the present tense

The negation of the present tense is based on the same form as the negation of the past tense (the noun of the imperfect with the negative particle) followed by the present tense of the verb 'to be'.

Чи юу хийж байна вэ?
Юу ч хийгээгүй байна.

What are you doing?
I am not doing anything.

7. The converb of the perfect (*converbum perfecti*)

This form takes the suffix *-аад*⁴, which is added according to the same rules as the *nomen imperfecti* (cf. L4, Gr. 12). It designates an action preceding another action, from which it is separate:

<i>яваад</i>	having gone
<i>очоод</i>	having visited
<i>ороод</i>	having entered
<i>ирээд</i>	having come
<i>өгөөд</i>	having given
<i>хийгээд</i>	having done
<i>аваад</i>	having taken
<i>тэгээд</i>	having done so (= then)

<i>Та хичээлээ тараад юу хийдэг вэ?</i>	What do you (usually) do after the lesson (lit.: having finished the lesson)?
<i>Би тэднийд зургаан цагт (зургаад) очоод долоо(н цаг) хүртэл сууж ярилцана.</i>	I will visit them at six and sit and talk till seven.

8. Verbal phrases

Verbal phrases use converbs for all the verbs except the last verb in a chain (which consists mostly of two verbs, sometimes of three or more verbs). They describe successive actions or parallel actions. In most European languages the respective verbs are usually linked by 'and' (cf. L4, Gr. 14). The two verbs need not follow each other immediately.

<i>... ирж уулзна.</i>	... will come and meet.
<i>... сууж ярилцана.</i>	... will sit and talk.
<i>... өглөө босоод нүүр гараа угааж, өглөөний дасгал хийдэг.</i>	... get up in the morning, wash (my) face and hands and make the morning exercise.

The converb of the imperfect of the verb *яа*- 'to do how', is often used in verbal phrases and is to be translated by the word 'how', 'in which way' (as against *ямар*, which asks about quality of action; cf. L4).

<i>Чи яаж мэдсэн бэ?</i>	How did you learn (about it)?
<i>Энийг яаж хийх вэ?</i>	How is it done (to be done)? (or: How shall I do it?)

9. Days of the week

Monday	нэгдэх өдөр	Даваа (гариг)	(Moon)
Tuesday	хоёрдахь өдөр	Мягмар (гариг)	(Mars)
Wednesday	гурвадахь өдөр	Лхагва (гариг)	(Mercury)
Thursday	дөрөвдэх өдөр	Пүрэв (гариг)	(Jupiter)
Friday	тавадахь өдөр	Баасан (гариг)	(Venus)
Saturday	хагас сайн өдөр	Бямба (гариг)	(Saturn)
Sunday	(бүтэн) сайн өдөр	Ням (гариг)	(Sun)

The words based on the numerals are used in spoken language. Only Saturday and Sunday are commonly spoken of as a 'half nice day' ('half holiday') and a 'complete nice day' ('full holiday'). The words mentioned in the second place are names of planets and are more often used in official documents or announcements. Though the rules of orthography require that names (including the names of planets and days of the week) are written with initial capital letters, this rule is not always observed.

In modern written Mongolian the suffix *-daki* / *-deki* of classical Mongolian is spelled variously – *-дахь* / *-дахи*, *-дэх* / *-дэхи*. It may be written both as a suffix and as a separate word. Its pronunciation, however, follows the rules of vowel harmony – [дах, дэх, дох, дөх].

10. Months

Numerals are also used to designate the months. The dative-locative of the 'month' means 'in'.

нэг сар(д)	(in) January	долоон сар(д)	(in) July
хоёр сар(д)	(in) February	найман сар(д)	(in) August
гурван сар(д)	(in) March	есөн сар(д)	(in) September
дөрвөн сар(д)	(in) April	арван сар(д)	(in) October
таван сар(д)	(in) May	арван нэгэн сар(д)	(in) November
зургаан сар(д)	(in) June	арван хоёр сар(д)	(in) December

In spoken language the numerals usually have the form mentioned above, though the ordinal numerals are supposed to be more correct (they are also used in spoken language):

нэгдүгээр сар(д) (in) January, etc.

11. Numerals

Another case form, in which numerals are often used, is the dative-locative. Its forms slightly vary according to whether it designates the hour or room number as against the day of the month (in the former we specify the pronunciation of some of the forms which deviates from the spelling).

hour, room (at one, in room No. one etc.)		day of the month (on the first etc.)	
нэгд	наймд	нэгэнд	найманд
хоёрт	есөд	хоёрт, хоёронд*	есөнд
гуравт	аравт [arəvt]	гурванд	арван нэгэнд
дөрөвт	арван нэгд	дөрвөнд	арван нэгэнд
тавд	хорьд	таванд	хоринд
зургаад	хорин нэгд	зургаанд	хорин нэгэнд
долоод	гучид	долоонд	гучинд

(* colloquial form)

etc.

12. Time in hours

When specifying the time, the verb *бол-* 'to become, to be' is used.

Хэдэн цаг болж байна? (Цаг) хэд болж байна? What time is it? What's the time?

Нэг цаг болж байна. Нэг болж байна. It is one o'clock. It is one.

Арван цаг хагас болж байна. Арав хагас болж байна. It is half past ten.

Таван цагт арван минут дутуу байна.

Тавд арван минут дутуу байна. It is ten minutes to five.

Хэдэн цагт? Хэдэд?

At what time?

Арван цагт. Аравт.

At ten (o'clock).

13. Abbreviated enumeration

The word *зэрэг* 'degree, grade, level' is placed at the end of an enumeration and has the meaning 'and others, and so forth' (Hangin's dictionary, 1686, lists it as *зэрэг* 2.d).

Манайд хэлний зүй, ярианы хэл, уншлага, үгсийн сан зэрэг хичээл ордог. We have grammar, spoken language, reading, lexicology and other lessons.

14. Subject indicating particle

The enclitic form of the third person pronoun *нь* may also be used with the subject of the sentence. It has a slightly foregrounding or actualising function.

Энэ нь гуравдахь өдөр юм. It is (in fact, exactly, actually) Wednesday.

15. Idioms and phrases

Тийм биш.	It is not so.
Яах вэ?	What shall I do?
Заа мэдлээ.	Well, I understand (understood). I see.

Vocabulary

Шинэ үг

амралт	vacation, leave; rest, relaxation; spa
барэг	almost, nearly
бич- (Э2.3) (бичиж, бичих, бичнэ)	to write
бос- (ГЗ) (босч, босож**, босох, босно)	to get up; to rise
бүгд	all, everybody; in all
бүтэн	whole, complete
бүтэн сайн өдөр	Sunday
гар	hand
гариг (гараг)	day of the week; planet
давт- (Э2.2) (давтаж, давтах, давтана)	to repeat
дараа (G.)	after
долоо хоног	week
дутуу	insufficient, incomplete; missing, short of
зав	free time
завтай	(to be) free, (to have) free time
завгүй	(having) no time, busy
завсарлага	intermission, break
завсарла- (Э2.1) (завсарлаж, завсарлах, завсарлана)	to interrupt, make a break
заримдаа	sometimes
зөвхөн	only, just
зэрэг 1.b (бага зэрэг)	grade, level a little)
ид- (Э2.2) (идэж, идэх, иднэ)	to eat
кино (н)	cinema; motion picture
маргааш	tomorrow
мах (ан)	meat
минут	minute
мөн	also, again
нөгөөдөр	day after tomorrow
нүүр	face
нэрлэ- (Э2.1) (нэрлэж, нэрлэх, нэрлэнэ)	to call by name
орой	evening; late
оройн хоол (цай)	supper

орчуул- (Г1) (орчуулж, орчуулах, орчуулна)	to translate
өглөө (н)	morning
өглөөний цай (хоол)	breakfast
өдөр	day
өнөөдөр (өнөө)	today
сар	month
сар (ан)	Moon
сонос-, сонс- (Г3) (соносч, сонсож**, соносох/сонсох, соносно/сонсоно)	to listen
сурлага	learning, studies
сүү (н)	milk
тар- (Э2.4) (тарж, тарах, тарна)	to end, to finish
төмс (өн)	potato, potatoes
тэгээд	then
угаа- (Э1) (угааж, угаах, угаана)	to wash
уншлага	reading
уржигдар	the day before yesterday
утас (ан)	thread, wire; telephone
утсаар ярь- уу- (Э1) (ууж, уух, ууна)	to speak by telephone
үг (үгс)	to drink
үгсийн сан	word(s)
үд	vocabulary, lexicology
үдээс хойш	noon
үдээс өмнө	in the afternoon
үдийн хоол (цай)	before noon
хаач- (Э2.3) (хаачиж, хаачих, хаачна)	dinner, lunch
хааяа	to go where
хагас	now and then, from time to time
хагас сайн өдөр	half
харь- (хари-; Э2.4) (харьж, харих, харина)	Saturday
хоног	to return, to go back
хоол (он)	day and night; twenty-four hours
хөгжим	meal
хөөрүүл- (Г1) (хөрүүлж, хөөрүүлэх, хөөрүүлнэ) (сүү хөөрүүл- хүртэл (Асс.)	music
хэддэх (хэд дэх)	to make boil (milk)
хэлний зүй (хэлзүй, хэл зүй)	to make milk boil)
цаг	till, until
цай (н*)	which (day of the week)
чана- (Э2.1) (чанаж, чанах, чанана)	grammar
	hour; time
	tea
	to boil

шөл (өн)	soup
эрт	early
эхэл- (Э2.4)	to begin, to start
(эхэлж, эхлэх, эхэлнэ)	
ярианы хэл (эн)	spoken language

Pronunciation

Дуудах

[ɔ]	орон, ном, хоног, Долгор, тоглох, тор
[ɔ:]	хоол, жолооч, доор, тоор, тоо, одоо
[u]	дунд, булан, тухай, уран, худалдаа
[u:]	буудал, залуу, орчуулах, туулай, нууц
[ü]	үд, үг, үс, бүр, бүтэн, дүрэм, хүсэл
[ü:]	дүү, үүд, түүний, хүү, түүх, үүсэл
[ö]	өдөр, өчигдөр, зөвхөн, өвөг, нөхөр, төмөр, өгнө, хөгжим, өд, өт
[ö:]	өглөө, өөр, хөдөө, цөмөөрөө, цөөхүүлээ
[ŋ]	малчин, хуучин, охин, хүн, ан, эн
[ɣ]	гарах, гариг, гар, гав, гал, бага, хуурга
[d]	доод, дээд, дарга, долоо, дунд, дүү, эд
[t]	тар, тэр, тэнд, тариачин, тарах, тогло
[ʃ]	олон, мал, болох, долоо, хоол, монгол, залуу, улс, алд, алт, алхах
[ʃ]	аль, өглөө, хэл, өвөл, бүл, боль, толь, ажил, билээ, ойлгох, аливаа, элбэг
[u:]	хууль, дууль, тууль, суурь, ууль
[æ:]	гааль, сааль, заарь, даалин, маалинга
[a ^u]	зав, сав, давс, хав
[ɔ ^u]	дов, овт, ховс, товор, товир, шовойх
[ɔ: ^u]	боов, оноов, хоовин
[ö ^u]	зөв, төв, өвөр, өвөл, бөвнөх, төлөв, төвлөрсөн

1. Асуулт

Чи ~ та	хэдэн цагт	ирсэн ~ ирэх	бэ?
Та нар ~ Дорж	хэдэд	явсан ~ явах	вэ?

Хариу

(Би) (Дорж) (Тэд нар)	нэг ~ хоёр ~ гурван дөрвөн ~ таван . . . арван нэгэн ~ арван хоёр арван гурван . . .	цагт	ирсэн. ирнэ. явсан. явна.
	нэгд ~ хоёрт ~ гуравт ~ дөрөвт ~ тавд ~ зургаад долоод ~ наймд ~ есөд ~ арвд ~ арван нэгд		

2. Асуулт

Чи	хэддүгээр	өрөөнд ~ тасагт	байсан	бэ? вэ?
Та	аль	ангид ~ сургуульд	байгаа	
Та нар Дорж	хэдэд		байдаг суралцдаг	

Хариу

(Би) (Дорж) (Тэд)	нэгдүгээр ~ хоёрдугаар ~ гуравдугаар тавьдугаар ~ ердүгээр эрэн тавдугаар	өрөөнд ~ тасагт ангид ~ сургуульд	байсан. байгаа. байдаг. суралцдаг.
	нэгд ~ хоёрт ~ гуравт ~ тавьд ~ ерд ~ эрэн тавд		

3. Асуулт

Чи ~ Та нар	хэдэн цагт хэдэд	унтсан явсан	бэ? вэ?
Та ~ Тэр хүн		энд байсан бичсэн уншиж дууссан явах	

Хариу

(Бид) (Би) (Тэд) (Тэр хүн)	оройн 6 цагт ~ шөнийн 2 цагт ~ 8 цагт өглөөний 6 цагт ~ өглөө эрт	унтсан. явсан. энд байсан. бичсэн. уншиж дууссан. явна.
	оройн 6-д шөнийн 2-т ~ шөнийн 8-д өглөөний 6-д	

(Би) (Тэр хүн) (Дорж) (Бид нар)	номоо хичээлээ сониноо) сэтгүүлийг(ээ)	үзсэн уншсан үзээгүй уншаагүй уншиж дууссан уншиж дуусаагүй	(юм).
--	---	--	-------

Хариу

Тэр хүн Дорж Та Та нар	номоо хичээлээ сониноо) сэтгүүлийг(ээ)	үзсэн уншсан уншиж дууссан	үү? үү? юм үү?
---------------------------------	---	----------------------------------	----------------------

6. Асуулт

(Тэр эмэгтэй) (Тэр) (Бат) (Тэд) (Тэр хоёр) (Дулмаа батш хоёр)	сүргүй нь рүү цэцэрлэг рүү зочид буудал рүү оюутны байр рүү хот (рүү) ~ хөдөө	явсан яваагүй	(юм).
--	---	------------------	-------

Хариу

Тэр эмэгтэй Бат Тэд Тэр хоёр Дулмаа батш хоёр	сүргүй нь рүү цэцэрлэг рүү зочид буудал рүү оюутны байр рүү хот (рүү) ~ хөдөө	явсан	үү? юм үү?
---	---	-------	---------------

5. Асуулт

(Би) (Тэд) (Тэр хүн)	6 (зургаан) ~ 2 (хоёр) ~ 1 (нэг) 4 ~ 8 ~ 9 ~ 11 (арван нэгтэн) 20 (хорин) ~ 21 (хорин нэгтэн)	цаг	уншсан. явсан. уншсан. энд байсан. бичсэн. унтдаг. явна.
----------------------------	---	-----	--

Хариу

Чи Та Та нар Тэр хүн	хэдэн цаг	уншсан явсан уншсан энд байсан бичсэн унтдаг явах	ба? ба?
-------------------------------	-----------	---	------------

4. Асуулт

Чин Та Тэр оюутан Танар Ананд Дулмаа	Радио Телевиз Сургууль руу Гэртээ Идсэн Хийсэн Үзсэн Очсон Үншсан Соноссон Явсан Харьсан	Кино Танайд Манайд Оройн хоолоо Сонин Цэцэрлэгт Хичээлээ Гэртээ Сургууль руу Телевиз Давтсан	Үү? Үү? юм үү?
---	---	--	----------------------

9. Асуулт

(Би) (Бид) (Дорж) (Оюун)	Хичээлээ ажлаа номын тавиур хоол(оо) цай(гаа)	Хийж идэж үүж	Хийсэн. дүүссан.
-----------------------------------	---	---------------------	---------------------

Хариу

Чин Та Танар Дорж Оюун	Хичээлээ ажлаа номын тавиур хоол(оо) цай(гаа)	Хийж идэж үүж	Үү? Үү? юм үү?
------------------------------------	---	---------------------	----------------------

8. Асуулт

(Би) (Бид) (Оюун) (Тэрэл)	хоол(оо) цай(гаа)	етлөөний хөөл(оо) цай(гаа)	идсэн. үүсан. идээгүй. үүгагүй.
------------------------------------	----------------------	----------------------------------	--

Хариу

Чин Та Танар Оюун Тэрэл	хоол(оо) цай(гаа)	етлөөний хөөл(оо) цай(гаа)	Үү? үүсан юм үү?
-------------------------------------	----------------------	----------------------------------	------------------------

7. Асуулт

Хариу

(Би) (Тэр оюутан) (Бид) (Ананд) (Дулмаа)	радио телевиз сургууль руу гэртээ хичээлээ цэцэрлэгт сонин оройн хоолоо манайд танайд кино	давтсан. ~ идсэн. очсон. ~ соноссон. үзсэн. ~ уншсан. харьсан. ~ хийсэн. явсан. давтаагүй. ~ идээгүй. очоогүй. ~ соносоогүй. үзээгүй. ~ уншаагүй. хариагүй. ~ хийгээгүй. яваагүй.
--	--	--

10. Асуулт

Чи Та Дорж	хэзээ	цай мах төмс	чанадаг	вэ?
		хоол шөл	хийдэг	

Хариу

(Би) (Та) (Дорж)	өглөө ~ бүтэн сайн өдөр үдэд ~ орой хичээлээ тараад гэртээ хариад үдээс хойш үдээс өмнө 20 цагаас өмнө	цай мах төмс	чанадаг.
		хоол шөл	хийдэг.

11. Асуулт

Багш ~ аав Та ~ тэр эмэгтэй Чи		ажлаа хичээлээ	тараад дуусаад	юу хийдэг (юм) бэ?
Таны	авгай	гэртээ хариад		
Танай	нөхөр	тэнд очоод		
Чиний	хүү	үдээс хойш		
Түүний	аав	үдээс өмнө		

Хариу

(Багш) ~ (аав)		ажлаа	тараад	амардаг. сонин уншдаг. хүүхэдтэйгээ тоглодог. хоолоо хийдэг. юу ч хийдэггүй.
(Би) ~ (тэр эмэгтэй)		хичээлээ	дуусаад	
(Манай)	авгай	гэртээ хариад		
(Миний)	нөхөр	тэнд очоод		
(Түүний)	хүү	үдээс хойш		
	аав	үдээс өмнө		

12. Асуулт

Чи Тэр хүн Дулмаа Ринчен	өнөөдөр маргааш нөгөөдөр	хаашаа	явах	вэ? бэ? юм бэ?
	өчигдөр уржигдар үдээс хойш үдээс өмнө		явсан	

Хариу

(Би) (Тэр хүн) (Дулмаа) (Ринчен)	өнөөдөр маргааш нөгөөдөр	хаашаа ч	явахгүй.
	өчигдөр уржигдар үдээс хойш үдээс өмнө		яваагүй.

13. Асуулт (present tense)

Дорж Дулмаа Тэр хүн	одоо	хаашаа хэнтэй юу	явж ярьж хийж	байна (вэ)?
---------------------------	------	------------------------	---------------------	-------------

Хариу (negation of present tense)

(Дорж) (Дулмаа) (Тэр хүн)	одоо	хаашаа хэнтэй юу	ч	яваагүй яриагүй хийгээгүй	байна.
---------------------------------	------	------------------------	---	---------------------------------	--------

14. Асуулт

Өнөөдөр Маргааш Нөгөөдөр	хэддэх өдөр	вэ? юм бэ?		
Уржигдар Өчигдөр		байсан	бэ? юм бэ?	

Хариу

Өнөөдөр Маргааш Нөгөөдөр	нэгдэх ~ хоёрдахь гуравдахь ~ дөрөвдэх тавдахь	өдөр	(юм). (байна).
Уржигдар Өчигдөр	зургаадахь ~ хагас сайн долоодахь ~ бүтэн сайн		байсан (юм).

15. Асуулт

Өнөөдөр Маргааш Нөгөөдөр	ямар гариг	вэ? (билээ)?
Уржигдар Өчигдөр		байсан (юм) бэ?

Хариу

Өнөөдөр Маргааш Нөгөөдөр	Даваа Мягмар Лхагва	(гариг)	(юм). (байна).
Уржигдар Өчигдөр	Пүрэв Баасан Бямба Ням		байсан (юм).

16. Асуулт А:

Та Чи Доржийнх Тэднийх	шинэ энэ тэр энд Монголд Улаанбаатарт	гэрт сууцанд байранд	хэзээ	орсон ирсэн	бэ? юм бэ?

Хариу Б:

(Би) (Доржийнх) (Тэднийх) (Манайх)	шинэ энэ тэр энд Монголд Улаанбаатарт	гэрт сууцанд байранд	нэг ~ хоёр ~ гурван ~ дөрвөн таван ~ зургаан ~ долоон найман ~ есөн ~ арван арван нэгэн ~ арван хоёр	сард	орсон ирсэн	(юм).
---	--	----------------------------	---	------	----------------	-------

Хариу В:

Тийм Аа тийм Тэгсэн Аа тэгсэн	үү?
--	-----

Хариу Г:

Тийм (ээ), Тэгсэн,	нэг ~ хоёр ~ гурван ~ дөрвөн таван ~ зургаан ~ долоон найман ~ есөн ~ арван арван нэгэн ~ арван хоёр	сард	орсон ирсэн	(шүү). (юм).
-----------------------	---	------	----------------	-----------------

Угуй, (би) (бид нар) (Дулмаа)	уншдаггүй. ~ унтдаггүй. ~ бичдэггүй. босдоггүй. ~ хийдэггүй. ~ үздэггүй. суудаггүй. ~ асуудаггүй. ~ хардаггүй. толгодоггүй. ~ харивилдаггүй. соноцдоггүй. ~ явдаггүй. ~ хоол иддэггүй. орчуулдаггүй. ~ авчирдаггүй.
--	--

Үгчилгэсэн хариу:

Тэгдэг, (би) (бид) (бид нар) (Дулмаа)	уншдаг. ~ унтдаг. ~ бичдэг. босдог. ~ хийдэг. ~ үздэг. суудаг. ~ асуудаг. ~ хардаг. толгодог. ~ харивилдаг. соноцдог. ~ явдаг. ~ хоол иддэг. орчуулдаг. ~ авчирдаг.
---	--

Батасан хариу:

Чи ~ та Та нар Дулмаа	уншдаг ~ унтдаг ~ бичдэг босдог ~ хийдэг ~ үздэг суудаг ~ асуудаг ~ хардаг толгодог ~ харивилдаг соноцдог ~ явдаг ~ хоол иддэг орчуулдаг ~ авчирдаг	үү? үү?
-----------------------------	--	------------

18. Асуул

Угуй, (би) (бид) (Тэр хүн) (Дорж гуай)	өчигдөр үржигдэр нэгдэх өдөр	гэртээ байрандаа сүргүүль дээрээ тэндийд	оноогүй. ирээгүй. байгаагүй. сүүж байгаагүй. унтаж байгаагүй.
--	------------------------------------	---	---

Үгчилгэсэн хариу:

Тэгсэн, (би) (бид) (Тэр хүн) (Дорж гуай)	өчигдөр үржигдэр нэгдэх өдөр	гэртээ байрандаа сүргүүль дээрээ тэндийд	орсон. ирсэн. байсан. сүүж байсан. унтаж байсан.
--	------------------------------------	---	--

Батасан хариу:

Чи Та Тэр хүн Та нар Дорж гуай	өчигдөр үржигдэр нэгдэх өдөр	гэртээ байрандаа сүргүүль дээрээ тэндийд	орсон ирсэн байсан сүүж байсан унтаж байсан	үү? үү?
--	------------------------------------	---	---	------------

17. Асуул

19. Асуулт

Чи ~ та Та нар Дулмаа	унших ~ бичих ~ харах соносох ~ орчуулах ~ босох унтах ~ тоглох ~ суух явах ~ цай чанах ~ хоол хийх	уу? үү?
-----------------------------	--	------------

Баталсан хариу:

Тэгнэ,	(би) (бид) (бид нар) (Дулмаа)	уншина. ~ унтана. ~ бичнэ. босно. ~ хийнэ. ~ үзнэ. сууна. ~ асууна. ~ харна. тоглоно. ~ хариулна. соносно. ~ явна. ~ хоол иднэ. орчуулна. ~ авчирна.
--------	--	---

Үгүйсгэсэн хариу:

Үгүй,	(би) (бид) (бид нар) (Дулмаа)	уншихгүй. ~ унтахгүй. ~ бичихгүй. босохгүй. ~ хийхгүй. ~ үзэхгүй. суухгүй. ~ асуухгүй. ~ харахгүй. тоглохгүй. ~ хариулахгүй. сонсохгүй. ~ явахгүй. ~ хоол идэхгүй. орчуулахгүй. ~ авчрахгүй.
-------	--	---

20. Асуулт

Чи ~ та Та нар Дулмаа	уншиж ~ бичиж ~ харж соносч ~ орчуулж ~ босч унтаж ~ сууж ~ тоглож явж ~ юм хийж	байна уу?
-----------------------------	---	-----------

Баталсан хариу:

Тийм ээ, тэгж байна.	(Би) (Бид) (Бид нар) (Дулмаа)	уншиж ~ бичиж ~ харж соносч ~ орчуулж ~ босч унтаж ~ сууж ~ тоглож явж ~ юм хийж	байна.
----------------------	--	---	--------

Үгүйсгэсэн хариу:

Үгүй,	(би) (бид) (бид нар) (Дулмаа)	уншаагүй ~ унтаагүй ~ бичээгүй босоогүй ~ хийгээгүй ~ үзээгүй суугаагүй ~ асуугаагүй ~ хараагүй тоглоогүй ~ хариулаагүй сонсоогүй ~ яваагүй ~ хоол идээгүй орчуулаагүй ~ авчираагүй	байна.
-------	--	--	--------

21. Асуулт

Чи ~ та Та нар Дулмаа Тэр хүн	(одоо)	уншиж ~ бичиж ~ орчуулж босч ~ унтаж ~ явж ~ цай ууж	байгаа юу?
--	--------	---	------------

Баталсан хариу:

Тийм ээ. Тэгж байгаа.	(Би) (Бид) (Бид нар) (Дулмаа) (Тэр хүн)	(одоо)	уншиж ~ бичиж ~ орчуулж босч ~ унтаж ~ явж ~ цай ууж	байгаа.
--------------------------	---	--------	---	---------

Үгүйсгэсэн хариу:

Үгүй.	(Би) (Бид) (Бид нар) (Дулмаа) (Тэр хүн)	(одоо)	уншаагүй ~ бичээгүй ~ орчуулаагүй босоогүй ~ унтаагүй ~ яваагүй цай уугаагүй	байгаа.
-------	---	--------	--	---------

Яриа

Conversations

1-р яриа

- Та өглөө хэдэн цагт босдог вэ?
– (Би) долоон цагт босдог.
- Та өглөө босоод юу хийдэг вэ?
– (Би) өглөө босоод нүүр гараа угааж, өглөөний дасгал хийдэг. Тэгээд цайгаа уугаад хичээлдээ явдаг.
- Та хичээлдээ хэдэн цагт явдаг вэ, найман цагт явдаг уу?
– Үгүй, (би) найман цаг хагаст гэрээсээ гардаг.
- Танай хичээл хэдэн цагт эхэлдэг вэ?
– (Манай хичээл) есөн цагт эхэлдэг.
- Та өдөрт хэдэн цагийн хичээл хийдэг вэ, зургаан цаг уу?
– Тийм, зөвхөн нэг өдөр дөрвөн цагийн хичээлтэй байдаг.
- Та долоо хоногт олон цагийн хичээлтэй юу?
– Олон, (долоо хоногт) хорин найман цагийн хичээлтэй байдаг.
- Танай хичээл хэзээ (хэдэн цагт) тардаг (дуусдаг) вэ?
– Манай хичээл 15 (арван таван) цагт тардаг. Харин өнөөдөр 13 (арван гурван) цагт тарна (дуусна).
- Тийм үү? Та хичээлээ тараад юу хийдэг вэ? Өнөөдөр хичээлийн дараа юу хийх вэ?

- (Би) хичээлээ тараад гэртээ харьж хоолоо идээд жаахан амардаг. Тэгээд даалгавраа хийдэг. Харин өнөөдөр Доржийнд очно.
- 9. Та Доржийнд хэдэн цагт очих вэ?
 - (Би) тэднийд 6 цагт очоод 7 цаг хүртэл сууж ярилцана.
- 10. Дараа нь гэртээ хариад та юу хийх вэ?
 - Би бага зэрэг ном уншаад есөн цагт унтана.

2-р яриа

- Өнөөдөр чи хэдэн цагийн хичээлтэй вэ?
- Зургаа (зургаан цагийн хичээлтэй).
- Зургаан цагийн хичээл гурван цагт тарах уу?
- Тэгнэ, (гурван цагт тарна).
- Өнөөдөр чи ямар ямар хичээлтэй вэ?
- (Би) өнөөдөр хэлний зүй, ярианы хэл, уншлагын хичээлтэй.
- Одоо танайд ямар (юуны) хичээл орж байна вэ?
- Одоо (манайд) ярианы хэл орж байна.
- Дараа нь ямар хичээлтэй вэ?
- Дараа нь уншлага орно.
- Чи одоо завсарлаж байна уу?
- Тийм, (завсарлаж байна).
- Танай хичээл хэдэн минут завсарладаг юм бэ?
- Таван минут (завсарладаг).
- Чи завсарлагаар юу хийдэг вэ?
- (Би завсарлагаар) монгол оюутантай ярьдаг (ярилцдаг).

3-р яриа

- Чи хичээл тараад хаачих вэ?
- Гэртээ харина. Чи бас харих уу?
- Харина. Тэгээд Доржийнд очно.
- Дорж өнөөдөр гэртээ бий юу?
- Бий, өнөөдөр ажилдаа яваагүй.
- Тийм үү, чи яаж мэдсэн юм бэ?
- Би өчигдөр орой утсаар ярьсан (юм). Чи надтай явах (манайд очих) уу?
- Би өнөөдөр завгүй.
- За, чи маргааш манайд очоорой.
- Хэдэн цагт? Чи маргааш гэртээ байх уу?
- Байна. Би маргааш хичээлгүй. Чи 2 (хоёр) цагт очоорой.
- За, за. Би маргаааш хичээлийн дараа танайд очно.

4-р яриа

- Хэдэн цаг болж байна? (Хэд болж байна?)
- Есөн цаг болж байна (Ес болж байна). Танай хичээл есөн цагт эхлэх үү?
- Үгүй ээ, найман цагт (наймд) эхэлнэ.

- Манай хичээл 9 (есөн) цагт эхлээд 18 (арван найман цагт) тардаг. Чи өнөөдөр хэдэн цагийн хичээлтэй вэ?
- Зургаа (6 цагийн хичээлтэй).
- Маргааш хэдэн цагтай вэ? (Маргааш хэдэн цагийн хичээлтэй вэ?)
- Маргааш бас 6 цагтай.
- Нөгөөдөр?
- Нөгөөдөр хичээлгүй. Хагас сайн шүү дээ, амарна.

5-р яриа

- Багш: - За, сайхан амарсан уу?
- Оюутан: - Сайхан амарсан.
- Багш: - Амралтаараа юу хийсэн бэ? Яриарай.
- Оюутан: - Би өчигдөр өглөө 8 цагт босоод, нүүр гараа угааж, өглөөний цайгаа (=өглөөнийхөө цайг) уусан. Дараа нь Доржийнд очсон. Доржийнд очоод, Дорж Дулмаа хоёртой жаахан ярьж суусан. Оройн 6 цагт бид кино үзсэн.
- Багш: - За, сайн байна. Гэрийн даалгавар чинь хаана байна?
- Оюутан: - Энэ (байна).
- Багш: - Уншаад яриарай.
- Оюутан: - За.
- Багш: - Сайн байна. Энийг орчуулсан уу, үгүй юу?
- Оюутан: - Орчуулаагүй.

6-р яриа

- Сайн байна уу?
- Сайн, сайн байна уу?
- Сайн. Ажил сайн уу?
- Сайн, чиний сурлага сайн уу?
- Зүгээр, сайн.
- Чи хаашаа явж байна?
- Ажилдаа явж байна. Чи?
- Би хичээлдээ явж байна.
- За, баяртай.
- Баяртай.

7-р яриа

- Сайн байна уу, би Дорж байна, Дулмаатай ярьж болох уу?
- Дулмаа байхгүй байна. Ажил нь дуусаад гэр лүүгээ явсан.
- Маргааш хэдийд түүнтэй ярьж болох вэ?
- Тэр маргааш (нэгдэхэд) үдээс хойш ажилдаа ирдэг.
- Нөгөөдөр?
- Нөгөөдөр (хоёр дахид) үдээс өмнө ирнэ.
- Заа мэдлээ, танд баярлалаа.

1. МИНИЙ АЖЛЫН ӨДӨР

Би өглөө 7 (долоон) цагт босдог. Тэгээд нүүр гараа угааж, өглөөний дасгал (гимнастик) хийдэг. Дараа нь өглөөний цайгаа уугаад хичээлдээ явдаг. Миний хичээл 9 цагт эхэлдэг. Би бараг өдөр бүр 4 цагийн хичээлтэй байдаг. Зөвхөн нэг өдөр хоёр цагийн хичээл хийдэг. Энэ нь гуравдахь өдөр юм. Би 7 (долоо) хоногт бүгд 18 (арван найман) цагийн хичээлтэй. Манайд хэлзүй, ярианы хэл, уншлага, үгсийн сан зэрэг хичээл ордог (байдаг). Манай хичээл өдрийн 15 (арван таван) цагт, заримдаа 11 (арван нэгэн) цагт тардаг.

Би хичээлээ тараад гэртээ харьдаг. Тэгээд хоолоо идээд жаахан амардаг. Дараа нь гэрийн даалгавраа хийж, хичээлээ давтдаг. Заримдаа номын санд очиж, ном уншдаг. Хааяа телевиз үзэж, хөгжим соносдог. Хагас бүтэн сайн өдөр кино үздэг. Завтай цагтаа найз нөхдийндөө очиж ярилцдаг. Оройн цагаар бага зэрэг ном уншаад арван цагт унтдаг.

2. ДОЛОО ХОНОГ

Долоо хоногийн өдрийг даваа (гариг), мягмар (гариг), лхагва (гариг), пүрэв (гариг), баасан (гариг), бямба (гариг), ням (гариг) гэж нэрлэдэг. Энэ 7 нэр бол төвөд хэлнээс орж ирсэн юм.

Бас нэгдэх өдөр, хоёрдахь өдөр, гуравдахь өдөр, дөрөвдэх өдөр, тавдахь өдөр, зургаадахь өдөр, долоодахь өдөр гэдэг. Энэ 7 нэрийг орос хэлнээс орчуулжээ. Мөн зургаадахь өдрийг хагас сайн өдөр, долоодахь өдрийг бүтэн сайн өдөр гэдэг. Хагас сайн өдөр нь хагас ажлын өдөр, бүтэн сайн өдөр нь бүтэн амралтын өдөр байсан.

Exercises

Дасгал

1. Хаалтандахь үгнүүдийг ашиглан **Answer according to the model while үлгэрийн дагуу хариул.** using the words in brackets.

ҮЛГЭР А: Чи хэзээ кино үзэх вэ? (МАРГААШ)

БИ МАРГААШ КИНО ҮЗНЭ.

(ХАГАС САЙН ӨДӨР, ӨНӨӨДӨР, ӨНӨӨ ОРОЙ, АМРАЛТААРАА, ХИЧЭЭЛИЙН ДАРАА, МЯГМАРТ, ЛХАГВАД, ТАВДХИД (ТАВДАХЬ ӨДӨР), НӨГӨӨДӨР, НӨГӨӨДӨР ОРОЙ)

ҮЛГЭР Б: Чи маргааш хэнтэй кино үзэх вэ? (СҮРЭН)

БИ МАРГААШ СҮРЭНТЭЙ(ГЭЭ) КИНО ҮЗНЭ.

(ДУЛМАА, ЭРДЭНЭ, БАГШ, НАЙЗ, ЭЭЖ, ДҮҮ, ГЭРИЙНХЭН, АНГИЙНХАН, ГАНЦААРАА)

2. Хаалтандахь асуултын оронд цаг заасан үг тавь. Replace the interrogatives in brackets by words denoting time.

Өнөөдөр аав маань (хэдэн цагт) гэртээ харина. Ээж маань (хэзээ) ажилдаа явдаг. Миний хичээл (хэдэн цагт) тардаг. Өнөөдөр би (хэзээ) харина. Чи манайд орой (хэдэн цагт) очоорой. Маргааш би (хэзээ) сургууль дээр ирнэ. Тэгээд хоёулаа (хэзээ) номын санд очно. Тэр хүн (хэзээ) энд байсан. Ананд маргааш биш, (хэзээ) ирнэ.

3. Хоёр өгүүлдэрийг үлгэрийн дагуу холбож хэл. Use the model in order to construct one sentence.

ҮЛГЭР: Аав орой ирдэг. Тэгээд хоолоо иддэг.
ААВ ОРОЙ ИРЭЭД ХООЛОО ИДДЭГ.

- а) Манайхан өглөө 7 цагт босдог. Тэгээд манайхан цайгаа уудаг.
- б) Манайхан өглөөний цайгаа уудаг. Тэгээд ажил сургуульдаа явдаг.
- в) Би өнөөдөр гэртээ гурван цагт ирсэн. Тэгээд би тэр киног үзсэн.
- г) Би өчигдөр Доржийнд очсон. Тэгээд би Дорж Дулмаа хоёртой кинонд явсан. Тэгээд би гэртээ ганцаараа харьсан.
- д) Би түүний нэрийг Дулмаагаас утсаар асуусан. Тэгээд мэдсэн.

4. Хаалтандахь асуултын оронд зохих үгийг тавь. Replace the interrogatives in brackets by suitable words.

Миний ээж (хаана) ажилладаг. Аав минь (хаана) ажилладаг. Би (хаана) суралцдаг. Дүү минь (хаана) суралцаж байна. Миний найз Ян (хаанаас) ирсэн. Одоо (хаана) суралцаж байна. Чи хичээлийн дараа (хаашаа) явна. Би (хаашаа) явна. Долгор гуай (хаана) ажилладаг. Миний найз Дорж амралтын өдөр (хаашаа) явсан. Багш (хаанаас) ирсэн.

5. Хаалтандахь үгийг ашиглан асуултад хариул. Answer the questions while using the words in brackets.

- а) Чи хаанаас ирсэн бэ ?
(сургууль, сургууль дээр, Доржийнх, номын сан, их сургуулийн тэнд, "Чингис хаан" зочид буудлын тэнд)
- б) Чи хаашаа явах вэ ?
(сургууль, Доржийнх, номын сан, зочид буудал, оюутны байр, танайх, гэр, ажил, хөдөө)

**6. Цэгийн оронд зохих үйл үгийг
үлгэрийн дагуу тавь.**

Use the model in order to fill in suitable words.

ҮЛГЭР: БИ НОМ УНШСАН.
БИ НОМ УНШИЖ БАЙНА.
БИ НОМ УНШИНА.

- А. Би одоо кино . . .
Би өчигдөр кино . . .
Би маргааш кино . . .
- Б. Аав ажлаасаа 5 цагт . . .
Аав ажлаасаа 5 цагт . . .
Аав ажлаасаа 5 цагт . . .
- В. Би гэрийн даалгавраа . . .
Би гэрийн даалгавраа . . .
Би гэрийн даалгавраа . . .
- Г. Дорж нүүр гараа . . .
Дорж нүүр гараа . . .
Дорж нүүр гараа . . .
- Д. Туяа өчигдөр хоолоо . . .
Туяа өнөөдөр хоолоо . . .
Туяа маргааш хоолоо . . .
- Е. Манай ээж одоо . . .
Манай ээж өчигдөр . . .
Манай ээж маргааш . . .

7. Өгүүлбэрүүдийг үгүйсгэх хэлбэрт оруул. Change the sentences into the negative.

Би өчигдөр Доржтой кино үзсэн. Дорж өнөөдөр ажилдаа явсан. Бид гэрийн даалгавраа хийсэн. Доржийн аав ээж хоёр ажил хийдэг. Тэд хотод байдаг. Миний хүү дээд сургуульд сурдаг. Би бүтэн сайн өдөр амарсан. Дорж гуай нэгдэх өдөр амардаг. Болд гэртээ харьсан. Дулмаа хоолоо хийсэн. Цэцэг орой хоол иддэг. Дорж хичээлээ өдөр бүр давтдаг. Цэрэн даалгавраа бичсэн.

8. Цэгийн оронд зохих үйл үгийг тавь. Fill in suitable verbs.

- а) Дорж Их сургууль дээр ярьж байна: Би өглөө 7 хагаст гэрээсээ . . . (явдаг, гардаг). Их сургууль хүртэл 15 минут . . . (ирдэг, очдог, явдаг). Тэгээд 7 цаг 45 минутад сургууль дээрээ . . . (ирдэг, очдог). Хичээлийн дараа бас гэрлүүтээ

15 минут ... (очдог, явдаг, харьдаг). Тэгээд 15 цагт гэртээ ... (ирдэг, харьдаг). Амралтын өдөр заримдаа би найзындаа ... (очдог, ирдэг). Заримдаа найз минь манайд ... (ирдэг, очдог).

б) Дорж гэртээ ярьж байна: Би өнөө өглөө 7 хагаст гэрээсээ ... (гарсан, явсан). Их сургууль хүртэл 15 минут ... (ирсэн, явсан). Тэгээд 7 цаг 45 минутад сургууль дээрээ ... (ирсэн, очсон). Хичээлийн дараа бас гэрлүүгээ 15 минут ... (явсан, харьсан). Тэгээд 15 цагт гэртээ ... (харьсан, ирсэн, очсон). Өнөө орой миний найз манайд ... (ирнэ, очно). Харин маргааш би найзындаа ... (ирнэ, очно, харина).

9. Орчуулах.

Translation.

Би саяхан нэг ажилд орсон. Хичээл тараад л би тэр ажил руу явдаг. Миний ажлын газар хол биш, 10 минут яваад л ажлынхаа газар очдог. Би тэнд 4 цаг ажилладаг. Ажлаа тараад орой 18 цагт гэртээ харьдаг. Миний найз бас 18 цагт ажлаасаа ирдэг. Тэгээд хоёулаа оройн хоол хийдэг.

10. Асуултад үлгэрийн дагуу хариул. Answer using the model.

ҮЛГЭР: Тэр хүн үдийн цайгаа уусан уу?

ТЭР ХҮН ҮДИЙН ЦАЙГАА УУГААГҮЙ.

ТЭР ХҮН ҮДИЙН ЦАЙГАА УУСАН.

ТЭР ХҮН ҮДИЙН ЦАЙГАА УУХГҮЙ.

ТЭР ХҮН ҮДИЙН ЦАЙГАА УУЖ ДУУССАН.

1. Тэр хүүхэд өглөө нүүр гараа угаасан уу?
2. Чи хичээл бүрийн яриаг орчуулсан уу?
3. Та нар үгсийн сангийн хичээлийн даалгавраа хийсэн үү?
4. Оюутнууд орой хөгжим соноссон уу?
5. Чиний хоёр дүү хүүхдийн өрөөнд тоглосон уу?
6. Тэр оюутан сэтгүүл уншсан уу?
7. Ананд 6 цагт боссон уу?
8. Дорж Цэцэг хоёр кино үзсэн үү?

11. Асуултыг нөх.

Fill in interrogative sentences.

1. - ...? - Тэгдэг. Өглөө 7 цагт босдог.
2. - ...? - Үгүй, би явахгүй.
3. - ...? - Үгүй, би яваагүй.
4. - ...? - Тэгсэн, бид кино үзсэн.
5. - ...? - Үгүй, Дорж босоогүй.
6. - ...? - Тэгсэн, би өчигдөр орой уншсан.
7. - ...? - Үгүй, би мах иддэггүй.
8. - ...? - Тийм ээ, би Батын эхнэрийг таньдаг.
9. - ...? - Тийм, Дулмаа үдээс өмнө ажилд яваад үдээс хойш хичээлдээ явдаг.

10. –...? – Үгүй, ач хүү маань унтаж байна.
11. –...? – Тэгнэ ээ, би маргааш авчирна.
12. –...? – Дорж сургууль дээрээ байна.
13. –...? – Тэр оюутан одоо Прагад яваа.
14. –...? – Тэгсэн юм. Энийг миний эхнэр хийсэн юм.
15. –...? – Үгүй, би эрт унтаж эрт босдог.
16. –...? – Тийм биш, Дорж орой унтаж орой босдог.

12. Асуулгад хариул.

Answer the questions.

1. Дорж гуай хаана юу хийдэг вэ?
2. Ажилдаа хэдэн цагт яваад хэдэн цагт харьдаг вэ?
3. Чи өнөөдөр хэдэн цагт харих вэ?
4. Тэр хүн хэзээ ирэх вэ?
5. Чи өчигдөр хэдэн цагт харьсан бэ?
6. Чи өчигдөр хариад юу хийсэн бэ?
7. Маргааш чи хэдэн цагийн хичээлтэй вэ?
8. Маргааш чи хэдэн хичээлтэй вэ?
9. Танай хичээл хэдэн цагт тарах вэ?
10. Та амралтын өдөр юу хийдэг вэ?
11. Чи өглөө хэдэн цагт босдог вэ?
12. Чи нөгөөдөр завтай юу, үгүй юү?
13. Чи уржигдар хичээлийн дараа Доржийнд очсон уу?
14. Ринчен өнөөдөр хичээлдээ явсан уу, үгүй юү?
15. Одоо хэдэн цаг болж байна ?
16. Доржийн хадам эх хотод байгаа юу?
17. Чи өглөө 9 цагт унтаж байсан уу?
18. Надад хагас сайны үдээс хойш зав гарахгүй. Яах вэ?

Homework

Даалгавар

1. Яриануудыг тогтоогоод ярь. Learn the conversations by heart.
2. Өөрийнхөө ажлын өдрийг ярь. Speak about your working day.
3. Эцэг эх, ах дүү, найз нөхдийнхөө ажлын тухай ярь. Speak about the work of your parents or friends.
4. Орчуул: Translate into Mongolian:
 1. At what time do you get up in the morning? At half past six.
 2. When do you leave for work? I leave at half past seven.
 3. When does your work begin? It begins at eight.
 4. How many hours a week do you work? I work 42 hours.

5. When does your work finish? My work finishes at 16 hours.
6. Do you also work on Saturdays and Sundays? No, I work only on Saturdays. I do not work on Sundays, I take a rest.
7. How many days in the week do you work? I work five days a week – from Monday till Friday.
8. Where will you go after work? I will go home after work.
9. What do you do after going home? I have a little rest and then watch TV. Sometimes I read.
10. When (at what time) do you go to bed? I go to bed at 11 o'clock.
11. What did you do yesterday? Did you go to school? No, I did not go to school, I was at home.
12. Did Dorji do the homework? He did not. Did he know about the homework? He did not.
13. What did you do yesterday? I did not do anything yesterday. I took a rest.
14. Where will you go tomorrow (the day after tomorrow, on Sunday)? I will not go anywhere, I will be learning Mongolian.
15. Will your elder brother be at home tomorrow? I will come to your house at five, right? (May I come to your house tomorrow at five?)
16. It is not possible tomorrow, I am going to the cinema with my brother. Come to see us the day after tomorrow.
17. Which day is it today? It is Monday today. It was Sunday yesterday.
18. Did you have a good rest yesterday? No, I did not have a rest. I was learning Mongolian the whole day.
19. Did you read the newspaper yesterday? Yes, I did. Did you read about the farmers? I did.
20. I will have a rest tomorrow morning and in the afternoon I will translate it.

Хэлзүй

Grammar

1. Nouns derived from adverbs

Adjectives or nouns may be derived from adverbs by the suffix *-x* (preceded by a linking vowel) with the meaning 'being somewhere' (cf. also the derivation of Collectives, L3, Gr. 1).

тэнд-э-х the thing (which is) there
энд-э-х the thing (which is) here

тэндэхийн / тэндхийн of the thing (which is) there
эндэхийн / эндхийн of the thing (which is) here

2. Reflexive pronoun

N. *өөрөө* ... self pl. *өөрсөд*... selves (written language)
өөрсдөө (with the affix *-аа*⁴)
өөрснөө (spoken language)

D.-L. *өөртөө* to ... self

This pronoun can be used with personal pronouns (*би өөрөө, та өөрөө, чи өөрөө*, etc.). In colloquial language *өөрөө* can be used instead of *та, чи*.

3. Sociative

The sociative case may also be used in some special phrases:

тавагтай хоол meal on the plate, plate of (any) meal
аягатай цай a cup of tea
тостой талх bread and butter

4. Voluntative

The voluntative takes the suffixes *-я*, *-е*, *-ѐ* after the final long vowel or diphthong, or *-ье*, *-ья/-ья*, *-ьѐ/-ьѐ* after the final consonant. The latter two pairs can also be written as *-ая*, *-оѐ* in male words. The suffix is pronounced [-(^h)j]/[-^hj]. Sometimes a long vowel (*aa*⁴) according to vowel harmony may be added at the end. The voluntative expresses an intention or invitation for the first person (both singular and plural) to perform an action.

<i>авъя</i>	[av ^h j/ av ^h j]	let me (us) take
<i>үзье</i>	[üç ^h j/ üç ^h j]	let me (us) see
<i>оръѐ</i>	[or ^h j/ or ^h j]	let me (us) enter
<i>хүлээе</i>	[χüle:j]	let me (us) wait
<i>тэгье</i>	[tæg ^h j/ tæg ^h j]	let me (us) do like that
<i>угаая</i>	[uga:j]	let me (us) wash
<i>өгье</i>	[ög ^h j/ ög ^h j]	let me (us) give
<i>хийе</i>	[çi:j]	let me (us) do, make
<i>барья</i>	[bar ^h j]	let me grasp
<i>хольѐ</i>	[xɔ ^h j]	let me mix
<i>оѐѐ</i>	[ɔ ^h j]	let me sew
<i>уяя</i>	[uj ^h j]	let me tie (up)

5. Deverbal adjectives

The suffix *-маар*⁴ forms verbal adjectives, which express the meaning ‘permitting or recommending the action of the verb’:

<i>идмээр</i>	eatable, what may be eaten.
---------------	-----------------------------

In connection with the verb ‘to be’ the phrase corresponds to ‘I want, you want’, etc.:

<i>авмаар байна</i>	I want to take
<i>ормоор байна</i>	I want to enter
<i>идмээр байна</i>	I want to eat
<i>өгмөөр байна</i>	I want to give
<i>уумаар байна</i>	I want to drink

With the negative particle *-гүй* the phrase corresponds to ‘I do not want to’, etc.:

<i>уумааргүй байна</i>	I do not want to drink
------------------------	------------------------

6. Verbal nouns as attributes

The verbal nouns (*nomen perfecti*, *nomen futuri*, *nomen usus*) may be used as attributes:

<i>захиалсан хоол</i>	ordered meal
<i>идэх хоол</i>	a meal to eat; a meal, which will be eaten
<i>уух юм</i>	something to drink
<i>суралцдаг сургууль</i>	a school in which a person studies

Such phrases correspond to English dependent clauses. The subject takes the form of the genitive. The phrases may also have other 'sentence elements' – the object, adverbials, etc.

<i>Доржийн захиалсан хоол</i>	the meal (which was) ordered by Dorji
<i>миний хичээл хийдэг анги</i>	the class where I teach the lesson
<i>Монголоос ирсэн оюутан</i>	the student(s) who came from Mongolia
<i>миний өчигдөр уншсан ном</i>	the book which I read yesterday

7. *Nomen imperfecti* of some verbs

In a few cases this form may also be used in the spoken language. The respective verbs express duration (to be, to sit/live) or a process (to go/move). They are mostly used for the third person in questions and answers to denote present duration or state (formation cf. L4, Gr. 12).

<i>яваа</i>	he left (is on the way; but also 'is, exists')
<i>байгаа</i>	is, is found
<i>суугаа</i>	sits, lives

(Би) (Тэр хүн) (Тэд)	энэ тэр	«Бэлэг дурсгал» «Халуун хоол» «Зочин бүүз»	дэлгүүрээс шүүдэнгээс дүтлүүрээс юу ч юм	Тэндээс ~ эндээс Доржоос ~ чамгаас	Талх чихээр сонин дүтлүй сүү цамц	авсан.	аваагүй.
	дэлгүүрээс мухагтаас шүүдэнгээс хүнээс						

Хариу

Та Чи Тэр хүн Тэд	энэ тэр	«Бэлэг дурсгал» «Халуун хоол» «Зочин бүүз»	дэлгүүрээс шүүдэнгээс дүтлүүрээс юу авсан бэ?	Тэндээс ~ эндээс Доржоос ~ чамгаас	дэлгүүрт очно.
	дэлгүүрээс мухагтаас шүүдэнгээс хүнээс				

4. Асуулт

(Би) (Дорж) (Тэд нар)	өнгидөр үржигдэр өртөө саяхан	дэлгүүрээс мухагтаас Доржоос багшаас	ном ~ юм сонин ~ сэтгүүл дүтлүй ~ цахилгаан ил захидал ~ марк цамц ~ гутал	авсан. аваагүй.
	хоёрдлаx өдөр	шүүдэнгээс		

Хариу

Чи Та Дорж Тэд нар	өнгидөр үржигдэр өртөө саяхан	дэлгүүрээс мухагтаас Доржоос багшаас	ном ~ юм сонин ~ сэтгүүл дүтлүй ~ цахилгаан ил захидал ~ марк цамц ~ гутал	авсан үү?
	хоёрдлаx өдөр	шүүдэнгээс		

3. Асуулт

Хариу

Бололгүй яахав, Тэдтэг,	тэнд тэр өрөөнд	өмсч өмсөөд	үз.
----------------------------	--------------------	----------------	-----

6. Асуулт

Надад энэ	хувцас гутал цамц пальто малгай	жаахан	томдож багадаж уртдаж богинодож	байна,	өөр	хувцас гутал цамц пальто малгай	үзье.
-----------	---	--------	--	--------	-----	---	-------

Хариу

Тэгвэл	энүүнийг энийг		өмсөөд үз.
	энэ	хувцсыг гутлыг цамцыг пальтог малгайг	

7. Асуулт

Энэ	цамцнаас ~ пальтоноос хувцаснаас ~ малгайнаас гутлаас	өөр ондоо	өнгө байна уу?
Энүүнээс Энэнээс			

Хариу

Байна,	ийм	цагаан ногоон улаан хөх хар	(өнгө) байна.
--------	-----	---	---------------

8. Хүсэлт

Энэ Тэр	номыг сэтгүүлийг маркийг		үзүүлэхгүй юү? үзүүлнэ үү? үзье ээ?
	хөх цагаан хар	цамцыг гутлыг малгайг	

Төрө,	хоёулаа	эхлээд замдаа	төв шүүдантаар хүнсний дэлгүүрээр оюутны байраар их сургуулиар ТҮЦ-ээр	орьё.
-------	---------	------------------	--	-------

Харуу

Хоёулаа	эхлээд замдаа	төв шүүдантаар хүнсний дэлгүүрээр оюутны байраар их сургуулиар ТҮЦ-ээр	орох уу?
---------	------------------	--	----------

11. Асуулт

(Би)	одоо үдээс хойш марташ нөгөөдөр марташ үдээс хойш	номын дэлгүүрээр дэлгүүрээр оюутны байраар шүүдантаар	явна. орно.
------	---	--	----------------

Харуу

Чи Та	одоо үдээс хойш марташ нөгөөдөр марташ үдээс хойш	хаагуур явах вэ? юу хийх вэ?
----------	---	---------------------------------

10. Асуулт

(Би)	(одоо)	их дэлгүүр лүү ~ оюутны байр лүү тамхины мухлаг рүү ~ ТҮЦ рүү хуудлааны төв рүү ~ төв шүүдэн рүү их сургууль рүү ~ баар лүү	явж байна. явна.
------	--------	--	---------------------

Харуу

Чи Та	(одоо)	хаашаа	явж байна (вэ)? явах вэ?
			хаачих нь вэ?

9. Асуулт

(Би) (Тэрхүүн) (Тэй)	Монголд Улаанбаатарт энд	Монгол хэл сурах Их сургуульд суралцах ном бичих хуудалдаа хийх	гэж хэргээр (ажлаар) ирсэн.
----------------------------	--------------------------------	--	--------------------------------------

Харуу

Чи Та Тэрхүү Тэй	Монголд Улаанбаатарт энд	мар хэргээр	ирсэн бэ?
---------------------------	--------------------------------	-------------	-----------

15. Асуулт

Тэр Энэ	номын хүнсний	гүанз мүзей баар	хөр найман гүван	цэгт	онгойно. хаана
	дэлгүүр				

Харуу

Тэр Энэ	номын хүнсний	гүанз мүзей баар	хэзээ хэдэн цэгт	онгойх вэ? хаах вэ?
	дэлгүүр			

14. Асуулт

Дэлгүүр Мүзей Мухал	онгорхой байна уу?	онгорхой байна Халттай байна.
---------------------------	--------------------	----------------------------------

Харуу

13. Асуулт

Чи Та	дэлгүүрт / дэлгүүрээр төв шууданд / төв шуудангаар Доржийнд / Доржийнхоор Түц-эд / Түц-ээр	орж очиж	талх авах захиа авуулах ном авах тамхи авах	гэсэн юм.
----------	---	-------------	--	-----------

Харуу

Чи Та	дэлгүүрт / дэлгүүрээр төв шууданд / төв шуудангаар Доржийнд / Доржийнхоор Түц-эд / Түц-ээр	орж очиж	юу авах юу хийх ях	гэсэн юм бэ?
----------	---	-------------	--------------------------	--------------

12. Асуулт

Асуулт

Яах гэж (= ямар хэргээр) ирсэн бэ?

Хариу

(Би) (Тэрхүн) (Дорж) (Тэд)	Монголд Улаанбаатард энд	чамтай уулзах тантай ярих цамц авах захиа авуулах кино үзэх худалдаа хийх хичээл хийх	гэж	энд ирсэн. Монголд ирсэн. танайд очсон. дэлгүүрт очсон. дэлгүүрээр явсан. Доржийнд очсон. шуудангаар орсон. ангидаа очсон. тэднийд очсон.
-------------------------------------	--------------------------------	---	-----	---

16. Асуулт

Чи Та Тэрхүн Тэд	Монголд Улаанбаатард Хархоринд энд	хэзээ хэдийд	ирсэн бэ?
---------------------------	---	-----------------	-----------

Хариу

(Би) (Тэрхүн) (Тэд)	Монголд Улаанбаатард Хархоринд энд	хөр мянган хөр мянга нэг хөр мянга хоёр хөр мянга гурван	саяхан	өчигдөр
		хөр мянган хөр мянга нэг хөр мянга хоёр хөр мянга гурван	онд	
		хөр мянган хөр мянга нэг хөр мянга хоёр хөр мянга гурван	сард	
		хөр мянган хөр мянга нэг хөр мянга хоёр хөр мянга гурван	өмнө	

ирсэн.

17. Асуулт

Энэ Тэр	хоёр гурван	хувцасны гутлын цамцны малгайн номын	аль ямар	нь	хамгийн сайн бэ? дээр вэ?
------------	----------------	--	-------------	----	------------------------------

Хариу

Энэ Тэр	хоёрын гурвын	ногоон тэр том хар жигжиг		нь	хамгийн сайн. дээр.
------------	------------------	---------------------------------------	--	----	------------------------

18. Асуулт

Баталсан хариу

Чи Та	их дэлгүүрт гуанзанд Доржийнд	очив уу?	Би	их дэлгүүрт гуанзанд Доржийнд	очлоо.
----------	-------------------------------------	----------	----	-------------------------------------	--------

Үгүйсгэсэн хариу

Би	их дэлгүүрт гуанзанд Доржийнд	очсонгүй. очоогүй.
----	-------------------------------------	-----------------------

19. Асуулт

Та Чи Дорж	дунд сургуульд Улаанбаатарт Монголд энд гэртээ	байхдаа	ямар сурч юу хийж	байсан бэ?	
			ямар хэл	сурах үзэх	вэ?
			орос хэл хятад хэл		уу? үү?

Хариу

(Би) (Дорж)	дунд сургуульд Улаанбаатарт Монголд энд гэртээ	байхдаа	сайн дунд	сурч	байсан.
			багш эмч	хийж	
			англи орос	хэл	үзнэ. сурна. сурахгүй. үзэхгүй.

20. Асуулт

Таныг Чамайг Дулмааг Та нарыг	дунд сургуульд Улаанбаатарт Монголд энд гэртээ	байхад	Дорж тэд Оюун	ямар сурч юу хийж		байсан бэ?
				ямар хэл	сурч үзэж	байсан уу?
				орос хэл хятад хэл	сурч үзэж	

Хариу

Намайг Дулмааг Биднийг	дунд сургуульд Улаанбаатарт Монголд энд гэртээ	байхад	Дорж тэд Оюун	сайн дунд муу	сурч	байсан. байгаагүй.
				багш эмч	хийж	
				орос хэл хятад хэл	сурч үзэж	

21. Мэдээлэл

Би	өчигдөр өнөөдөр сая	гуанзанд дэлгүүрт танайд	очихдоо	төв шуудангаар орсон. Доржтой дайралдсан. сонин гудамжаар явлаа. нэг ном авлаа. хэдэн захиа явуулсан. Оюутай танилцаж чадлаа.
		сургуулиас танайхаас дэлгүүрээс	харихдаа	

22. Мэдээлэл

Намайг Доржийг Долгорыг Тэд нарыг Та нарыг Таныг	гуанзанд дэлгүүрт танайд сургуулиас танайхаас дэлгүүрээс	очиход ороход байхад явахад харихад гарахад	Дулмаа Оюу багш тэр хүн тэд нар би чи	тэнд сууж байсан. замд явж байсан. утсаар ярьсан. их дэлгүүр лүү явсан. их дэлгүүрээс ирсэн. цай чанаж байсан. надтай ярьж байсан.
---	---	--	---	--

23. Мэдээлэл

Доржийг Тэднүүсийг Багшийг	гуанзанд ороход манайд очиход дэлгүүрт очиход	(нь)	Бат сууж байсан. тэд нар ярилцаж байсан. шинэ юм гарч байсан.
Их дэлгүүрийг Тэр мухлагийг	хааж байхад онгойж байхад		би орсон. би үүнийг авсан. Дорж талх авсан.

24. Асуулт

Та Чи Оюу чи Дорж гуай та	хэнтэй ямар хүнтэй	ярих уулзах танилцах	вэ? гэсэн юм бэ?
------------------------------------	-----------------------	----------------------------	---------------------

Хариу

Би Оюу Дорж	Дулмаатай Багштай эмчтэй жолоочтой	ярья. уулзъя.	
	найзтайгаа* нөхөртэйгөө авгайтайгаа эхнэртэйгээ	уулзах ярих	гэсэн юм.
		уулзмаар яримаар	байна.

*With these words -aa¹ is obligatory.

25. Асуулт

Чи Та Оюу Амуу	багштай Дулмаатай түүнтэй чамтай гантай авгайтайгаа найзтайгаа нөхөртэйгөө	хаана (хаа)	дайралдсан уулзсан ярилцсан танилцсан	бэ?
-------------------------	---	----------------	--	-----

Хариу

Би Оюу Амуу	багштай Дулмаатай түүнтэй чамтай гантай авгайтайгаа найзтайгаа нөхөртэйгөө	гудамжинд их дэлгүүрт оюутны байрны үүдэнд		дайралдсан. уулзсан. ярилцсан. танилцсан.
		шатан шуудан их сургууль зах	дээр	

1-р яриа

- Би нэг цамц авмаар байна. Хаанаас авч болох вэ?
- Тэгвэл хоёулаа Их дэлгүүрт очъё. Ер нь би чамд Их дэлгүүрийг үзүүлье. Бараа нь чанартай.
- За, яасан сайн юм бэ! Одоо явах уу?
- Тэгье.
- Би бас нэг захиа явуулмаар байна.
- Тэгвэл хоёулаа замдаа төв шуудангаар оръё. Их дэлгүүрт очих замд төв шуудан байгаа.

2-р яриа

- За, төв шуудан энэ байна. Тэр шуудангийн хайрцаг байна. Энгийн захиаг тэр хайрцагт хийдэг.
- Марк хаана худалдаж байна?
- Тэр цонхонд худалддаг.
- Хэдэн төгрөгийн марк хэрэгтэй вэ?
- Хоёр зуун төгрөгийн марк хэрэгтэй.

3-р яриа

- Тэр цонхонд юу худалдаж байна?
- Тэнд марк, дугтуй, ил захидал, утасны карт худалддаг.
- Тэрний хажуугийн цонхонд?
- Тэрний хажуугийн цонхонд цахилгаан (мэдээ), факс хүлээн авдаг.
- Бас тэр нэг юун цонх вэ?
- Тэр өөрөө авах тасаг. "Өөрөө авах" гэсэн хаягтай захиаг тэндээс авна.
- Сонин сэтгүүл хаана худалдаж байна?
- Нөгөө танхимд худалддаг.
- Очих уу?
- Очъё.
- "Өнөөдөр" сонин ямар үнэтэй вэ?
- Гурван зуун төгрөг.
- "Монгол улс" сэтгүүл?
- Нэг мянга таван зуу.

4-р яриа

- Тэр юун танхим бэ?
- Тэр, илгээлт явуулдаг танхим.
- Бас тэр?
- Тэр, утсаар ярьдаг танхим.
- Ямар ч хот руу ярьж болох уу?

- Болно. Чи Прага руу яримаар байна уу?
- Үгүй үгүй. Дараа.

5-р яриа

- За, Улсын их дэлгүүр тэр байна.
- Зургаан давхар сайхан барилга байна. Доод давхарт нь юу байдаг вэ?
- Хүнсний дэлгүүр байдаг.
- Дээд давхарт нь юу байна?
- Би сайн мэдэхгүй байна. Нэг ресторан байгаа байх.
- Энд юу юуны худалдаа байна?
- Энэ талх, боовны тасаг. Янз бүрийн талх худалдаж байна. Тэр, чихрийн худалдаа байна. Чи юм авмаар байна уу?
- Би нэг хайрцаг янжуур авмаар байна.

6-р яриа

- За, дээшээ гарах уу?
- Тэгье.
- Энэ, жижиг барааны тасаг, тэр гутлын худалдаа, хажууд нь бэлэг дурсгалын худалдаа байна.
- Бэлэн хувцасны тасаг нь хаана байна?
- Энэ давхарт байхгүй. Энэний дээд давхарт байгаа.
- Бичгийн хэрэгслийн тасаг энд байна уу?
- Бас энэний дээд давхарт байгаа байх.
- Тэгвэл дээшээ гаръя.

7-р яриа

- Худалдагч аа, тэр цагаан цамцыг үзүүлэхгүй юү?
- Танд ямар (хэдэн) хэмжээ хэрэгтэй вэ?
- Гучин ес.
- Энэ хааныхын цамц вэ?
- Германых.
- За, би энийг авъя.

8-р яриа

- Би тэр малгайг өмсч үзмээр байна. Өмсч үзэж болох уу?
- Бололгүй яах вэ.
- Энэ малгай надад яаж байна?
- Жаахан томдож байна.
- Тэгвэл тэрнийг өмсч үзье.
- Одоо яаж байна?
- Жаахан багадаж байна. Чи энийг өмсч үз.
- За одоо?

- Яг таарч байна.
- Энэ малгай надад зохиж байна уу?
- Сайхан зохиж байна.
- За тэгвэл энүүнийг авъя.

9-р яриа

- Би хагас (тал) талх авмаар байна, ямар үнэтэй вэ?
- Нэг зуун хорин төгрөг.
- Өөр юм авахгүй юу?
- Авахгүй ээ, баярлалаа.

10-р яриа

- Чи хажуугийн дэлгүүрээс ирэв үү? Одоо онгорхой байна уу?
- Онгорхой байна.
- Орой хэдэн цагт хаадаг юм бэ?
- Арван найман цагт хаадаг байх.
- Өглөө хэдэн цагт онгойдог вэ?
- Өглөө долоон цагт онгойдог.

11-р яриа

- Чи хаанаас ирэв?
- Дэлгүүрт очоод ирлээ.
- Юу авав?
- Үзэг авлаа.
- Аль вэ, үзье.
- Ямар (үзэг) байна?
- Сайн (чанартай) үзэг байна.

12-р яриа

- Чи даалгавраа хийв үү?
- Үгүй, хийгээгүй.
- Яагаад хийгээгүй вэ?
- Би даалгавраа ойлгохгүй юм (байна). Тэгээд хийгээгүй.

13-р яриа: Утсаар ярих

- Байна уу?
- Байна, хэн бэ?
- Би Оюу байна. Амуутай яримаар байна.
- Амуу одоо байхгүй байна. Удахгүй ирнэ.
- За баярлалаа, баяртай.

- Байна уу?
- Байна, хэнтэй ярих вэ?
- Дулмаатай ярья. Дулмаа (гэртээ) байна уу?
- Би Дулмаа байна.
- Би Дорж байна. Дулмаа аа, чи нөгөө номоо маргааш өглөө аваад ирэхгүй юу?
- За тэгье. Өөр юмгүй юү?
- Өөр юмгүй ээ, баяртай.
- - -
- Байна уу?
- Дулмаа юу? Би Дорж байна. Чи завтай байна уу?
- Завтай байна, юу гэж?
- Чи надтай хамт дэлгүүрт очихгүй юү?
- Чи юу авах гэсэн юм бэ?
- Би нэг дээл авах гэсэн юм. Өөрөө ганцаараа авч чадахгүй байна. Чамтай хамт очмоор байна.
- За тэгье. Би бас идэж уух юм авна.

Бичвэр

Text

1. ДЭЛГҮҮРТ

Дулмаа бид хоёр өнөөдөр дэлгүүрээр явлаа. Дулмаад идэж уух юм хэрэгтэй байсан учир эхлээд хүнсний дэлгүүрт очлоо. Дулмаа нэг кило хонины мах, нэг хар талх, хагас кило цагаан будаа, (нэг) кило хагас төмс авсан. Би хүнсний дэлгүүрээс юу ч авсангүй.

Дараагаар (дараа) нь бид хоёр нэг шинэ дэлгүүрт очлоо. Энэ дэлгүүр, өөртөө үйлчилдэг том дэлгүүр юм. Бэлэн хувцасны, цахилгаан хэрэгслийн, бэлэг дурсгалын, гэрэл зургийн, цагийн зэрэг олон тасагтай юм. Энэ дэлгүүр, нэгдүгээрт шинэ, хоёрдугаарт өнөөдөр бүтэн сайн өдөр байсан болохоор тун их (олон) хүнтэй байлаа. Бид хоёр бэлэн хувцасны тасагт очиж олон дээл үзлээ. Би нэг хар дээл авмаар байсан юм. Гэвч Дулмаа надад: "энэ хар хувцас чамд зохихгүй байна" гэсэн учир би авсангүй. Харин Дулмаа: "энэ хүрэн дээл чамд сайхан зохино" гэлээ. Тэрнийг би өмсч үзлээ. Дулмаа: "энэ дээл чамд томдох ч үгүй, багадаа ч үгүй, яг таарч байна. Сайхан ч зохиж байна" гэлээ. Тэр дээл их үнэтэй байлаа. Гэвч Дулмаа ав гэсэн болохоор би (худалдан) авлаа.

2. ШУУДАН

Манай ангийн Амуу өнөөдөр надад төв шуудан үзүүлээ. Төв шуудан "Энхтайвангийн" гудамжинд байдаг. Бид хоёр нэг том танхимд орлоо. Танхимын эргэн тойрон олон цонх байна. Тэр олон цонхонд марк, дугуй, ил захидал, утасны ялтас (карт) худалддаг, цахилгаан мэдээ, факс хүлээн авдаг. Тэр танхимын дунд нь олон ширээ байна. Улсууд (хүмүүс) тэнд сууж захиа, цахилгаан бичиж байлаа. Танхимын нэг талд шуудангийн олон жижиг хайрцаг байсан. Тэндээс улсууд захиа, захиалсан сонин сэтгүүлээ авдаг.

Танхимын үүдэнд хоёр том модон хайрцаг байна. Би тэр хайрцагт захиа хийсэн. Төв шуудан бас утсаар ярьдаг, илгээлт хүлээн авдаг танхимтай. Дэргэд нь сонин сэтгүүлийн, номын хоёр мухлагтай. Дорж тэр мухлагаас "Өнөөдөр" сонин авсан.

Exercises

Дасгал

1. Цэгийг нөх.

Fill in suitable words.

1. Энэ цамц чамд...
2. Тэр... танд томдож байна.
3. Энэ хар гутал надад...
4. Их дэлгүүрийн... давхарт ... тасаг байдаг.
5. Үдийн хоолны дараа... цагийн орчим бид хоёр...
6. Би гэртээ нэг мэдээ...
7. Маргааш энэ номын дэлгүүрт шинэ ном...
8. Доржийн ээж их дэлгүүрт... хийдэг.
9. ... утсаар ярьж, цахилгаан бичиж болно.
10. Тамхины мухлагт... бий.

2. Хаалтан дахь үгийг зохих хэлбэрт тавь. Use the correct forms of the words in brackets.

Би шинэ (сонин) үзмээр байна. Би энэ (сонин) үзмээр байна. Тэр (цамц) үзүүлэхгүй юү? Та энэ (цамц) үз. Би таны (малгай) үзсэн. Харин энэ (малгай) үзээгүй. Та монгол (дээл) өмсч үзэх үү? За тэгье, чиний (дээл) өмсч үзье. Та надад монгол хувцасны зурагтай (марк) үзүүлэхгүй юү? Үгүй, энэ биш, тэр (марк) би авъя. Би Бээжин рүү (мэдээ) явуулъя. Энэ (мэдээ) одоо явуулна. Би (Дорж) танина. Дорж (би) танина.

3. Хаалтан дахь үгсийг ашиглан үлгэрийн дагуу асуултад хариул. Answer using the model while using words in brackets.

ҮЛГЭР А: Та юу (худалдаж) авмаар байна? (МАРК, ДУГТУЙ)
БИ МАРК ДУГТУЙ АВМААР БАЙНА.
(БЭЛЭГ ДУРСГАЛ, ЭНЭ СОНИН, ХҮҮХДИЙН ХУВЦАС, ТЭР ГУТАЛ,
НОМЫН ТАВИУР, МАЛГАЙ, МОНГОЛ МАЛГАЙ)

ҮЛГЭР Б: Та хэнтэй ярих вэ? (БАГШ)
БИ БАГШТАЙ ЯРИМААР БАЙНА.
(ЖИЖҮҮР, ДҮҮ, АХ, НАЙЗ, ЧИНИЙ НАЙЗ, АВГАЙ, ОЮУН,
РИНЧЕН, АМУУ, НЭГ ХҮН)

ҮЛГЭР В: Чи дэлгүүрт очиж яах вэ? (ГУТАЛ АВ)
БИ ДЭЛГҮҮРТ ОЧИЖ ГУТАЛ АВМААР БАЙНА.
(ДЭЭЛ ӨМСЧ ҮЗ-, ГУТАЛ ҮЗ-, ЦАМЦ ХУДАЛДАЖ АВ-, ХАГАС
КИЛО ХОНИНЫ МАХ АВ-, НӨГӨӨ ЮМЫГ АВ-)

4. Үгсийг холбон өгүүлбэр зохио. Use the following words in sentences.

1. Их дэлгүүр, тасагтай, олон, улсын
2. төв шуудангийн, худалддаг, мухлаг, сонин сэтгүүл, марк, дугтуй, бий, дэргэд
3. давхарт, байдаг, гуравдугаар, бэлэг дурсгалын тасаг
4. гарна, дөрөвдүгээр, давхарт, би
5. цамц, энэ, надад, байна уу, таарч
6. танд, дээл, ногоон, тэр, уртдаж, жаахан, байна
7. хоёр зуун грамм, чихрийн тасгаас, авлаа, чихэр, сайхан, Дорж
8. танхимтай, саруул, төв шуудан, том, юм

5. Өгүүлбэрүүдийг асуух өгүүлбэр болго. Construct interrogative sentences.

1. Энэ дэлгүүр дотроо олон янзын тасагтай.
2. Би бэлэн хувцасны тасгаар орж хар пальто худалдаж авсан.
3. Би өчигдөр Дулмаатай утсаар ярьсан.
4. Мах консервийн худалдаа доод давхарт байдаг.
5. Тэр эмэгтэй, кассанд долоон зуун жаран төгрөг өгч байна.
6. Эрэгтэй хүний энэ гутал монголынх.
7. Их дэлгүүр Энхтайвангийн гудамжинд байдаг.
8. Утасны ялтсаар хаашаа ч ярьж болно.

6. Асуултад үлгэрийн дагуу хариул. Answer using the model.

1. Ян гурван жилийн өмнө монголоор ярьж байсан уу?
Ян гурван жилийн өмнө монголоор ярьдаг байсан уу?
2. Ян хоёр жилийн өмнө монгол ном уншиж байсан уу?
Ян хоёр жилийн өмнө монгол ном уншдаг байсан уу?
3. Та 1994 онд монголоор бичиж байсан уу?
Та 1994 онд монголоор бичдэг байсан уу?
4. Та "Алтай" ресторанд хоол идэж байсан уу?
Та "Алтай" ресторанд хоол иддэг байсан уу?
5. Чи хичээлээ тараад гэртээ харьж байсан уу?
Чи хичээлээ тараад гэртээ харьдаг байсан уу?
6. Чи монгол найзтайгаа уулзаж байсан уу?
Чи монгол найзтайгаа уулздаг байсан уу?

7. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу өөрчил. Change the sentences using the model.

ҮЛГЭР А: Тэр хүн Улаанбаатарт байхдаа монгол кино үздэг байсан уу?
ТЭР ХҮН УЛААНБААТАРТ БАЙХДАА МОНГОЛ КИНО ҮЗДЭГ
БАЙСАН.
ТЭР ХҮН УЛААНБААТАРТ БАЙХДАА МОНГОЛ КИНО ҮЗДЭГҮЙ
БАЙСАН.

1. Та их дэлгүүрт очихдоо чихэр авдаг байсан уу?
2. Та найзындаа очихдоо киноны тухай ярьдаг байсан уу?
3. Та нар театрт очихдоо театрын үүдэнд уулздаг байсан уу?
4. Батын аав хөдөө явахдаа хүүдээ шинэ дээл захиалдаг байсан уу?
5. Та монгол ном уншихдаа толь хардаг байсан уу?
6. Чи дэлгүүрээс сонин авахдаа бас тамхи авдаг байсан уу?

ҮЛГЭР Б: Таныг дэлгүүрт очиход шинэ бараа зарламдаж байсан уу?
НАМАЙГ ДЭЛГҮҮРТ ОЧИХОД ШИНЭ БАРАА ЗАРЛАМДАЖ
БАЙСАН.
НАМАЙГ ДЭЛГҮҮРТ ОЧИХОД ШИНЭ БАРАА ЗАРЛАМДААГҮЙ
БАЙСАН.

1. Та хоёрыг төв шууданд очиход шинэ марк гарч байсан уу?
2. Чамайг Монголд ирэхэд Антони оюутны байранд сууж байсан уу?
3. Чамайг Улаанбаатарт очиход чех оюутан байсан уу?
4. Таныг хүнсний зах дээр очиход шинэ айраг зарж байсан уу?
5. Таныг Прагад ирэхэд энэ байранд монгол оюутан сууж байсан уу?
6. Батыг гуанзанд ороход тэд хоол идэж байсан уу?
7. Чамайг утсаар ярихад оройн 8 цаг болж байсан уу?
8. Чамайг гэртээ харихад тэр дэлгүүр хааж байсан уу?
9. Өчигдөр намайг утасдахад чи унтаж байсан уу?
10. Биднийг энд ярьж байхад тэр хоёр, өрөөндөө байсан уу?

8. Асуултад үлгэрийн дагуу хариул. Answer using the model.

ҮЛГЭР А: Та өчигдөр Оюунтай уулзсан уу?
БИ ӨЧИГДӨР ОЮУНТАЙ УУЛЗСАН.
БИ ӨЧИГДӨР ОЮУНТАЙ УУЛЗААГҮЙ.

1. Чи өчигдөр захиа явуулсан уу?
2. Тэр хүн уржигдар ирсэн үү?
3. Дулмаа толь бичиг худалдаж авсан уу?
4. Та олон дугтуй үзсэн үү?
5. Чи ногоотой шөл идсэн үү?
6. Та солонгос ресторанд орсон уу?
7. Чи энэ хотын барааны зах дээр очсон уу?

8. Чи Оюутай утсаар ярьж чадсан уу?
9. Чи чех пиво ууж үзсэн үү?
10. Чи өнөөдөр номын дэлгүүрт байсан уу?

ҮЛГЭР Б: Та маргааш энд ирэх үү?
 БИ МАРГААШ ЭНД ИРНЭ.
 БИ МАРГААШ ЭНД ИРЭХГҮЙ.

1. Хоёулаа өнөө (өнөөдөр) орой кинонд явах уу?
2. Чи хүнсний дэлгүүр явах уу?
3. Та одоо цай уух уу?
4. Чи хоолоо хийх үү?
5. Чи тэр хүнийг таних уу?
6. Дорж ном худалдаж авах уу?
7. Чи надтай утсаар ярих уу?
8. Чи өнөө орой манай руу утасдах уу?
9. Хоёулаа маргааш барааны зах дээр очих уу?
10. Чи миний хийсэн хоолыг идэх үү?

ҮЛГЭР В: Чи энийг ойлгов уу?
 БИ ЭНИЙГ ОЙЛГОЛОО.
 БИ ЭНИЙГ ОЙЛГОСОНГҮЙ.

1. Чи тэр хүнийг танив уу?
2. Та Дулмааг харав уу?
3. За, сонсов уу?
4. Мэдэв үү?
5. Гуанз онгойв уу?
6. Цэцэг унтав уу?

9. Цэгийн оронд асуух өгүүлбэр тавь. Fill in interrogative sentences.

1. –...? Номын дэлгүүр, их дэлгүүрийн орчим байдаг юм.
2. –...? Төв шуудан, тэр дэлгүүрийн өмнө байдаг.
3. –...? Нэгдэх өдөр үдээс хойш би завгүй.
4. –...? Би өчигдөр шуудангаас олон марк авсан.
5. –...? Тэгсэн, би өчигдөр захиа явуулсан.
6. –...? Би нөгөөдөр танайд очно.
7. –...? Тэг тэг, өмсөөд үз.
8. –...? Амуу, дэлгүүрээс юу ч аваагүй.
9. –...? Энэ, манай ангийн оюутны дэвтэр биш байна.
10. –...? Энэ хувцаснаас, өөр өнгө байхгүй.
11. –...? Энэ хувцас надад яг таарч байна.
12. –...? Бид энэ сайн өдөр дэлгүүрээр явна.
13. –...? Бид уржигдар хотын төвөөр явсан.
14. –...? Би дэлгүүрт очиж ногоо авах гэсэн юм.

15. –...? Тэгсэн, бид хоёр харих замдаа дэлгүүрээр орсон.
16. –...? Би энд монгол хэл сурах гэж ирсэн.
17. –...? Тэр хүн наймаа хийх гэж зах дээр очсон.
18. –...? Энэ ном эндэхийн дэлгүүрт гараагүй.
19. –...? Намайг бага сургуульд байхад Дулмаа орос хэл мэддэг байсан.
20. –...? Би бага сургуульд байхдаа монгол бичиг сурсан.
21. –...? Зурагтаар (телевизээр) их сонин зарлам (реклам) гарч байна.

10. Өгүүлбэрийг гүйцээ.

Finish the sentences.

1. Намайг гэртээ байхад...
2. Би гэртээ байхдаа...
3. Таныг Их сургууль дээр байхад...
4. Та Их сургууль дээр байхдаа...
5. Намайг очигдөр дэлгүүр лүү явж байхад...
6. Би дэлгүүр лүү явж байхдаа...
7. Доржийг эмчтэй уулзаж байхад...
8. Дорж, эмчтэй уулзаж байхдаа...
9. Намайг найзтайгаа ярьж байхад...
10. Би найзтайгаа ярьж байхдаа...
11. Оюуг захиа бичиж байхад...
12. Оюу захиа бичиж байхдаа...
13. Амууг орж ирэхэд...
14. Амуу орж ирэхдээ...

11. Орчуулах.

Translation.

Улаанбаатарт олон дэлгүүр бий. Хамгийн том нь Улсын Их дэлгүүр. Энд янз бүрийн юм худалдах олон тасаг, танхим байдаг. (Би) Прагаас ирээд оюутны байрнаасаа зочид буудалд байсан найзтайгаа утсаар ярьж уулзлаа. Бид хоёр уулзаад Улсын Их дэлгүүрт очиж хүнс худалдаж аваад замдаа төв шуудангаар орж захиа хийв. Би тэндээс утасны ялтас худалдаж авлаа. Тэгээд Прага руу утасдаж, гэрийнхэнтэйгээ ярилаа.

12. Асуултад хариул.

Answer the questions.

1. Танай гэрийн (байрны) ойр ямар ямар дэлгүүр байдаг вэ?
2. Хүнсний их дэлгүүр (ХИД) хаана байдгийг мэдэх үү?
3. Чи ХИД-эд орж үзсэн үү?
4. Танай хичээлийн байранд хүнсний мухлаг бий юү?
5. Бэлэг дурсгалын юм хаанаас авч болох вэ?
6. Төв шуудан эндээс хол байна уу?
7. Улаанбаатараас Прага руу энгийн захиа явуулахад хэдэн төгрөгийн марк хэрэгтэй вэ?
8. Цахилгаан бичихэд нэг үг ямар үнэтэй вэ?
9. Эмэгтэй хүний өвлийн дулаан гутал энд ямар үнэтэй байдаг вэ?

10. Чи ямар өнгийн (= өнгөтэй) цамцанд дуртай вэ?
11. Чамд ямар хэмжээний (= хэмжээтэй) гутал таардаг вэ?
12. Чи Монголд ямар хэргээр ирсэн бэ?
13. Та энд худалдааны ажлаар ирсэн үү?
15. Та надтай уулзах гэж явна уу (ирэв үү)?
16. Чи тэр залуутай Прагад танилцсан уу?
17. Чи монгол хоол (бууз) хийж чадах уу?
18. Та түүний шуудангийн хаягийг мэдэх үү?
19. Таны шуудангийн хаягийг авч болох уу?
20. Би энд цахим шуудантай болоход яах хэрэгтэй вэ?
21. Чи өнөөдөр гэртээ хариад юу хийх вэ?

Даалгавар

Homework

1. Яриануудыг тогтоо. Learn the conversations by heart.
2. Дэлгүүр, шууданд очсон тухайгаа ярь. Speak about how you went shopping (how you went to a post office).
3. Найзтайгаа шуудангийн тухай харилцан ярь. Talk about the post office with a colleague.
4. Орчуулах. Translate into Mongolian:
 1. There is a new department store in our town. Have you been there (to see it)? – I went there (to see it) two days back (on Monday). It is very interesting, there are very many sections inside.
 2. Have you bought something there? – I have not bought anything. I just passed through several departments and then I left.
 3. Now (this week) they have nice coats there. Have you not seen (them)? – I have, but they had only blue and black coats. Blue and black colours do not suit me.
 4. Which colour do you like (best)? – I like brown (best). They had no brown coat. Thus I have not bought any coat.

* * *
 5. Have you bought milk this morning? – I have bought milk but I haven't bought bread. I will get bread in the afternoon.
 6. Would you also get one loaf for me? Since we have lectures all day, I cannot go to the shop. – But of course. Do you need anything else?
 7. I need nothing else.

* * *
 8. Do you have (a loaf of) bread for 150 Tgr.? – Yes, we do, will you have it?
 9. I will, and I should like to have 750 g of candies for 2500 Tgr. Can I get them here? – You can. Here you are. Would you like anything else? (lit.: Will you have anything else?)

10. I do not take anything else. Thank you.

* * *

11. I would like to get a pair of shoes. What type of shoes do you have? – We have these black shoes and one pair of brown shoes. What is your size?

12. My size is 39. Will the brown (pair of) shoes fit me? – It will not, the brown shoes are size 35. Will you have the black shoes?

13. I will not take the black shoes. When will you get brown shoes? – Come and ask tomorrow.

* * *

14. I would like (lit.: I will have) 600 Tgr. stamps, have you nice stamps? – We do, have a look. How many stamps will you have?

15. I will have ten 600 Tgr. stamps. I would also like (lit.: I will also have) ten postcards, one envelope and one 150 Tgr. stamp. How much is it?

16. It comes to 8,000 Tugrigrs altogether.

Хэлзүй

Grammar

1. Partial number

In this lesson we will encounter further examples of the use of partial number in the sense of the delimitation of a certain number of items of a given class, or in a generalising function:

<i>таны захиалсан номууд</i>	the books you have ordered
<i>Улаанбаатарын үзэсгэлэнгийн танхимуудад</i>	in the exhibition halls of Ulanbator
<i>залуучууд</i>	the youth

2. Postpositions

With the genitive:

<i>наана</i>	on this side (closer to me), before
<i>цаана</i>	beyond, yonder, behind (on the other side than mine)
<i>дотор</i>	within, in the course of
<i>төв шуудангийн цаана</i>	behind the G. P. O.
<i>хүүхдийн паркийн наана</i>	on this side of the children's park
<i>нэг сарын дотор</i>	within a month

With the ablative:

<i>цааши</i>	after (a term), beyond, farther
<i>бусад</i>	excepting, besides; (the) other than
<i>нэг сараас цааши</i>	(for a time) beyond one month, after one month
<i>бүтэн сайнаас бусад өдөр</i>	a day (or days) other than Sunday

3. Cases

The **genitive** is used in phrases designating time (not obligatory):

<i>өглөөний найман цагаас</i>	from eight in the morning
<i>оройн 17 цаг хүртэл</i>	till 17 o'clock in the evening
but also:	
<i>өглөө наймаас</i>	from eight (in the) morning

The **instrumental** is used to designate period of time (term) and place:

<i>Нэг сараар авч болно.</i>	It may be borrowed for one month.
<i>Гэрээр авч болохгүй.</i>	(It is) not possible to take (it) home.
<i>хэдий (ямар) хугацаагаар</i>	for how much time (what term) (also sociative: <i>хугацаатай</i>)

Sociative: The phrase *-тай бол-* means 'to obtain something':

<i>үнэмлэхтэй бол-</i>	to obtain a certificate
------------------------	-------------------------

4. Numerals

The **ablative** of numerals without the inserted *-н-* is used to designate the hours: 'from one o'clock', 'from two' etc. (cf. L5, Gr. 12 and L14, Gr. 2a):

<i>нэгээс</i>	<i>наймаас</i>
<i>хоёроос</i>	<i>есөөс</i>
<i>гурваас</i>	<i>арваас</i>
<i>дөрвөөс</i>	<i>арван нэгээс</i>
<i>таваас</i>	<i>арван хоёроос</i>
<i>зургаагаас</i>	<i>хориос</i>
<i>долоогоос</i>	<i>хорин нэгээс</i>

5. Expressing a condition (*converbum conditionale*)

In a nominal sentence after nouns and verbal nouns the particle *бол* is used. Verbs take the suffix *-вал⁴/-бал⁴* (*converbum conditionale*). The form with initial *-б* is used after final *-м, -в, -л*.

<i>явбал</i>	if (he, she) goes, if (I, you) go, etc.
<i>үзвэл</i>	if (he, she) sees, if (I, you) see, etc.
<i>орвол</i>	if (he, she) enters, if (I, you) enter, etc.
<i>өгвөл</i>	if (he, she) gives, if (I, you) give, etc.

If the two clauses have the same subject, the subject takes the form of the nominative.

With two different subjects, the subject in the conditional clause is in the accusative:

<i>Би ирвэл чамд мөнгө өгнө.</i>	If I come, I will give you money.
<i>Чамайг ирвэл би чамд мөнгө өгнө.</i>	If you come, I will give you money.

To express a negative condition, the form *-хгүй бол* is used:

Би ирэхгүй бол чамд захиа явуулна. If I do not come, I will send you a letter.
Чамайг ирэхгүй бол би чамд захиа явуулна. If you do not come, I will send you a letter.

Similarly the condition can be expressed in the past:

Ном гарсан бол тэнд байна. Had the book been published, it would be there (lit.: it is there).
Ном гараагүй бол удахгүй гарна. Had the book not been published (already), it would have been published soon (lit.: it will be published soon).

At the beginning of a conditional clause the word *хэрэв, хэрвээ* may be used. Other examples of the use of the particle *бол* or of the conditional verb forms may be seen in Sentence Patterns 6–12, 17–21.

Note: The form *авах бол* (Pattern 14) may appear to be an abbreviated form of *авах болбол*. But there is a slight semantic difference between the two forms. The particle *бол* indicates the conditional in the proper sense, while *болбол* indicates a possible inevitability, objective or situational need of the action, not one's own wish or consent (cf. further Par. 10b).

6. Quick completion of an action (*verba intensiva*)

The suffix *-чих* is added to the root (stem) forming a new stem (which can be used as the imperative), to which past suffixes (*-сан⁴, -лаа⁴, -жээ/-чээ*) can be added. The form expresses an immediate or intensive completion of an action. In spoken language this suffix is rather frequent.

Захиалчих. Place (your) order.
Энд гарын үсгээ зурчих. Put your signature here.
Бат явчихсан. Bat has left (is away).

Note that in colloquial usage the pronunciation of the suffix is strongly reduced, sometimes there are two levels of reduction, one being general colloquial (first form), the other (even shorter second form) being a very quick speech (for practice cf. the section on Pronunciation):

-чих + -сан⁴- full pronunciation: 1. [ʧixsɑŋ²] for male words (*а, о*),
 2. [ʧixsɛŋ²] for female words (*э, ө*)
 reduced pronunciation in: 1. [ʧixs²ŋ⁴], 2. [ʧs²ŋ⁴]
-чих + -лаа⁴- full pronunciation: 1. [ʧixla:²] for male words (*а, о*),
 2. [ʧixlɛ:²] for female words (*э, ө*)
 reduced pronunciation in: [ʧla:⁴]
-чих + -жээ- full pronunciation: [ʧixʒɛ:], [ʧixʒɛ:]
 reduced pronunciation in: 1. [ʧɛʒɛ:], 2. [ʧiʒɛ]

7. Short and long duration of action

a) Short duration of the *voluntative* form (1st person) is expressed by the suffixes -аадахъя [a:tɬaj], -ээдэхье [ɛ:tɬɛj], -оодохъё [o:tɬoɣj], -өөдөхөө [ö:tɬöj].

Би үзээдэхье (хараадахъя).

Let me see (have a look).

Би бичээдэхье.

Let me write (quickly).

Би ороодохъё.

Let me enter (drop in, pop in).

b) Prolongation of an action can be implied by placing the particle *л* between the converb and the verb *байна*.

Нямаа номоо үзэж л байна уу?

Does Nyamaa keep reading? Is Nyamaa still reading?

Дорж гуанзанд суугаад л байна уу?

Does Dorji keep sitting in a restaurant? Is Dorji still sitting in a restaurant?

Note the pronunciation of the particle *л* in combination with converbs. After the final [ʧ, ʤ] a 'linking' vowel *-i-* is inserted before the particle in spoken Mongolian. After the final [d] a 'linking' indistinct vowel [ə], perhaps sometimes perceived as *a*⁴, is inserted before the particle in spoken Mongolian. In purely colloquial pronunciation the particle merges with the final [d] of the converb into [l], though it can be pronounced as fully merging with the final dental in 'standard' spoken Mongolian [a:tl⁴]. The allophone of the lateral is palatalised or nonpalatalised according to the vocalic environment.

-ж /-ч + л

[ʤil, ʧil]

-аад⁴ + л

[a:dəl⁴], [a:tl⁴] reduced: [a:t⁴]

8. The form -маар⁴ as an attribute

үзмээр музей

a museum worth seeing

9. Composite form of verbs

Besides duration in the present (L2, Gr. 10) and past (L7, Gr. 8a), it is possible to express duration with a recent action and with the imperative.

Чи аль танхимд сууж байв (аа)?

In which hall have you been sitting?

Би нийтийн уншлагын танхимд сууж байлаа.

I have been sitting in the public reading hall.

Манай музейд дахин дахин ирж байгаарай.

Keep coming to our museum.

10. *Nomen futuri*

a) Followed by the word *ёстой* 'necessary, must':

байх ёстой (it) (certainly) must be

b) With the verb *бол-* 'to become, be, occur' (expressing future, further cf. L11, Gr. 5c)

та үзэх болно you will see

c) In connection with *гэж байна, гээд байгаа юм* (lit.: just saying) the *nomen futuri* implies 'I intend, I am about to'.

Би одоо тийшээ явах гэж байна. I am about to go there.

11. Verbal phrases

The verb *өг-* 'to give' in a verbal phrase after a *converbum imperfecti* can imply the meaning 'to do something for somebody'.

Би үнэмлэх бичиж өгнө. I will make out the licence (for you).

Та миний пальтог өлгөж өгөхгүй юу? Would you hang my coat (for me)?

Sometimes it may be difficult to distinguish, whether the verb 'to give' is used in the more grammaticalised sense, or whether it keeps (something of) its original meaning:

Та сонин, сэтгүүлийнхээ нэрийг, дугаартай нь бичээд өгчих.

Write down the name of the newspaper and/or magazine together with the shelf (catalogue) number for me.

OR (because it is said by the librarian to the reader who orders the newspaper):

Write down the name of the newspaper and/or magazine together with the shelf (catalogue) number and give it to me.

It is also possible to use the verb 'to take' in this grammaticalised manner (L7, Gr. 13) and it is not always easy to distinguish, whether it has preserved (some of) its lexical meaning:

Бид... олон шинэ юм мэдэж авлаа. We have learnt many new things.

Номоо захиалж авч болох уу? Is it possible to order (and take, obtain) the book?

The phrase consisting of the verbs of movement 'to come, to go' etc. with the verb *ав-* has a different meaning. It usually corresponds to the phrase 'come and take, come to take' and the like.

Та 15 минут болоод ирж аваарай. Come to collect (your book) in fifteen minutes.

Би маргааш ирж, үнэмлэх авъя. I will come tomorrow to collect the certificate.

Одоо л ирж авна даа. It is only now that I am coming to collect (the certificate).

Some of the phrases are difficult to classify unequivocally and they must be translated according to the context by one verb or by a phrase. This usually involves a description of a concrete action, which may be described by only one word in English (or in another European language).

Би аваад ирье (авчиръя).

Та шифрийг бичээд ир.

За, бичээд ирлээ.

Номоо захиалж уншиж болно.

Тэнд суугаад үзээрэй.

Та шифрийг хуудсан дээр бичээд захиалчих.

*Уншлагын танхимд очоод өөрөө
аваад уншиж болно.*

*Би уншлагын танхимд сууж байгаад
гарч ирлээ.*

Тэр үзэсгэлэнгээр ороод гарах уу?

I will bring (lit.: having taken I will come).

Write the shelf mark (catalogue number) and come.

Well, I have written (and come).

It is possible to order and read your book.

Sit there and read (the book etc.).

You may order by writing this shelf mark (catalogue number) on a card (lit.: having written order).

You may go to the reading hall, take (the book) yourself and read.

I have come from the reading room, where I had been sitting (lit.: having sat I left and came).

Shall we drop in to that exhibition (on the way)? (lit.: having entered shall we leave?)

12. Particles and similar expressions

a) сан 'would':

Би захиалах гэсэн юм сан.

I would (like to) order.

b) байх(аа) 'may be,' perhaps'; this particle is used after nouns or verbal nouns:

Тэнд байгаа байх.

It may be there.

Ирэх байх.

He (she, etc.) may come.

Ирсэн байхаа.

He (she, etc.) may have come.

c) ч гэсэн 'though' (lit.: even when said):

Залуучууд ч гэсэн сайхан зурдаг юм байна.

Though (they are) young, they paint nicely.

d) ч after an interrogative = 'any' (in a positive sentence):

Хэзээ ч авч болно.

(You) may take any time.

e) аа emphasis:

Аль танхимд сууж байв аа?

In which reading hall (then) have you been sitting?

13. Idioms and phrases

хаалганы тэнд
энэ хооронд

over there at the door
in the meantime, meanwhile

Шинэ үг

авьяас
ард
ардын зураач
байгаль
байгалийн
биз дээ
билет
боловсрол
бусад
бүтээл
гадаад
гайхамшигтай
ганц
гарын үсэг
гарга- (Э2.1)
(гаргаж, гаргах,
гаргана)
дахиад, дахин
дотор (G.)
дүрслэх урлаг
ёстой 2.
жишээ нь
загвар
зарим
захиалга
зохиол
зохио- (Э1)
(зохиож, зохиох,
зохионо)
зураач
зур- (Э2.4)
(зурж, зурах, зурна)
илүү
ингэ- (Э2.1)
(ингэж, ингэх, ингэнэ)
лам
музей
наана (G.)
нийтийн
номын сан (г)
номын санч
нээрэн
ордон
орчин үе(ийн)

talent, gift
people (the masses)
national artist (painter)
nature
natural
is it not?
ticket
education; training
the others, the rest; excepting, besides (Abl.)
product, work, creation
foreign; abroad
marvelous, admirable
alone; single, lonely; singular, only
signature
to make out, distinguish

again, anew
within, in the course of
fine arts
obliged to (after future verbal noun)
for example
pattern, mold; form; model
some, a certain
subscription, order
writing, literary creation
to compose, write

painter
to draw, paint

too much (many), excessive, extra
to do thus, in this way

lama, a Buddhist monk
museum
on this side, before (on this side)
public, social
library
librarian
really, indeed, truly
palace
(of) the present, contemporaneity; contemporaneous

Vocabulary

өлгүүр	hanger; hook, peg; cloak room
паспорт	passport
сан (pcl.)	conditional particle
санагд- (Э2.1)	to seem, appeal to (a person's fancy)
(санагдаж, санагдах, санагдана)	
сунгуул- (Г1)	to prolong (a term), postpone
(сунгуулж, сунгуулах, сунгуулна)	
сурах бичиг	textbook
сүм	temple, monastery
сэдэв	theme, topic, subject
тайлбарла- (Э2.1)	to explain
(тайлбарлаж, тайлбарлах, тайлбарлана)	
тайлбарлагч	excursion guide
танхим (уншлагын т.)	hall (reading hall)
тасалбар (= билет)	ticket
товъёг	catalogue, register
түлхүүр	key; also (= шифр) shelf mark, label
түүх	history
тэнхим	(University) department
удаан	slow(ly)
улс төр	politics
уншигч	reader
уншлагын танхим	reading room, hall
уран зохиол	belles lettres
урлаг	art, craft
ухаан	intellect, reason
үзэсгэлэн	exhibitor
үнэмлэх	certificate, card, licence
үнэн	truth
үсэг	letter, character; writing
хаан	king
ховор	rare; scarce
холбогдолтой	relating to, on the topic of
хооронд	between, in between
хуваарь (цагийн)	time-table
хувь	copy
хувьсгал	revolution
хугацаа (н)	time limit, deadline
хуудас (ан)	sheet of paper; page
хүс- (Э2.5)	to wish, desire
(хүсэж, хүсэх, хүснэ)	
хүүе	hi, hey
хүүхэн	girl, woman
хэвлэл	press, publication; impression
хэдийд	when
хэзээ ч	any time
хэл- (Э2.4)	to speak, say, tell
(хэлж, хэлэх, хэлнэ)	
хэрвээ/хэрэв	if
цаана (G.)	beyond, yonder, behind (on the other side then mine)
цааш (Abl.)	farther, beyond, after

чиг (= ч)	even, too, also
шат- (Э2.2) (шатаж, шатах, шатна)	to burn, to be burned up
шинжлэх ухаан	science
ширхэг	piece
шифр	shelf mark, label
шөнө	night
шургуулга (н)	drawer
эрхлэгч	manager, director
яар- (Э2.4) (яарч*, яарах, яарна)	to hurry, hasten
ялангуяа	especially, particularly

Дуудах

Pronunciation

[а – а:] сам – саам, тах – таах, тар – таар
сад – саад, над – наад, зах – заах
авах – аваад, гарах – гараад, дадах – дадаа
залхах – залхаах, мананд – манаанд
ханах – ханаах, таавар – таваар

[ε – ε:] хэр – хээр, дэр – дээр, тэр – тээр
тэг – тээг, бэр – бээр, бэх – бээх
тэмцэл – тэмцээн, бэхэл – бэхээр
бэртэх – бэртээх, бүтэх – бүтээх
гэмтэх – гэмтээх, сэвтэх – сэвтээх
дээшээ – тийшээ, сэтгүүлээ – гэртээ, хээээ

[ɔ – ɔ:] ор – доор, оор – оор, осол – оосор
зог – зоог, зос – зоос, босох – боос
боролдой – бороолох, дотор – дотоод
монголорхуу – монголоор, мохох – мохоох
ноцох – ноцоох, одох – одоохон, орох – ороох

* * *

Full pronunciation of the suffix *-чих*:

-чихсан⁴: 1. [tʃixsɑn²] for male words (a, o), 2. [tʃixsɛŋ²] for female words (э, ө):
явчихсан, орчихсон, үзчихсэн, өгчихсөн, биччихсэн

-чихлаа⁴: 1. [tʃixla:²] for male words (a, o), 2. [tʃixlɛ:²] for female words (э, ө)
явчихлаа, орчихлоо, үзчихлээ, өгчихлөө, биччихлээ

-чихжээ: [tʃixʤɛ:], [tʃixʤɛ:]
явчихжээ, орчихжээ, үзчихжээ, өгчихжээ, биччихжээ

Reduced pronunciation of the suffix *-чихсан*⁴: 1. [ʧsʰŋ⁴], 2. [ʧsʰŋ⁴]

[явчсан, явацдан]

[орчсон, орццон]

[үзэчсэн, үзэццэн]

[өхчсөн, өхццөн]

[бичичсэн, бичиццэн]

Reduced pronunciation of the suffix *-чихлаа*⁴: [ʧla:⁴]

[явчлаа], [орчлоо], [үзэчлээ], [өгчлөө], [бичичлээ]

Reduced pronunciation of the suffix *-чихжээ*: 1. [ʧɕʤe:], 2. [ʧɕʤ]

[явчижээ], [орчижээ], [үзчижээ], [өгчижээ], [биччижээ]

[явчиж], [орчиж], [үзчиж], [өгчиж], [биччиж]

Pronunciation of the particle *л* after converbs:

-ж / -ч + л [ʧɕil, ʧil]

-аад⁴ + л [a:dəl⁴], reduced: [a:l⁴]

-ж л / -ч л [ʧɕil, ʧil]

байж л байна	[байжил байна]
хэлж л байна	[хэлжил байна]
тэгж л байна	[тэгжил байна]
гэж л байна	[гэжил байна]
сууж л байна	[суужил байна]
өгч л байна	[өгчил байна]
үзэж л байна	[үзэжил байна]
бичиж л байна	[бичижил байна]
гарч л байна	[гарчил байна]
авч л байна	[авчил байна]

-аад⁴ л [a:tl⁴]

-аадал⁴ = -аал⁴[a:dəl⁴], reduced: [a:l⁴]

байгаад л байна	[байгаадал, байгаал байна]
хэлээд л байна	[хэлээдэл, хэлээл байна]
тэгээд л байна	[тэгээдэл, тэгээл байна]
гээд л байна	[гээдэл, гээл байна]
суугаад л байна	[суугаадал, суугаал байна]
өгөөд л байна	[өгөөдөл, өгөөл байна]
үзээд л байна	[үзээдэл, үзээл байна]
бичээд л байна	[бичээдэл, бичээл байна]
гараад л байна	[гараадал, гараал байна]
аваад л байна	[аваадал, аваал байна]

1. Асуулт

Би Дорж Энэ хүн	уншигчийн үнэмлэх үнэмлэх паспорт	авмаар байна. авах гэсэн юм.
-----------------------	---	---------------------------------

Хариу

Тэгвэл Тийм бол	хоёр гурван	хувь ширхэг	зурагтай ирээрэй.
--------------------	----------------	----------------	-------------------

Номын санч Лувсан гуай Би	танд чамд Доржид	үнэмлэх паспорт	бичиж өгнө.
---------------------------------	------------------------	--------------------	-------------

2. Асуулт

Миний Түүний Бидний	захиалсан	ном сонин сэтгүүл сурах бичиг	хэр удаж хэдийд (хэзээ)	гарах вэ?
Би Тэр, Бид		номоо сониноо сэтгүүлээ сурах бичгээ	хэдийд (хэзээ)	авах вэ? авч болох вэ?

Хариу

Таны (захиалсан)	ном сонин сэтгүүл сурах бичиг	үдээс хойш		гарна.	
		нэг хоёр арван	цагт		
Та (захиалсан)	номоо сониноо сэтгүүлээ сурах бичгээ	нэг хоёр арван	цагаас	хойш өмнө	(ирж) аваарай.
		үдээс хойш			

3. Асуулт

Энэ ном	хэзээ	хэдэн онд	хэдэн очь хэдэн сард	хэвлэлээс	Улаанбаатар	Их сургуульд	дунд сургуульд	гарсан	орсон	бэ?
---------	-------	-----------	----------------------	-----------	-------------	--------------	----------------	--------	-------	-----

Хариу

(Тэр ном)	1870	онд	хэвлэлээс	Улаанбаатар	Их сургуульд	дунд сургуульд	гарсан	ирсэн	орсон
	1935								
(Ийм ном)	1990								
(Би)	2000								
(Ринчен)	2001	оны	хөёр	сард					
	2003		нэг	сард					

4. Хүсвэл

Наадам	Уран зохиолын түүхийн монгол хэлний урлагийн аурсгах урлагийн ярианы хичээлийн	холобогдолтой сэдэвтэй	ном сэтгүүл сүрах бичиг юм	хэрэгтэй байна.
--------	--	---------------------------	-------------------------------------	-----------------

Хариу

Та	Доржоос тэр хүнээс номын санаас тэр эмэгтэйдээс эрхлэгээс	асуу. асуухгүй юу?
----	---	-----------------------

5. Асуулт

Тэр	мүзей	хэзээ	хэдээс	онгойх вэ?
Энэ	дэлгүүр	хэдэн нэн цагаас	хэд хүртэл	ажиллаж байна вэ?
Танай	номын сан үзэсгэлэн гуанз ресторан			ажилладаг вэ?

Хариу А

Тэр Энэ Танай	номын сан музей дэлгүүр үзэсгэлэн гуанз ресторан	найман есөн	цагт	онгойдог. онгойно.
---------------------	---	----------------	------	-----------------------

Хариу Б

Тэр Энэ Танай	номын сан музей дэлгүүр үзэсгэлэн гуанз ресторан	найман есөн арван	цагаас	арван зургаан хорин хорин нэгэн	цаг хүртэл	ажилладаг.
---------------------	---	-------------------------	--------	---------------------------------------	------------	------------

6. Мэдээлэл А

Би Дорж Амуу Дулмаа Цэрмаа	маргааш нөгөөдөр өнөөдөр орой өглөө	ирвэл,	танд мөнгө өгнө. танд мөнгө өгч чадахгүй. ном авчирна. ном авчирч чадахгүй.
		ирэхгүй бол,	

Мэдээлэл Б

Та Чи Бат Тэр,	маргааш нөгөөдөр өнөөдөр орой өглөө ажлаа хоолоо тэр юмыг	ирвэл, хийвэл, уншвал, идвэл,	манайд оч. энэ номыг уншина. манайд очно. гэртээ байна. чамд өгч болно. манайд очиж болно. энийг уншиж болно. манайд очиж болохгүй. энийг үзэж чадахгүй.
		ирэхгүй хийхгүй уншихгүй идэхгүй	

7. Мэдээлэл

Таны ном Бат гуай Аав Тэр,	гарсан ирсэн явсан харьсан гараагүй ирээгүй яваагүй хариагүй	бол,	тэр хайрцагт байна (бий). тэнд байна. гэртээ байна. сургууль дээрээ байна. Прагад байгаа байх. хоолоо хийж байгаа байх. утасдах байх. утасдахгүй байх.
-------------------------------------	---	------	---

8. Мэдээлэл А

Намайг Доржийг Чамайг Таныг Тэднийг	ирвэл,	Дулмаа би ээж	хоол хийнэ. хоол хийхгүй ирнэ.
	ирэхгүй бол,	Цэрмаа Чойжамц тэд	ирэхгүй. мөнгө өгнө. мөнгө өгөхгүй.

Мэдээлэл Б

Таныг Чамайг Тэднийг	дэлгүүрт очвол, кино үзвэл, гуанзанд орвол, шуудан руу явбал,	би чиг (= би ч)	очно. үзнэ. орно. явна.
----------------------------	--	--------------------	----------------------------------

9. Хүсэлт

Та Чи	завтай хичээлгүй ажилгүй	бол,	энэ тухай ярьж энийг орчуулж надад цай чанаж энүүнийг бичиж	өгөхгүй	юү?
			надтай хамт явахгүй энийг орчуулахгүй		
			надтай Доржтой	дэлгүүрт номын санд гуанзанд	

Хариу А

Хариу Б

За, тэгье.	Би	завгүй хичээлтэй ажилтай	байна.
------------	----	--------------------------------	--------

10. Хүсэлт

Таныг Чамайг	завтай хичээлгүй ажилгүй	бол,	би	энэ тухай ярьж энийг орчуулж	өгье. өгөх гэсэн юм.		
				тантай чамтай	хамт	дэлгүүрт гуанзанд	очъё. очих гэсэн юм.

Хариу А

Хариу Б

Тэг тэг. Би завтай байна.	Би	завгүй хичээлтэй ажилтай	байна.
---------------------------	----	--------------------------------	--------

11. Хүсэлт

Та Чи	одоо өнөөдөр	завгүй ажилтай хичээлтэй	бол,	дараа маргааш	хэлж бичиж орчуулж	өгөхгүй юү? өгөөрэй.
					тийшээ явахгүй юү?	

Хариу

За. = За за. = Тэгье. = За тэгье. = За за тэгье.

12. Асуулт

Чамайг Таныг	завтай	бол,	(ирэх)	хагас сайн бүтэн сайн нэгдэх хоёрдахь гуравдахь дөрөвдэх тавдахь	өдөр	хоёулаа
-----------------	--------	------	--------	--	------	---------

тэнд ресторанд тэднийд манайд танайд	очиж,	(хамт)	хоол ном үзэсгэлэн сэтгүүл юм	идэх ~ үзэх унших ~ авах	уу? үү?
				идэж ~ авч уншиж ~ үзэж	болох

Хариу

За, Бололгүй яах вэ, Тэгэлгүй яах вэ, Тэгье тэгье.	(би завтай.) (би завтай байлгүй яах вэ.)
---	---

13. Асуулт

Танайхаас Эндээс Номын сангаас	ном сонин сэтгүүл	ямар хэдий	хугацаатай хугацаагаар	авч	болох вэ?
--------------------------------------	-------------------------	---------------	---------------------------	-----	-----------

Хариу

Нэг Хоёр Гурван	сарын долоо хоногийн жилийн	хугацаатай хугацаагаар	авч	болно.
-----------------------	-----------------------------------	---------------------------	-----	--------

14. Асуулт

Хэрэв нэг хоёр гурван	сараас долоо хоногоос жилээс	илүү	хугацаатай хугацаагаар	авъя гэвэл авмаар байвал авах хэрэгтэй бол авах болбол (авах бол)	яхах (ёстой) вэ?
-----------------------	------------------------------	------	------------------------	---	------------------

Хариу

Нэг Хоёр Гурван	сараас долоо хоногоос жилээс	илүү	хугацаатай хугацаагаар	авъя гэвэл авмаар байвал авах хэрэгтэй бол авах болбол (авах бол)
-----------------	------------------------------	------	------------------------	---

номын санчтай уулз.**номын санчтай уулзах хэрэгтэй.**

номын санчтай уулзаад	(хугацаа)	сунгуулах ёстой (хэрэгтэй). сунгуулж болно (болдог).
-----------------------	-----------	--

15. Асуулт

Номын сан Талхны дэлгүүр Тамхины мухлаг Тэр үзэсгэлэн	хаана (= хаа)	байна? байдаг вэ?
---	---------------	-------------------

Хариу

(Номын сан) (Талхны дэлгүүр) (Тамхины мухлаг) (Тэр үзэсгэлэн)	төв шуудангийн тэр гудамжны байгалийн музейн тэр байшингийн	цаана наана өмнө хойно	байна. байдаг.
---	---	------------------------	----------------

16. Асуулт

Тэр чинь тийм	үзмээр уншмаар авмаар уумаар идмээр	(сонин) (сайхан) (аятайхан)	НОМ ПИВО ТОЛЬ МАРК ХООЛ ЮМ	уу? үү? юу? юу?
---------------	-------------------------------------	-----------------------------	----------------------------	-----------------

Хариу

Нээрэн	үзмээр уншмаар авмаар уумаар идмээр	сонин сайхан аятайхан	ном пиво толь марк хоол юм	шүү. байна. байгаа юм.
--------	---	-----------------------------	---	------------------------------

17. Асуулт

Та Чи	энийг (= энэнийг) тэрийг (= тэрнийг)	үзмээр авмаар уншмаар	бол, байвал,	хэлээрэй,	хамт	үзнэ авна уншина	шүү.
----------	---	-----------------------------	-----------------	-----------	------	------------------------	------

Хариу

За за, би	үзмээр авмаар уншмаар	бол, байвал,	танд чамд	хэлнэ. хэлэлгүй яах вэ. (= хэлэлгүй яахав).
-----------	-----------------------------	-----------------	--------------	---

18. Хүсэлт

Дорж оо, Багш аа,	чи та	энэ тэр	пивыг цайг хоолыг шөлийг ногоог юмыг	идмээргүй уумааргүй	бол, байвал,	битгий	идээрэй. уугааррай.
----------------------	----------	------------	---	------------------------	-----------------	--------	------------------------

19. Хүсэлт

Та Чи	унтмаар харимаар суумаар босмоор юм идмээр юм уумаар	бол, байвал,	унт унт. харь харь. суу суу. бос бос. ид ид. уу уу.
----------	---	-----------------	--

20. Мэдээлэл

Таныг Чамайг	босмоор харимаар юм уумаар унтмаар	байгаа бол, байвал, бол,	би ч	(бас)	босно. харина. юм ууна. унтана.
-----------------	---	--------------------------------	------	-------	--

21. Асуулт

Хариу

Та Чи	энэ тэр	номыг үзгийг юмыг	авах уу?	Таныг Чамайг	өгвөл,	(би)	авна.
----------	------------	-------------------------	----------	-----------------	--------	------	-------

22. Асуулт

Хариу

Дорж оо, Амуу аа, Болд гуай аа, Аюуш аа,	Дулмаа Лхагва Ням	тасагтаа өрөөндөө танхимд	байна уу?	За би (одоохон) үзээдэхье.
		номоо үзэж л (= үзээд л) Оюунтай яриад л (= ярьж л) хичээлээ хийгээд л (= хийж л) бааранд суугаад л (= сууж л) тасагтаа унтаад л (= унтаж л)		

23. Хүсэлт

Та Чи Миний дүү	үүнийг	бичиж орчуулж хийж зурж	чадахгүй байна уу? Аль вэ, би	бичээдэхье. орчуулаадахъя. хийгээдэхье. зураадахъя.
-----------------------	--------	----------------------------------	-------------------------------	--

Хариу

За тэг!	Би чадахгүй нь. Би чадахгүй байна. Би чадахгүй байгаа юм.
---------	---

Conversations

Яриа

1-р яриа

- Би ном авмаар байна.
- Та уншигчийн үнэмлэхтэй юү?
- Байхгүй шүү. Яаж уншигчийн үнэмлэхтэй болох вэ?
- Та хоёр хувь зурагтай ирээд хэзээ ч үнэмлэх авч болно.
- Уншигчийн үнэмлэх та өгөх үү? Хаанаас авах вэ?
- Тэгнэ, би өгнө.

- За тэгвэл би маргааш зурагтай ирнэ. Маргааш хэдээс онгойх вэ?
- Манай цагийн хуваарь тэр байна. Бүтэн сайнаас бусад өдөр өглөөний 8 цагаас оройн 20 цаг хүртэл ажиллана.

2-р яриа

- Би нэг хэдэн ном захиалах гэсэн юм. Захиалж авч болох уу?
- Ямар ном захиалах (авах) гэсэн юм бэ Та?
- Монгол бичгийн сурах бичиг, нэг монгол- орос толь авах гэсэн юм.
- Хэний зохиосон, хэдэн оны хэвлэл бэ?
- Д. Чойжилсүрэнгийн зохиосон монгол бичгийн сурах бичиг. 1970 оны хэвлэл байх аа. Бас Ковалевскийн зохиосон монгол-орос- франц хэлний хуучин толь их хэрэгтэй байна.
- Чойжилсүрэн гуайн сурах бичиг манайд бий. Харин тэр Ковалевскийн толь манайд байхгүй. Хэрэв хэрэгтэй бол Улсын төв номын санд байгаа.
- За яахав, би тэр монгол бичгийн сурах бичгийг одоо л авмаар байна.
- За би аваад ирье (авчирья).

3-р яриа

- Улсын номын сан хаа байдаг вэ?
- Төв шуудангийн цаана байдаг. Би одоо тийшээ явах гэж байна. Хамт явах уу?
- За яасан сайн хэрэг вэ. Хамт явъя.
- Чи уншигчийн үнэмлэхтэй биз дээ?
- Үнэмлэхгүй ээ. Одоо очиж авна, Чи?
- Би уншигчийн үнэмлэхтэй ээ.

4-р яриа: Номын сан

- Сайн байна уу? Уншлагын танхим ажиллаж байна уу?
- Сайн, сайн байна уу? Ажиллаж байна.
- Хувцасны өлгүүр хаа байна?
- Тэр, хаалганы тэнд байна.
- Би, монгол хэлний холбогдолтой хэдэн ном үзмээр байна.
- Та, товъёгийн 12-р шургуулганаас номынхоо шифрийг бичээд ир.
- За, бичээд ирлээ. Захиалсан ном хэр удаан (удаж) гарах вэ?
- Хорин минут болоод гарна.
- Тэгвэл энэ хооронд 1999 оны "Өнөөдөр" сонин үзээдэхье.
- Энд сонин сэтгүүл байхгүй. Та сонин сэтгүүлийн танхимд очоод өөрөө аваад үзэж болно.
- За, баярлалаа.

5-р яриа

- Энэ номыг гэрээр авч болох уу?
- Болно. Та хэдий (ямар) хугацаагаар авах вэ?

- Энэ ном надад тун их хэрэгтэй байгаа юм. Нэг сараар авч болох уу?
- Болно. Та энд гарын үсгээ зур. Хугацаа сунгуулж болно шүү.
- Танд их баярлалаа. Би танаас нэг юм асууя. Гадаад улсын номын сангаас ном захиалж авч болох уу?
- Зарим улсаас захиалж болно. 305-р өрөөнд захиалга хүлээн авдаг. Захиалсан ном нэг сарын дотор ирнэ.

6-р яриа

- Миний захиалсан ном гарсан уу?
- Та хэдийд захиаллаа аа? (захиалсан бэ?)
- Хоёр цагийн өмнө захиалсан.
- За би үзээдэхье. Гарсан байна. Май, энэ таны захиалсан номууд.
- Уучлаарай, нэг ном байхгүй байна. Гараагүй байна уу?
- Та тэр жижиг хайрцагт үз. Гараагүй бол тэнд таны захиалгын хуудас байгаа байх.
- Аа, тийм байна. "Уншлагад байгаа" гэж бичсэн байна.

7-р яриа

- Хүүе Бат аа ! Чи энд сууж байсан юм уу? Аль танхимд сууж байсан бэ?
- Чи бас энд байсан юм уу? Би сонин сэтгүүлийн танхимд байсан.
- Би нийтийн уншлагын танхимд байсан.
- Чи ямар ном үзэв (уншив)?
- Би Владимирцовын "Монгол хэлний зүй" үзэж байгаад гарч ирлээ.
- Гэрээр авч болохгүй байна уу?
- Тэр ном, номын санд ганц хувь байдаг гэнэ. Ганц хувь байдаг номыг гэрээр өгдөггүй гэнэ.
- Петр найз минь, чи одоо харих уу? Яарч байна уу?
- Харина аа. Яараагүй байна. Юу гэж?
- Тэгвэл хоёулаа тэр зургийн үзэсгэлэнгээр ороод гарах уу?
- Тэгье тэгье. Би ч бас энэ үзэсгэлэнг үзмээр байсан юм.

8-р яриа

- Чамд энэ үзэсгэлэн ямар санагдав?
- Их сонин байна. Ардын зураач Ядамсүрэнгийн зурсан монгол зураг гайхамшигтай байна.
- Залуу зураач нарын (зураачдын) зурсан орчин үеийн сэдэвт зураг ямар санагдаж байна?
- Зүгээр. Залуучууд ч гэсэн авьяастай зураач нар (зураачид) байна.
- Чи Улаанбаатарт өөр ямар музей, үзэсгэлэн үзсэн бэ?
- (Би) Байгалийн түүхийн музей, Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, Түүхийн музей үзсэн. Дүрслэх урлагийн музейг л үзээгүй байна.
- Аа, чи олон юм үзсэн байна. Тэр дүрслэх урлагийн музей чинь үзмээр музей байгаа юм даа.
- Тэр музейд зөвхөн монгол урлагийн бүтээл байдаг уу?

- Голдуу монгол урлагийн бүтээл байдаг. Гадаад улсын урлагийн зарим бүтээл байдаг байх.
- Дараагийн (ирэх) сайн өдөр үзье. Чи үзмээр байна уу?
- Чамайг үзвэл би бас үзнэ.

9-р яриа

- Улсын нийтийн номын санд ямар ямар уншлагын танхим байдаг вэ?
- Олон уншлагын танхим бий.
- Жишээ нь?
- Жишээ нь үү? За, нэгдүгээрт нийтийн танхим, хоёрдугаарт, сонин сэтгүүлийн танхим, гуравдугаарт, шинжлэх ухааны уншлагын танхим, дөрөвдүгээрт улс төрийн уншлагын танхим.
- Ийм дөрвөн танхимтай юм уу?
- Бас өөр танхим бий байх аа, би мэдэхгүй байна.

10-р яриа

- Чи уншигчийн үнэмлэх авсан уу?
- Авсан.
- Аль вэ, үзээдэхье.
- За энэ.
- Энэ хэний гарын үсэг вэ? (Энд хэн гарын үсэг зурсан байна вэ?)
- Энэ миний гарын үсэг (Энд би гарын үсэг зурсан юм).
- Энэ, номын сангийн эрхлэгчийн гарын үсэг үү?
- Тийм ээ. Энд номын сангийн эрхлэгч гарын үсгээ (гарынхаа үсгийг) зуржээ.
- Номын сангийн эрхлэгчийн нэр нь хэн юм бэ?
- Би энэ гарын үсгийг гаргахгүй байна. Чи гаргаж байна уу?
- Би ч бас гаргахгүй байна.
- Үнэмлэхийн хугацаа 12-р сарын 31-нд дуусах юм байна. Хугацаа нь дуусвал яах вэ?
- Хугацаа дуусвал дахиад нэг жилээр сунгуулж болдог.

Бичвэр

Text

1. НОМЫН САН

Манай хотод номын сан, уншлагын танхим олон бий. Эдний нэг нь манай их сургуулийн номын сан. Манай их сургууль хоёр номын сантай. Нэг нь хоёрдугаар хичээлийн байрын дөрөвдүгээр давхарт, нөгөө нь гуравдугаар хичээлийн байрын хоёрдугаар давхарт байдаг. Хичээлийн байр бүр уншлагын танхимтай. Оюутны байранд ч уншлагын танхим бий. Бас тэнхим бүр өөрийн номын сантай байдаг.

Номын санд олон мянган сонин сайхан ном, сурах бичиг, толь бичиг, сонин сэтгүүл бий. Гадаадын олон хэлээр ном сэтгүүл байдаг. Манай номын сангаас

дуртай номоо гэрээр авч болно. Номын сан өдөр бүр өглөө найман цагаас орой арав хүртэл, заримдаа арван нэг хүртэл ажилладаг.

Манай номын сангийн түүхэнд харамсалтай юм ч бий. Юу гэвэл, далан хэдэн онд хоёдугаар хичээлийн байрын номын сан шатаж, олон мянган ном байхгүй болсон юм.

2. МУЗЕЙ, ҮЗЭСГЭЛЭН

Та Улаанбаатарт очвол (ирвэл) янз бүрийн олон сонин сайхан музей, үзэсгэлэн үзэх болно (үзнэ). Байгалийн түүхийн музей, Улаанбаатар хотын музей, Түүхийн музей, Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм-музей их сонин. Улаанбаатарын үзэсгэлэнгийн танхимуудад бараг сар бүр янз бүрийн сэдэвтэй үзэсгэлэн гардаг. Нэг сарын өмнө ардын уран бүтээлийн үзэсгэлэн гарсан. Саяхан залуу зураач нарын бүтээлийн үзэсгэлэн гарсан байна. Бид саяхан дүрслэх урлагийн музей үзэв. Тэнд голдуу монголын урлагийн хуучин, шинэ бүтээл байсан. Орчин үеийн монгол зураач нарын олон сонин зураг үзсэн.

Бид тэр музейн бүх тасгаар орсон. Музейн тайлбарлагч хүүхэн их л сайхан тайлбарлаж байв. Бид монгол хэлэнд сайнгүй болохоор их юм мэдэж чадсангүй. Монгол хэлэнд сайн болоод дахин үзмээр санагдав. Гэвч бид энэ музейгээс Монголын тухай, монгол урлагийн тухай олон шинэ юм мэдэж авлаа. Биднийг музейгээс гарахад музейн эрхлэгч "манай музейд дахин дахин ирж байгаарай" гэсэн.

Exercises

Дасгал

1. Хаалтан дахь үйл үгийг тохирох хэлбэрт нь тавь. Use the correct forms of the verbs in brackets.
1. Хэд хоногийн өмнө надтай... хүн тэр байна. (танилц-)
 2. Амарсанаа маргааш Дүрслэх урлагийн музей... (үз-)
 3. Би завгүй учир тэр номыг уншиж... (чад-)
 4. Бид саяхан их сонин ном... авсан. (худалд-)
 5. Миний өглөө... сэтгүүл сая гарлаа. (захиал-)
 6. Захиалсан ном чинь нэг цагийн дараа... (гар-)
 7. Таныг... би дуртай авна. (өг-)
 8. Чи энэ пивыг... байна уу? (уу-)
 9. Өнөө орой зурагтаар шинэ монгол кино... (гар-)
 10. Этнографийн музейд монгол хувцасны үзэсгэлэн... гэнэ. (гар-)
 11. Чи надтай хамт суумааргүй... надад хэлээрэй. (бай-)
 12. Чамайг... би ч явна. (яв-)

2. Хаалтан дахь үйл үгнүүдээс тохирохыг тавь.

Choose the correct verb forms.

ҮЛГЭР: Би энэ номыг гэрээр... (АВАХ, АВСАН)
БИ ЭНЭ НОМЫГ ГЭРЭЭР АВСАН.

1. Би 1974 оны «Утга зохиол урлаг» сонин үзэх... юм. (ГЭЛЭЭ, ГЭСЭН)
2. Удахгүй бид түүхийн музей... (ҮЗНЭ, ҮЗДЭГ, ҮЗЭХ)
3. Удахгүй бидний... түүхийн музей энэ. (ҮЗЭХ, ҮЗНЭ, ҮЗЛЭЭ)
4. «Нацагдорж» гудамжинд... нэг ресторанд бид сууж байсан. (БАЙДАГ, БАЙЖ)
5. Та энэ хуудсан дээр захиалах номынхоо шифрийг... (БИЧЭЭДЭХЬЕ, БИЧЭЭРЭЙ)
6. Энэ үгийг монгол хэлний тайлбар толинд... хэрэгтэй. (ХАРНА, ХАРЖ, ХАРАХ)
7. Уучлаарай, би гэр лүүгээ... байна. (ЯАРЧ, ЯАРАХ)
8. Би Д.Нацагдоржийн зохиолыг уншихыг... байна. (ХҮСЬЕ, ХҮСЭЖ, ХҮСНЭ)

3. Үгсийг холбон өгүүлдэр зохио.

Use the following words in sentences.

1. уншигчийн үнэмлэх, чи, авсан, хэзээ, вэ?
2. авахдаа, та, хоёр хувь, ирээрэй, зурагтай, үнэмлэх
3. номын сан, манай, хүртэл, найман цагаас, арван долоон цаг, онгойж ажилладаг
4. гэр, манай, их дэлгүүрийн, байгалийн түүхийн музейн, цаана, наана, байдаг
5. танхимд, уншиж байна, уншлагын, сэтгүүл, монгол, Дорж
6. хийгээрэй, тэр хайрцагт, хуудсыг, захиалга бичсэн, та
7. захиалга, хэр (хир), миний, гарах, удаж, вэ?
8. жижүүр, номын санд, ажилладаг, номын санч, нар
9. чаддаггүй, ном, сүмийн лам, уншиж, нар, энэ, монгол хэлээр

4. Хаалтан дахь асуух үгсийн оронд зохих үгийг тавь.

Replace interrogatives in brackets by suitable words.

1. Улаанбаатарт (ямар) зэрэг музей байдаг.
2. Улсын номын сан (хаана) байдаг.
3. Байгалийн түүхийн музейд (юу юу) бий.
4. Би (юуны) холбогдолтой ном үзмээр байна.
5. Хоёулаа орчин үеийн сэдэвтэй (юу) үзье.
6. Энэ үзэсгэлэн (ямар) үзмэрүүдтэй юм.
7. (Аль) номын санд гадаад хэлний ном олон байдаг.
8. Монголын лам нар (ямар) хэлээр номоо уншдаг.
9. Тэр хүн орой (хэдийд) унтаж, өглөө (хэдийд) босдог.
10. Амарсанаа (яагаад) өглөө эрт ирж чадаагүй.
11. Би (яагаад) чамруу утасдаж чадаагүй.

**5. Баглах өгүүлбэрийг үгүйсгэх,
хүсэх өгүүлбэр болго.**

Change using the model.

ҮЛГЭР А: Та монгол ардын урлагийн бүтээлийг үздэг.

ТА МОНГОЛ АРДЫН УРЛАГИЙН БҮТЭЭЛИЙГ ҮЗДЭГГҮЙ.

ТА МОНГОЛ АРДЫН УРЛАГИЙН БҮТЭЭЛИЙГ ҮЗМЭЭР ЮМ.

1. Дорж монгол ардын хөгжим сонсдог.
2. Чи уран зохиолын ном уншдаг.
3. Батдорж номын санд очдог.
4. Чи монгол үг олныг тогтоодог.
5. Чи харилцаа яриа цээжилсэн.
6. Та тэр үзэсгэлэнг үзсэн.
7. Чи Оюумаатай танилцсан байна.
8. Та монгол бичгээр уншиж сурсан.
9. Миний дүү заримдаа ингэдэг.
10. Чи долоо хоногт нэг өдөр амардаг.

ҮЛГЭР Б: Та номын санд байсан (очсон).

ТА НОМЫН САНД БАЙГААГҮЙ (ОЧООГҮЙ).

ТА НОМЫН САНД БАЙГААРАЙ (ОЧООРОЙ).

1. Чи өчигдөр Их сургууль дээр байсан.
2. Чи тэр үзэсгэлэнг үзсэн (үзсэн байсан).
3. Та нар Богд хааны ордон музей рүү явсан.
4. Чи гэртээ харьсан (харьсан байсан).
5. Та монгол авгай авсан.
6. Чи надтай нэг ширээнд суусан.
7. Миний найз тэр хүүхэнтэй суусан.
8. Та улс төрийн ном уншсан.
9. Чи энд гарын үсэг зурсан.
10. Та надад мянган төгрөг өгсөн.

**6. "бол", -бал4, -вал4 -ийн аль
тохирохоор цэгийг нөх.**

**Fill in the conditional particle or condi-
tional converb suffixes.**

1. Чи энэ шөлийг уумааргүй... битгий уу.
2. Би чамайг ир-... бууз хийж өгнө.
3. Чамайг чадахгүй... би хийгээдэхье.
4. Дулмааг танайд байгаа... би орохгүй.
5. Дулмааг танайд байхгүй... би орно.
6. Сонин монгол зураг бай-... би авна.
7. Би оросоор ярьж чаддаггүй, гэвч бусад хүн ярь-... жаахан ойлгодог.
8. Чамайг хүс -... би чамтай хамт тэр ресторанд очмоор байна.
9. Би чад-... өнөө орой танайд очно, чадахгүй... чамтай утсаар ярина.
10. Энэ хоол чамд аятайхан санагдсан... би дараа дахиад хийж өгнө.

7. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу Join the sentences using the model.
холбож хэл.

ҮЛГЭР: Би төв шуудан дээр очно. Тэгвэл нөхөртөө захиа явуулна.
БИ ТӨВ ШУУДАН ДЭЭР ОЧВОЛ НӨХӨРТӨӨ ЗАХИА ЯВУУЛНА.

1. Та уншигчийн үнэмлэх авна. Тэгвэл тэр сэтгүүлийг захиалаарай.
2. Та одоо захиалгаа өгнө. Тэгвэл номоо 10 минутын дараа авч болно.
3. Та энэ жижиг номыг сайн уншаарай. Тэгвэл монголын түүхийг мэдэж болно.
4. Чи номын дэлгүүрээр орно. Тэгвэл тэр номын үнийг мэдээд ирээрэй.
5. Та дүрслэх урлагийн музейд очно. Тэгвэл тэр гайхамшигт бүтээлийг үзнэ.
6. Та одоо тийшээ яваарай. Тэгвэл Байгалийн түүхийн музейн гурван давхар цагаан байшин харагдана.
7. Танайх шинэ байранд орно. Тэгвэл манай эхнэрт хэлээрэй.
8. Та тэр номын түлхүүрийг бичээд ир. Тэгвэл би тэр номыг удахгүй аваад ирье.
9. Чи энэ (гэрэл) зурагт их дуртай байна. Тийм бол чамд нэг хувийг би өгнө.
10. Чи хоол хийхгүй. Тэгвэл (би) гуанз руу явна гэж нөхөр нь эхнэртээ хэлсэн.

8. Орчуулах. Translation.

Өнөөдөр бид юу хийв?

Өнөөдөр ням гариг. Би долоон цагт босоод цайгаа уусны дараа хичээлээ жаахан үзэв. Тэгээд есөн цаг болоход цүнхээ авч номын санд очсон. Тэндээс түүхийн холбогдолтой хоёр ном захиалж аваад дүрслэх урлагийн музейд очиход миний найз хүлээж байв. Бид хоёр тэр музейн бүх тасгаар орж үзээд, дараа нь нэг гуанзанд орж хоол идсэн. Хоолны дараа нэг залуу зураачийн үзэсгэлэн рүү явмаар байсан. Гэвч цаг орой болчихсон байв.

9. Дараахи үгнүүдээр асуух өгүүлбэр Construct interrogative sentences.
зохио.

1. уншлагын танхим, унш-, ном, олон хүн, байсан
2. авч, чи, өчигдөр, уншигчийн үнэмлэх, чадаагүй
3. хэдээс, номын сан, Их сургууль, ажилладаг, хэд хүртэл
4. тэр дэлгүүр, онгойгоогүй, өнөөдөр
5. явах, эндээс, руу, Боловсролын их сургууль, яаж
6. уншлагын танхим, унш-, ном, олон хүн, хэзээ, байсан
7. авч, чи, өчигдөр, уншигчийн үнэмлэх, чадаагүй, яагаад
8. номын сан, Их сургууль, ажилладаг, Ням гаригт
9. тэр дэлгүүр, онгойгоогүй, өнөөдөр, яагаад
10. явах, эндээс, руу, Боловсролын их сургууль, чи

10. Цэгийн оронд асуух өгүүлбэр

Fill in interrogative sentences.

тавь.

- 1? Бололгүй яах вэ, та дуртай номоо авч болно.
- 2? Тийм ээ, Чойжилсүрэнгийн зохиосон сурах бичиг.
- 3? Би гэрээр авахгүй, танхимд сууж үзнэ.
- 4? Би монгол-чех толь захиалах гэсэн юм.
- 5? Манайд тэр ном чинь байхгүй дээ.
- 6? Би тэр номыг одоо л авмаар байна.
- 7? Хоёр цагийн дараа гарна.
- 8? Ном чинь гараагүй л байна.
- 9? Би тийм үзэсгэлэн үзэх дургүй.
- 10? Би тэр музейг үзэхийг хүсэхгүй байна.
- 11? Энэ хотод тийм олон музей байхгүй.
- 12? Нээрэн, үзмээр сайхан кино шүү.
- 13? Тийм ээ, би монгол хэл сурах бичиг хоёрыг авах гэсэн юм.
- 14? Таны захисан (захиалсан) ном уншлагад байгаа.
- 15? Захиалгын хуудаснууд тэр хайрцагт байна.
- 16? Тийм, би энэ танхимд байсан юм.
- 17? Би монголын урлагийн тухай нэг жижигхэн боловч сонин ном уншлаа.
- 18? Болохгүй. Энэ ном манайд ганц хувь байгаа юм.
- 19? Энэ үзэсгэлэн надад тийм аятайхан санагдаагүй.
- 20? Тийм ээ, манай Бат зургийн авьяастай хүн.
- 21? Чамайг очвол очъё.
- 22? Их олон мянган номтой.
- 23? Багш, шинжлэх ухааны уншлагын танхимд сууж байна.
- 24? За, би одоо аваад ирье.

11. Асуултад хариул.

Answer the questions.

1. Номын санд унших номоо яаж захиалах вэ?
2. Номын сангаас ном яаж гэрээр авч болох вэ?
3. Номын сангийн уншигчийн үнэмлэх яаж авах вэ?
4. Эндээс хамгийн ойрхон номын дэлгүүр хаана байдаг вэ?
5. Номын дэлгүүрт худалдагчаас юу асуудаг вэ?
6. Яагаад уншлагын танхим дандаа олон хүнтэй байдаг вэ?
7. Энэ танхимд ямар ямар толь бичиг байна вэ?
8. Чи номын сангийн цагийн хуваарийг хэлж өгөөч?
9. Энэ сайхан тайлбар толийг та хаанаас авсан бэ?
10. Тэр үзэсгэлэнгийн юу нь аятайхан, юу нь аятайхан биш санагдсан бэ?
11. Чи тэр музейн зарим тасгаар л орсон уу?
12. Монгол ардын хувцасны загвар хаана үзэж болох вэ?
13. Монгол урлагийн тухай чи ямар номоос мэдсэн бэ?
14. Энд гадаадын урлагийн бүтээл үзэж болох газар бий юү?
15. Монголын номын санд гадаад улсаас, жишээ нь Хятад улсаас ном захиалж үзэж болох уу?

16. Монгол хэлээр номоо уншдаг сүм хаана байдаг вэ?
17. Монголын буддийн сүмийн лам нар яагаад төвд хэлээр уншиж байна?, монголчууд төвд хэлийг мэддэг учраас тэгж байна уу?
18. Монгол улсын нийтийн номын сангийн гайхамшигтай сонин ховор (хамгийн том, хамгийн жижиг зэрэг) номуудын тухай та юу мэдэх вэ?

Даалгавар

Homework

1. **Номын сан, музей, үзэсгэлэнгийн тухай цээжээр ярь.** Learn to speak about a library, a museum, an exhibition by heart.
2. **Номын сан, музей, үзэсгэлэнгийн сэдвээр харилцан ярилц.** Talk about a library, a museum, an exhibition with a colleague.
3. **Үзсэн музей, үзэсгэлэнгийн тухай бичвэр зохион бич.** Write a short essay about a museum or an exhibition you have visited.
4. **Орчуулах.** Translate into Mongolian:
 1. Can I read a book about Mongolian in this library?
 2. If you have a library card, you can (read).
 3. Since I have arrived recently in Ulaanbaatar, I do not have a library card. How can I obtain one?
 4. If you want to obtain a library card, bring two photographs (of yourself).
 5. Who will issue (lit.: write) the card for me?
 6. I will issue (it) and the head of the library will sign (it) and put a stamp (on it).
 7. Is it possible to take books home from your library?
 8. Some books may be taken home, but old books may be read only here.
 9. For what length of time is it possible to borrow books from your library?
 10. (From our library) it is possible to borrow for one month (for the term of one month). The term of loan may be extended.

* * *

 11. Bat, yesterday I was in the Museum of History. It is very interesting.
 12. What other museums have you seen in Ulaanbaatar?
 13. I saw the Museum of Nature, the Museum of Nacagdorji and the temple museum of Choijin Lam. But I have not seen the palace museum of Bogd Khan.
 14. It is really worth seeing. Which section of the Museum of Nature did you like best?
 15. I liked best the ethnographic section, there are Mongolian folk costumes, folk art and many other interesting things.
 16. Are you interested in modern paintings? They have now opened an exhibition of the works of young Mongolian painters.
 17. Can we go and see it together?
 18. O.K. then. Let us talk about it more specifically tomorrow or the day after tomorrow.

Хэлзүй

Grammar

1. Derivation

a) The suffix *-x /-хь (-хи)*, is used to form nouns from adverbs and from postpositions (cf. L6, Gr. 1):

<i>хувьсгалаас өмнөх манай ард</i>	the life of our people before the revolution
<i>түмний амьдрал</i>	
<i>хувьсгал ялсны дараахь монголын ард түмний амьдрал</i>	the life of Mongolian people after the victory of the revolution

b) The suffix *-хан⁴* can also imply a higher amount of a quality (cf. L1, Gr. 4):

<i>томхон, томоохон</i>	fairly large, rather large
-------------------------	----------------------------

2. Echo words

Repeating the same word with an altered initial syllable is a frequent manner of referring to an indefinite group of things related to a certain word (notion). In this sense this is an analytical manner of forming new lexemes, which can be used with all word classes. Such phrases may be translated with an additional phrase '...and the like, and such things'. The initial consonant usually turns into *м-*, an initial *м-* or *н-* turns into *з-*. An initial *м-* is added if the word starts in a vowel.

<i>кино мино</i>	cinema and the like
<i>сандал мандал</i>	chairs and similar furniture
<i>мах зах</i>	meat and similar victuals
<i>мал зал</i>	cattle and the like
<i>аяга маяга</i>	cups and the like
<i>ном зом</i>	books and the like
<i>дэвтэр мэвтэр</i>	copybooks and the like
<i>Дорж морж</i>	Dorji and people like him

In colloquial language, similar echo formations are also frequent with verbs. The first member of the pair takes the form of imperfect converb in *-ж/-ч*, and the meaning of the construction is roughly equivalent to *-ж/-ч барь-*.

<i>дуулж муулах = дуулж барих</i>	to sing and the like
<i>тоглож моголох = тоглож барих</i>	to play and the like
<i>наймаа хийж мийдэг = наймаа хийж барьдаг</i>	(he, she) keeps doing profiteering and the like (pejorative)
<i>уулзаж муулзаж = уулзаж барьж</i>	having met (people) and the like

This being an emotionally loaded phrase, the combinations may also vary between various temporal forms of the verbs:

<i>дуулах муулах = дуулах барих</i>	to sing and the like
<i>дуулсан муулсан = дуулсан барьсан</i>	(he, she, etc.) sang and the like
<i>дуулдаг муулдаг = дуулдаг барьдаг</i>	(he, she, etc.) sings (permanently) and the like

Some researchers and stylists do not accept these constructions, though the pairing of words is an intrinsic part of the structure of all agglutinative languages.¹

3. Partial number

In this lesson we encounter the form in final *-᠔* for final *-н*: *амьтан* > *амьта᠔* animals

4. Cases

a) The dative-locative is used with some words designating quality – ‘good’, ‘bad’:

<i>монгол хэлэнд сайн</i>	good at Mongolian
<i>монгол хэлэнд муу</i>	bad at Mongolian

Furthermore, the dative-locative is used in special phrases, like ‘playing the part of ...’, or ‘go and get’:

<i>Цогт Тайжид хэн тоглосон бэ?</i>	Who played the part of Cогt Taiji?
<i>Тасалбарт явсан.</i>	He went to buy tickets.
<i>Талханд явсан.</i>	He went to buy bread.

b) Mongolian uses ‘double cases’, which correspond to subordinate clauses in English. Their grammatical nature in Mongolian, however, will have to be defined later. Here we encounter a combination of sociative and accusative.

Ямар кинотойг ч мэдэхгүй байна. I do not even know what is on.

c) The accusative case suffix *-ийг/-ыг* followed by enclitic pronouns *минь*, *чинь*, *нь* etc. loses the final *-г* and is used also after nouns ending in long vowels (with a linking *-г*):

аавы минь my father (Acc.)

¹ For this cf. e.g. J. Vacek, B. Pürev-Ochir, Lexical Pairs in Mongolian, *Archiv Orientální* 55,4, 1987, pp. 370–386 (with further references).

<i>ээжий нь</i>	his (her) mother (Acc.)
<i>алдаагий нь</i>	his (her) mistake (Acc.)

In present-day texts, however, we can encounter the full accusative suffix before enclitic pronouns, which is not in agreement with spoken usage and might even be considered incorrect.

5. Postpositions

<i>цуг</i>	together, jointly (sociative): <i>чамтай цуг</i> <i>надтай цуг</i>	(together) with you (together) with me
<i>шиг</i>	as, like (with the nominative of nouns or oblique of personal pronouns; cf. Patterns No. 21–22): <i>багш шиг</i> <i>ширээ шиг</i> <i>над шиг</i> <i>бидэн шиг /бид нар шиг</i> <i>чам шиг</i> <i>тан шиг</i> <i>энэн /энүүн/ үүн шиг</i> <i>тэрэн /тэрүүн/ түүн шиг</i> <i>тэдэн шиг</i> <i>багш шиг</i>	like the teacher like the table like me like us like you like you (pl., hon.) like him, like this (one) like him, like that (one) like them, like those (ones) like the teacher
<i>хойш</i>	after (Abl.) <i>25-наас хойш</i>	after the twenty-fifth (note that in colloquial usage the postposition can be omitted; cf. Sentence Pattern No. 1 below)

6. Numerals

Numerals may also stand after the noun, which they determine and then they take the case suffixes. Grammatically this is to be understood as a phrase, where the numeral is the head of the construction and the respective noun is the ‘attribute’.

Найман цагийн хоёр тасалбар авъя.

OR:

Найман цагийн тасалбар хоёрыг авъя. I will have (lit.: let me take) two tickets for eight o'clock.

7. Precative

This form takes the suffix *-аач*⁴ and expresses a polite wish or request.

<i>туслаач</i>	help (please)	<i>бичээч</i>	write (please)
<i>өгөөч</i>	give (please)	<i>орооч</i>	enter (please)

8. Preteritum imperfecti

This verbal form takes the suffixes *-жээ*, *-чээ* (cf. the table of verbal forms in the Supplement). Before interrogative particles or before other particles the form takes only *-ж*, *-ч*. The form expresses past action, which proceeded for some time and which the speaking person did not see with his own eyes or did not notice. Thus it may also include an action, which occurred in a more remote past¹ (it often appears in fairy tales, legends and similar narratives). It mostly refers to the third person, rarely to the first and second persons. In purely colloquial language the short form without the long vowel at the end can occur even without following particles.

<i>Чи сайхан юм үзжээ!</i>	You saw something nice!
<i>Хумберто цирк ирж гэнэ.</i>	They say that the Humberto Circus has come.
<i>Зарлал нь гарч уу?</i>	Has the announcement of it appeared?

9. Intensity or duration of an action

In this lesson (cf. also L8, Gr. 7b) we shall have the combination of a *converbum perfecti* with the particle *л* and the verb 'to be'.

<i>Кинон дээр нэг хэдэн хүн яриад л байсан.</i>	During the projection (of the film) several people kept talking.
<i>Үзээд л баймаар сайхан концерт юм.</i>	It is a nice concert I would like to listen to (permanently).

10. Nomen futuri

a) In connection with the third person enclitic pronoun (cf. also L6, Gr. 12) *nomen futuri* sometimes expresses the immediate future. In pattern No. 20 below it implies the meaning 'is about to' and the speaker presumes that the addressed person is informed (as against pattern No. 19 – that is also why the answers differ accordingly).

b) The connection of *nomen futuri* with *юм сан* roughly corresponds to the phrase 'would like to':

<i>Чамтай цуг л үзэх юм сан.</i>	I would like to see (it) together with you.
----------------------------------	---

¹ N. Poppe (1951, p. 80, paragraph 160), however, has a different definition, which may have been based on a different than the Khalkha dialect. Cf. also Kullmann, Tserenpil 1996, p. 185.

c) In connection with *санаатай* (lit. 'with the intention', i.e. having the intention) *nomen futuri* expresses the meaning 'to intend to, to plan to':

... нэг үзэх санаатай байна. Once I intend to go and see ...

d) *Nomen futuri* in dative-locative followed by *баяртай бай-* 'to be glad':

Дөрвүүлээ үзэхэд би баяртай байна. I am glad the four of us will see it (together).

e) *Nomen futuri* as a predicate can be followed by *нь*, which implies that the subject has decided or intends to act, or that the action is sure to take place soon (cf. L6, Gr. 12; further see Pattern No. 19 below). The phrase roughly corresponds to *nomen futuri* followed by *гэж байна* (cf. L8, Gr. 10c).

Та маргааш ирэх үү? Will you come tomorrow? (neutral question)

Та маргааш ирэх нь үү? Do you intend to come tomorrow?

11. *Nomen usus*

Nomen usus in accusative corresponds to object clause in English:

Хэд байдгийг сайн мэдэхгүй байна. I do not know exactly how many there are.

12. *Nomen perfecti*

The patterns Nos. 8 and 9 specify two different phrases. In No. 8 *авсан номоо* is the object and *та* is the subject of the sentence. In No. 9 the whole phrase *таны авсан ном* is the subject of the sentence.

13. Postpositions after verbal nouns

a) The postposition *шиг* 'like' is used after the nominative of *nomen futuri*, *nomen perfecti*, *nomen usus* and *nomen imperfecti*. With *nomen imperfecti* the word *юм* is always used, while with the other *nomina* it is used if the situation is exactly defined (e.g. in an answer to a question; more examples in patterns Nos. 16–20):

Монголын ард түмний амьдралыг I felt like seeing the life of Mongolian
үзэх (үзсэн) шиг санагдсан. people.

b) The postposition *өмнө* 'before' is used with the genitive or ablative, while the meaning of the phrase is the same. The use of *-аа*⁴ or *нь* follows the same rules as those specified for the dative-locative of *nomen futuri* (L7, Gr. 11):

Циркийг буцахаас нь өмнө л нэг Just before the circus leaves, I intend to
үзэх санаатай байна. see it once.

Та буцахаасаа өмнө энийг хий.

Та буцахынхаа өмнө энийг хий. Do this before leaving.

14. Verbal phrases

In this lesson we will find the following phrases:

<i>Зааж өгье.</i>	Let me teach (you). Let me show (you).
<i>Дуулж сурсан уу?</i>	Have you learnt to sing?
<i>Тэгж тогтъя.</i>	Let us agree thus.

The verb *өг-* can also be connected with the *converbum perfecti*:

<i>Заагаад өгье.</i>	Let me teach (you). Let me show (you).
<i>Хэлж өгнө.</i>	
OR: <i>Хэлээд өгнө.</i>	I will tell (you).

The verb *тогт-* 'to agree' follows the *converbum imperfecti* only in the above colloquial phrase *тэгж тогт-*, or *ингэж тогт-*. Otherwise it is connected with the instrumental of *nomem futuri*:

<i>Бид хоёр орой есөн цагт уулзахаар тогтох шив дээ?</i>	So we have agreed to meet at nine in the evening, haven't we? (or: It appears that we have agreed ..., does it not?)
--	--

In colloquial speech the phrase *шив* *вэ* is contracted to *шив*.

15. The verb *гэ-*

a) Some forms of this verb in certain contexts may be translated as 'they say, reportedly':

<i>Дулмаа Жаргал хоёр үзнэ гэнэ.</i>	They say that Dulma and Jargal will (go and) see.
--------------------------------------	---

<i>Өнөөдөр сургуультай амьтад, ... оролцсон хөтөлбөртэй гэнэ.</i>	They say that today the program includes trained animals, ...
---	---

Further cf. No. 8 above.

b) The form *гэвэл* is used as a quotation word in conditional clauses, e.g.:

<i>Хэрвээ та ... сонсъя гэвэл, өнөөдөр сонсч болно.</i>	If you decide to listen to ..., you can listen today (lit.: 'if saying: I will listen')
---	---

16. Conditional clauses

If the two clauses have different subjects, the subject in the conditional clause is in the accusative case. With inanimate subjects the accusative suffix is used only if the subject is exactly defined (cf. also L8, Gr. 5):

<i>Монгол кино гарвал та үзэх үү?</i>	If a Mongolian film is on, will you see it?
<i>Энэ монгол киног гарвал та үзэх үү?</i>	If this Mongolian film is on, will you see it?

17. Comparison

Comparison can also be expressed by way of the form *бодвол* (after Acc.) 'if considering' (free translation 'in comparison with'). In colloquial speech this form is less frequent, the colloquial usage seems to prefer the ablative (cf. L2, Gr. 15).

<i>Өчигдрийн киног бодвол их сонин байна.</i>	As compared with yesterday's film, it is more interesting.
<i>Чи намайг бодвол монгол хэлэнд сайн хүн.</i>	You are better at Mongolian than me (lit.: As compared with me ...)

18. 'Object clause'

As in other cases of 'dependent clauses', the subject of 'object clauses' depending on main clauses with the verbs 'to know, to think, to hear' takes the form of the accusative, if it is different from the subject of the 'main clause'.

<i>Чамайг юм үздэггүй хүн гэж би дуулсан юм.</i>	I have heard that you do not see anything much.
<i>Гэхдээ чамайг циркт дуртай байх гэж бодож байна.</i>	Still I think you like the circus.

The respective independent clauses are as follows:

<i>Чи юм үздэггүй хүн.</i>	You do not see anything much.
<i>Чи циркт дуртай.</i>	You like the circus.

19. Particles

a) *билээ* is an interrogative particle implying that the person asking the question has already heard about the matter, but has forgotten the exact circumstances or cannot remember (cf. pattern No. 7).

b) *aa* is a particle having mainly an emphasizing function, but can also express astonishment:

<i>Энэ кино чинь түүхийн сэдэвтэй кино юм aa?</i>	Oh, that is a film with a historical topic?
---	---

20. Idioms and phrases

<i>кинон дээр</i>	during the (film) performance
<i>нэг хэдэн</i>	several, a few
<i>энд тэндгүй</i>	here and there
<i>найз нь (= би)</i>	I, me (lit.: his, your friend) (intimate expression)

... хийх зав гарахгүй (л) байна.

Би юм үздэггүй хүнийг бодвол юм
үздэг хүн шүү.

Яасан сайн хэрэг вэ!
Яриа юу байх вэ!

Яриад яах вэ!
Яриангүй тийм!
Үзсэн ч яах вэ.

I have no time to do ... (lit.: No time to do ... is available.)

I still go and see something (lit.: In comparison with a man who sees nothing, I do see something; i.e. it is not that I do not see anything at all)
Oh, how fine!

Don't mention it, not necessary to speak about it. (That's how it is.)

id.

id.

It may as well be seen. We (I) may as well see it (I do not really mind/desire seeing, but I leave it to the other person; sometimes it implies resignation).

Vocabulary

алга (н)
алга таш-(Э2.3)
(ташиж, таших, ташина)
алдаа (н)
амьдрал
амьтан
анги
ард түмэн
аялгуу (н)
баримтат
баяртай бай-
бод -(Э2.2)
(бодож, бодох, бодно)
болгон (encl.)
болон
бөгөөд
буц- (Э2.4)
(буцаж, буцах, буцна)
бүжиг
бүжгийн жүжиг
бүжигчин
бүхэн (encl.)
гайхалтай
гоёчил- (Э2.4)
(гоёчилж, гоёчлох,
гоёчилно)
гол 2.а
гол 2.с
голын суудал
гэвчиг (= гэвч)
гэхдээ

palm of hand
to clap one's hands, applaud
mistake, error
life
animal; living creature
part (of a film)
people; the masses
melody, (also: pronunciation)
documentary
to be happy, glad
to think, reflect
each, every
and (lit. 'having become')
and (lit. 'having become')
to go back, return
dance
ballet
ballet dancer; dance
all, each
wonderful, astonishing
idealize, paint in glowing colours
centre, middle, (core, nucleus; the aorta)
main, chief, central, pivotal, essential (for 2.b cf. L12)
a seat in the middle
but, however
but, however

Шинэ үг

даан ч (дан ч)	unfortunately, I am afraid...
драмын театр	dramatic theatre
дурд- (Э2.2)	to mention
(дурдаж, дурдах, дурдана)	
дуу (н)	song
дуул- (Э2.4)	to sing; to hear
(дуулж, дуулах, дуулна)	
дуурь	opera
дуучин	singer
дэлгэц (эн)	movie screen
дэлхий	earth, world
ёстой 1.	real, proper
жишээлбэл	for example
жүжиг	play (in theatre)
жүжигчин	actor, actress
заавал	for certain, must
зарлал	poster; announcement
засаг	administration, authority, government
зоогло- (Э2.1)	to eat, drink (honor.)
(зооглож, зооглох, зооглоно)	
зун	summer; in summer
илбэ [eliv, iliv]	magic; sleigh of hand
инээдэмт (инээдмийн)	comedy
жүжиг	
ихэнх	for the most part
кино зохиол	screenplay, script
кино зураг ав-	to shoot a film
кинотеатр	cinema
коммунист дэглэм	communist régime
концерт	concert
лимбэ	flute
морин хуур	a string instrument (of the size of a cello)
мэргэжил	specialization
найруул- (Г1)	to produce, direct (a film)
(найруулж, найруулах, найруулна)	
найруулагч	producer, director
номер	number (of a program)
нугаралт	bending
ойрдоо	recently
ол- (Г1)	to find, obtain
(олж, олох, олно)	
онцгой	special
оролц- (Э2.2)	to participate, take part in
(оролцож, орлцох, оролцоно)	
орон 2.	country; territory
өнгөрсөн	past, bygone; last
өндөр	high, tall
өргөө (н)	palace, residence (also name of a cinema)
санаатай	intending to (after future verbal noun in -x)
сансар	cosmos, material world (name of a cinema)
соёл	culture

сургуультай амьтан	performing animals (with training)
сүүлчийн, сүүлийн	last, final; the latest, recent
сүүлийн үеийн	recent (lit.: of recent time)
суудал	seat
тоглолт	performance
тогт- (Э2.2)	to settle, stop; decide, agree
(тогтож, тогтох, тогтоно)	
томхон, томоохон	somewhat large, big, larger, fairly large
тохилог	comfortable
тусгүй	useless, unnecessary
түм (эн)	ten thousand
тэнгис	sea, lake (name of a cinema)
удаа	time, instance; times (after numerals)
удирдаач	conductor (in music)
урь- (Э2.4)	to invite
(урьж, урих, урина)	
үе	time, moment, period
үзвэр	spectacle, show
үзэгч, (үзэгчид)	spectator, audience, (spectators)
үйлдвэр	industry
үйлдвэрлэ- (Э2.1)	to produce, manufacture
(үйлдвэрлэж, үйлдвэрлэх, үйлдвэрлэнэ)	
хайр, хайр сэтгэл	love, affection
хамтлаг	ensemble, music band
харуул- (Г1)	to show, demonstrate
(харуулж, харуулах, харуулна)	
хөгжимчин	musician
хөтөлбөр	programme
хүүхэлдэй	puppet, doll
хүүхэлдэйн театр	puppet theatre
цирк	circus
цуг (Сос.)	together with, jointly
чуулга	ensemble (dance and music)
шаардлага	demand, requirement
шанз (ан)	a musical instrument /with three strings)
шиг	like, simillare to
эгнээ (н)	row
эмгэнэлт жүжиг	tragedy
эхний	initial
ял- (Э2.4)	to conquer, defeat; win
(ялж, ялах, ялна)	
ялалт	victory
яриан жүжиг	drama
ятга	zither, harp

Дуудах

Pronunciation

- [i - i:] би - бий, чи - чий, иш - ийш, им - ийм, ир - тийр,
хил - хийлгэх, жиргэх - жийрэг, мисир - мий
- [ö - ö:] өр - өөр, өд - өөд, өх - өөх, хөх - хөөх, зөн - зөөн, бөн - бөөн,
хөрөх - хөөрөх, өнгө - өнгөө, мөнгө - мөнгөөр
- [ü - ü:] үр - үүр, үл - үүл, үд - үүд, дүр - дүүр, түлээ - түүлээ,
үнэ - үүнийг, үлгэр - үүлгэр, түрэх - түүрэг
- [u - u] хур - хуур, тулах - туулах, тухай - туухай,
судаг - суудаг, сулдах - суулгах, мухар - муухан
- [ɔ, ɣ, ʰ] холбогдолтой - тогдолзуулах, солбицолдох - зодоглуулах,
золголготой - доголдох, дололгох - долоолгох, ботголуулах
- [a, ɣ, ʰ] батлуулах, задлуулах, балмадлуулах, халалцуулах,
далбалзуулах, залилуулах, баталгаатай, налдайлгах

Загвар

Sentence Patterns

1. Асуулт

Та	хэзээ хэдийд	явах буцах хэлэх амрах өгөх ирэх үзэх үзүүлэх	вэ?	
			гэж	байна вэ? байгаа вэ?

Хариу

(Би)	өнөөдөр маргааш 7 хоногийн дараа удахгүй 25-нд 25-наас	явах буцах хэлэх амрах өгөх ирэх үзэх үзүүлэх	санаатай	(байна). (байгаа).
------	---	--	----------	-----------------------

2. Асуулт

Та	хаашаа	явах	гэж байна (вэ)?
----	--------	------	-----------------

Хариу

(Би)	хот руу Прага хөдөө кинотеатр луу концертийн танхим руу цирк рүү гэр лүүгээ	явах	гэж байна. санаатай (байна).
------	---	------	---------------------------------

3. Асуулт

Дорж оо, Багш аа, Найз аа, Бат гуай аа,	чи та	өнөөдөр маргааш сайн өдөр зун 25-нд	яаж амрах юу үзэх юу хийх	гэж	байна? байгаа вэ?
--	----------	---	---------------------------------	-----	----------------------

Хариу

(Би)	өнөөдөр маргааш сайн өдөр зун 25-нд	гэртээ байх гэртээ амрах театрт очих кино үзэх хөдөө явах номын санд суух концерт үзэх доктортой уулзах	санаатай	(байна). (байгаа).
------	---	--	----------	-----------------------

4. Асуулт

Оюун Багш	байна уу? байхгүй юү? хаачсан бэ? (= хаа очсон бэ?)
--------------	--

Хариу

(Оюун) (Багш)	талханд усанд киноны тасалбарт маханд юманд ногоонд сүүнд	явсан, явлаа	удахгүй одоохон		ирнэ. ирэх байх.
	кинонд хоолонд сургууль руу найз руугаа найзын руугаа танай руу		15 минутын цагийн хагас цагийн	дараа	
			15 минут цаг хагас цаг	болоод	

5. Асуулт

Чи Оюун	одоо	хаачих вэ? (= хаачхав?) хаашаа явах вэ? юу хийх вэ? (= юу хийхэв?)
------------	------	--

Хариу

(Би) (Оюун)	(одоо)	талханд маханд элсэн чихэрт тасалбарт	явна.	
		хоолонд танай руу дэлгүүр лүү	явах	санаатай байна. гэж байна.

6. Асуулт

Энэ Тэр	юун хэний		байшин ном бичиг захиа сонин зохиол ажил	бэ? вэ?
	хэний	захиалсан хийсэн авсан бичсэн		

Хариу

(Энэ) (Тэр)	драмын театрын манай миний Амуугийн багшийн	байшин захиа ном сонин бичиг ажил		(байна).
		захиалсан хийсэн авсан бичсэн	ном бичиг захиа ажил	

7. Асуулт

Энэ Тэр	юун ямар	хүн багш дарга оюутан	вэ? бэ? билээ?
------------	-------------	--------------------------------	----------------------

Хариу

(Энэ) (Тэр)	миний Доржийн миний найзын	танилцсан уулзсан ярилцсан	хүн оюутан багш дарга	(байна).
	манай багш Боловсролын их сургуулийн оюутан кинотеатрын дарга циркийн жүжигчин			

8. Асуулт

Та	авсан захиалсан бичсэн уншсан	номоо тасалбараа захиалгаа захиагаа юмаа зургаа	яасан бэ? хаа (хаана) тавьсан бэ? хэнд өгсөн бэ?
----	--	--	--

Хариу

(Би)	авсан захиалсан бичсэн уншсан	номоо тасалбараа захиалгаа захиагаа юмаа зургаа	тэнд тавьсан. тэр хүнд өгсөн. шууданд хийсэн. гэртээ мартжээ. танд өгсөн.
------	--	--	---

9. Асуулт

Таны Оюуны Доржийн	авсан захиалсан бичсэн уншсан зурсан авчирсан	ном тасалбар захиа хоол зураг сэтгүүл	хаа	байна? (байгаа вэ?)
--------------------------	--	--	-----	------------------------

Хариу

Миний Оюуны Доржийн	авсан захиалсан бичсэн уншсан зурсан авчирсан	ном тасалбар захиа хоол зураг сэтгүүл	энд энэ ширээн дээр Амууд надад	байна. байгаа.
---------------------------	--	--	--	-------------------

10. Асуулт

Тэр хүн Багш Дорж	хэзээ хэдийд	ирэх явах буцах	вэ?
-------------------------	-----------------	-----------------------	-----

Хариу

Тэр хүн Багш Дорж	маргааш өнөөдөр зун өвөл 10-нд	ирнэ. явна. буцна.	
		ирэх явах буцах	байх.

11. Асуулт

Тэр оюутан Чи Оюумаа	энийг энэ тухай	ойлгосон мэдсэн бичсэн хэлсэн авсан сонссон	үү? уу?
	дуурь сонссон жүжиг үзсэн чамд хэлсэн		

Хариу

Тэр оюутан Чи Оюумаа	энийг энэ тухай	ойлгосон мэдсэн бичсэн хэлсэн авсан сонссон	(байх).
	дуурь сонссон жүжиг үзсэн надад хэлсэн		

12. Асуулт

Намайг Оюумааг Тэрнийг Багшийг	зааж өгвөл заавал уривал хэлбэл оролцвол	чи Амуу Аюуш тэр хүүхэн багш Ананд	сурах үзэх очих явах ойлгох баярлах	уу? үү?
			сурна явна очно үзнэ ойлгоно оролцоно	биз дээ?

Хариу

Чамайг Оюумааг Тэрнийг Багшийг	зааж өгвөл заавал уривал хэлбэл оролцвол	би Амуу Аюуш тэр хүүхэн багш Ананд	сурах үзэх очих явах ойлгох баярлах	байх.
			сурна. явна. очно. үзнэ. ойлгоно. оролцоно.	

Та Чи Ананд аа	нэг дүү дуулж өгөхгүй юу? энийг орчуулж өгөхгүй юу? энэ архийг уучихгүй юу? энэ пиво уу? энэ мах ий?	Учраарай, би	дуулж чаддаггүй орос хэл мэддэггүй архи ууж чаддаггүй мах иддэггүй	дуулж чаддаггүй орос хэл мэддэггүй архи ууж чаддаггүй мах илэх дургүй	дууимааргүй байна. архи уумааргүй байна. пиво уумааргүй байна. мах идмээргүй байна.
			дуулж чаддаггүй орос хэл мэддэггүй архи ууж чаддаггүй мах иддэггүй	дуулж чаддаггүй орос хэл мэддэггүй архи ууж чаддаггүй мах илэх дургүй	дууимааргүй байна. архи уумааргүй байна. пиво уумааргүй байна. мах идмээргүй байна.

14. Хүсвэг
Харуу

Чамайг Таньт Оюуг Түүнийг	сүрхгүй язахгүй орохгүй ярихгүй	бол	би би бас (= би ч гэсэн)	сүрхгүй язахгүй орохгүй ярина. ~ ярихгүй.	сүрхгүй байна. язааргүй байна. оромооргүй байна. яримааргүй байна.
	сүрхгүй язахгүй орохгүй ярихгүй	бол		сүрхгүй байна. язааргүй байна. оромооргүй байна. яримааргүй байна.	сүрхгүй байна. язааргүй байна. оромооргүй байна. яримааргүй байна.

Харуу

Оюу Би	кино үзэхгүй герман хэл сурхгүй театрт явахгүй гуанзанд орохгүй тэр хүнтэй ярихгүй	гэсэн. гэнэ.	байна. байна гэнэ.	кино үзэхгүй герман хэл сурхгүй театрт явахгүй гуанзанд орохгүй тэр хүнтэй ярихгүй.	кино үзэхгүй герман хэл сурхгүй театрт явахгүй гуанзанд орохгүй тэр хүнтэй ярихгүй.
	кино үзэхгүй герман хэл сурхгүй театрт явахгүй гуанзанд орохгүй тэр хүнтэй ярихгүй			кино үзэхгүй герман хэл сурхгүй театрт явахгүй гуанзанд орохгүй тэр хүнтэй ярихгүй.	кино үзэхгүй герман хэл сурхгүй театрт явахгүй гуанзанд орохгүй тэр хүнтэй ярихгүй.

13. Мэдээлэл

15. Асуулт

Энэ	хотод сургуульд байранд үйлдвэрт номын санд музейд	хэдэн	хүн оюутан ажилчин номын санч тайлбарлагч	суудаг ажилладаг суралцдаг байдаг	вэ? (юм бэ?)
-----	--	-------	---	-----------------------------------	-----------------

Хариу

Энэ	хотод сургуульд байранд үйлдвэрт номын санд музейд	яг	хэдийг хэд байдгийг			мэдэхгүй. сайн мэдэхгүй.
			хэдэн	хүн оюутан ажилчин номын санч тайлбарлагч	байдгийг суудгийг суралцдагийг ажилладгийг	

16. Асуулт

Чи	энэ	киног номыг театрт хүнийг	үзсэн уншсан байсан таних	уу? үү?
----	-----	---------------------------	---------------------------	------------

Хариу

(Би)	энэ	киног номыг театрт хүнийг	үзсэн уншсан байсан таних	юм шиг	байна. санагдаж байна.
			үзээгүй уншаагүй байгаагүй танихгүй		

17. Асуулт

Хариу

Чи	энэ хүнийг	таних уу? мэдэх үү?	Би	энэ хүнийг	таних = таньдаг мэдэх = мэддэг	юм шиг	байна. санагдаж байна.
		таньдаг уу? мэддэгүү?			танихгүй мэдэхгүй		

18. Асуулт

Хариу

Энд Энэ ерөөнд	хүн оюутан багш	байна уу?		Байх Байгаа	шиг юм шиг	байна.
		байх шиг байгаа юм шиг	байна уу?	Байхгүй		

19. Асуулт

Хариу

Амуу Чи Тэр кино	маргааш удахгүй	ирэх үү? гарах уу? буцах уу?	Амуу Тэр кино Би	маргааш удахгүй	ирнэ. гарна. буцна.
					ирэх(гүй) байх. гарах(гүй) байх. буцах(гүй) байх.

20. Асуулт

Хариу

Та Таны найз Тэр кино	маргааш удахгүй	ирэх гэж байна уу? гарах гэж байна уу? буцах гэж байна уу?	Би Миний найз Тэр кино	маргааш удахгүй	ирэх байх. ирэх юм шиг байна. гарах байх. гарах юм шиг байна. буцах байх. буцах юм шиг байна.
		ирэх нь үү? гарах нь уу? буцах нь уу?			ирэх нь. гарах нь. буцах нь.

21. Мэдээлэл

Хариу

Над Чам Тан Энүүн/энэн/үүн Тэрүүн/тэрэн/түүн Бидэн Тэдэн Дорж	шиг	сайн ухаантай өндөр удаан хурдан муу үнэтэй сайхан	хүн багш жүжигчин оюутан ундаа юм	байхгүй.	Тийм үү? Тийм байх аа. Нээрэн үү? Яг үнэн. Сонин юм. Гайхалтай юм.
--	-----	---	--	----------	---

22. Шаардлага**Хариу**

Над Энүүн/энэн/үүн Тэрүүн/тэрэн/түүн Бидэн Тэдэн Дорж Амуу Багш	шиг	(сайхан) (хурдан)	бич! унш! зур! хий!	Заа. Заа тэгье. Чадахгүй байх аа. Чадахгүй юм.
--	-----	----------------------	------------------------------	---

23. Мэдээлэл**Хариу А**

Би түүнтэй Би тэр хүнтэй	ганилцах уулзах явах үзвэр үзэх	дуртай (байна).	Тэгвэл би чамайг түүнтэй Тэгвэл би чамайг тэр хүнтэй	ганилцуулъя. уулзуулъя. явуулъя. үзвэр үзүүлье.
-----------------------------	--	-----------------	---	--

Хариу Б

Би	тэр хүнтэй	уулзахад юм үзэхэд	баяртай байна. баярлаж байна.
	энийг сонсоход ингэхэд тэгэхэд		

24. Асуулт

За хоёулаа маргааш	уулзахаар энэ юмыг хийхээр манайд очихоор кинонд явахаар	тогтох	шив дээ. (шиг вэ дээ.) уу? уу даа?
	18 цагт уулзана / уулзъя энэ юмыг хийнэ / хийе манайд очно / очъе кинонд явна / явъя		гэж тогтох уу?

Хариу

Тэгье,	ингэж тэгж	тогтгье.
	18 цагт уулзана энэ юмыг хийнэ танайд очно кинонд явна	гэж тогтгье.

25. Мэдээлэл

Хэрэв та	тасалбарт хөдөө үзвэр хөгжим	явъя үзье сонсьё	гэвэл гэж байгаа бол	одоо маргааш өнөөдөр	явж үзэж сонсож	болно.
----------	------------------------------	------------------	----------------------	----------------------	-----------------	--------

Хариу

За тэгье.
За бодъё.
Бодож үзье.

26. Асуулт

Чи Та	намайг Оюуг энэ хүнийг энэ номыг	юунд дуртай ямар хүн ямар оюутан юун ном	гэж бодож байна?
----------	---	---	------------------

Хариу

(Би)	(чамайг) (Оюуг) (энэ номыг)	театрт дуртай амьтанд дуртай байх сайн оюутан сайн хүн монгол хүн монгол хэлний ном муу юм хийдэг байх	гэж бодож байна.
------	-----------------------------------	--	------------------

Яриа

Conversations

1-р яриа

- Амар аа, өнөөдөр "Тэнгис" кинотеатрт (Тэнгист) ямар кинотой вэ?
- Ямар кинотойг ч мэдэхгүй байна. Ойрдоо ажил их. Кино мино үзэх зав гарахгүй л байна.
- Сайхан кино байвал үзэх үү?
- Сайхан кино байвал үзсэн ч яах вэ (= үзэж болно).
- Тэгвэл хоёулаа киноны зарлал үзье.
- За, энэ зарлал байна. Аа, "Тунгалаг Тамир" -ын нэгдүгээр анги байна. Үзэх үү?
- Харин ээ, энэ кинонд юу гардаг юм бэ?
- Энэ кинонд уу? Энэ кинонд эхлээд 1921 оны ардын хувьсгалаас өмнөх манай ард түмний аж байдлыг харуулаад, дараа нь Ардын засагийн ялалтыг үзүүлдэг (юм).

- Тэгвэл энэ кино чинь түүхийн сэдэвтэй юм шив дээ. Би түүхийн сэдэвт дуртай. Үзье.
- За тэгвэл хоёулаа "Тэнгис" рүү явъя. Оройн 6 цагийн тасалбар авъя.

2-р яриа

- Зургаан цагийн тасалбар хоёрыг авъя.
- Зургаан цагийнх дууссан. Наймынх л байна, авах уу?
- Авах уу? Яах вэ? За авъя. Голын суудал байвал өгөөч.
- Байна аа байна. Аравдугаар эгнээний ес, аравдугаар суудал (арвын ес, арав) байна.
- Сайхан суудал байна, баярлалаа.

3-р яриа

- Өнөөдрийн кино чамд ямар санагдав?
- Өчигдрийн киног(өчигдрийнхийг) бодвол их сонин байна. Өчигдрийн кинон дээр нэг хэдэн хүн яриад л байсан.
- Чи намайг бодвол монгол хэлэнд сайн хүн. Тэр киног сайн ойлгосон байх.
- Танай Петрийг бодвол би монгол хэлэнд муу хүн шүү. Гэхдээ тэр киног сайн ойлгосон.
- Цогт тайжид хэн тоглосон юм бэ?
- Ардын жүжигчин Цэвэгмид гарсан (тоглосон). Ёстой сайн жүжигчин шүү.
- Энэ киноны найруулагч нь хэн бэ?
- Нэг орос найруулагч. Тарич гэдэг байх.

4-р яриа

- Улаанбаатарт театр олон байна уу?
- Олон биш. Улсын драмын (эрдмийн) академик театр, дуурь-бүжгийн (эрдмийн) академик театр, хүүхэлдэйн театр бий.
- Үзэгчид ямар жүжигт дуртай вэ?
- Яриан (драмын) жүжиг, инээдэмт жүжиг, эмгэнэлт жүжиг, ялангуяа инээдэмт жүжигт илүү дуртай (байх) шиг байдаг.
- Дуурь-бүжгийн академик театрт ойрдоо юутай байна?
- "Учиртай гурван толгой" гэдэг дуурь байна
- Аа тийм үү? Түүнийг сайхан, сонин дуурь гэж багш маань хэлсэн юм.
- Нээрэн сайхан даа. Би хэд хэдэн (= хэдэн) удаа үзсэн. Одоо ч дахиад үзмээр байна.
- (Тэр дуурь) дахиад хэзээ гарах вэ? Чамтай цуг(хамт) л үзэх юм сан.
- Дахиад хагас сайнд гарна. Манай ангийн Дулмаа, Жаргал хоёр үзнэ гэсэн. Тэгээд дөрвүүлээ хамт үзэцгээе.
- За тэгье. Тэдэнтэй(цуг) үзэхэд би дуртай байна.

5-р яриа

- Би өчигдөр нэг концерт үзлээ.
- Ямар?
- Ардын дуу бүжгийн чуулгын концерт.
- Тэгээд ямар байна?
- Үзээд л баймаар сайхан байсан.
- Ёстой л үзээд баймаар концерттой чуулга шүү. Чи сайхан юм үзжээ. Тэгээд чамд юу нь онцгой сайхан санагдав?
- Юм бүхэн нь(сайхан байна). Монгол ардын дуу хөгжим онцгой сайхан юм аа. Даан ч хэлий нь мэдэхгүй болохоор тусгүй байна. Гэвч монгол орон, монголын ард түмний тухай их юм мэдэж авсан.
- Монгол бүжиг ямар байна?
- Гайхалтай сонин байсан. Үзэгчид их алга ташиж байсан. Монголын ард түмний амьдралыг үзэх(үзсэн) шиг санагдсан.
- Тэр концерт дээр ямар хөгжим байсан бэ?
- Морин хуур, лимбэ, ятга, шанз хөгжим байсан. Бас миний мэдэхгүй хөгжмүүд байсан.
- Чи монгол ардын дуу мэдэх үү? Дуулж сурсан уу?
- За, одоо хүртэл ганц дуу сураагүй л байгаа шүү. Ер нь би дуунд муу, дуулж чаддаггүй. Гэвч дуу сурах бас дуртай.
- Би чамд нэг дуу зааж өгье. Намайг зааж өгвөл чи сурна биз?
- Чамайг заавал ч амархан сурна аа.
- Ямар дуу заах нь (= заах гэж байна) вэ?
- Хайрын (хайр сэтгэлийн) тухай дуу зааж өгнө өө.
- За тэгээрэй, би заавал сурна.

6-р яриа

- Оюун аа, чи цирк үзэх үү?
- Чамд илүү тасалбар байгаа юм уу?
- Үгүй ээ, чамайг юм үздэггүй хүн гэж би дуулсан юм. Гэхдээ чамайг циркт дуртай байх гэж бодож байна.
- Би юм үздэггүй хүнийг бодвол юм үздэг хүн шүү. Чамайг үзвэл би үзнэ.
- Өнөөдөр сургуультай амьтад, илбийн номер оролцсон хөтөлбөртэй гэнэ.
- За тэгье, үзэлгүй яахав. Чамтай(гаа) хамт үзэхгүй бол хэнтэй хамт үзэх вэ!

7-р яриа

- Хумберто цирк ирж гэнэ (= ирсэн гэнэ).
- За, яасан сайн хэрэг вэ. Тэгээд хэзээ тоглох нь вэ? Зарлал нь гарч уу (гарсан уу)?
- Зарлал нь гарсан байна. Нэг бүтэн сар энд тоглох юм байна.
- Эхний нь тоглолтыг л үзэх юм сан. Тасалбары нь зарж байна уу? Эхний тоглолтын тасалбар ч дуусчихсан байх даа?
- Үгүй ээ, дуусаагүй байна. Циркийн кассанд ч байна, энд тэндгүй зарж байна.

- Тэгвэл (хоёулаа цуг) тасалбарт явах уу?
- За Оюун минь уучлаарай. Найз нь (найз чинь) тун их ажилтай байгаа. Хумберто циркийг буцахаас нь өмнө л нэг үзэх санаатай байна.
- За тэгвэл яахав. Эхний нь тоглолтыг би Долгор Туяа хоёртой үзнэ. Харин сүүлчийн нь тоглолтыг чамтай (хамт) үзмээр байна.

8-р яриа

- Театрт ажилладаг улсын мэргэжлийн нэрийг хэлээч.
- Дуучин, хөгжимчин, бүжигчин, найруулагч, удирдаач зэрэг олон мэргэжлийн улс (хүн) байна.
- Таныг сайн бүжигчин гэсэн?
- Үгүй үгүй. Би биш. Миний эхнэр театрт бүжигчин хийдэг. Чи тэр тухай сонссон байх.
- Тэгвэл та бүжигт их дуртай байх даа?
- Дуртай, орчин үеийн бүжигт дуртай.
- Бүжгийн жүжигт бүр их дуртай юу?
- Яриа юу байх вэ(яриангүй тийм).

9-р яриа

- Танай гэрийнхний дуртай үзвэрийн тухай чамаас асуумаар байна?
- Манай гэрийнхэн янз бүрийн үзвэрт дуртай. Жишээ нь манай аав ээж хоёр, сонгодог урлаг, сонгодог хөгжимд илүү дуртай. Би бол сүүлийн (орчин) үеийн дуу хөгжмийн шинэ хамтлагуудын тоглолтод дуртай.
- Өвөө эмээ хоёр чинь?
- Тэд нар ардын дуу хөгжим, "Учиртай гурван толгой" дуурьт л дуртай.

9-р яриа

- Чи нөгөө юмаа сайн орчуулсан уу?
- Сайн орчуулж чадаагүй. Олон алдаа гарсан.
- Алдаагийг нь зассан уу?
- Засаагүй. Би засаж чадахгүй байна.
- Надаар засуулах уу?
- Яасан сайн юм бэ, чи одоо засаад өгч чадах уу, завтай байна уу?
- Завтай завтай. Аль вэ, аваад ир. Ямар ч алдаагүй болгоод өгье.
- За одоохон. Би чамд их баярлаж байна шүү.

Улаанбаатар хотод тохилог бөгөөд олон хүний суудалтай орчин үеийн кинотеатр, театр, цирк олон байдаг. Жишээлбэл (= жишээ нь) кинотеатраас, "Тэнгис", "Өргөө", "Сансар", "Солонго" зэрэг томоохон кинотеатрыг дурдаж (= хэлж) болно.

Эдгээр кинотеатрт монгол кино үйлдвэрийн болон бусад олон улсын кино үйлдвэрийн шинэ бүтээлүүд гардаг. Монгол киноны ихэнх нь орчин үеийн (одоо үеийн) сэдэвтэй юм. Түүхийн болон хувьсгалын сэдэвтэй кино олон байдаг. Коммунист дэглэмийн үеийн кинонуудад болон урлагийн бусад бүтээлүүдэд амьдралыг гоёчилсон юм олон бий. Сансар кинотеатрт одоо нэг баримтат кино гарч байна. Энэ кинонд ардын засгаас өмнөх болон ардын засгийн дараахь коммунист дэглэмийн үеийн монголын ард түмний амьдрал гардаг юм.

Улсын драмын академик (эрдмийн) театр болон дуурь бүжгийн академик театр зэрэг бусад театрт яриан жүжиг, инээдэмт (инээдмийн), эмгэнэлт (эмгэнэлийн), хүүхэлдэйн жүжиг гардаг (тоглодог). Хэрэв та монгол ардын уртын дуу, хөгжим сонсьё гэвэл эдгээр театрын алинд нь ч очиж болно. Монгол ардын уртын дуу, морин хуур, лимбийн аялгуу, монголын залуучуудын дуу хөгжмийн хамтлагуудын тоглолт танд сонин сайхан санагдах байх.

Дасгал

Exercises

1. Хаалтан дахь үгээр цэгийг нөх. Complete the sentences using the model.

ҮЛГЭР: Бид хоёр орой... (КОНЦЕРТ, ЯВ-)
БИД ХОЁР ОРОЙ КОНЦЕРТОД ЯВНА.

1. Би өглөөнийхөө цайг... (ГУАНЗ, УУ-)
2. Та ямар... (ХООЛ, ЗАХИАЛ-)
3. Тэр эмэгтэй, цагаан цамц... (ӨМС-, ДУРТАЙ)
4. Намайг утсаар ярихад... (ХЭН Ч БАЙ-)
5. Биднийг ороход... (КИНО ЭХЭЛ-)
6. Энэ кинонд... (ОЮУТНЫ АМЬДРАЛ, ҮЗҮҮЛ-)
7. Ардын жүжигчин... (ТЕАТР, ДУУЛ-)
8. Чамд уртын дуу... (ЗАА-, ӨГ-)
9. Гадаадын цирк буцахаас өмнө... (ҮЗ-, САНААТАЙ)
10. Хэрэв та дуурь сонсохыг хүсвэл... (ДУУРЬ БУЖИГ, ТЕАТР, ОЧ-)
11. Тэр хамтлагийн тоглолтыг... (БИ ЗААВАЛ ҮЗ-)

2. Цэгийн оронд "өг-" гэдэг үйл үгийг гурван цагт тавь. Fill in the verb өг- in three tenses.

1. Би танд энэ бичвэрийг уншиж...
2. Багш, оюутнуудад жишээ гаргаж...

3. Бат надад номын дэлгүүрээс нэг ийм ном олж...
4. Ээж нь хүүдээ зуны гутал авч...
5. Энэ үгийг багш толиноос харж...
6. Музейн тайлбарлагч бидэнд тайлбарлаж...
7. Миний найз тэдэнд хөгжим зааж...
8. Та миний захиаг орчуулж ...
9. Та Монгол улсын их сургуулийн тухай ярьж...
10. Миний нэг найз чамд дуу зааж...

**3. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу Join the sentences using the model.
холбож хэл.**

ҮЛГЭР: Би гэрийн даалгавраа хийнэ. Дараа нь жүжиг үзнэ.

БИ ГЭРИЙН ДААЛГАВРАА ХИЙСНИЙ ДАРАА ЖУЖИГ ҮЗНЭ.

1. Би энэ сониныг уншина. Дараа нь талханд явна.
2. Би энэ концертыг соносно. Дараа нь гуанзанд орно.
3. Би тэр бичвэрийг уншъя. Дараа нь мэдэхгүй үгээ толиноос харъя.
4. Би одоо хоолоо хийнэ. Дараа нь телевизээр кино үзье.
5. Би шуудангаас марк дугтуй авмаар байна. Дараа нь гэр лүүгээ захиа явуулна.
6. Дорж шинэ үгээ тогтоож байгаа. Дараа нь Дуурь бүжгийн академик театр явна.
7. Би энэ сайхан дууг сонсмоор байна. Дараа нь хоёулаа тийшээ явъя.
8. Хоёулаа музей үзье. Дараа нь манайд очиж тэр тухай ярилцах уу?
9. Эхлээд би морин хуурын аялгуу соносно. Дараа нь уртын дууны концерт үзнэ.
10. Бид энэ жил монгол хэлний үгсийн сан үзнэ (сурна). Дараа нь ирэх жил хэлзүй үзнэ.
11. Эхлээд сургуультай амьтад гарсан. Дараа нь илбийн номер байлаа.
12. Би Оюунтай дэлгүүрт уулзсан. Дараа нь хоёулаа номын санд очлоо.
13. Би энэний тухай сайн бодно. Дараа нь чамд тайлбарлаж өгье.
14. Долоон сард манай хичээлийн жил дуусдаг. Дараа нь оюутнууд хөдөө явдаг.

**4. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу Join the sentences using the model.
холбож хэл.**

ҮЛГЭР: Би кинонд явна. Түүнээс өмнө (= түүний өмнө= эхлээд) даалгавраа хийнэ.

БИ КИНОНД ЯВАХААСАА (ЯВАХЫНХАА) ӨМНӨ ДААЛГАВРАА ХИЙНЭ.

1. Хоёулаа концерт үзье. Түүний өмнө гуанзанд орох уу?
2. Би гэр лүүгээ захиа явуулна. Эхлээд шуудангаас марк, дугтуй авах ёстой.
3. Уртын дууны концерт үзээрэй. Түүнээс өмнө морин хуурын аялгуу сонсоорой.
4. Бид ирэх жил үгсийн сан сурна. Эхлээд энэ жил хэлзүй сурмаар байна.

5. Бид улсын цирк рүү явсан. Эхлээд зарлалы нь үзлээ.
6. Дулмаа, найзтайгаа музей үзсэн. Түүний өмнө манайд очиж надтай ярилцсан.
7. Миний дүү зурагтаар кино үзнэ. Эхлээд гэрийнхээ даалгаврыг сайн хийнэ.
8. Бид монгол бичгийн хэл сурна. Түүнээс өмнө монгол ярианы хэл сурна.
9. Би энэ тухай чамд сайн хэлж өгнө. Эхлээд жаахан бодъя.
10. Би энэ бичвэрийг тогтооно (цээжилнэ). Түүний өмнө мэдэхгүй үгээ толиноос харна.

**5. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу Join the sentences using the model.
холбож хэл.**

ҮЛГЭР: Би монголоор уншдаг. Дорж илүү сайн уншдаг.
НАМАЙГ БОДВОЛ ДОРЖ (ИЛҮҮ) САЙН УНШДАГ.

1. Энэ хөх өнгийн (= өнгөтэй) цамц сайхан. Гэхдээ тэр улаан нь илүү сайхан байна.
2. Баг англи хэлээр жаахан ярьдаг. Гэхдээ Туяа илүү сайн ярьдаг.
3. Миний гэр хол байдаг. Харин тэднийх манайхаас ч илүү хол байдаг.
4. Би ятганд дуртай. Гэхдээ би морин хуурт илүү дуртай.
5. Манай анги том. Тэдний анги маш том.
6. Би баримтат кино үздэг. Гэхдээ уран сайхны кино бүр их үздэг.
7. Оюу дэлгүүрээс их юм авлаа. Туяа Оюугаас ч их юм авсан.
8. Би ардын хөгжим сонсох дуртай. Одоогийн хамтлагт бүр ч дуртай.
9. Би энэ бичвэрийг ойлголоо. Гэхдээ Ананд сайн ойлгожээ.
10. Чи орчуулж чадна. Гэхдээ Дулмаа сайн орчуулна.

**6. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу Change the sentences using the model.
өөрчилж хэл.**

ҮЛГЭР: Тэр хүн юу ч мэдэхгүй.
ЮУ Ч МЭДЭХГҮЙ ХҮН.
Энэ ажлыг би хийсэн.
ЭНЭ МИНИЙ ХИЙСЭН АЖИЛ.

1. Энэ хүн Батыг таньдаггүй.
2. Тэр хүн монголоор ярьдаггүй.
3. Тэр хүн монголоор бичдэггүй.
4. Энэ хүн бүжгийн жүжигт дургүй.
5. Энэ хүнийг би таньдаг
6. Энэ бичвэрийг чи орчуулсан.
7. Тэр сэтгүүлийг Дулмаа уншдаг.
8. Тэр хүн Анандтай утсаар яарьсан.
9. Тэр хүүхэд дуу дуулдаггүй.
10. Тэр хүн надтай тэнд байсан.
11. Тэр хүүхэн мах иддэггүй.
12. Тэр хүн ингэж хэлдэггүй.

13. Энэ ширээнд би суудаг.
14. Энэ үзгээр би бичдэг.
15. Хүүхэд ганцаараа тоглодог.

**7. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу Join the sentences using the model.
холбож хэл.**

ҮЛГЭР: Чи сургууль руу явах уу? Надад хэлээрэй.
ЧИ СУРГУУЛЬ РУУ ЯВБАЛ НАДАД ХЭЛЭЭРЭЙ.

1. Та Хархорумд очих уу? Миний нэг найзтай уулзаарай.
2. Чи номын сан руу явах уу? Миний энэ захиаг шууданд хийхгүй юү?
3. Чи номын дэлгүүр явах гэж байна уу? Надад ийм дэвтэр авчрахгүй юу.
4. Та Оюумаагийн шуудангийн хаягийг олох уу? Надад түргэн явуулаарай.
5. Чи номын санд очно. Тэгвэл надад түүхийн хоёр боть ном захиалахгүй юу.
6. Чамд монгол чех том толь байдаг. Энэ хэдэн үгийг хараад өгөөч.
7. Одоо хичээлдээ явах гэж байна уу? Хоолоо ид.
8. Чи хөгжим сонсох дуртай юу? Тэгвэл тэр өрөөнд очиж сонс.
9. Миний гар утас цүнхэн дотор алга уу? Тэгвэл орон дээр үзээрэй.

**8. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу Join the sentences using the model
холбож хэл.**

ҮЛГЭР А: Би явна. Чи бас явах уу?
НАМАЙГ ЯВБАЛ ЧИ БАС ЯВАХ УУ?

1. Бат гуай дуурь бүжгийн академик театр руу явна. Та нар тийшээ явах уу?
2. Та номын сан руу явах уу? Би ч гэсэн явмаар байна.
3. Телевизээр монгол кино гарна. Та үзээрэй.
4. Та Их сургууль дээр концерт үзэх үү? Би гэртээ байна.
5. Та түүхийн музейд очих уу? Би тантай цуг явъя.
6. Чи номын мухлагаар орох уу? Би хэдэн дэвтэр захимаар байна.
7. Цэцэгмаа номын санд очно. Хоёулаа номоо явуулъя.
8. Музейн тайлбарлагч ирнэ. Би зарим юмыг асууна.
9. Та ийм номыг уншмаар байна уу? Би гэрээсээ авчирч өгье.
10. Та "Баянгол" зочид буудалд очно. Тэнд миний найз тантай уулзана.
11. Энэ оюутнууд концерт тоглоно. Хүмүүс (=улсууд) дуртай үзнэ.
12. Танд лимбэ хөгжим байна уу? Би яаж тоглохыг үзүүлье.
13. Бид монгол хэлээр ярина. Манай багш их баярладаг.
14. Манай тоглолт танд сайхан санагдана. Бид баярлана гэж тэр жүжигчин хэлсэн.
15. Манай тоглолт танд сайхан санагдсан. Бид баярлаж байна гэж тэр жүжигчин хэлсэн.

ҮЛГЭР Б: Би явахгүй. Чи явах уу?

НАМАЙГ ЯВАХГҮЙ БОЛ ЧИ ЯВАХ УУ?

1. Бат гуай дуурь бүжгийн театр руу явахгүй. Та нар тийшээ очих уу?
2. Та номын сан руу явахгүй юу? Би явмаар байна.
3. Телевизээр монгол кино гарахгүй. Та үзэж чадахгүй.
4. Та концерт үзэхгүй. Би гэртээ байхгүй.
5. Дорж түүхийн музей рүү явахгүй. Би ч бас явахгүй.
6. Чи номын мухлагаар орохгүй. Би өөрөө орж үзье.
7. Цэцэгмаа номын санд очихгүй. Хоёулаа тийшээ очъё.
8. Та "Баянгол" зочид буудал руу очихгүй. Тэгвэл миний найз тантай уулзаж чадахгүй.
9. Оюунчимэг тэр концертод дуулахгүй. Тэгвэл хүмүүс концерт үзэхгүй.
10. Музейн тайлбарлагч ирэхгүй. Бид юмаа асууж чадахгүй.
11. Та энэ номыг уншихгүй. Тэгвэл би авчрахгүй.
12. Бид монгол хэлээр ярихгүй. Тэгвэл тэр худалдагч ойлгохгүй.
13. Танд лимбэ хөгжим байхгүй. Тэгвэл би яаж тоглохыг үзүүлж чадахгүй.
14. Монгол кино өнөөдөр гарахгүй. Тэгвэл та телевиз үзмээр байна уу?
15. Тэд биднийг гэртээ урихгүй. Бид тэднийд очихгүй.

9. Цэгийн оронд асуулт тавь.

Fill in interrogative sentences.

1. – ...? Тийм ээ, Өргөө кинотеатр их тохилог байсан.
2. – ...? Энэ кино бол монгол кино үйлдвэрийн шинэ бүтээл юм.
3. – ...? Би түүхийн сэдэвтэй кинонд илүү дуртай.
4. – ...? Жүжиг надад их сайхан санагдсан.
5. – ...? Ринчен гуай Хархорумд нэг долоо хоног байх юм байна.
6. – ...? Тасалбар нь дуусчихсан байна.
7. – ...? Өглөө намайг очиход тасалбар дуусаагүй байсан шүү дээ.
8. – ...? Илүү тасалбар алга даа.
9. – ...? Би ойрдоо их завгүй байна.
10. – ...? Би долоо хоногийн дараа завтай болно.
11. – ...? Батбаяр орой энд ирнэ гэсэн.
12. – ...? Тэгсэн. Ирнэ гэсэн.
13. – ...? Тэр киног найруулсан хүний нэрийг би мэдэхгүй.
14. – ...? Ойрдоо онцгой сонин юм алга.
15. – ...? Хүн болгон л энэ номыг сонин гэж байна.
16. – ...? Миний бодоход (= намайг бодоход) энэ бол япон зохиолчийн бүтээл.

10. Орчуулах.

Translation.

Улаанбаатарт үзвэрийн газар олон бий. Та тэнд очвол эхлээд байгалийн түүхийн музей болон түүх соёлын холбогдолтой хэд хэдэн музей, зургийн үзэсгэлэн үзээрэй. Мөн Монголын ард түмний амьдрал түүхийг голдуу харуулсан уран сайхны болон баримтат кинонуудыг үзэж болно. Оройн цагаар монгол ардын урт, богино дуу, монгол бүжигтэй концерт үзэж, ардын хөгжмийн сайхан, сонин

аялгуу сонсоход аятайхан шүү. Үүнээс гадна, монгол циркийн амьтдын тоглолт, уран нугаралт их сонин байдаг.

Хэрэв та дуртай бол дуурь бүжгийн академик театрт монголын болон дэлхийн сонгодог бүжгийн жүжиг үзэж болно. Та хөдөө явбал монгол мал, малчны сонин гайхалтай амьдралыг үзнэ.

11. Асуулгад хариул.

Answer the questions.

1. Та ямар монгол кино үзсэн бэ, юу нь сонин байсан бэ?
2. "Хунт нуур" бүжгийн жүжгийг хаана үзэж болох вэ?
3. Та уртын дуу сонссон уу, юу бодогдсон бэ?
4. Монголын ямар ямар хөгжмийг мэдэх вэ?
5. Орчин үеийн монгол урлагийн тухай та юу бодож байна?
6. Та ямар жүжигт дуртай вэ? Түүнийхээ тухай ярина уу?
7. Улаанбаатарт голдуу ямар гадаад улсын кино гарч байна?
8. Кино концерт үзэхдээ та ямар суудалд суух дуртай вэ?
9. Монголын циркийн онцгой юмыг та юу гэж бодож байна?
10. Монгол уран зургийн тухай та юу бодож байна?
11. Монголын уран зохиолоос танай улст орчуулсан бүтээл юу байна?
12. Монголын залуучуудын хөгжмийн хамтлагуудын тоглолтыг үзсэн үү?

Homework

Даалгавар

1. Үзвэрийн тухай цээжээр ярь. Speak about various shows.
2. Үзвэрийн тухай нөхөртэйгөө харилцан ярь. Talk about a show with a colleague.
3. Үзвэрийн холбогдолтой бичвэр зохион бич. Write a short essay on the various "shows".
4. Орчуулах. Translate into Mongolian:

1. What films do you like?
2. I am very fond of historical and documentary films.
3. Would you go with me to the cinema tonight?
4. What film is on?
5. Historical film 'Transparent Tamir'. Have you not seen it?
6. I have not. Is it worth seeing? What is the film about?
7. First it shows the life of Mongolian people before the revolution and then the victory of the revolution.
8. Then I will go and see it.
9. O.K., then I will buy two tickets.

* * *

10. What sort of theatres are there in your town?
11. In our town there is a theatre, an opera house, a puppet theatre and several other theatres.
12. Which dance do you like best? Modern or classical dance?
13. I like classical dance better than modern dance.

* * *

14. Have you (ever) heard Mongolian folk music?
15. I have. I like to listen to Mongolian folk songs.
16. Have you also heard the 'long' songs, or not?
17. I heard the 'long' songs several times (once or twice). They have (had) a very beautiful melody.

* * *

18. What sort of acts (lit.: numbers) are performed in the circus?
19. Mostly they present performing animals, a magic (act), (an acrobatic display of) 'bending' and various other acts.

Хэлзүй

Grammar

1. Postpositions

Some verbal forms may fulfil the syntactical function of postpositions (cf. also L6, Gr. 18: *болоод*). The *converbium modale* or *converbium perfecti* of the verb *эхэл*- 'to start' may be used in this function (with Abl.; referring to both time and space). The verb *ав*- 'to take' can be used with the same meaning with a more colloquial tinge.

<i>эхлэн, эхлээд</i>	starting from (Abl.)
<i>эрт цагаас эхлэн</i>	starting from the early times
<i>надаас эхлээд</i>	starting from me
<i>аван, аваад</i>	starting from (Abl.)
<i>эрт цагаас аваад</i>	starting from the early times
<i>надаас аваад</i>	starting from me

Further note the phrase with postposition *өмнө*:

<i>тэмцээн эхлэхээс гучин минутын өмнө</i>	thirty minutes before the beginning of the competition
--	--

2. Numerals

Numerals between tens following each other in coordinate phrases can be used in full (including the word for the respective 'ten'), or they can be abbreviated without repeating the 'ten':

<i>арван нэг арван хоёр</i> (or: <i>арван нэг хоёр</i>)	eleven and (to) twelve
<i>17–18</i> (<i>арван долоо арван найман</i>)	
<i>настай хүн</i> (or: <i>арван долоо найман настай хүн</i>)	17–18 year old man

3. Potential

The form takes the suffix *-мз* and refers to the 1st. pers. sg. It expresses the subjective or objective expectation or qualification that the speaking person will do s.th.

очимз

(I will) surely come, (I) intend to come

4. Doubts about a past action

The forms of *presens perfecti* in *-лаа⁴* may also be used in questions (with an interrogative). If an interrogative particle follows the form, the final *-аа⁴* is dropped. This appears to be a shorter variant of the form *-сан бил үү?* (further cf. Par. 13b below).

Та бид хоёр хаана уулзлаа?

Where was it that we met?

Та надтай уулзлуу?

Have you met me before?

In an indicative sentence, however, the meaning of the form is different in that it refers to the recent past (cf. L3, Gr. 6):

Би сая мэдлээ.

I have learnt (about it) recently. I have found out recently.

5. *Converbum terminale*

This converb expresses an action, which is a final deadline of another action. It takes the suffix *-тал⁴*. As for the use of the possessive suffix *-аа⁴*, the enclitic pronoun *нь* and the use of the accusative form as the subject of the clause, the rules are the same as with other nominal forms of verbs (cf. L7, Gr. 11).

Намайг иртэл хүлээж байгаарай.

Wait until I come

Шөнө болтол тоглосон ч яах вэ.

We may play till the night comes.

Тэр хүн гэртээ харьтлаа энд сууна.

The man will sit here till he goes home.

Доржийг иртэл хүлээе.

I will (let me) wait till Dorji comes.

Иртэл нь хүлээе.

I will wait till he comes.

6. *Nomen imperfecti*

This verb form may also be used to describe a past action with a consequence in the present (by way of its result or the like):

Олон хүн медаль аваа биз дээ?

Many (people) have got medals, haven't they?

Олон хүн медаль авсан биз дээ?

Many (people) got medals, didn't they?

7. *Converbum abtemporale*

This verb form takes the suffix *-саар*⁴. It describes an action constituting a limit, from which another action starts to develop. It roughly corresponds to ‘since the time when . . . , after having done s.th.’.

Та Монголд ирсээр удаж байна уу? Have you been long in Mongolia (after coming)? Lit.: Since coming to Mongolia have you stayed (long)?

The same temporal relation can be expressed by the *converbum perfecti*, although with less accentuation of the exact ‘time limit *ab quem*’.

Та энд ирээд ямар тэмцээн үзэв? What competitions have you seen after coming here?
Тэмцээн хэзээ дууссан бэ? When did the competition finish?
Дуусаад хоёр хонож байна. Two days ago. (Lit.: After having finished, two days have passed.)

8. *Nomen futuri*

a) In connection with the word *юм* it can imply a general action (like the form in *-на*¹), only there is an emphasis on the action:

Энэ Дашдондог дандаа бөхийн тэмцээн үзэх юм. This Dashdondog just keeps watching wrestling.

b) Phrase explained earlier:

аврага шалгаруулах . . . тэмцээн a competition, in which the champion will be selected; i.e. a championship

c) *Nomen futuri* in D.-L. can also have the meaning of purpose: ‘in order to’

Эрүүл байхад юу хэрэгтэй вэ? What is required (in order) to be healthy?

d) *Nomen futuri* with possessive – *аа*⁴ as an object of another verb:

Би кинонд явахаа мартжээ. I forgot to go to the cinema. Lit.: I forgot (my) going to the cinema.

9. 'Negative dependent clause'

The form corresponding to this type of clause is based on the negative *nomen futuri* of a negative verbal noun in -л. The verb in the 'main clause' expresses a general future or a general permanent action.

Тэр хүн хичээлээ ч	хийхгүй хийлгүй	бөх	үзэх юм. үздэг юм.
--------------------	--------------------	-----	-----------------------

That man does not study and keeps watching wrestlers. Lit.: That man having not done his lessons (without doing his lessons), would watch (keeps watching) wrestlers.

10. *Nomen usus* + бол-

This phrase usually expresses a permanent change and corresponds to 'start to...':

Би мэддэг боллоо.

I got to know (started to know). Lit.: I became (permanently) knowing.

11. *Verbum vicarium*

The verb *ингэ*- 'to do thus, in this manner' can also be used before another verb in a verb phrase:

Би бас ингэж дуулсан юм.

I have also heard it in this way.

12. Predicate for a rational subject

If the subject of a nominal predicate is a rational being, the predicate may have the word *хүн* instead of *юм*. It may have an additional meaning of wondering or astonishment.

Та юу хийж байгаа хүн бэ?

What are you doing? Lit.: What doing man are you?

Та юу хийж байгаа юм бэ?

What are you doing then? Lit.: What doing (quasi impersonal noun) are you?

Манай багийн ахлагч, спортын мастер хүн.

Our foreman is a distinguished sports master.

13. Particles

a) The particle *бол* is sometimes incorrectly called the ‘particle of the subject’, but it can also follow the direct or indirect object. It has a ‘foregrounding’ function, sometimes slightly adversarial: ‘as for; but, as against that’.

Харин гар бөмбөгийг бол их сонирхдоггүй юм.

But (on the other hand) I am not very interested in volleyball.

Ялангуяа цанаар бол нэлээн (=нилээн) сайн явна.

But in particular I can ski well. (As for skiing in particular, I can ski well.)

b) In questions the particle *билээ* (*билүү* in a question without an interrogative word) expresses uncertainty or makes the question polite by implying that the speaker has heard about the matter and only wants to be reminded (cf. L9, Gr. 19). It can also imply mild astonishment.

Та олон улсын бөхийн тэмцээн үзсэн гэсэн билүү?

So you have seen the international wrestling match (I have heard, they say)?

Чи чинь ямар зэрэгтэй билээ?

What is the title you have got? (I suggest that I know he/she has got one.)

Тийм бил үү (билүү)?

Oh, that is it!?

In an indicative sentence the particle (colloquially pronounced as [le:]) has a different meaning. The speaker implies that he has seen or experienced the described action:

Монгол бөхчүүд олон байна билээ [bainle:].

There are many Mongolian wrestlers.

Олон хүн медаль авч байна билээ [bainle:].

Many people obtain medals.

c) In colloquial language the particle *аа*⁴ can appear in interrogative sentences finishing in *лаа*⁴. The pronunciation of the two long final vowels is only slightly longer than the pronunciation of a single long vowel. The melody is slightly rising.

Тэгэхэд та юу гэж хэллээ ээ?

Then what did you say (at that time)?

14. Idioms and phrases

зөв гар (coll.) = *баруун гар* (official)

right hand

буруу (солгой) гар (coll.)

left hand

= *зүүн гар*

(official)

Note: The above colloquial forms (*зөв / буруу гар*) are usually used in the context of ‘giving’ or ‘receiving’ s.th. by the respective hand. Polite manner is to use the right hand for such acts. The word *солгой* refers to left-handed persons.

Баруун / зүүн гараа бариад яв.

Go keeping you your right / left.

Албан бичгийн хэл: <i>Миний, чиний, Доржийн баруун/зүүн гар талд</i>	Official (written) style on my, your, Dorji's right/left side
Жолоочийн хэл: <i>Баруун /зүүн гар тийш(ээгээ)/тал руугаа эргэ –</i>	Drivers' speech: to turn to one's right/left ...
Ардын (нүүдэлчдийн) хэл: <i>Баруун /зүүн тийш(ээгээ)/тал руугаа эргэ-</i>	Popular (nomadic) speech: to turn to one's right/left.
<i>Тэг л дээ. Тэгсэн ч яах вэ.</i>	Just do it. Go on, do it. It may as well be done. We (I) may as well do it (I do not really mind/desire doing, but I leave it to the other person; sometimes it implies resignation; cf. L9, Gr. 20).

Vocabulary

аврага, аварга	champion
агаар	air, atmosphere
алт (ан)	gold
амжилт	success
анх (удаа)	(for) the first time
атлетик	athletics
ахлагч	foreman, team leader
баг	sports team
байр эзэл- (Э2.4) (эээлж, эзлэх, эзэлнэ)	to win a place
байрла- (Э2.1) (байрлаж, байрлах, байрлана)	to occupy (a place)
баруун	right (hand, leg)
баяр	festivity, celebration; joy
биеийн тамир	sport, physical training
биеийн тамирын ордон	sports palace
бокс	boxing
бөгсөн бие	lower part of the body
бөмбөг (өн)	ball
бөөрөнцөг	the shot (for shot put)
бөх	wrestler; strong, robust
булчин	muscle
буруу	wrong; error, mistake
бэлтгэ- (Э2.1) (бэлтгэж, бэлтгэх, бэлтгэнэ)	to prepare
бэлтгэл	preparation
гар бөмбөг(өн)	volleyball
гимнастик	gymnastics

Шинэ үг

гулга- (Э2.1) (гулгаж, гулгах, гулгана)	to glide; to skate
гулгалт (уран гулгалт)	skating (figure skating)
гүй- (Э1) (гүйж, гүйх, гүйнэ)	to run
гүйлт	run, race
даам	draughts
дасгалжуулагч	coach, trainer
дугуй	bicycle; wheel
дух	forehead
дэлгэр- (Э2.4) (дэлгэрч*, дэлгэрэх, дэлгэрнэ)	to spread, develop
зүйтэй	proper, right, correct(ly)
зүүн	left (hand, leg)
зэрэг I.a	rank; title; degree
зээрэнцэг	discus
март- (Э2.2) (мартаж, мартах, мартана)	to forget
машин	automobile, car
медаль	medal
морь (ин)	horse
мотоспорт	motor sport
мотоцикл	motorcycle
мөр (өн)	shoulder
мэт	as, like; such as
наадам	game, festival, celebration
нилээн, нэлээн	considerably
нүд (эн)	eye
одон бөмбөг (өн)	table tennis
одон бөмбөгийн ширээ	table for table tennis
олон улсын	international
оролд- (Э2.2) (оролдож, оролдох, оролдоно)	to be busy with, to try; to participate in
өвдөг(өн)	knee
сагсан бөмбөг(өн)	basketball
солгой	left side of the body; left-handed (person); awkward
сонирх- (Э2.2) (сонирхож, сонирхох, сонирхоно)	to be interested in
спортын мастер	sports master (title)
сур	leather thong (archer's target)
сургууль хий-	to study; practice, train
тааруухан	not too good, mediocre
тал I.a	steppe, plain; level space
тамир	bodily strength, energy
тамирчин	sportsman, athlete
тоглоом	play, game, entertainment
толгой	head
тохой	elbow
төрөл	kind, sort, species; birth
төрөл бүрийн	of all kinds
төрөл зүйл	assortment, set

түрүүл- (Э2.4) (түрүүлж, түрүүлэх, түрүүлнэ)	to be first, win a race
тэмцээн	match, competition
тэшүүр	skates
уралдаан	contest, competition, race
урсгал	flow, stream, current
уруул	lip
уулын спорт	mountaineering
хайр (хайртай, хайргүй)	love (in love; not liking)
хамар	nose
харайлт	jump(ing), leaping
хацар	cheek
хож- (Э2.3) (хожиж, хожих, хожино)	to win (in a game)
хожигд- (Э2.2) (хожигдож, хожигдох, хожигдоно)	to loose
хоккей	hockey
хоно- (Э2.1) (хонож, хонох, хононо)	to pass the night
хоолой	throat
хорхойтой бай- (with D.-L.)	to be a fan
хорхойтон	a fan
хөгж- (Э2.3) (хөгжиж, хөгжих, хөгжинө)	to prosper, develop
хөл	foot
хөл бөмбөг (өн)	football
хөмсөг (өн)	eyebrow
хөнгөн	light (not heavy)
хуруу (н)	finger
хүзүү (н)	neck
хүнд	heavy, difficult
хүрэл	bronze
хүрээлэн (г)	garden; institute
хүч (ин)	strength, power
хүчтэй	strong
цана	ski
цол	title, rank
цөөн	few, little
цэнгэлдэх хүрээлэн	amusement park
цээж (ин)	chest, breast
цээжин бие	chest, rib-cage
чих (эн)	ear
шалгаруул- (Г1) (шалгаруулж, шалгаруулах, шалгаруулна)	to examine, check, verify; select
шанаа (н)	cheek(s)
шатар	chess
шилбэ (н)	shin, shank
шүүгч	judge; umpire, referee
ээл- (Э2.4) (ээлж, эзлэх, эзэлнэ)	to occupy, take possession of

эргэ- (Э2.1) (эргэж, эргэх, эргэнэ)	to turn, revolve, move round
эрт	early; former, ancient
эрүү (н)	chin
эрүүл	health; healthy
эрхтэн	organ (of the body)
эрэг 1.	shore, bank, coast

Дуудах

Pronunciation

- [ɔ – ɔ:] тос- тоос, дор- доор, ноцох- ноцоох
оролт- ороолт, оролдох-ороолдох
бор тос- боорцог, хорхой- цоорхой
- [ö – ö:] өр-өөр, бөс- бөөс, зөгнөх- зөөлдөх
өмнөд-өмнөөс, өмөрхий-өмөөрөх
өнгөрөх-өнгөрөөх, өгсөх-өгсөөх
- [a^ɔ] айл, аймаг, гай, гайх, сайн, сайхан
найр, царай, арай, далай, найдах
- [aj^(a)] ая, ная, хаяг, саяхан, таяг, таягдах
- [ɔ^ɔ] ой, ойх, нохой, шохой, ойртох, тойрог
ойно, хойно, олгой, хорхой, ондоолой
- [ɔj^(a)] оёх, оёг, оёдол, хоёр, ноён, ноёрхуу
- [l] plus liquids and/or consonant groups (front vowels)
- [i] илүү, илрүүлэх, илүүчлэх, илүүтгэх,
нийтлүүл, илэрхийлэл, илрэл,
илтэд, илтгэл, илтгэлтэй, илтгэгч,
үл, үлдэх, үйл, үйлчлэх, үйлчлэгч
- [ɛ] бэлтгэл, нэгдэл, нэмэрлүүлэх,
нэмэгдэл, мэдрэл, мэдрүүлэх,
мэдрэлийн, мэлмэлзүүлэх, зэдлэх,
зэллэх, зэрлэг, эрүүл, ээрүүл
- [ö] өл, өлүүр, өлөн, зөөлрөх, мөлхүүлэх
өдлөх, өдлүүлэх, өдөөлгөх,
мөрдлөг, мөргөлдүүлэх, зөрөлдүүлэх
зөрөлдөх, зөрөлцөх, нөхцөлтэй

1. Асуулт

Та Чи Дорж	Монголд ирсээр их сургуульд орсоор зочид буудалд буусаар тэр хүнтэй танилцсаар	болсоор	удаж байна уу?
	монголоор ярьдаг тэшүүрээр гулгадаг дугуйгаар явдаг хоккей тоглодог		

Хариу

(Би) (Дорж)	Монголд ирсээр их сургуульд орсоор зочид буудалд буусаар тэр хүнтэй танилцсаар	удаж удаагүй хэдхэн (хоёрхон) хонож нэг сар болж хоёр долоо хонож		байна.
	монголоор ярьдаг тэшүүрээр гулгадаг дугуйгаар явдаг хоккей тоглодог	болсоор	нэг жил хоёр сар жил хагас	

2. Асуулт

Хариу

Та Чи Ринчен	энд Монголд Улаанбаатарт хөдөө	удах уу?	(Би) (Ринчен) (Ринчен гуай) (Тэр)	удна. удахгүй.	
				нэг жил жил хагас хоёр сар	болно. болох байх.
				гурав долоо хэд хэд гурав (=хэдхэн)	хононо. хонох байх.

3. Асуулт

Танай Манай	баг бөх тамирчид	алтан мөнгөн хүрэл	медаль	авч гэнэ !
	Туяа Оюу Танай баг Тэд		алт мөнгө хүрэл	

Хариу А

Тийм гэнэ ээ, Тэгсэн гэнэ, Тэгж гэнэ,	би	дуулсан. сонссон. мэдсэн.	
		сая сая л	дууллаа. сонслоо. мэдлээ.

Хариу Б

Аа тийм үү, Тэгсэн гэнэ үү, Тэгж гэнэ үү,	би	дуулаагүй сонсоогүй мэдээгүй	л	байна. байгаа шүү.
---	----	------------------------------------	---	-----------------------

4. Мэдээлэл

Манай Танай	баг багийнхан тамирчид	түрүүлэх нэгдүгээр байр эзлэх алтан медаль авах	байх (аа).
Танайхан Эрдэни Туяа Амина			

Хариу

Тэгэх байх. Би бас	тэгж тэгэх байх гэж	бодож байна.
--------------------	------------------------	--------------

5. Асуулт

Тэр хүн Та Чи	гар хөл сагсан одон	бөмбөг	тоглодог уу?
	хөзөр бильярд теннис		

Хариу

Тэр хүн Та Чи	гар хөл сагсан одон	бөмбөг	тоглодоггүй, тоглож чаддаггүй,	гар хөл сагсан одон	бөмбөг	сайн жаахан муухан	тоглодог. тоглож чадна.
	хөзөр бильярд теннис			шатар даам хөзөр бильярд теннис			

6. Мэдээлэл

Би	энийг тэрнийг	мэднэ,	харин	энийг тэрнийг	бол	мэдэхгүй.
	хөл бөмбөгт	дуртай,		гар бөмбөгт		дургүй.

7. Асуулт

Чи Та	шатар дааманд цананд тэшүүрт хөзөрт бильярдад морин спортод теннист спортод	дуртай юу?
----------	---	------------

Хариу

Би	шатар дааманд цананд тэшүүрт хөзөрт бильярдад морин спортод теннист спортод	бол	дургүй,	шатар дааманд цананд тэшүүрт хөзөрт бильярдад морин спортод теннист спортод	бол	дуртай хүн	шүү. шүү дээ.
----	---	-----	---------	---	-----	------------	------------------

8. Асуулт

Чи Батсүх	ямар спорт	оролддог вэ? сонирхдог вэ?
--------------	------------	-------------------------------

Хариу

Би тэр	бөх морь сур хөл бөмбөг агаарын теннис	спорт	оролддог. сонирхдог.
	бөхийн морин сурын цанын тэшүүрийн хөл бөмбөгийн		

9. Асуулт

Тэр (хүн) Чи Лхагва	юу хийж байна?		
	юу хийж байгаа вэ?		
	юу хийж байгаа	хүн юм	бэ?

Хариу

Тэр Би Лхагва	тэмцээнд бэлтгэж захиа бичиж монгол бөхийн дасгалжуулагч хийж	байна.	
	тэмцээнд бэлтгэж захиа бичиж монгол бөхийн дасгалжуулагч хийж	байгаа	хүн. юм.

10. Асуулт

Дорж Тэр, Найз чинь	хөл бөмбөг шатар ном дуу хөзөр	тоглодог мэддэг бичдэг дуулдаг сонирхдог	уу? үү? юм уу? хүн үү?
---------------------------	--	--	---------------------------------

Хариу

Ер нь	тоглодоггүй мэддэггүй бичдэггүй дуулдаггүй	(юм), (хүн),	одоо л	эхлэн	тоглож бичиж дуулж	сурч байгаа	юм.
	сурч байгаа						

11. Асуулт

Би	чамайг таныг тэрнийг	хэд хэдэн цаг	хүртэл болтол	хүлээх вэ?
----	----------------------	---------------	---------------	------------

Хариу

Чи Та	намайг тэрнийг	гурав хагас хоёр хагас орой өглөө 15 цаг шөнө дунд	хүртэл болтол	хүлээ. хүлээгээрэй. хүлээж бай. хүлээж байгаарай.
-------	----------------	--	---------------	---

12. Мэдээлэл

Би	чамайг	15 цаг Оюуныг өглөө кино	хүртэл явтал иртэл болтол эхэлтэл	хүлээнэ (шүү).
----	--------	--------------------------	-----------------------------------	----------------

Хариу А

Чи	намайг	15 цаг Оюуныг өглөө кино	хүртэл явтал иртэл болтол эхэлтэл	битгий хүлээ(гээрэй). хүлээх хэрэггүй. хүлээгээд яахав.
----	--------	--------------------------	-----------------------------------	---

Хариу Б

Тэгээрэй.

13. Асуулт

Танай Монголын Энэ багийн	тамирчдын бөхийн боксчидын шатарчдын	дотор дунд	медальтай зэрэгтэй цолтой алдартай	хүн тамирчин	олон	байна уу? бий юү?
---------------------------	--------------------------------------	------------	------------------------------------	--------------	------	-------------------

Хариу А

Олон бий.

Тийм олон биш.

Тийм ч их олон биш.

Хариу Б

Хоёр Нэг Нэг хоёр Хэд	бий.
--------------------------------	------

14. Асуулт

Монголын Танай	бөх баг тамирчид хөл бөмбөгчид хоккейчид	медаль авсан ялсан түрүүлсэн нэгдүгээр байр эзэлсэн	уу? үү? биз?
Мөнхбат Бат-Эрдэни Оюу			

Хариу А

Тэгсэн,	Монголын манай	бөх баг тамирчид хөл бөмбөгчид хоккейчид	медаль авсан. ялсан. түрүүлсэн. нэгдүгээр байр эзэлсэн.
	Мөнхбат Бат-Эрдэни Оюу		

Хариу Б

Үгүй ээ,	Монголын манай	бөх баг тамирчид хөл бөмбөгчид хоккейчид	медаль аваагүй. ялаагүй. түрүүлээгүй. нэгдүгээр байр эзлээгүй	
	Мөнхбат Бат-Эрдэни Оюу	медаль авч ялж түрүүлж нэгдүгээр байр эзэлж	чадаагүй.	

15. Асуулт

Хэний Ямар	баг	түрүүлэв?	
	бөх	оролцов?	
	тамирчин	нэгдүгээр (1-р)	байр(ыг) эзлэв? байранд оров?
	хөл бөмбөгч	хоёрдугаар (2-р)	
		гуравдугаар (3-р)	

Хариу

Манай Танай Монголын Чехийн Хөл бөмбөгийн	баг	түрүүлээ.	
	бөх	яллаа.	
	тамирчин	нэгдүгээр (1-р)	байр эзэллээ. байранд орлоо.
	хөл бөмбөгч	хоёрдугаар (2-р)	
		гуравдугаар (3-р)	

16. Асуулт

Танай Монголын Чехийн Тэдний	баг	яав?		
	бөх	яасан бэ?		
	боксчид	хэр	зэрэг	байсан бэ?
	тамирчин	аль		

Хариу

Манай Монголын Чехийн Тэдний	баг	хожигдлоо.		
	бөх	яллаа.		
	боксчид	нэгдүгээр (1-р)	түрүүлээ.	
	тамирчин	хоёрдугаар (2-р)	байр эзэллээ.	
		гуравдугаар (3-р)	байранд орлоо.	

17. Асуулт

Та Чи Дулмаа Танай багш Тэр хүүхэн	сайн	тамирчин		юм! юм байна! байна!
		шатарч	бөх	
		гимнастикч	гүйгч	
		харайгч	дугуйчин	
Таны	эхнэр	гар	бөмбөгч	
Чиний	нөхөр	хөл		
	дүү	одон		

Хариу А

Баярлалаа.

Хариу Б

Тийм ээ,	манай тэр	багш эхнэр хүүхэн нөхөр	сайн	тамирчин шатарч бөх гимнастикч гүйгч харайгч дугуйчин	шүү.
				гар хөл одон	

Хариу В

Би тийм ч сайн	тамирчин шатарч бөх гимнастикч гүйгч харайгч дугуйчин . . .	биш шүү.
----------------	--	----------

18. Асуулт

Танд Чамд	тэр тамирчин тэр бөх дасгалжуулагч нь шүүгч дуучин үзэсгэлэн	ямар санагдав?
	энэ тэр Монголын Японы манай	

Хариу

Тэр тамирчин Тэр бөх Дасгалжуулагч нь Шүүгч Дуучин Үзэсгэлэн			
Энэ Тэр Монголын Японы Манай	концерт дуучин дасгалжуулагч шүүгч бөх үзэсгэлэн хөгжимчид хамтлаг	сайн муу тааруу(хан) аятайхан зүгээр	байна. байсан. санагдсан.

19. Асуулт

Монголоор Гадаад хэлээр Англиар	ярьж уншиж бичиж	сурья	гэвэл,	яах хэрэгтэй вэ?
---------------------------------------	------------------------	-------	--------	------------------

Хариу

Монголоор Гадаад хэлээр Англиар	ярьж уншиж бичиж	сурья	гэвэл,	их	ярих унших бичих	хэрэгтэй.
---------------------------------------	------------------------	-------	--------	----	------------------------	-----------

20. Асуулт

Чи өчигдөр	Дулмаатай надтай түүнтэй тэдэнтэй	театрт тэнд тэднийд	дайралдсан танилцсан байсан сууж байсан дайралдсан гэсэн байсан гэсэн	бил үү?
			танилцлуу? сууж байлуу? байлуу? дайралдлуу?	

Хариу

Үгүй, өчигдөр биш шүү дээ [biʃiʃde:].

Энэ Тар	Залуу охин хүн	Хичээлээ ажлаа амрахаа унтахаа хоолоо	Ч	Хийхгүй	Хийлгүй	Идэхгүй	Мэдэхгүй	Мартаад	Марчихаад	Миний дүү
				Кино бөх зургагт хөл бөмбөг интернэт компьютер	Толодог. Үзэх юм. Оролдог. Оролдох юм.	Толодог.	Толох юм.			

22. Асуулт

Дорж танилцъя гэсэн	Шүү дээ байх аа.
---------------------	------------------

Хариу

Тэгээд хэн	Дулмаатай	Миний дүүтэй	Танилцъя	Уулзъя	Тэгсэн билээ?
------------	-----------	--------------	----------	--------	---------------

Асуулт

Би	Тэгэлгүй	Тэгж хэлээгүй	Шүү дээ.
----	----------	---------------	----------

Хариу асуулт

Чи	Дулмаатай	Миний дүүтэй	Танилцъя	Уулзъя	Тэгсэн	Байх аа?	Биз дээ?
----	-----------	--------------	----------	--------	--------	----------	----------

Хариу

Чи намайг	Орой 9 цагт ир	Тал үү,	Тэгсэн бил үү,	8 цагт ир	Тал үү?	Тэгсэн бил үү?
-----------	----------------	---------	----------------	-----------	---------	----------------

21. Асуулт

Тэгээд ч хэзээ	Дулмаатай	Надтай түүнтэй тэдэнтэй	Театрт тэнд тэндийд	Дайралдсан	Танилцсан	Байсан	Сүж байсан	Дайралдсан гэсэн	Байсан гэсэн	Бил ээ?
				Дайралдлаа?	Танилцлаа?	Сүж байлаа?	Байлаа?	Дайралдлаа?		

Хариу асуулт

Хариу А

Тэр	муу буруу	шүү. даа.
-----	--------------	--------------

Хариу Б

Тэгж ч болохгүй дээ.
Дандаа тэгж болохгүй шүү.
Заримдаа ч тэгж болох юм.
За яах вэ.

Хариу В

Хичээлээ Ажлаа	хийгээд	киногоо бөхөө интернетээ	үзмээр үзэж баймаар оролдмоор	байна. юм.
		тогломоор тоглож баймаар тэр юмаа хиймээр		

Хариу Г

Кинонд Бөхөд Тоглоомд Интернетэд	их тун	дуртай хорхойтой	хүн залуу охин	байна даа. юм даа.
---	-----------	---------------------	----------------------	-----------------------

23. Харьцуул:**А:**

Би	спортод биеийн тамирт хөгжимд теннис	дуртай. сонирхолтой. хорхойтой.
	спорт хөгжим биеийн тамир теннис	сонирхдог.

Б.

Би	спортод кинонд талханд хөгжимд тэр хамтлагт хүүхэнд хүүхдэд моринд	дуртай. дургүй.
	тэр хүүхэнд тэр хүүхдэд чамд эхнэртээ нөхөртөө мориндоо хүүхдэдээ	хайртай. хайргүй.

24. Мэдээлэл

Дорж Тэр	надаас асуулгүй эмчтэй ярилгүй хичээлээ хийлгүй	тоглосон байна. тоглож байна. тоглох гэж байна. эм уусан байна. эм ууж байна. эм уух гэж байна. интернет дээр (интернетэд) суусан байна. интернет дээр (интернетэд) сууж байна. интернет дээр (интернетэд) суух гэж байна.
-------------	---	--

Хариу а) өнгөрсөн цагт

Тэр	муу тааруухан	юм	болж. болжээ.
Надаас асуусан Эмчтэй ярьсан Хичээлээ хийсэн	бол	сайн дээр	байсан. байж. байх байсан.

Хариу б) одоо, ирээдүй цагт

Тэгж болохгүй.
Надаас асуух хэрэгтэй (асуусан нь дээр = асуувал дээр).
Эмчтэй ярих хэрэгтэй (ярьсан нь дээр = яривал дээр).
Хичээлээ хийх хэрэгтэй (хийсэн нь дээр = хийвэл дээр).

25. Харьцуул:

а)

Спортын ямар төрөл зүйл байдаг вэ гэвэл (гэж асуувал) уулын спорт, морин спорт, өвлийн спорт гэх зэрэг олон юм бий.
Өчигдөр тэнд хэн хэн байсан бэ гэвэл Амуу, Ананд, Аюуш, Амина – ийм дөрвөн оюутан байсан.
Ангид юу юу байна вэ гэвэл ширээ, сандал, самбар, шүүгээ зэрэг олон юм байна.

б)

Хүн эрүүл байа гэвэл (байхыг хүсвэл) спорт оролдох хэрэгтэй.
Чи түүнтэй танилцъя гэвэл орой 9 цагт манайд ир.
Чи түүнд мөнгө өгье гэвэл дараа биш, одоо өгөх хэрэгтэй.

в)

Чи энэ юмгы үнэтэй гэвэл (гэж бодож байгаа бол) битгий худалдаж ав.
Тэр хүнийг чи гэвэл (гэж хэлбэл) (тэр хүн) дуртай, та гэвэл дургүй.
Тэр хүүхэн өөрийгөө монгол гэвэл их баярлана.

г) баруун гар= зөв гар, зүүн гар= солгой гар= буруу гар

Хүн баруун гараараа юм хийдэг. Зүүн гараараа юм хийдэг хүнийг <u>солгой</u> хүн гэдэг. <u>Солгой</u> гараараа сайхан зурдаг хүн байдаг. Хүнд юм өгөхөд <u>зөв</u> (баруун) гараар өгдөг. Хүнээс юм авахад бас зөв (баруун) гараараа авдаг. <u>Буруу</u> (зүүн) гараар өгч, авч болохгүй.
--

Нүүдэлчдийн хэл: газарзүйн зүг

Speech of nomads: geographical directions

Баруун /зүүн тал:

Уулын Голын Их сургуулийн Манай (манай гэрийн) Танай (танай гэрийн)	баруун зүүн	талд биед	айл дэлгүүр	байна.
---	----------------	--------------	----------------	--------

But:

Миний Чиний Доржийн	баруун зүүн	талд	суу. сууж байна.
---------------------------	----------------	------	---------------------

Голын урсгалын дагуу

Down the stream of the river

... голын	баруун зүүн	эрэгт эрэг дээр
-----------	----------------	--------------------

1-р яриа

- Чи спортод аль хэр дуртай вэ?
- Их дуртай. Ялангуяа хөнгөн атлетикт. Чи ямар спортод дуртай вэ?
- Би монгол бөхөд дуртай. Бүр их дуртай гэж болно. Бас хөл бөмбөг сонирхдог. Харин гар бөмбөгийг бол сонирхдоггүй.
- Би гар бөмбөг тоглох дуртай. Цана, тэшүүрээр гулгах бүр их дуртай. Чи гулгадаг уу?
- Цанаар муухан гулгадаг. Тэшүүрээр гулгаж ер чаддаггүй.
- Хоккей тоглодог уу?
- Үгүй. Ерөөсөө манай оронд энэ спорт хөгжөөгүй юм.
- Одон бөмбөг тоглодог биз дээ?
- Тоглолгүй яах вэ.
- Тэгвэл чамтай нэг тоглож үзэх юм сан.
- Тэгье. Хэзээ завтай вэ? Өнөөдөр завтай бол хоёулаа тоглоё.
- Тэгсэн ч яах вэ. Хаана тоглох вэ?
- Чи манай сургууль дээр оч. Оройн 17 цагт очиж чадах уу?
- Чадна. Хаана, ямар өрөөнд?
- Гуравдугаар давхарт, спортын танхимын хажуугийн нэг өрөөнд одон бөмбөгийн сайхан ширээ бий.
- Яасан сайн юм бэ! Бүтэн цаг тоглож болно биз?
- Болно гэж бодож байна.

2-р яриа

- Монгол оронд хамгийн их дэлгэрсэн (хөгжсөн) спорт юу байна?
- Бөх, сур, морь.
- Би бас ингэж сонссон. Та (надад) энэ монгол спортын тухай ярьж өгөхгүй юү?
- За тэгнэ ээ. Дараа ярьж өгье. Энэ гурвыг эрийн гурван наадам гэдэг. Наадам жил бүр болдог. Та үзээгүй биз дээ?
- Үзээгүй. Энэ (ирэх) зун л үзэх санаатай.
- Та энд ирээд ямар тэмцээн үзэв?
- Нэлээн (нэлээд) хэдэн юм үзлээ. Саяхан бөхийн өргөөнд олон улсын бөх (бөхийн тэмцээн) үзлээ. Өнгөрсөн бүтэн сайн өдөр морин спортын тоглолтыг сонирхсон.
- Та өчигдөр монгол бөх үзээгүй юү?
- Үгүй ээ. Хаана байсан бэ?
- Өчигдөр орой монгол телевизээр гарсан.
- Тийм үү, би мэдээгүй.

3-р яриа

- Та олон улсын бөхийн тэмцээн үзсэн гэсэн бил үү? Олон орны бөх байсан уу? Хаанахын бөх сайн байна?

- 10 (арван) орноос бөх ирсэн байсан. Монгол бөхчүүд олон байна билээ [bainle:]. Тэдний дунд нэлээд хэдэн аврага байсан.
- Танайхаас бөхчүүд олон оролцсон уу?
- Манайхаас цөөн бөх байсан.
- Ямар улсын бөх 1-р байр эзэлсэн (түрүүлсэн) бэ?
- Монголын бөх 1-р байр эзэлсэн (түрүүлсэн).
- Зүйтэй. Олон хүн медаль аваа (авсан) биз?
- Олон бөх медаль авч байна билээ. Танай багаас 5 хүн алт, 2 бөх мөнгө, 3 хүн хүрэл авч байна билээ.
- Тэмцээн хэзээ дууссан бэ?
- Дуусаад хоёр хонож байна.

4-р яриа

- Танай багт зэрэгтэй тамирчид олон уу (байгаа юу)?
- Олон бий. Манай багийн ахлагч спортын гавьяат мастер. Манай багийн 4 хүн, улсын 1-р зэрэгтэй, 2 хүн, улсын 2-р зэрэгтэй тамирчин.
- Чи ямар зэрэгтэй вэ?
- Би спортын зэрэг цолгүй.
- Тийм үү. Өчигдрийн тэмцээнд танай баг яав?
- 2-р байранд орсон. Нэгд орж чадаагүй.
- Тэмцээний шүүгч хэн байсан бэ?
- Олон улсын шүүгч Дондог байсан.
- Хаанахын баг түрүүлсэн бэ?
- Улсын их сургуулийн баг түрүүлсэн. Их хүчтэй, сайн баг байна.
- Дасгалжуулагч нь ямар хүн байдаг вэ?
- Улсын гавьяат багш Баяр гуай.

5-р яриа

- Чи маргааш юутай вэ (юу хийх вэ)? Завтай юу?
- Завтай, Би маргааш амарна.
- Тэгвэл надтай (хоёулаа) цэнгэлдэх хүрээлэн орох (явах) уу?
- Тэнд юутай юм бэ? Тэмцээнтэй юу?
- Хотын аврага шалгаруулах төрөл бүрийн тэмцээн болно.
- Тэгвэл үзэх юм сан.
- Би тэмцээнд өөрөө оролцох гэж байна!
- Зүйтэй. Чи юугаар оролцох юм бэ?
- Би дугуйгаар (дугуйн уралдаанд) оролцоно. Бас 100 метрт гүйх санаатай байна.
- За тэгвэл чамайг харъя. Чамд их амжилт хүсье.
- Баярлалаа. Хоёулаа маргааш цэнгэлдэх хүрээлэн дээр уулзъя. Өнөөдөр найз нь (≈найз чинь) завгүй. Бэлтгэл хийнэ.
- Тэгэлгүй яах вэ. Би маргааш тэмцээн эхлэхээс гучин минутийн өмнө очимз.
- За тэгээрэй. Хоёулаа цэнгэлдэхийн (цэнгэлдэх хүрээлэнгийн) хойно, тамирчдын байранд уулзах уу?
- Бололгүй яах вэ.

6-р яриа

- Энэ Очирбат дандаа бөх үзэх юм ! хичээлээ хийхгүй, бөхийн тэмцээн рүү явдаг. Яагаад тэгж байна?
- Тэр чинь (Тэр Очирбат чинь) бөхийн хорхойтой байхгүй юу (хорхойтой байна шүү)!
- Бөхийн хорхойтой хүн (хорхойтон) танайд (танай монголд) олон байдаг уу?
- Олон байдаг. Гэхдээ Очирбат илүү хүн шүү.

7-р яриа

- Энэ залуус хаашаа явж байна?
- Спортын төв рүү явцгааж байна.
- Тэнд яах гэж байгаа юм бэ? Тоглох гэж байна уу?
- Ихэнх нь тоглох гэж явна. Зарим нь тэмцээний бэлтгэл (сургууль, дасгал) хийх гэж байна.
- Чи юуны бэлтгэл хийдэг вэ?
- Би тэмцээний бэлтгэл сургууль хийдэггүй, агаарын теннис тоглодог.
- Чиний найз хүүхэн бас агаарын теннис рүү явж байна уу?
- Үгүй, тэр уран гимнастик оролддог.

8-р яриа

- Дамба аа, чамаас нэг юм асууя.
- За.
- Тэр нэг жижиг байшинд дандаа залуучууд орж гарч байна. Ямар учиртай байна?
- Тэр байшинд монгол бөхийн тэмцээний тасалбар худалддаг. Тэгээд л (тийм учраас) тэгж байгаа юм.
- Аа тийм үү? Бас нэг асуулт байна. Сонин сэтгүүлийн мухлагт тавдахь өдрийн өглөө маш олон хүнтэй, бусад өдрийн өглөө цөөн хүнтэй байх юм (байдаг). Яагаад тэгж байна?
- Аа тэр тэгэлгүй яах вэ. Үнэгүй өгдөг "Зах" сониныг авах гэж байгаа нь тэр. Тэр сонин дээр дараагийн 7 хоногийн спортын тухай, бас зурагтын зарлал гардаг байхгүй юу (гардаг юм л даа)!

9-р яриа

- Уучлаарай, таны нэр хэн билээ?
- Миний нэр Бадмаа. Сайн байна уу?
- Би тантай нэг уулзсан юм шиг санагдана. Та бид хоёр хаана уулзлаа аа?
- Прага хотод. Монголын жүжигчдийн концерт дээр...
- Тийм бил үү? Та чинь хөгжимчин байх аа.
- Үгүй, би дуучин...
- Ямар дуу дууллаа аа?
- Монгол морь гэдэг дуу...

- Аа тийм тийм, уучлаарай. Би сая л мэдлээ. Би танд цэцэг өгсөн.
- Тэгсэн. Концертийн дараа та надтай уулзлуу? Тэгэхэд та юу гэж хэллээ ээ?
- ...
- Би чамайг хэзээ ч мартахгүй гэж хэллүү?
- Тэгсэн. Тэгэхэд та монгол хувцастай байсан. Одоо европ хувцастай байна. Тэгээд би таныг яг таньж чадсангүй. Уучлаарай.

Text

Бичвэр

БИЕИЙН ТАМИР, СПОРТ

- Хүн бүхэн эрүүл байхыг хүснэ. Эрүүл байхад юу хэрэгтэй вэ? гэвэл олон юм хэрэгтэй. Тэдгээрийн нэг нь, миний бодоход биеийн тамир, спорт. Эрүүл байя гэвэл биеийн тамир хийх хэрэгтэй, спортоор оролдох (хичээллэх) хэрэгтэй.
- Ямар ямар төрлийн спорт байдгийг та хэлнэ үү?
- Их олон төрөл зүйлийн спорт байдаг. Жишээ нь: хүнд атлетик, хөнгөн атлетик, спорт тоглоом, дугуйн болон мото-спорт, уулын спорт, бөхийн спорт, уран гулгалт, агаарын болон усан спорт, өвлийн, зуны спорт...
- Хөнгөн атлетикийн төрөлд юу юу байна?
- Миний сая (саяын) хэлсэн спортууд, дотроо бас олон төрөл зүйлтэй. Жишээ нь: сая чиний асуусан хөнгөн атлетикт юу юу орох (байдаг) вэ гэвэл, янз бүрийн гүйлт, харайлт, зээрэнцэг, бөөрөнцөг гэх мэт олон спорт байна (орно).
- Шатар хөнгөн атлетикт орох уу?
- Үгүй, шатар бол спорт-тоглоомд орно.
- Спорт-тоглоомд ондоо юу юу байдаг вэ?
- Спорт-тоглоомд ондоо юу юу орох вэ гэвэл, даам, одон бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг орно.
- Мото-спортод юу юу ордог вэ?
- Мото-спортод мотоциклийн уралдаан, машины уралдаан орно.
- Өвлийн спортод?
- Өвлийн спортод цана, тэшүүр, хоккей зэрэг олон юм бий.
- Танай тамирчид ямар спортод сайн бэ?
- Манай тамирчид уран гимнастик, уран гулгалт, усан спортод их сайн.
- Монголд хэзээнээс спорт хөгжсөн юм бэ?
- Монголд маш эрт цагаас өөрийн спорт байсан. Олон зүйлийн ардын спорт хөгжиж байсан. Жишээ нь бөх, морь, сурын спорт байна. Энэ гурвыг эрийн гурван наадам (тоглоом) гэдэг. Жил бүрийн 7-р сарын 11-13-нд (долдугаар сарын арван нэгнээс арван гурванд) 1921 оны хувьсгалын баяр болдог. Тэр өдрүүдэд энэ гурван спортын уралдаан, тэмцээн байдаг. Үүнийг "Наадам" гэнэ.
- Наадам хаана болдог вэ?
- Наадам энд тэндгүй, хот хөдөөгүй болно. Улаанбаатарт бол Төв цэнгэлдэх хүрээлэнд болдог.

ХҮНИЙ БИЕ

Цээжин биед: толгой, хүзүү, хоолой, цээж, мөр, дал, гар, тохой, шуу, гарын хуруу, хумс.

Бөгсөн биед: хөл, гуя, өвдөг, шилбэ, хөлийн ул, өсгий, өлмий.

Толгойд: нүүр, дух, хөмсөг, нүд, чих, хацар, шанаа, хамар, ам, уруул, шүд, хэл.

Дасгал

Exercises

1. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу тайлбарла. Explain the sentences using the model.

ҮЛГЭР: За, би энэ үгийг мэдэж авлаа.

ЭНЭ ҮГИЙГ БИ САЙН МЭДМЭЭР БАЙСАН, ГЭВЧ МЭДЭЖ
ЧАДАХГҮЙ БАЙСАН.

ТЭГЭЭД САЯХАН МЭДЭЖ ЧАДЛАА. ТЭГЭЭД БИ БАЯРТАЙ
БАЙНА.

1. Би өнөөдөр сайн унтаж авлаа.
2. Би тэр киног үзэж авсан.
3. Би даалгавраа хийж авлаа.
4. Би түүнд хэлэх ёстой үгээ хэлж авлаа.
5. Би өнгөрсөн жил эхнэртэй болж авсан.
6. Би улсын зэрэгтэй тамирчин болж авлаа.
7. Би саяхан олон улсын шүүгч болж авлаа.
8. Их сайхан айраг байна, ууж аваарай.

2. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу холбож хэл. Join the sentences using the model.

ҮЛГЭР А: Өглөөний 10 цаг болсон. Би тэр хүртэл унтсан.

БИ ӨГЛӨӨНИЙ 10 ЦАГ БОЛТОЛ УНТСАН.

1. Шөнө дунд болно. Би тэр хүртэл сууж уншина.
2. Энэ спорт манайд хөгжсөн. Тэр болтол олон жил болов.
3. 1984 он болно. Тэр хүртэл би энд байна.
4. Олон улсын бөхийн тэмцээн дуусна. Тэр болтол хоёр хоног байна.
5. Би унтана. Тэр болтол чи энэ ажлыг хий.

ҮЛГЭР Б: Тэр хүн гэртээ харина. Тэр болтол тэр хүн энд сууна.

ТЭР ХҮН ГЭРТЭЭ ХАРЫГЛАА ЭНД СУУНА.

1. Би энэ хэлээр сайн ярьдаг болно. Тийм болтол сурна.
2. Би энэ дууг сурна. Тэр болтол оролдоно.
3. Батбаяр явна. Явах болтлоо энд байна.

4. Би унтана. Тэр болтол би энийг орчуулна.
5. Би хичээлд явна. Тэр болтол шинэ үг тогтооно.
6. Би оройн кинонд явна. Тэр хүртэл би энэ номыг үзнэ.
7. Дорж манайд ирнэ. Тэр болтол Дорж Дулмаатай ярилцана.
8. Тэр хүний бие эрүүл болно. Тэгтэл тэр хүн гимнастик хийнэ.

3.

А. Хоёр өгүүлбэрийг сонсож үлгэрийн дагуу холбож хэл. Join the sentences using the model.

ҮЛГЭР А: Дорж гэртээ харина. Тэр болтол би хүлээнэ.
 ДОРЖИЙГ ГЭРТЭЭ ХАРЬТАЛ (БИ) ХҮЛЭЭНЭ.

1. Дулмаа монголд буцна. Тэр хүртэл би уулзах байх.
2. Бат тэмцээнд оролцсон. Тэр хүртэл би цэнгэлдэх хүрээлэнд байсан.
3. Багш намайг дуудна. Тэр хүртэл би эндээс явахгүй.
4. Цэмбэл сургуульдаа явна. Тэр хүртэл би энд сууж ярилцъя.
5. Жадамба утсаар ярина. Тэр хүртэл би гэрээсээ гарч болохгүй.
6. Дорж ийшээ ирнэ. Тэр хүртэл хүлээе.

Б. Хоёр өгүүлбэрийг уншаад үлгэрийн дагуу хариу хэл. React using the model.

ҮЛГЭР Б: Дорж байна уу? Удахгүй ирнэ.
 ЗА, ИРТЭЛ НЬ ХҮЛЭЭЭ.

1. Дулмаатай уулзъя! Одоо ажлаа дуусах байх.
2. Би багшид энэ номыг өгмөөр байна. Багш 30 минут болоод гарч ирнэ.
3. Би гадаа гармаар байна. Одоохон энэ кино дуусна.
4. Би энэ аягатай сүүг уух уу? Энэ аягатай сүүг дуустал уувал сайн.
5. Цэмбэл сэрээгүй л байна уу? Би Цэмбэлийг сэртэл дуудаж чадахгүй байна.

4. Үлгэрийн дагуу холбож хэл. Join the sentences using the model.

ҮЛГЭР: Би одоо ирнэ. Чи хүлээж байхгүй юү?
 НАМАЙГ ИРТЭЛ ЧИ ХҮЛЭЭЖ БАЙХГҮЙ ЮҮ?

1. Би хоолоо хийе. Чи сэтгүүл уншиж байгаарай.
2. Би талх аваад ирнэ. Та цай чанаж байгааай.
3. Найз минь хүрч ирлээ. Би даалгавраа хийж дуусна.
4. Би танайд очсон. Дорж хүлээж байлаа.
5. Би театраас ирье. Та нар тэнд байж байхгүй юү?
6. Би энэ бичвэрийг орчуулна. Чи дасгалаа дуусгаарай.
7. Концерт эхэлсэн. Хүмүүс ярилцаж байлаа.
8. Олон улсын бөхийн тэмцээн дуусна. Бид телевизээр үзнэ.
9. Хурдан морь уралдана. Зургийн үзэсгэлэн үзээд явъя.

5. Өгүүлбэрийг гүйцээ.

Complete the sentences.

1. Намайг иртэл ...
2. Би иртлээ ...
3. Би сонин уншиж дуустлаа ...
4. Намайг сонин уншиж дуустал ...
5. 1984 он болтол ...
6. Шөнийн 12 цаг хүртэл ...
7. Багшийг явтал ...
8. Багш явтлаа ...
9. Би тэшүүрээр сайн гулгадаг болтлоо ...
10. Намайг тэшүүрээр сайн гулгадаг болтол ...

6. «Өмнө, дор, дотор, хойно, дунд, дараа» гэсэн үгээр цэгийг нөх.

Fill in postpositions.

1. Тэдгээр тамирчдын . . . алтан медальтан олон бий.
2. Спортын төрөл зүйлийн . . . бөх их сонирхолтой.
3. Тэр морь ер нь морины . . . ордоггүй, дандаа түрүүлдэг.
4. Миний найз түрүүлсэн тамирчнаас 2 секундйн . . . ирлээ.
5. Оюутнуудын . . . спортын зэрэг цолтой тамирчид бий.
6. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн . . . талд тамирчдын байр байдаг.
7. Би түүнийг ирсний . . . очсон.
8. Тэмцээн хагас цагийн . . . дуусна.
9. Би тэшүүрээр чиний . . . орохгүй шүү.
10. Манай баг гар бөмбөгөөр тэдний . . . орлоо.
11. Тэр шар шүүгээн . . . ном бий.
12. Номын тавиурын . . . жижиг улаан ширээ байна.
13. Тэр ном чинь номын шүүгээн . . . бий.
14. Манай байрны . . . нэг дэлгүүр байдаг.

7. Өгүүлдэрүүдийг «-бал¹, дараа, өмнө» гэсэн хэлбэрээр холбо.

Make conditional or temporal clauses.

1. Чи сургуулиасаа өдөр ирэх үү? Хоёулаа шинэ үзэсгэлэн үзье.
2. Та номын дэлгүүр явах уу? Би нэг ном захъя.
3. Тэд нар цирк рүү явж байгаа. Та ч гэсэн цуг яваач.
4. Бат уралдаанд түрүүлж ирлээ. Бид баяр хүргэлээ.
5. Миний найз хөдөөнөөс ирлээ. Надад захиа бичсэн юм.
6. Улсын гавьяат жүжигчид концертонд оролцоно. Бид их дуртай үзнэ.
7. Манай сургуулийн баг сая түрүүллээ. Тэдний баг өнгөрсөн жил түрүүлж байсан.
8. Оюутнууд хичээлээ тарсан. Оюутнууд бөхийн тэмцээн үзэх гэж явжээ.

8. Цэгийн оронд ‘-бал’, -вал’, -тал’ Fill in temporal or conditional converbs.
-ын тохирохыг бич.

1. Биеийн тамир хий- . . . хүний бие сайн болно.
2. Хүн эрүүл бай- . . . жаргал нь тэр юм.
3. Хичээл эхэл- . . . би чамайг хүлээсэн.
4. Та энэ юмыг унш- . . . ойлгоно.
5. Таныг юм унш- . . . би бас уншина.
6. 9 цаг бол- . . . намайг хүлээгээрэй.
7. 9 цаг 10 минут бол- . . . намайг битгий хүлээгээрэй.
8. Таныг хий гэ- . . . би хийнэ.
9. Таныг уншиж дуус- . . . би тэр номыг авахгүй.
10. Удалгүй кино эхэлнэ. Кино эхэл- . . . энд хоёулаа жаахан сууя.

9. Өгүүлбэрүүдийг холбоо үг болго. Change the sentences into phrases using the model.

ҮЛГЭР: Энэ хүн хотод байна.
ХОТОД БАЙГАА ХҮН.

1. Хүүхэд цанаар гулгаж байна.
2. Охин тэшүүрээр явж байсан.
3. Өчигдөр Мөнхбат тэмцээнд түүрлсэн.
4. Дулмаа одон бөмбөг тоглодог.
5. Энэ ангид тэр хүүхэн суралцаж байсан.
6. Тэр хүн өглөө бүр гимнастик хийдэг.
7. Би энэ сургуульд суралцана.
8. Жил бүр энэ морь түүрүүлж байгаа юм.
9. Би сая үг хэлсэн.
10. Чи сая хөнгөн атлетикийг асуусан.

10. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу Join the sentences using the model.
холбо.

ҮЛГЭР: Би Прага хотод ирсэн. Түүнээс хойш нэг сар боллоо.
БИ ПРАГА ХОТОД ИРСЭЭР НЭГ САР БОЛЛОО.

1. Би энэ номыг уншсан. Түүнээс хойш 2 хонож байна.
2. Дорж гэртээ харив. Түүнээс хойш 30 минут болов.
3. Би Дулмааг энд хүлээж эхэлсэн. Түүнээс хойш нэг цаг боллоо.
4. Би монгол хэл сурсан. Тэрнээс хойш олон жил өнгөрлөө.
5. Би эхнэр авсан. Тэр цагаас хойш таван жил өнгөрлөө (боллоо).

ҮЛГЭР: Би энэ номыг уншсан. Тийм учир (тэгээд) оройн кинонд явахаа мартжээ.

БИ ЭНЭ НОМЫГ УНШСААР (БАЙГААД) ОРОЙН КИНОНД ЯВАХАА МАРТЖЭЭ.

1. Тэр тамирчин жил бүр тэмцээнд оролцсон. Тэгээд аварга боллоо.
2. Миний нөхөр бусад хүнээс хурдан гүйсэн. Тэгээд энэ тэмцээнд түрүүлээ.
3. Бид хоёр одон бөмбөг тоглосон. Тэгээд хоолоо идэхээ мартжээ.
4. Би даалгавраа хийж байсан. Тэгээд телевиз харж чадсангүй.
5. Тэр хүүхэн өдөр бүр дасгал хийдэг. Тэгээд сайн тамирчин болсон юм.
6. Сүрэнгийн бие их муу байсан. Сүрэн өдөр бүр гимнастик хийж байсан. Тийм учраас Сүрэнгийн бие эрүүл боллоо.
7. Би хичээл бүрийн шинэ үгийг тогтоож байсан. Тэгээд одоо олон үг мэддэг боллоо.
8. Доржийн хоёр хүүхэд тоглож байсан. Тэгээд шөнө болтол гэртээ хариагүй.

11. Цэгийн оронд асуух өгүүлбэр бич. Fill in interrogative sentences.

1. - . . . ? Цэнгэлдэх хүрээлэнгийн билет сая дууссан байна.
2. - . . . ? Надад илүү билет байхгүй.
3. - . . . ? Манай ангид спортын зэрэгтэй хүн байхгүй.
4. - . . . ? Цолтой хүн ч байхгүй.
5. - . . . ? Ер нь спортод дуртай хүн олон бий.
6. - . . . ? Тийм ээ, энэ шатрын хорхойтой юм.
7. - . . . ? Бат гэр дүүгээ дугуйгаар явсан.
8. - . . . ? За, би чамайг иртэл сууж байя.
9. - . . . ? Ямар баг нэгдүгээр байр эзэлснийг би мэдсэнгүй.
10. - . . . ? Бат биш, Мөнх алтан медаль авсан.
11. - . . . ? Тэглээ, сая үзлээ.
12. - . . . ? Хөл, гуя, өвдөг, шилбэ бол бөгсөн биеийн эрхтэн.
13. - . . . ? Манайхан уран гимнастикт тааруухан.
14. - . . . ? Үгүй байх аа. Дорж ялж чадахгүй байх.
15. - . . . ? Бат одоо л энэ хөгжмийг эхлэн сурч байгаа юм.
16. - . . . ? Тэр, тэмцээнд бэлтгэж байгаа хүн (байна).
17. - . . . ? Үгүй ээ, Гэрэл медаль авч чадахгүй.
18. - . . . ? Их л ярих хэрэгтэй.
19. - . . . ? За тэгээрэй. Та 1984 онд дахин ирээрэй.
20. - . . . ? Би өнгөрсөн шөнө өглөөний 3 цаг болтол унтаж чадсангүй.
21. - . . . ? Тийм ээ, Монголын ард түмэн эрт цагаас эхлэн (аваад) одоо болтол гэрт сууж байгаа юм.
22. - . . . ? Уучлаарай, би ном үзэж суусаар байгаад тантай утсаар ярихаа мартжээ.
23. - . . . ? Та тэгж болохгүй шүү.

Монголын бүх бага, дунд, дээд сургуульд биеийн тамирын хичээл үздэг. Улсын Багшийн Их сургуулиас биеийн тамирын дээд мэргэжлийн багш гардаг. Сургууль бүр биеийн тамирын танхимтай. Улаанбаатар хотод биеийн тамирын төв ордон бий. Энэ ордны танхимуудад улсын болон олон улсын тэмцээн болдог. Монголд эрт цагаас эхлэн «Эрийн гурван наадам» гэдэг спортын гурван төрөл зүйл их хөгжжээ. Одоо биеийн тамир, спортын хэрэг их хөгжиж байгаа учир, монголын тамирчид, дэлхийн олон тэмцээнд оролцдог боллоо.

13. Асуултад хариул.

Answer the questions.

1. Та спортод аль хир дуртай вэ?
2. Ямар спортод илүү дуртай вэ?
3. Яагаад энэ спортод их дуртай вэ?
4. Та ямар спортын сургууль хийдэг вэ?
5. Та одон бөмбөгийн сургууль хийдэг үү?
6. Биеийн тамирын танхим хаана байдаг вэ?
7. Та юугаар тоглох дуртай вэ?
8. Танай улст ямар спорт их хөгжсөн бэ?
9. Та спортын зэрэгтэй юү?
10. Улаанбаатарын төв цэнгэлдэх хүрээлэнд юу юу болдог вэ?
11. Хоккейн дэлхийн аварга баг хаанахынх вэ?
12. Та юунд хорхойтой вэ?
13. Та ямар тэмцээн үзэх дуртай вэ?
14. Та Монголд ирсээр ямар тэмцээн үзсэн бэ?
15. Хөнгөн атлетикт ямар ямар спорт байдаг вэ?

Homework

Даалгавар

1. Биеийн тамирын тухай цээжээр ярьж сур. **Speak about sport.**
2. Биеийн тамирын талаар найзтайгаа ярилц. **Talk about sport with a colleague.**
3. Спортын тухай жижиг бичвэр зохио. **Write a short essay about sport.**
4. Орчуулах. **Translate into Mongolian:**

1. Do you like sports? Which sports do you like?
2. I like sports. I go in for light athletics a bit. Do you like sports?
3. I like (them) very much. A few years ago I took part in running competitions.

4. Do you also go in for sport at present?
5. I do almost nothing. Because I have very little leisure, I play ping-pong occasionally.

* * *

6. Have you seen Mongolian wrestlers?
7. I have not seen Mongolian wrestlers, I have only heard about wrestlers. I want to see (them).
8. It is a Mongolian national sport. One of the 'three manly sports'.
9. Where is it possible to see them?
10. In the Sports Palace it is possible to see them almost every week. The greatest competition takes place at the time of the Nadam.
11. When does the Nadam take place?
12. The Nadam takes place during the days of the Mongolian revolution of July 11-13, 1921.
13. What are the 'three manly sports'?
14. The 'three manly sports' are three types of Mongolian national sports: wrestling, archery and horse-racing.

* * *

15. Where did your team come? (Lit.: Which place did your team occupy?)
16. Our team is in the second place.
17. Which team has won?
18. The team of the University has won.
19. It is a really good team. There are two 'sports masters' in it.
20. The competition took place in the stadium. Were there many people there?
21. Oh no, no. It took place in the University Sports Centre. There were so many people. Only students came.

Хэлзүй

Grammar

1. Pair words

In pairing words it is also possible to combine words of opposite meanings, which often results in a lexical unit with an abstract meaning. It is also possible to make coordinative phrases of words of similar meaning.

*өндөр нам
үндэстэн ястан
(халуун хүйтэн*

height (< high + low)
nationalities
temperature)

2. Postpositions

*төдийгүй
арьсны төдийгүй . . . үсний өнгө*

not only (but also); the posposition is used
after a noun or a verbal noun
not only the colour of skin but also of eyes...

3. Causatives

We have seen the form in *-уул/-үүл* (cf. L7, Gr. 5), which is added to verbs of the vocalic class. In this lesson we shall see another form in *-лга⁴*, which is added to verbs ending in a long vowel or diphthong (Э1) and the suffix creates verbs of the class Э2 (cf. the table of verb classes in the Supplement):

хий- to do – *хийлгэ-* to have s.th. done

With most verbs, whose stem or root finishes in a consonant, the causative suffix is *-га⁴*:

хүр- to reach, arrive – *хүргэ-* to send, deliver

Special formation:

авхуул- (Г1) to have s.th. taken

4. Elision of the predicate

Converbium perfecti can be used without the final verb as a colloquial form. The question 'why didn't he come?' would be answered without the final verb (did not come):

Шүд нь өвдөөд . . . (= өвдсөн учир) (Because) he had toothache . . .

5. *Nomen futuri*

a) *Nomen futuri* can be an object of a verb (L10, Gr. 8d). If the subject is the same for both clauses *-аа*¹ is added. If there are two different subjects the *nomen futuri* takes the accusative case suffix.

... ямар эмчид үзүүлэхээ хэлнэ.
have his medical check-up done.

Lit.: ... (he) says, by which doctor he will

... хэддүгээр өрөөнд үзүүлэхийг
бичсэн байна.

Lit.: ... (it) is written, in which room he
will have the check-up.

b) *Nomen futuri* in Abl. followed by the postposition *гадна* 'apart from, besides':

... бүх төрлийн өвчний эмч байхаас ... Lit.: ... besides there being doctors for
гадна ... олон бий. all diseases, there are many sections.

c) *Nomen futuri* followed by the verb *бол-* expresses the future (written language; cf. also L8, Gr. 10b):

Хүнийн бие эрүүл байх болно.

The human body will be healthy.

If *nomen futuri* is followed by the form *болдог*, the phrase means 'it is (usually) necessary' (also a colloquial form):

... заримдаа хагалгаа хийлгэх болдог. ... sometimes it is necessary to have an
operation.

6. *Presens imperfecti*

This form can also have the meaning of a general tense 'it is done in that way', and the like.

Энэ эмийг өдөрт нэг (удаа) ууна.

This medicine is taken once a day.

7. *Nomen perfecti*

a) In the answer to a question *nomen perfecti* can be followed by the 3rd person enclitic pronoun *нь*, which implies a choice between more possibilities:

Эмнэлэгт хэвтсэн нь дээр.

It is better to go to the hospital (be hospitalised).

b) *Nomen perfecti* followed by the particle *ч* has the meaning 'even if':

Бие муу байсан ч ийм эм уухгүй.

Even if I were ill, I would not take such medicine.

Дорж уу гэсэн ч би уухгүй.

Even if Dorji told me to take it, I would not take it.

c) In the accusative form the *nomen perfecti* represents a phrase, from which the determined concrete noun was omitted. Thus it means: 'what was written, done, said, etc.'

Би таны хэлснийг ойлгосон.

Би таны хэлсэн үгийг ойлгосон.

I have understood what you said.

8. Verba vicaria

The interrogative verb *яа-* can also be used as a quasi-imperative to ask about the imperative of the full verb:

Эмч чамайг яа гэж байна?

What does the doctor tell you to do? Lit.: The doctor tells you 'do what'?

Эмч намайг «Хэвт» гэж байна.

The doctor tells me to stay in bed. Lit.: The doctor tells me 'lie (in bed)'.

9. Verbal phrases

a) *Converbum imperfecti* + *магадгүй* 'perhaps, probably, may be':

байж магадгүй

(he, she, it, etc.) may be

явж магадгүй

(he, she, it, etc.) may (might) go

b) The verb 'to begin' in the form of *converbum imperfecti* usually precedes the main verb, but sometimes a more idiomatic form of expression may omit the verb 'to begin' completely:

Хэзээ эхэлж өвдсөн бэ?

When did it start to ache?

Хэдийгээс өвдсөн бэ?

Since when has it been aching?

10. Accusative plus the verb 'to say'

In the phrase 'to tell s.o.' or 'to say s.th. about s.th.' the noun is in accusative:

Эмч намайг «Хэвт» гэсэн.

The doctor said I should stay in bed. Lit.: The doctor told me (Acc.) to stay in bed.

Тэр эмийг эмч их сайн эм гэсэн.

Эмч эмийг их сайн гэсэн.

The doctor said that the medicine is (was) a good one. Lit.: The doctor said this medicine (Acc.) (to be) very good.

11. Particles

a) *бол* as an interrogative particle implies a polite question. It can be followed by another particle *доо*, which makes the question more relaxed (or leisurely):

Яасан юм бол доо?

What is the matter? What happened?

With the verb of existence the question would be rather abrupt or would imply surprise. It may be offensive and therefore we do not recommend students to use it, though it is useful to know the difference:

Яасан юм бэ?

What is the matter? What happened?

b) *ч* after an interrogative pronoun in a positive sentence implies 'any...' (cf. also L8, Gr. 12d):

Хаана ч очиж болноо (<болно оо).

It is possible to enter anywhere.

Хэнтэй ч ярьж болноо (<болно оо).

It is possible to speak to anybody.

Note the mildly emphasising final particle *аа*⁴, whose pronunciation is only slightly longer than the pronunciation of the respective short vowel, and which usually also has a reassuring or quietening overtone (cf. also L9, Gr. 19b).

12. Idioms and phrases

За нэг амарлаа.

So that is a relief (I feel relieved).

Бид яах вэ, . . .

Well, concerning us..., As for us.... (hesitation, embarrassment)

Vocabulary

Шинэ үг

авхуул- (Г1) (авхуулж, авхуулах, авхуулна)	to have s.th. taken, removed
амбулатори амьсгал- (Э2.4) (амьсгалж, амьсгалах, амьсгална)	out-patients clinic to breathe
ангай- (Э1) (ангайж, ангайх, ангайна)	to open (the mouth)
арьс (ан) арьстан	skin race; 'having the skin (white, black etc.)'
битүү битүүр- (Э2.4) (битүүрч*, битүүрэх, битүүрнэ)	firmly closed, shut (also about full nose) to be closed, obstructed, stopped up
бичүүл- (Г1) (бичүүлж, бичүүлэх, бичүүлнэ)	to have s.th. written

бөглө- (Э2.1) (бөглөж, бөглөх, бөглөнө)	to fill (the tooth)
бөөр (өн)	kidney
буур- (Э2.4) (буурч*, буурах, буурна)	to diminish, decline
бүдүүн бүдүүн гэдэс бүт- (Э2.2) (бүтэж, бүтэх, бүтнэ)	large, big; gross, rough large intestines to consist of, be made up of
бүх	all, whole
бэлхүүс (эн)	waist
гадна (Abl.)	apart from, besides
гайгүй	not (too) bad, tolerable; tolerably
гарга- (Э2.1) (гаргаж, гаргах, гаргана)	to take out, release
гашуун	bitter
гэдэс (эн)	stomach, abdomen; intestines
гэмтэл	damage, injury; defect; section of injuries
гэрэл	light; X-ray apparatus
давсаг	urinary bladder
дагуу (G.)	according to
даралт (ан)	pressure
дотрын эмч	internist
дууд- (Э2.2) (дуудаж, дуудах, дуудна)	to call; summon
жин	(hot) water bottle (халуун жин)
жор	medical prescription, recipe
зай	space, gap, interval
зайтай	having space, distant
зөвшөөр- (Э2.4) (зөвшөөрч*, зөвшөөрөх, зөвшөөрнө)	to approve, permit, agree to
зүйл	item, article; kind, sort; category
зүрх (эн)	heart
карт	card
картын өрөө	card-index, files
ломбод- (Э2.2) (ломбодож, ломбодох, ломбодно)	to fill (teeth)
магадгүй	possibly, perhaps
мэс засал	operation
мэдрэл	consciousness; feeling
нам 2.	low, deep; calm
нарийн	fine, delicate; thin
нарийн гэдэс	small intestine
нийт	all; total; society; the public
нунтаг	powder (also medicine)
олгой	colon, large intestine (obsolete)
өвд- (Г4) (өвдөж, өвдөх, өвдөнө)	to be ill; be painful
өвчин	illness, disease
өвчтэй	sick, ill
өвчтөн	patient(s)

өндөр нам	height
өөдөөс харсан	opposite
сав (ан) 2.	womb, uterus
салхи (н)	wind
салхинд цохиул-	to catch cold (in the wind)
сувилагч	nurse
тайл- (Э2.4)	to undress; untie
(тайлж, тайлах, тайлна)	
тариа (н) 2.	injection, inoculation
тариа хий- (тарь-)	to inoculate, inject
тарь- (Э2.4)	to sow, plant; inoculate
(тарьж, тарих, тарина)	
тариул- (Г1)	to get inoculated
(тариулж, тариулах, тариулна)	
тодорхой	clear, specific, concrete
төдийгүй (postp.)	not only
тусал- (Э2.4)	to help, aid
(тусалж, туслах, тусална)	
тусламж	help, assistance
тустай	useful
түргэн	quick, rapid
түргэн тусламж	ambulance, first aid
тэг	zero
усан эм	liquid medicine
уушиг (ин)	lungs
үзүүл- (Г1)	to show; undergo medical check-up
(үзүүлж, үзүүлэх, үзүүлнэ)	
үндэстэн	nationality, race
үс (эн)	hair
хагалгаа(н)	operation
халуун	temperature
халууны шил	thermometer (only when taking human temperature)
халуур- (Э2.4)	to have a fever
(халуурч*, халуурах, халуурна)	
хамаагүй	of no concern, does not matter
ханиад (ан)	cough, influenza
ханиалга- (Э2.1)	to cough
(ханиалгаж, ханиалгах, ханиалгана)	
хараа (н)	vision, sight
хийлгэ- (Э2.1)	to have s.th. done
(хийлгэж, хийлгэх, хийлгэнэ)	
хуурай	dry
хүр- (Г2)	to reach, arrive at
(хүрч, хүрэх, хүрнэ)	
хэвт- (Э2.2)	to lie down, lie upon
(хэвтэж, хэвтэх, хэвтэнэ)	
хэвтүүл- (Г1)	to make lie down; put s.o. in bed
(хэвтүүлж, хэвтүүлэх, хэвтүүлнэ)	
хэлээ гарга-	to stick out one's tongue

хэмжүүл- (Г1) (хэмжүүлж, хэмжүүлэх, хэмжүүлнэ)	to measure
хэрэглэ- (Э2.1) (хэрэглэж, хэрэглэх, хэрэглэнэ)	to use, apply
цохиул- (Г1) (цохиулж, цохиулах, цохиулна)	to let hit, beat
цөс (өн)	bile
цус (ан)	blood
цэнхэр	light blue, pale blue
цээжил- (Э2.4) (цээжилж, цээжлэх, цээжилнэ)	to learn by heart
чимээгүй	silent, noiseless
шалгуул- (Г1) (шалгуулж, шалгуулах, шалгуулна)	to take an examination; undergo a (medical) check-up
шүд (эн)	tooth
шүд ав-	to extract a tooth
шүд авхуул-	to have a tooth extracted
шүдний эмч	dentist
эдгэр- (Э2.4) (эдгэрч*, эдгэрэх, эдгэрнэ)	to recover from illness; heal up
эдгээ- (Э1) (эдгээж, эдгээх, эдгээнэ)	to cure, heal
элэг (эн)	liver
эм 2.	medicine
эм уу-	to take medicine
эмийн сан (г)	pharmacy, dispensary
эмийн санч	pharmacist
эмчилгээ (н)	medical treatment
эмнэлэг	hospital; medical treatment; medicine a science
эмчил- (Э2.4) (эмчилж, эмчлэх, эмчилнэ)	to cure, treat medically
эмчлүүл- (Г1) (эмчлүүлж, эмчлүүлэх, эмчлүүлнэ)	to undergo treatment (by a medical doctor, эмчээр)
эрүүл (мэнд)	health; healthy
эсрэг (G.)	against
яаралтай	hasty, urgent(ly)
ялгаа (н)	difference, distinction
ялгаатай	different
яс (ан)	bone
ястан	race, people

Pronunciation

Дуудах

- [a – a:] зураг-зураас, халдах-халдаах, надад-надаас
 [ɔ – ɔ:] орох-ороогүй, болох-болоогүй, олох-олоогүй, хорох-хороох, хорсох-хорсоогүй, хорон-хорооны
 [u – u:] гулгуур, уруул, суртахуун, суруулах, хулуу, нуруулдах
 [ü – ü:] хүзүү, хүзүүдүүлэх, үзүүр, үзүүрлүүлэх, түлхүүр, түгшүүр, сүрдүүл, нүдүүр
 [ö – ö:] сөхөх-сөхөөч, сөнөх-сөнөөх, өрөл-өрөөл, өнгөрөх-өнгөрөөх, өлсөх-сөөвгөр, өмөрсөн-өмөөрөх
 [ɛ – ɛ:] үлэх-үлээх, үлдэх-үлдээх, сүлбэх-сүлбээлэх, мэдэл-мэдээлэл, идэр-идээд, ивэх-ивээх, зэрэгцэх, зэрэгцээгээр
- [a, u, ɔ, γ, l, r] баллуур, орлого, орилуулах, уурлах, улайрах, улайлгах, уруулаар, улирал, тулгуурлах, дарлал, холбогдолтой, болгоомжлол, уулархуу
 [i, ɛ, ö, g, l, r] илтгэл, тэлрүүлэх, түрүүлүүлэх, түдгэлзүүлэх, өлүүр, өлүүлэх, өлдүүлэх, өлийлгөх, өлгүүл, бэлтгэл, нийлэлтгүй, нийтлүүлэх, дүрслэл, өлбөрүүлэх

«Элээ, хэрээ, галуу гурав»

Sentence Patterns

Загвар

1. Асуулт

Би Бид	(дахиад)	хэзээ хаана хэнтэй хэдэн цагт юу	ирэх явах уулзах очих ярих өгөх	вэ?
			ирж явж уулзаж очиж ярьж өгч	болох вэ?

Та нар Чи Тар	ямар	ээзээ		Тэр хүнээс Доржоос сайдаас ларгаас деканаас надаас	агуугаарай. мэдэрэй. агууж болно. мэдэж болно.
		эмчид ном хүнтэй жүжит бичиг кино зураг	үзүүлэхээ уншихаа уулахаа үзэхээ бичихээ зурахаа явахаа бүцэхээ		

Харуу А

Би Дорж Бид	ямар	ээзээ		Хэнээс	агуух вэ?
		эмчид ном хүнтэй жүжит бичиг кино зураг	үзүүлэхээ уншихаа уулахаа үзэхээ бичихээ зурахаа явахаа бүцэхээ		

5. Асуулт

Та	ямар	эмчид үзүүлэхээ ном уншихаа декантай уулахаа хэдэн цагийн тасалбар авахаа	Тэр хүнд номын санчид надад тасалбар худалдагчид	Хэл, Төгсхөд	Танд	Дугаар карт ном пал билет мэдээ	Өгнө. Бичнэ
----	------	---	---	-----------------	------	--	----------------

Харуу

(Би)	эмчид ном декантай кино	яаж	үзүүлэх вэ? (үзүүлдэг юм бэ?) авч унших вэ? уулаах вэ? үзэх вэ?
------	----------------------------------	-----	---

4. Асуулт

Хариу Б

Таныг Тэр хүнийг Доржийг Та нарыг	ямар	эмчид ном хүнтэй жүжиг бичиг кино зураг	үзүүлэхийг уншихыг үзэхийг бичихийг зурахыг явахыг буцахыг авахыг	тэр хүн Дорж сайд декан дарга эмч би	мэднэ.	
		хэзээ			хэлж зааж	өгнө.

6. Асуулт

Та Тэр хүн Дулмаа	миний багшийн тэрний тэдний	хэлсэн бичсэн захиалсан		үгийг захаг бичгийг тасалбарыг номыг юмыг киног зүйлийг бичвэрийг	ойлгосон үзсэн авсан авчирсан уншсан орчуулсан тогтоосон цээжилсэн	уу? үү?
		үз орчуул унш бич тогтоо цээжил	гэсэн			

Хариу

Би Тэр хүн Дулмаа	таны багшийн тэрний тэдний	хэлснийг бичсэнийг захиалсныг		ойлгосон. үзсэн. авсан. авчирсан. уншсан. орчуулсан. тогтоосон. цээжилсэн.
		үз орчуул унш бич тогтоо цээжил	гэснийг	

7. Мэдээлэл

Тэр	хүн эмч залуу	дуу	дуулахаас дуулдгаас	гадна	бүжиг нүдний шил эмчилгээ	хийдэг.
		шүд	авахаас авдгаас			
		монгол хэл	сурахаас сурдгаас			
					хятад хэл үздэг.	

8. Асуулт

Эмч Багш Дорж Декан Номын санч	юу гэж	байна? хэлсэн бэ?
	юу	гэсэн бэ? гэв? гэнэ?

Хариу

(Эмч) (Багш) (Дорж) (Декан) (Номын санч)	«хэвт» «маргааш ир» «шүдээ авхуул» «чамтай уулз» «үнэмлэх ав» «хичээлд суу» «монгол кино үз» «зөвшөөрөхгүй» «болохгүй» «тариул»	«сайн унт» «агаарт явж бай» «уулзаж байгаарай» «ирэхгүй» «ирнэ» «мэдэхгүй» «мэднэ» «ярьж өгнө» «надад бий»	гэж	байна. хэлсэн.
			гэсэн. гэлээ. гэнэ.	

9. Асуулт

Эмч, таныг Багш, Дулмыг Дорж, чамайг	яа	гэсэн бэ? гэж байна? гэв? (гэж хэлсэн бэ?)
--	----	--

Хариу

Эмч Багш Дорж	намайг Дулмыг	«хэвт» «сур» «энэ номыг унш» «маргааш ир»	гэсэн (гэж хэлсэн.) гэж байна. гэлээ.
---------------------	------------------	--	---

10. Асуулт

Эмч Багш	чамайг таныг Дулмааг	нүдийг зүрхийг даалгаврыг орчуулгыг	юу	гэсэн бэ? гэв? гэж байна? (гэж хэлсэн бэ?)
	чиний таны түүний			

Хариу

Эмч Багш	намайг Дулмааг		өвчтэй эрүүл сайн муу	гэсэн. гэлээ. гэж байна. (гэж хэлсэн.)
	миний түүний	нүдийг зүрхийг даалгаврыг орчуулгыг		

11. Асуулт

Энд Тэнд			юу гэж бичсэн байна (вэ)?
Энэ Тэр	өрөөний хаалган дээр номд сонинд		

Хариу

Энд Тэнд	«Эмч үзэж байна» «Гаднын хүн орж болохгүй» «Чимээгүй»		гэж бичсэн байна.
Энэ Тэр	өрөөний хаалган дээр номд сонинд	«Билет дууссан» «Ресторан нийтэд үйлчлэхгүй» «Үнэмлэхээ үзүүл» «Зургаан сард нэг хэл сурч болно»	

12. Асуулт

Та Дорж	эмчийг багшийг Дулмыг	ир уулз тогло	гэвэл	ирэх үү? уулзах уу? тоглох уу?
------------	-----------------------------	---------------------	-------	--------------------------------------

Хариу

Би Дорж	эмчийг багшийг Дулмыг	ир уулз тогло	гэвэл	ирнэ. тоглоно. уулзана.	
				ирэх уулзах тоглох	байх.
				ирж уулзаж тоглож	магадгүй.

13. Асуулт

Эмч Багш Дулмаа	таныг Доржийг	хэвт ир хий сур	гэвэл	(та) (Дорж)	хэвтэх ирэх хийх сурах	үү? уу? болов уу?
-----------------------	------------------	--------------------------	-------	----------------	---------------------------------	-------------------------

Хариу

Эмч Багш Дулмаа	намайг Доржийг	хэвт ир хий сур	гэсэн чиг гэсэн ч	(би) (Дорж)	хэвтэхгүй ирэхгүй хийхгүй сурахгүй	(байх).
		яасан чиг яасан ч				

14. Асуулт

Чи Та Дорж	ямар	эмчилгээ тариа шүд	хийлгэж	байна байгаа	вэ?
------------------	------	--------------------------	---------	-----------------	-----

Хариу

(Би)	дотрын чихний мэс заслын хамрын мэдрэлийн шүдний нүдний	эмчилгээ	хийлгэж	байна. байгаа.
	пенциллин ясан шүд алтан шүд			

15. Асуулт

Чи Та Дорж	хэнээр ямар эмчээр	эмчлүүлж	байна байгаа	вэ?
------------------	-----------------------	----------	-----------------	-----

Хариу

(Чи) (Та) (Дорж)	Дорлигоор Дорлиг эмчээр Сүрэн доктороор	эмчлүүлж	байна. байгаа.
	дотрын ардын	эмчээр	

16. Асуулт

Бид одоо яах вэ?	Кинонд явах Номын сан руу явах Хичээл хийх Доржийнд очих	уу, үү.	театрт явах гэртээ харих телевиз үзэх ном үзэх	уу? үү?
------------------	---	------------	---	------------

Хариу

Кинонд Театрт Номын сан (руу) Хичээл Доржийнд Гэртээ Телевиз	явсан хийсэн очсон харьсан үзсэн	нь	дээр.
--	--	----	-------

Зөвшөөрөх

Тэгсэн (нь) дээр ээ.
Тэгсэн дээр (байх аа).
Тийм байх аа.
За тэгье.

17. Ерийн асуух

Чи Та Дорж	ажлаа хийж эм ууж амарч	байгаа юу?
------------------	-------------------------------	------------

Хариу

Тийм ээ,	би Дорж	ажлаа хийж эм ууж амарч	байгаа. байна.
----------	------------	-------------------------------	-------------------

18. Гайхан асуух

Чи Та Дорж	ажлаа хийж эм ууж амарч	байгаа юм уу?
------------------	-------------------------------	---------------

Хариу

Тийм ээ, (тэгэлгүй яах вэ,)	би Дорж	ажлаа хийж эм ууж амарч	байгаа (юм). байна.
--------------------------------	------------	-------------------------------	------------------------

19. Мэдээлэл (ерөнхий)

Дорж	өнөөдөр	ажилдаа хичээлдээ	ирэхгүй
		эмнэлэг рүү явсан. явсан. явна. багштай ярьсан.	

Хариу – асуулт

Яасан юм бэ?
Яасан юм бол?
Яагаад ирээгүй юм бэ?
Яагаад ирээгүй юм бол?
Хаашаа?
Хаашаа явсан юм бол?
Хаашаа явах юм бэ?
Хаашаа явах юм бол?
Юун тухай ярьсан бэ?
Юун тухай юм бол?

Хариу

Бие нь муу байгаа (байсан, байна), (байгаа юм шиг байна).
Шүд нь өвдөөд (өвдсөн, өвдсөн байх).
Хот руу явсан, хот руу явсан байх, (явсан байж магадгүй).
Архангай явна, явах байх, явах юм гэнэ.
Чиний тухай ярьсан, (ярьсан байх).

20. Мэдээлэл

Дорж	өнөөдөр	ажилдаа хичээлдээ	ирээгүй	байна.
		эмнэлэг рүү явсан явсан явах юм багштай ярьсан		

Хариу – асуулт

Яасан юм бол?
Яагаад ирээгүй юм бол?
Хаашаа явсан юм бол?
Хаашаа явах юм бол?
Юун тухай (ярьсан) юм бол?

Хариу

Бие нь муу байгаа юм шиг байна.
Шүд нь өвдсөн байх.
Мэдэхгүй, хот руу явсан байж магадгүй.
Архангай явах юм гэнэ.
Чиний тухай ярьсан байна.

Яриа

Conversations

1-р яриа: Их сургууль дээр

- Хэрэв би өвдвөл хаана (ямар эмнэлэгт) үзүүлэх вэ?
- Хотын гуравдугаар эмнэлэгт үзүүлж болно.
- Энэ эмнэлэг (амбулатори) хаана байдаг вэ?
- Байгалийн музейг та мэднэ шүү дээ. Өөдөөс нь харсан байшин байгаа.
- Эмнэлэгт үзүүлэхэд яаж үзүүлдэг юм бэ?
- Эхлээд эмнэлэг дээр очиж картын өрөөнд карт бичүүлнэ. Тэнд ямар эмчид үзүүлэхээ хэлнэ. Тэгэхэд танд дугаар (номер) өгнө. Тэр дугаарт хэдэн цагт, ямар эмчид, хэддүгээр өрөөнд үзүүлэхийг бичсэн байна.
- За, мэдлээ. Түргэн тусламж дуудаж болох уу?
- Бололгүй яах вэ, 103 (нэг зуун гурав) дугаар утсаар дуудна.

2-р яриа: Эмнэлэг дээр

- Сайн байна уу? Би дотрын эмчид үзүүлмээр байна.
- Та картгүй биз дээ. Паспортаа үзүүлэхгүй юү? Би танд карт бичье. Та хаана ажилтай вэ? (Та хаана суралцдаг вэ?)
- За, энэ миний паспорт, энэ оюутны үнэмлэх. Би Их сургуулийн оюутан.
- Май, энэ дугаар. Өнөөдөр 11 цагаас 14-р өрөөнд Буд эмчид очоорой.

3-р яриа: Эмчийн өрөөнд

- Сайн байна уу? Эмч ээ.
- Сайн, сайн байна уу? За суу.
- Миний бие муу байна. Толгой өвдөөд халуунтай байх шиг байна (байгаа юм шиг байна.)
- Амаа ангай! Хэлээ гарга! Аа гээ! За, Хувцсаа тайл! Амьсгал! Урт амьсгал! За боллоо. Ханиалгаж байна уу? Хамар чинь битүүрч байна уу?
- Тийм ээ, эмч ээ, хамар битүү, их ханиалгаж байна.
- За, та энд хэвт. Энд өвдөж байна уу?
- Үгүй ээ.
- Тэгвэл энд?
- Жаахан өвчтэй (өвдөж) байна.

- За, бос доо. Хэзээ эхэлж өвдсөн бэ?
- Өчигдөр орой.
- Та ханиад хүрч(ээ). Та салхинд цохиулж(ээ). Гайгүй ээ, та хэвтээд эмээ сайн уух хэрэгтэй байна.
- За, баярлалаа эмч ээ.

4-р яриа: Шүдний эмчид

- Амаа ангай, энэ шүд өвдөж байна уу?
- Аан-г.
- Энэ шүд?
- Аан-г.
- За, болно. Таны хоёр шүд өвчтэй байна. Нэгий нь авна. Нөгөөгий нь бөглөнө. Та авхуулах уу?
- Авхуулъя авхуулъя.
- За, та нөгөөдөр (дахиад) ирээрэй.
- За нэг амарлаа. Энд шүд хийдэг үү?
- Хийнэ ээ, та хэд хоногийн дараа ирж шүд хийлгээрэй.
- За баярлалаа, баяртай.

5-р яриа: Эмийн санд

- Энэ эмийг хаанаас авах вэ?
- Тэр «жор хүлээн авна» гэсэн цонх байна.
- Энэ эм манайд байхгүй юм байна. Бусад нь байна. Таван зуун төгрөг боллоо.
- Энэ эмийг хаанаас авч болох вэ (авах вэ)?
- Төв эмийн сангаас авч болно. Тэнд байгаа. Энэ эмийг хоолныхоо өмнө өдөрт нэг (удаа) ууна. Энэ эмийг 6 цагийн зайтай ууна шүү. Хоёр цагийн дараа ирж усан эмээ аваарай.
- Хоёр цагийн дараа? За мэдлээ.

6-р яриа: Хичээл дээр

- Дорж (өнөөдөр) яасан бэ?
- Өвчтэй (байгаа).
- Яасан юм бол?
- Толгой нь өвдөөд халуунтай байгаа.
- Эмчид үзүүлсэн үү?
- Үзүүлсэн. Түргэн тусламж дуудаж үзүүлсэн.
- Тэгээд юу гэж байна?
- Эм бичиж өгсөн. Гурав хоног хэвт гэсэн.
- Эмээ авсан уу?
- Авсан, би авч өгсөн.
- Ямар эм ууж байгаа вэ?
- Халууны эм, бас нэг шинэ эм. Тэр эмийг эмч их сайн эм гэсэн.

- За, би хичээлийн дараа эргэж очно оо. (За, би хичээлийн дараа очиж уулзана аа.)

7-р яриа.

- Чиний халуун одоо хэд байна?
- Саяхан үзэхэд 38 байсан. Халуун буурч байна.
- (Цусны) даралтаа үзүүлсэн үү?
- Үзүүлсэн, даралт зүгээр (их, бага) байна гэсэн.
- Ямар эмчилгээ хийлгэж байна?
- Толгойн эм, халууны эм, нэг усан эм ууж байгаа. Өчигдөр нэг тариа хийлгэсэн (тариулсан).
- Чи (энэ) ийм эм ууж байгаа юм уу?
- Тийм ээ, эмч энэ эмийг сайн гэсэн.
- Эмнэлэгт хэвтсэн нь дээр биш үү?
- Гайгүй байх аа, эмч гэртээ хэвт гэсэн.
- Халууны шил бий юу? Халууны чинь одоо нэг үзээдэхье!
- Бий, энэ байна.

Бичвэр

Text

ЭМНЭЛЭГ

Их сургуулийн оюутан 1-р эмнэлэгт үзүүлэх хуваарьтай байдаг. Энэ эмнэлэгт бүх л төрлийн өвчний эмч байхаас гадна өвчтөнийг хэвтүүлэн эмчлэх олон тасаг бий. Яаралтай үзүүлэх гэвэл түргэн тусламж дуудаж болно. Эндэхийн чих, хамар хоолой, нүд мэдрэл, мэс засал, дотор, эмэгтэйчүүд, гэмтэл, гэрлийн зэрэг тасаг нь 2, 3-р давхарт байдаг. Заримдаа оюутнууд энд ирж, биеэ үзүүлэх, цусны даралтаа хэмжүүлэх, нүдний хараагаа шалгуулах, шүдээ эмчлүүлэх, тариа хийлгэх, хагалгаа хийлгэх болдог. Өвчтөн хүн эмчид үзүүлээд эм бичүүлж аваад 1-р давхарт байдаг эмийн сангаас жорын дагуу хуурай болон нунтаг, усан эм авч болно. Эмээ цагаар уувал тустай. Тэнд бас халууны шил, тарианы хэрэгсэл, дусаагуур, жин, нүдний шил, тариа гэх мэт олон зүйл бий. Эмийн санч эмийг яаж хэрэглэхийг тодорхой зааж өгнө. Эм хэдий гашуун ч өвчинд тустай гэж монголчууд ярьдаг. Хүнд өвчин хүрлээ ч гэсэн эмээ сайн уугаад байвал түргэн эдгэрдэг шүү дээ. Мөн биеийн тамир сайн хийж байвал хүний бие эрүүл байх болно.

ХҮНИЙ ЭРХТЭН

Хүний дотор эрхтэн бол их нарийн юм. Дотор эрхтэнд: уушиг, зүрх, элэг, цөс, нарийн гэдэс, бүдүүн гэдэс (олгой), бөөр, давсаг, сав ордог. Хүний бие, яс, мах, арьс, цуснаас бүтнэ. Манай дэлхийд цагаан, шар, хар гурван арьстан бий. Үндэстэн бүрийн арьсны төдийгүй нүд, үсний өнгө, өндөр нам нь ялгаатай байна. Жишээлбэл: Нүд хар, хүрэн, цэнхэр, ногоон байхад, үсний өнгө хар, шар, хүрэн, цагаан байдаг.

1. Цэгийн оронд зохих үгийг тавь. Fill in suitable words.

1. Төв эмнэлэг ... байдаг.
2. Эмчид үзүүлэхэд ... хэрэгтэй юү?
3. Таны бие ... байна уу?
4. Таны юу ... вэ?
5. Та хэвтээд ... уух хэрэгтэй байна.
6. Миний ... өвдөж байна.
7. Би ... бөглүүлэх гэсэн юм.
8. Эмч ... бичиж өгсөн.
9. Энэ эмийг өдөрт ... ууна шүү.
10. Бид өвчтэй найзыгаа ... очсон.
11. Та ямар ... хийлгэж байна.
12. Та ... ууж байна уу?
13. Таны ... хэд хүрч байна?
14. Тэр оюутан ... явсан.

2. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу Join the sentences using the model.
холбож хэл.

ҮЛГЭР: Та энэ эмийг уугаарай. Тэр эм сайн шүү.
ЭНЭ УУХАД САЙН ЭМ ШҮҮ. ЭНЭ ЭМИЙГ УУХАД САЙН ШҮҮ.

1. Та энэ жүжгийг үзээрэй. Их сонирхолтой юм.
2. Чи тэр номыг уншаарай. Маш сайхан юм.
3. Чи цанаар гулгаж амраарай. Сайхан байна.
4. Та нар биеийн тамир хийж байгаарай. Биенд сайн болно.
5. Эмээ жорын дагуу уугаарай. Түргэн эдгэрнэ.
6. Хичээлдээ, өвчтэй үедээ битгий яваарай. Бие бүр муудна.
7. Та төв эмийн санд очоорой. Бүх төрлийн эм байдаг.
8. Бүтэн сайн өдөр номын санд суугаарай. Их юм хийж болно.
9. Өглөө бүр гимнастик хийгээрэй. Эрүүл мэндэд тустай.

3. Цэгийн оронд ”-х гэсэн, -х, -х ёстой, -сан”, -аагүй”, -ж, -ч байгаа”
хэлбэртэй үйл үгийг тавь. Fill in suitable verbal forms.

1. Энэ усан эм (бол) миний ... эм (байна).
2. Тэр миний ... ном (байна).
3. Энэ (бол) миний ... дуурь юм байна.
4. Энэ (бол) бидний явж ... газар байна.
5. Тэр (бол) бидний очиж ... дэлгүүр байна.
6. Энэ хуурай эм, миний ... эм юм.
7. Тэр (бол) эмчийн ... эм.

8. Энэ миний ... шил байна.
9. Энэ (бол) миний дэлгүүрээс ... шил байна.
10. Энэ миний ... тариа байна.

4. Хаалтандхи үгийг зохих хэлбэрт хэл. Use correct verbal forms.

1. Би саяхнаас усанд сэлж (сур-)
2. Бид монгол хэл сурч (эхэл-)
3. Миний толгой өчигдөр оройноос өвдөж (эхэл-)
4. Эмч өвчтөнүүдийг үзэж (дуус-)
5. Дорж эмийн сангаас эм авч (уу-)
6. Бид номын дэлгүүрээс ном худалдаж (ав-)
7. Оюутнууд ажлаа цагтаа хийж (эхэл-, дуус-)
8. Наран эмнэлэгт хэвтэж (эмчлүүл-)
9. Чулуун дэлгүүрээс талх, мах, гурил худалдаж (ав-)
10. Би дүүдээ одон бөмбөг яаж тоглохыг зааж (өг-)

5. Өгүүлбэрүүдийг «-тал^д, -вал^д, -саар^д, (-аад^д)» дагавраар тохируулан холбож хэл. Join the sentences by way of suitable converbs.

1. Би концертонд очлоо. Тэд гадаа хүлээж байсан.
2. Таны шүд өвдсөн үү? Шүдний эмчид очоорой.
3. Номын сан хаасан. Бид тэнд байсан.
4. Би тэр хүнтэй хамт суралцдаг. Одоо дөрвөн жил болж байгаа.
5. Чиний бие эдгэрнэ. Би өдөр бүр ирж байя.
6. Та энэ эмийг уугаарай. Хурдан эдгэрэх болно.
7. Хүнд өвчин хүрээ юү? Эмнэлэгт хэвтсэн нь дээр.
8. Халууны эм уусан. Таны халуун буурч байна.
9. Та нар одоо дуурь бүжгийн театрт очоорой. Шинэ жүжиг үзэх болно шүү.
10. Та эмнэлэгт үзүүлээрэй. Картаа бичүүлээд дугаар аваарай.

6. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу холбож хэл. Join the sentences using the model.

ҮЛГЭР: Биеийн тамир хийнэ. Эрүүл мэндэд сайн гэсэн.

БИЕИЙН ТАМИР ХИЙХЭД ЭРҮҮЛ МЭНДЭД САЙН ГЭСЭН.

БИЕИЙН ТАМИР ХИЙВЭЛ ЭРҮҮЛ МЭНДЭД САЙН ГЭСЭН.

1. Ханиад хүрчээ. Ханиадны эм уувал сайн гэсэн.
2. Шүдээ авахуулсан уу? Дараа нь шүд хийлгэвэл сайн гэсэн.
3. Салхинд цохиулсан уу? Халууны эм уувал сайн гэсэн.
4. Ханиад хүрсэн үү? Эмчид хурдан үзүүлбэл сайн гэсэн.
5. Эмээ байнга уугаарай. Түргэн эдгэрэхэд сайн гэсэн.
6. Сонгодог хөгжим соносоорой. Аятайхан амрахад сайн гэсэн.

7. Хөнгөн атлетик хийгээрэй. Биеийн эрүүл мэндэд сайн гэсэн.
8. Монгол хүнтэй ярилцаарай. Хэл сурахад сайн гэсэн.
9. Хичээл бүрийн шинэ үгийг сур. Дараахь хичээл үзэхэд сайн гэсэн.
10. Тэр зургийн үзэсгэлэнг үзээрэй. Монгол зурагтай танилцахад сайн гэсэн.

7. Цэгийн оронд асуулт тавь.

Fill in interrogative sentences.

1. – ...? Тийм ээ, өчигдөр эхэлж өвдсөн.
2. – ...? Эмч энэ эмийг уу гэсэн.
3. – ...? Үгүй, дотрын тасагт хэвтэж байгаа.
4. – ...? Би одоо эмийн сан руу явна.
5. – ...? Одоо миний бие сайн болсон.
6. – ...? Түргэн тусламж дуудаагүй.
7. – ...? Толгой өвдөхгүй байвал уншина.
8. – ...? Тэгнэ, би шүдээ авхуулна.
9. – ...? Бие муу байсан ч би ийм эм уухгүй.
10. – ...? Эмч ирэх байх.
11. – ...? Тэр эмч үзэхгүй юм шиг байна.
12. – ...? Эмчийн бичээгүй эм.
13. – ...? Энэ эмийг байхгүй гэсэн.
14. – ...? Би одоо гэртээ л харимаар байна.

8. Өгүүлбэрүүдийг үлгэрийн дагуу холбо.

Join the sentences using the model.

ҮЛГЭР: Энэ эм сайн. Ингэж эмч хэлсэн.

ЭНЭ ЭМИЙГ ЭМЧ САЙН ГЭЖ ХЭЛСЭН.

ЭМЧ ЭНЭ ЭМИЙГ САЙН ГЭСЭН.

1. Энэ тариа танд тустай. Ингэж эмч хэллээ.
2. Тэр бөх хүчтэй. Тэгж хүмүүс ярилцдаг.
3. Тэр концерт сайхан. Ингэж үзэгчид ярьж байна.
4. Биеийн тамир эрүүл мэндэд тустай. Бид тэгж хэлсэн.
5. Та сайхан дуулдаг. Тэд нар тэгж хэлж байсан.
6. Тэр хүн спортын 1-р зэрэгтэй. Би сая хэллээ.
7. Бат тэргүүний оюутан. Ингэж багш нар ярьдаг.
8. Морины уралдаан сонин. Монголд очсон хүмүүс ингэж ярьдаг.
9. Наран эмч сайн. Эмчлүүлсэн хүмүүс тэгж хэлдэг.
10. Тэр хүн монгол хэлэнд сайн. Ангийнхан нь ингэж ярьдаг юм.

9. Орчуулах.

Translation.

Эмнэлэг дээр.

Өглөө босоход миний толгой өвдөөд бие муу байлаа. Би нөхдөдөө хэлээд сургуулийн эмнэлэгт очив. Тэнд тариа хийлгэж байгаа, шүдээ үзүүлэх, чихээ үзүүлэх гэсэн нилээд оюутан байв. Би дотрын эмчид үзүүлье гэж дугаар авч

орлоо. Эмч намайг үзээд ханиад хүрсэн байна гээд эм бичиж өгөв. Би мөн тэндэхийн эмийн сангаас, жороо өгч эмээ авсан. Маргааш нь миний бие зүтээр болж эдгэрсэн учраас хичээлдээ явсан.

10. Асуултад хариул.

Answer the questions.

1. Таны юу өвдөж байна?
2. Та юуны эмчид үзүүлсэн бэ?
3. Эмч юу гэсэн бэ?
4. Наран юуны (аль) тасагт хэвтэж байгаа вэ?
5. Эмээ хаанаас яаж авах вэ?
6. Төв эмнэлэгт юу юуны тасаг бий вэ?
7. Та юу юуны эмч мэдэх вэ?
8. Эмийн санд юу юу байдаг вэ?
9. Ханиад хүрэхэд яадаг вэ?
10. Муу шүдийг яадаг вэ?
11. Таны шүд ямар вэ?
12. Түргэн тусламж яаж дуудах вэ?
13. Та ямар эм ууж байгаа вэ?
14. Бие тань одоо яаж байна?
15. Энэ эмийг өдөрт хэдэн удаа, яаж уух вэ?
16. Таны хараа ямар вэ?

Даалгавар

Homework

1. Яриануудыг тогтоо.

Learn the conversations by heart.

2. «Эмнэлэг» сэдвээр яриа зохио.

Write a text about the hospital.

3. «Хүний бие» сэдвээр зохиож бич.

Write a text about the human body.

4. Орчуулах.

Translate into Mongolian:

1. Is there a hospital in your town?
2. (In our town) there are two hospitals.
3. You are healthy? When were you last ill? Are you ill sometimes?
4. I am healthy (O.K.). If I fall ill occasionally, I go and see the doctor.
5. What do you do if you fall ill?
6. If necessary, I stay in bed, but I mostly stay at home and take medicine.
7. When you stay in the hospital, do you pay for it in your country?
8. If you have health insurance, your stay (lit.: when you stay) in the hospital, is free of charge.
9. If you fall seriously ill, do you stay in bed at home or do you go to the hospital?
10. It is better to go to the hospital.

* * *

11. When did your stomach start to ache?
12. (It started to ache) in the morning the day before yesterday.
13. Why did you not come on that very day? Now you are in bed, aren't you?
14. If you tell me to stay in bed, I will stay in bed.
15. Here I will write a prescription for you. It is a good treatment (lit.: medicament) for stomach ache. Stay in bed and do not do anything. Let me see you (lit.: come and show [it]) the day after tomorrow.
16. Thank you, doctor.
17. If one has no health insurance, this treatment can be very expensive.

Хэлзүй

Grammar

1. Partial number

In this lesson we will encounter further forms of partial number:

<i>үсчин – үсчнүүд</i>	barber, barbers, headdressers
<i>цагчин – цагчнууд</i>	watchmaker, watchmakers
<i>засварчин – засварчнууд</i>	repairman, repairmen

Note on colloquial pronunciation: In colloquial language the nouns in final *-н* and *-н(г)* seem to merge due to analogy and the colloquial pronunciation of the above words often includes *-г*-. [üsʃɪŋü:d], [ʧagʃɪŋü:d], [ʒasvərʃɪŋü:d]. Very formal variant: *засварчид*.

2. Numerals

In the phrase 'a picture of 3 x 4cm', the numerals have the following form: *гурав дөрвийн зураг*

3. Causatives

a) Formation of causatives (see L7, Gr. 5 and L11, Gr. 3 and the Table of Verbs in the Supplement):

Suffix *-aa⁴* is used with the stems in short vowels:

сэр- (Э2.4) > *сэрээ-* (Э1) to wake up – to wake s.o. up

Suffix *-гаа⁴, -га⁴*:

уна- (Э2.1) > *унагаа-* (Э1) / *унага-* (Э2.1) to fall – to drop, let fall

Suffix *-га⁴* with consonantal stems:

хүр- (Г2) > *хүргэ-* (Э2.1) to reach, arrive – to send, deliver

бол- (Г1) > болго- (Э2.1)

to become – to make or turn s.th. into s.th.

Suffix *-лга*⁴ after a long vowel or diphthong:

хий- (Э1)

хийлгэ- (Э2.1)

to do – to have s.th. done

заа- (Э1)

заалга- (Э2.1)

to teach – to have s.th. explained, shown,
learn (from s.o.)

b) In many cases causatives have the meaning ‘to cause an action’. The direct object is in Acc., the indirect object is in D.-L.:

Би энүүнийг Доржид үзүүлсэн.

I showed this to Dorji.

Би аавыг сэрээсэн.

I woke up father.

c) Besides that causatives have often the meaning ‘to have s.th. done, to let s.th. be done’. In that case the actor takes the form of the instrumental:

Би Доржоор сахлаа хусууллаа.

I had my beard shaved by Dorji.

4. Verbs derived from adjectives

The suffix *-д-²*, which originally had a vocalic ending (Э2.2.), implies that the respective quality is not pleasant or suitable (see L7, Gr. 6).

Besides that there are two suffixes *-д-¹*, *-с-*, which were not followed by a vowel and which are neutral with regard to the evaluation of the quality expressed by the verb (i.e. they do not express discomfort). Verbs formed in this way belong to the consonantal class. Their causatives are formed by the suffix *-га⁴*, before which *-д-* > *-м-*:

багасга-, багатга- (Э2.1)

to make small(er)

богиносго-, богинотго- (Э2.1)

to make short(er)

нарийсга-, нарийтга- (Э2.1)

to make narrow(er)

өргөсгө-, өргөтгө- (Э2.1)

to make broad(er)

томсго-, томтго- (Э2.1)

to make big(ger)

уртасга-, уртатга- (Э2.1)

to make long(er)

5. Passive voice

The passive is formed by the suffix *-гд-*, which originally had a vocalic ending. In the colloquial style this form is used especially with verbs of perception. This roughly corresponds to an impersonal statement:

...харагдаж байна

it is seen, it looks like

...сонсогдож байна

it is heard

Та аятайхан харагдаж болно.

You will look nice.

Үсчнүүд . . . үнэртэй ус түрхэж

Barbers are seen anointing perfume...

харагдана...

With other verbs passive voice is formed especially if one is unable to do s.th., or is exposed to s.th.:

... тэд нар ялагдсан

they were defeated (from *ял-* to win)

Further suffixes:

-д-	after -л-
-т-	after -р-, -г-, -д-, -в- (these last suffixes mostly in written language)

ол- (Г1)	to find	олд- (Э2.2)	to be found
үнэр	odour, smell	үнэрт- (Э2.2)	to smell
ав- (Г5)	to take	авт- (Э2.2)	to be taken

6. Verba diminutiva

The suffix *-зна-* (Э2.1) creates special forms of verbs, which express a short or momentary action:

<i>Байзна!</i>	Wait (a little)!
<i>Азна!</i>	id.

<i>Та байзнахгүй юү?</i>	Would you wait a little?
--------------------------	--------------------------

7. Prohibition, refusal

Besides the form explained in L4, Gr. 10, prohibition can also be expressed by way of a verbal noun in *-лт* followed by a negative particle. This is a mild form, which can also be linked with the first person. The meaning is very close to that of the analytical construction of the *converbium perfecti* + *ях вэ*:

<i>тослуулалтгүй</i>	it is not necessary to put oil (on my hair), I do not want to apply oil
<i>Би тослуулаад яах вэ.</i>	It is not necessary to put oil (I do not wish it) (for more examples cf. Pattern No. 22)

8. Perfective action

Verba intensiva (see L8, Gr. 6), formally resulting from a combination of the basic verb and of the verb *орхи-* (Э2.1) 'to leave, abandon', have a perfective meaning and languages having the respective forms can use perfective verbs in translation. In very distinct and slow speech the original phrase may also emerge (cf. Exercise No. 5). An intensive verb can take the suffixes of past tenses:

<i>мартачихаж</i>	(I) forgot	< <i>мартаж орхиж</i>
<i>хагарчихаж</i>	(it) broke	< <i>хагарч орхиж</i>
<i>унагачихсан</i>	(I) dropped	< <i>унагаж орхисон</i>
<i>унагачихлаа</i>	(I) dropped	< <i>унагаж орхилоо</i>

9. Deverbal adjectives

Deverbal adjectives are formed by the suffix *-ууштай/-үүштэй* and their meaning is 'suitable for', 'necessary, usable' and the like. In predicate and attribute the meaning of this form is close to that of the forms in *-маар*⁴:

<i>танилцууштай</i>	(worth) making acquaintance with
<i>байгууштай</i>	which should be
<i>үзүүштэй</i>	worth seeing

10. Benedictive

In written language the *benedictive* is formed by the suffix *-гтун/-гтүн* and its meaning is that of a polite instruction (direction and the like):

<i>суугтун</i>	you may sit, (kindly) sit
----------------	---------------------------

11. Immediate future

Besides meaning the recent past, the suffix *-лаа*⁴ can also mean the immediate future:

<i>Дарлаа шүү, боллоо.</i>	I am pressing it, finished.
----------------------------	-----------------------------

12. Imperative forms for an action of short duration

The imperative of the second person of a verb expressing short duration (see L8, Gr. 7a) takes the suffix *-аадах*⁴ [*-аад*⁴ + *орхи*- (Э2.1) 'to leave, abandon']:

<i>мэдээдэх</i>		<i>хараадах</i>	
<i>мэдээдхээч</i>	find out	<i>хараадхаач</i>	have a look
<i>мэдээдхээрэй</i>		<i>хараадхаарай</i>	

13. *Nomen perfecti*

In connection with a postponed pronoun of the 2nd person (*чинь*) the noun takes the meaning of a temporal clause: 'when s.th. happened', 's.th. happened.. and then...' and the like. This form at the same time implies a mild astonishment, accidental event, occurrence of an impediment and the like. This form is explicitly colloquial:

<i>Газар унагачихсан чинь шил нь</i>	I dropped (it) and the glass (lit.: its glass) broke.
<i>хагарчихлаа.</i>	
<i>Би өчигдөр танайд очсон чинь хүн</i>	I came to your house yesterday and nobody was there. (When I came to your
<i>байхгүй байсан.</i>	house yesterday, nobody was there.)

14. Verbal phrases

a) The prepositional phrase 'in two days, in three days' etc. is best rendered into Mongolian by a verbal phrase: 'having spent two days' etc.

Долоо хоноод ирж загвар өмсөж үзээрэй. Come to try it on in seven days.

b) Attaching the linking verb *бөгөөд* ('and', lit.: 'having been') to the verbal noun predicate:

Үсчнүүд үс засаж, . . . будаж байх бөгөөд . . . түрхэж харагдана. Barbers are seen cutting hair... colouring and ... smearing.

In the written language *бөгөөд* can also stand between two nouns in the sense of 'and'.

15. Noun in an adverbial function

...цаг буруу яваад . . . the watch went *wrong*...

16. Adjective (qualitative noun) in sociative case as a predicate

Хүн ихтэй юү? (Are there) many people?
Хүн ихтэй. (There are) many people.

17. Idioms and phrases

Юүхэв! (юү хийх вэ) Enough! No more! Not necessary!
Хэдэн цагт ч гэсэн болно. It is possible at any time.
Урьдчилгаа болгож 2000 төгрөг тушаая. (Урьдчилгаанд 2000 төгрөг тушаая.) I will give 2000 Tg. as an advance.

Цаг буруу яваад болохгүй байна. The watch went (lit.: having gone) wrong and it is not possible (bearable).
олны дунд among people
дурсгал болгож / дурсгаж as a souvenir; in remembrance of (a present, gift)

аваач- (Э2.3) (аваачиж, аваачих, аваачна)	to remove, carry away
айлга- (Э2.1) (айлгаж, айлгах, айлгана)	to frighten, scare
анхаар- (Э2.4) (анхаарч*, анхаарах, анхаарна)	to pay attention, bear in mind
ар	back, rear
арай	barely, scarcely; not quite; not yet (+ neg.)
багасга- (Э2.1) (багасгаж, багасгах, багасгана)	to make smaller
байнга	permanent(ly), regular(ly)
бичгийн машин	typewriter
богиновтор	rather short
болго- (Э2.1) (болгож, болгох, болгоно)	to make or turn s.th. into s.th.
буд- (Э2.2) (будаж, будах, будна)	to paint, dye
буулга- (Э2.1) (буулгаж, буулгах, буулгана)	to let down, cause to come down; to lower; to unload
гол 2.б	axle, axleshft; spindle (for 2.a, c, cf. L9)
дар- (Э2.4) (дарж, дарах, дарна)	to press down, squeeze; oppress
дөрвөлжин	square (geom. form); rectangular
дуу хураагуур (магнитфон)	tape recorder
ерийн, ердийн жишүү	ordinary, black-and-white (photograph)
задал- (Э2.4) (задалж, задлах, задална)	slanting, oblique; obliquely to dismantle (an instrument)
зан	heel (of a shoe)
засвар	repair(s)
засварчин	repairman
засуул- (Г1) (засуулж, засуулах, засуулна)	to have s.th. repaired
зах (ан) 1.	edge, border, outskirts, suburb; collar
захал- (Э2.4) (захалж, захилах, захална)	to cut into shape (hair); trim
зурагчин	photographer
зүү (н)	needle; hand (of a watch)
кармаа (н)	pocket (coll.)
костюм (ан)	suit of clothing
машинд- (Э2.2) (машиндаж, машиндах, машиндана)	to work, cut with a machine
наа- (Э1) (нааж, наах, наана)	to paste, glue; stick

оё- (Э2.1) (оёж, оёх, оёно)	to sew
оёдолчин	tailor
орхи- (Э2.1) (орхиж, орхих, орхино)	to leave, abandon
өлгүүл- (Г1) (өлгүүлж, өлгүүлэх, өлгүүлнэ)	to have s.th. hung
өнгөт	having colour; colourful
өргөн	broad; wide; width, breadth
пиджак	coat, jacket
резин (эрзээн)	eraser
саад	obstacle; difficulty; disturbance
саарал	grey
саатуул- (Г1) (саатуулж, саатуулах, саатуулна)	to hinder, delay, prevent; disturb
савхи (н)	morocco leather made from goatskin; saffian leather
сам	comb
самна- (Э2.1) (самнаж, самнах, самнана)	to comb
сахал	beard
соль- (Э2.4) (сольж, солих, солино)	to change, exchange, substitute
сонго- (Э2.1) (сонгож, сонгох, сонгоно)	to choose, elect, select
сэрээ- (Э1) (сэрээж, сэрээх, сэрээнэ)	to wake s.o.
тавиул- (Г1) (тавиулж, тавиулах, тавиулна)	to have s.th. placed, fixed
тайр- (Э2.4) (тайрч*, тайрах, тайрна)	to cut off, clip
тайруул- (Г1) (тайруулж, тайруулах, тайруулна)	to have s.th. cut
танилцуул- (Г1) (танилцуулж, танилцуулах, танилцуулна)	to introduce s.o., to acquaint s.o. with
тасалбар	coupon, receipt
тахлуул- (Г1) (тахлуулж, тахлуулах, тахлуулна)	to have (a shoe) soled
ташаа (н)	side; hip joint
товч (ин) 1.	button
товч 2.	brief, short, abridged
тос (он)	grease, ointment, oil (also for hair)
тослуул- (Г1) (тослуулж, тослуулах, тослуулна)	to smear, apply grease
тус 2.	help, aid, assistance
тус үзүүл-	to render assistance, help

тус бол-	id.
тус хүргэ-	id.
тушаа- (Э1) (тушааж, тушаах, тушаана)	to hand in (money), pay
түрх- (Э2.2) (түрхэж, түрхэх, түрхэнэ)	to smear, anoint
угаа- (Э1) (угааж, угаах, угаана)	to develop (a film)
уна- 1. (Э2.1) (унаж, унах, унана)	to fall, fall down
унага- (Э2.1) (унагаж, унагах, унагана)	to drop, make fall
унагаа- (Э2.1) (унагааж, унагаах, унагаана)	id.
урд (G.)	in front of; (south, in the south)
урьдчилгаа (н)	advanced payment
учир- (Э2.4) (учирч*, учрах, учирна)	to meet, be confronted
үйлчилгээ (н)	service(s)
үнэг (эн)	fox
үнэр	odour, smell
үнэртэй ус	perfume
үсчин	barber
хагар- (Э2.4) (хагарч*, хагарах, хагарна)	to break, fall to pieces
хайч (ин)	scissors
хайчил- (Э2.4) (хайчилж, хайчлах, хайчилна)	to cut, shear
хальс (ан)	film (negative); (skin; membrane; husk; shell)
ханга- (Э2.1) (хангаж, хангах, хангана)	to provide, furnish, supply
ханцуй	sleeve
харагд- (Э2.4) (харагдаж, харагдах, харагдана)	to be seen, visible
харьц- (Э2.2) (харьцаж, харьцах, харьцана)	to have a relation with, connection to
хими	chemical
хойт	back, rear; northern
хөвөн	cotton
хугар- (Э2.4) (хугарч*, хугарах, хугарна)	for long objects to break (in two pieces)
хураалга- (Э2.1) (хураалгаж, хураалгах, хураалгана)	to pay, give payment

хус- (Э2.5) (хусаж, хусах, хусна)	to shave
хууз	whiskers
хүргэ- (Э2.1) (хүргэж, хүргэх, хүргэнэ)	to send, deliver
хэмжээ (н)	measure, size; standard, extent
хэрэгцээ (н)	need(s); necessity
хэсэг	part, portion
цаасанд буулга- цагчин	to copy photographs watchmaker
цахилгаан машин	electric apparatus, appliance
цэвэрлэгээ(н)	cleaning (service)
чухам	reality, actuality; exactly (before interrogatives)
шил (эн)	glass; bottle
шингэл- (Э2.4) (шингэлж, шингэлэх, шингэлнэ)	to rarefy, thin out (hair)
шир (эн)	hide, skin (of great cattle)
шуулга- (Э2.4) (шуулгаж, шуулгах, шуулгана)	to cut short (hair)
эвгүй	inconvenient, inappropriate
эвдэр- (Э2.4) (эвдэрч*, эвдрэх, эвдэрнэ)	to break down, fall to pieces
яалга- (Э2.1) (яалгаж, яалгах, яалгана)	to have s.th. done how

Дуудах

Pronunciation

- [ɔ – ʊ] тог – туг, ор – ур, бор – бур, бос – бус, тор – тур, дор – дур
- [ɔ: -u:] оор – уур, ооно – ууна, бороо – буруу, томоо – томуу, тоо – туу
- [ö – ɔ] өр – ор, төв – тов, бөс – бос, төс – тос, төр – тор, дөр – дор, өд – од
- [ö: – ɔ:] өөр – оор, төө – тоо, төөнө – тооно, өнөө – оноо, хөөсдөх – хоосдох
- [ö – ʊ] өр – ур, өд – уд, бөс – бус, төс – тус, төр – тур, дөр – дур, өс – ус
- [ö: – u:] өөр – уур, өөх – уух, хөөрөг – хуурай, бөө – буу, төө – туу

«Манай хааны мянган мөнгөн бөмбөлөг»

Sentence Patterns

Зарвар

1. Асуулт

Та Чи Тэд нар Декан	хэнд ямар улст (улсад) ямар хүмүүст ямар хүнд	кино жужиг театр пирк ном сэтгүүл	үзүүлсэн бэ?
------------------------------	--	--	--------------

Хариу

Над Тэдэнд оюутанд багш нар монголчуудад	кино жужиг театр пирк ном сэтгүүл	үзүүлсэн.
--	--	-----------

2. Асуулт

Та Чи Багш Дорж	намайг чамайг тэр хүнийг багшийг миний эхнэрийг	явуулах явуулах очуулах очуулах	бэ? бэ?
--------------------------	---	--	------------

Хариу

(Би) (Багш) (Дорж)	чамайг тэр хүнийг багшийг таны эхнэрийг	дэлгүүр лүү гуанз руу сүргүүль рүү ууланд хөдөө хот	явуула. явуула. явуула. очуула. очуула.
--------------------------	--	--	---

3. Асуулт

Та Тэр хүн Дорж багш Дарга Ээж нь	намайг чамайг тэрнийг Сүрэнг Тэр оюутныг хүүгээ	юунд явуулах явуулах	бэ? бэ?
---	--	----------------------------	------------

(Би) (Төр хүн) (Дорж) (Барш)	надаар чамаар танаар Дулмаар эмчээр Доржоор	ном(оо) талх захиа(гаа) үс(ээ) дуу цаг(аа) зураг хэмжээгээ гимнастик гутлаа хөл бөмбөг	уншуулсан. бичүүлсэн. авчруулсан. дуулуулсан. явуулсан. зурдуулсан. засуулсан. авхуулсан. хийлгэсэн. тоглуулсан.
---------------------------------------	--	--	---

Хариу

Та Чи Дорж Барш	Доржоор надаар Дулмаар эмчээр	юу хийлгэсэн бэ? яалтасан бэ?
--------------------------	--	----------------------------------

5. Асуулт

Доржоор Даш багшаар Дорлиг гуайтаар Нэг жүжигчнээр Даргаар Нэг өндөр хүнээр	(захиа) (ном) (бичиг) (илгээлт) (мөнгө) (юм)	явуулна. явуулсан.
--	---	-----------------------

Хариу

багшид Сүрэнд над Дамба гуайд багш нартаа	захиа ном бичиг илгээлт мөнгө юм	хэнээр ямар хүнээр	явуулах бэ? явуулсан бэ?
---	---	-----------------------	-----------------------------

4. Асуулт

(Би) (Төр хүн) (Дорж) (Дарга) (Ээж нь)	чамайг төрнийг Сүрэнг Тэр оюутныг хүүгээ	усанд талханд маханд чихэрт архинд пивонд	явуулна. явуулсан.
--	--	--	-----------------------

Хариу

6. Асуулт

Та Дорж Багш Эмч	Доржийг багшийг намайг чамайг эмчийг ээжийг аавыг тэр хүнийг	юу хийлгэсэн бэ? яалгасан бэ?
---------------------------	---	----------------------------------

Хариу

Би Дорж Багш Эмч	Доржийг багшийг намайг чамайг аавыг эмчийг ээжийг тэр хүнийг	явуулсан. гаргасан. ирүүлсэн. сэрээсэн. босгосон. айлгасан. унтуулсан. саатуулсан.	
		кино жүжиг театр	үзүүлсэн.
		архи цай пиво	уулгасан.

7. Асуулт

Чи Та Дорж Тэд нар	хэмжээ зургаа захиалга тасалбар цамц дээл малгай гутал цүнх	авхуулсан уу? бичүүлсэн үү? хийлгэсэн үү?
-----------------------------	---	---

Хариу

(Би) (Дорж) (Тэд нар)	хэмжээ зургаа захиалга тасалбар цамц дээл малгай гутал цүнх	авхуулсан. бичүүлсэн. хийлгэсэн.
-----------------------------	---	--

8. Асуулт А

Та	хэнээр	хэмжээ зургаа захиалга тасалбар цамц дээл малгай гутал цүнх	авхуулав? авхуулсан бэ? бичүүлэв? бичүүлсэн бэ? хийлгэсэн бэ? хийлгэв?
----	--------	---	---

Асуулт Б

Таны	зургийг хэмжээг тасалбарыг захиалгыг цамцыг дээлийг малгайг гутлыг цүнхийг	хэн	авав? авсан бэ? бичив? бичсэн бэ? хийсэн бэ? хийв?
------	--	-----	---

Хариу А

(Би)	зурагчнаар Доржоор оёдолчноор үйлчилгээний төвөөр эхнэрээрээ	авхуулсан. авхууллаа. бичүүлсэн. бичүүлээ. хийлгэсэн. хийлгэлээ.
------	--	---

Хариу Б

Зурагчин Дорж Оёдолчин үйлчилгээний төв Эхнэр маань	авсан. бичсэн. хийсэн.
---	------------------------------

9. Асуулт

Миний		зураг цамцыг дээлийг цүнхийг гутлыг малгайг	аль хир хэр (хир) зэрэг	гарч вэ? хийж вэ? хийсэн байна вэ?
Тэр Энэ	хүний			

Хариу

Чиний Таны		зураг цамцыг дээлийг цүнхийг гутлыг малгайг	сайхан муу тааруухан зүгээр эвгүй цэвэрхэн	гарч(ээ). хийж(ээ). хийсэн байна.
Тэр Энэ	хүний			

10. Хүсэлт А

Би	таныг даргыг чамайг сайдыг багшийг эмчийг	их саатууллаа, уучлаарай.
----	--	---------------------------

Хүсэлт Б

Би	танд даргад чамд сайдад багшид эмчид	их саад боллоо, уучлаарай.
----	---	----------------------------

Хариу

За, зүгээр.
Зүгээр зүгээр.

11. Асуулт

Та Чи	хаа хэнээр ямар үсчинд	үсээ сахлаа	тайруулав? засуулав? хусуулав?
----------	------------------------------	----------------	--------------------------------------

Хариу

(Би)	их сургуулийн тэндэх зочид буудлын	үсчинд	үсээ сахлаа	засууллаа. тайрууллаа. хусууллаа.
	үсчнээр (үсчингээр) найзаараа Доржоор			

12. Асуулт

Миний Чиний Таны Доржийн	үсийг цагийг дуу хураагуурыг радио бичгийн машиныг	сайн засаж уу?	
		аль хир	засаж вэ? зассан байна вэ?

Хариу

Таны Чиний Доржийн	үсийг цагийг дуу хураагуурыг радио бичгийн машиныг	сайн сайхан муу муухан тааруухан эвгүй	засжээ. зассан байна.
--------------------------	--	---	--------------------------

13. Асуулт

Та	ямар ямар даавуугаар юугаар	цамц пиджак дээл малгай пальто гутал өмд цүнх	хийлгэх юм бэ?
----	-----------------------------------	--	----------------

Та	миний	хувцсыг өлгөж	хувцсыг өлгөж
		сахлыг	хуцаж
		үсийг	засаж тайрч тослож авч
		цагийг машинныг дуу хурааруурыг	засаж
		район	

Хүсэнт Б

(Б)	үсээ	цаг(аа) бичгийн машин(аа) дуу хурааруур(аа) район(гоо)	засуулъя.
		засуулъя. тайруулъя. тослуулъя. авхуулъя.	засуулъя.
		хувцсаа өнгүүлбэ.	хуцаж хуруулъя.

14. Хүсэнт А

(Б)	ноосон даавуу монгол ширэн савхин үнгэсн	ноосон ноосон хөвөн	савхиар ширээр ноосоор	цамц	өмд пиджак малгай гүтэл цүнх	хийлгэнэ, хийлгээ.
				дээл		
				пальто		
				өмд		

Харуу

Хариу А

За (би)	хувцсы	тань чинь	өлгөө.
	сахлы		хусъя.
	үсий		засъя. тайръя. тосолъя. авъя.
	машины дуу хураагууры радиоигий		засъя.

Хариу Б

За (би)	хувцсы	тань чинь	өлгөж.	өгье.
	сахлы		хусаж	
	үсий		засаж тайрч тосолж авч	
	машины дуу хураагууры радиоигий		засаж	

15. Хүсэлт

Энэ	өмд дээл цамц малгай	над чамд Доржид	томдож томдоод	байна, байгаа юм,	жаахан	багасгамаар багатгамаар	байна.
-----	-------------------------------	-----------------------	-------------------	----------------------	--------	----------------------------	--------

Хариу

Чамд Танд Доржид	энэ	өмд дээл цамц малгай	томдож байгаа бол	би	багасгаж багатгаж	өгье.
------------------------	-----	-------------------------------	-------------------	----	----------------------	-------

16. Хүсэлт

Энэ	өмд дээл цамц малгай	над чамд Доржид	багадаж багадаад жигигдэж жигигдээд	байна, байгаа юм,	жаахан	томсгомоор томтгомоор	байна.
-----	-------------------------------	-----------------------	--	----------------------	--------	--------------------------	--------

Маргаш Удахгүй 15-нд Бямбад	явна. ирна. бүгна. гарна.	байх. юм шиг байна. нб.
	явах бүцах ирэх гарах	

Харуу

Тар Тал нар Дорж Дулмаа	жүжит кино ном	хэзээ	явах бүцах ирэх	нб	вэ?
	хэлэнд				

18. Асуу

Тэвэл энэ	дээли пальтоги цамцы өмдий хувцсы	чнь тань	би	нарийсаад нарийтаад богиностоод богиртаад уртасаад уртаад	өвч.
	пальто цамц өмд хувцас				

Харуу

Энэ	дээл пальто цамц өмд хувцас	над	үрдэж богинодож нарийндаж	байна!
	дээл цамц өмд хувцас			

17. Хувант

Чамд Танд Доржид	энэ	дээл цамц малгай	багадаж багадад жигийдэж жигийдээд	бол байтаа	би	томстож томтож	өвч.
	дээл цамц малгай						

Харуу

19. Асуулт

Чи Та	(одоо) нэг цагт таван минут болоод маргааш	явах буцах гарах хэлэх унших	нь	уу? үү?
	үсээ засуулах усанд орох кинонд явах			

Баталсан хариу

Үгүйсгэсэн хариу

а) Тэгье	ээ. аа.	а) Үгүй ээ.	явахгүй. буцахгүй. гарахгүй.
б) Тэгнэ Явна Буцна		б) Үгүй ээ,	
в) Гарна Хэлнэ Уншина		в) Арай болоогүй Хоёр цагт буцна Нөгөөдөр явна	аа. ээ.

20. Асуулт

Чи та	одоо	явах унших гарах бичих буцах унтах харих	нь	уу? үү?
----------	------	--	----	------------

Батлах хариу

Үгүйсгэх хариу

Тэглээ! Явлаа! Буцлаа! Харилаа! Уншлаа! Унтлаа!	а) Үгүй үгүй! Гүй гүй!	
	б) Арай болоогүй ээ.	
	в) Явахгүй Гарахгүй	ээ! аа!

21. Мэдээлэл

Би одоо	явлаа! гарлаа! буцлаа! унтлаа! хэвтлээ!
---------	---

Хариу

а)	Тэг тэг!
б)	Тэг дээ тэг!
в)	За.
г)	За, яв даа. За, гар даа.
д)	Азна! Жаахан азна! Жаахан азнахгүй юү? Жаахан байзна! Жаахан байзнахгүй юү?

22. Асуулт

Би	маргааш одоо	энд хичээлдээ тийшээ	ирэх байх явах	уу? Үү? хэрэгтэй юү? ёстой юү?
	чамтай танайд энэ номыг энийг		уулзах очих унших цээжлэх	болох уу?
			ирж уулзаж байж очиж цээжилж явж уншиж	

Батлах хариу

а)	Тэг. Ир. Бай. Яв. Уулз....
б)	Хэрэгтэй. (хэрэгтэй байлгүй яах вэ!)
в)	Ёстой (ёстой байлгүй яах вэ!)
г)	Болно (бололгүй яах вэ!)

Үгүйсгэсэн хариу

а)	Юу хийх вэ! Юүхэв!
----	-----------------------

б)	Болохгүй(ээ).
----	---------------

Чиг Та Дорж Дулмаа	тэр хүнтэй Дулмаатай Доржтой	тэр	юм! =	танлицмаар уламгаар сугмаар уншмаар үзмээр	юм! =	танлицуштай уулагуштай сугтууштай уншууштай үзүүштай	юм!
		кинот номыг					

24. Санаа

в) Тэгвэл	би	танлицмаар байна. танлицна (аа). танлицпах юмсан.
-----------	----	---

а) Тийм үү?
б) Нэрэн үү?

Хариу

Энэ Тэр	хүн батш хүүхэн кино ном	танлицмаар хараад баймаар үзмээр уншмаар	=	танлицуштай хараад байгууштай үзүүштай уншууштай	хүн батш хүүхэн кино ном	шүү!

23. Мэдэвэл

Ирж Байж Явж	болохгүй.
--------------------	-----------

д)

(Юү хийх вэ?), (Юүхэв!),	ирэлгүй. явалгүй. байлгүй. уулаалгүй. оонилгүй. уншилгүй. цээжлэлгүй.	=	ирээд яваад байгаад уулаад оооод уншаад цээжлээд	вах вэ!
-----------------------------	---	---	--	---------

в)

г)

1-р яриа: Үсчинд

- Сайн байна уу Та? Хүн ихтэй юү?
- Сайн, сайн байна уу? Та үсээ засуулах нь уу?
- Тийм ээ, хувцасны өлгүүр хаана байна?
- Тэр буланд байна. Та тэнд хувцсаа өлгөчих дөө.
- За, цүнхээ яах вэ? Аваад орох уу?
- Тэг тэг.
- Үс засуулах ямар үнэтэй вэ?
- Та яаж засуулах вэ?
- Зүгээр л жаахан багасгаж тайруулмаар байна.
- Тэгвэл хоёр зуун төгрөг. (Та) 5 дугаар үсчинд оч.
- Мөнгөө танд өгөх үү?
- Тэгнэ ээ, та эхлээд үсээ засуулчих. Дараа нь мөнгөө өгдөг юм.
- За, мэдлээ, баярлалаа.

2-р яриа: Үсчинд

- 5-р үсчин та юү?
- Тийм ээ, та суугтун. Үсээ яаж засуулах вэ Та?
- Уртаас нь тайруулж нэлээд багасгамаар байна.
- Хир урт тайрах вэ?
- За, бараг хоёр хуруу (хир) тайрчихгүй юү?
- За. Та их өтгөн үстэй юм аа?
- Тийм ээ. Та жаахан шингэлж өгөхгүй юү?
- За тэгнэ ээ. Сахлаа яаж засуулах вэ?
- Ээ, тэрнийг чинь мартагчаж. Бүр хусуулчихна аа.
- Хуузыг тань захлах уу?
- Захалчих.

(Үсчин үсий нь засаж дуусаад ард нь толь барьж харуулав).

- Сайхан болж ээ. Баярлалаа.
- (Үсээ) тослуулахгүй юү?
- Тослуулалтгүй ээ, юүхэв! (Юу хийх вэ!)
- Үнэртэй ус хийлгэхгүй юү?
- За, юүхэв. Танд их баярлалаа. Баяртай.

3-р яриа: Цаг засварт (цагчинд)

- Сайн байна уу? Энд цаг засдаг уу?
- Тийм ээ, та цаг засуулах нь уу?
- Миний цаг ойрдоо буруу яваад болохгүй байна. Газар унагачихсан чинь шил нь бас хагарчихаж.

(Цагчин цагий нь авч нэлээд үзээд)

- Шил нь хагарсан учраас зүүгээ саатуулж байгаа юм байна. Хэрвээ та засуулъя гэвэл энэ бичгийг кассанд өгөөд мөнгөө хураалгаад тасалбар аваад ирээрэй.
- За, энэ тасалбар авахгүй юү?
- Та нэг тасалбары нь өөрөө ав.
- Хэдийд гарах вэ?
- Нөгөөдөр, хэдэн цагт ч болно.

4-р яриа: Цагчинд

- Та миний цагийг үзээд өгөхгүй юү?

(Цагчин цагийг задалж нэлээд үзээд)

- Гол нь хугарсан байна.
- Тэгвэл засаж болохгүй юү?
- Болно болно. Голы нь солих хэрэгтэй дээ.
- За, хэзээ авч болох вэ?
- Би одоо солиод өгнө.

5-р яриа: Хувцас захиалга

- Хувцас захиалгын газар хаана байдаг юм бэ?
- Их дэлгүүрийн тэнд байдаг. Чухам юу захиалах гэсэн юм бэ?
- Би савхин цамц хийлгэмээр байна. Аятайхан даавуу байвал костюм ч захиалах санаатай.
- Тэгвэл өвлийн хувцасны захиалга авч байна уу? (Чи мэдээдхээрэй)

(Тэр хүн, хувцас захиалгын газар ирэв).

- Сайн байна уу? Савхин цамц захиалах гэсэн юм сан.
- Тэгвэл тэр байгаа савхинаас сонгоорой.
- Би энэ хүрэн савхиар хийлгэе.
- Та мөнгөө өгөөд / тушаагаад хэмжээгээ авхуулаарай.
- Үйлчлэгч ээ, би урьдчилгаа болгож хоёр мянган төгрөг тушаая.
- За, энэ тасалбар аваарай.
- Та миний хэмжээг авахгүй юү?
- Тэгье, эхлээд цээжний өргөн, ханцуйн хэмжээ авъя. Одоо ханцуйн урт, мөрний хэмжээг авъя. Уртхан хийлгэх үү?
- Үгүй ээ, богиновтор (бас) зах нь дөрвөлжин байвал сайн. Талдаа 4 товчтой хийлгэе.
- Болно оо.

6-р яриа: Хувцас захиалга

- Сайн байна уу? Би костюм захиалах гэсэн юм. Сайн даавуу бий юү?
- Бий, бий. Та энэ даавуунаас үз л дээ.
- Энэ саарал даавуугаар хийлгэвэл зуны цагт зүгээр байх.

- Та энэ даавуугаа аваачиж үзүүлээд захиалга бичүүлээд ир.
- Би костюм захиалъя. Даавуу нь энэ байна.

(Мөн овог нэр, хаягаа бичүүлээд мөнгөө хураалгаж тасалбар аваад, хэмжээ авагч дээр очив).

- Энэ тасалбараа та аваарай. Дараа ирж загвар өмсөхдөө үзүүлээрэй. Одоо хэмжээгий тань авъя. Нуруу, цээж, бэлхүүс, ханцуй, ташааны урт өргөний хэмжээгий тань авлаа. (Та долоо хоноод ирж загвар өмсөж үзээрэй).
- За баярлалаа.

7-р яриа.

- Та зургаа хаана авхуулсан бэ?
- Би энэ зургийг түргэн зурагчинд авхуулсан юм. Ямар гарсан байна?
- Сайхан гарсан байна. Түргэн зурагчин хаана байдаг юм бэ?
- Би та хоёрт зааж өгье. Гурвуулаа хамт явъя.
- Бид хоёр түргэн зураг авхуулмаар байна. Эндээс хол уу?
- Холгүй ээ, их сургуулийн хажуу талд байдаг юм.

8-р яриа

- Түргэн зурагчин хаана байдгийг та надад зааж өгнө үү?
- Та Түүхийн музейг мэдэх үү?
- Мэднэ.
- Тэгвэл Түүхийн музейн урд талд байдаг юм.
- Сайн байна уу? Би зургаа яаралтай авхуулах гэсэн юм сан.
- (Та) ямар зураг авхуулах вэ?
- (Би) паспортын зураг авхуулмаар байна. Ямар үнэтэй вэ?
- 400 төгрөг. За, та ингэж суугаад над руу хараарай! Анхаараарай! Дарлаа шүү! Боллоо.
- Зурагчин гуай аа, зураг хэдийд гарах вэ?
- Одоохон, 5 минутын дараа (ирээд аваарай).

9-р яриа: Зурагчин

- Сайн байна уу?
- Сайн. Сайн байна уу?
- Би зургаа авхуулах гэсэн юм сан.
- Та ямар хэмжээний зураг авхуулах вэ?
- 3x4 –ийн (гурав дөрвийн) зураг авхуулмаар байна. Ямар үнэтэй вэ?
- 450 төгрөгийн үнэтэй. За, та энд суу даа. Аль вэ, жаахан жишүү хар! Дарлаа шүү! Боллоо.
- Зургаа хэдийд ирж авах вэ?
- Май, энэ тасалбар. (Та) маргааш өглөө 10 цагт ирээд зургаа аваарай.
- 10 цагт гэнэ ээ?
- Тийм ээ, 10 цагт.

10-р яриа

- Чиний хувцас ямар гоё харагдаж байх юм бэ [xaragdʒe:χi:n]! Хаанаас (худалдаж) авсан бэ [afsi:n]?
- Захиалгаар хийлгэсэн юм [χi:lɛgsi:n] .
- Энд ийм гоё хийж байна [χi: ɕɛ:n] гэж үү! Яасан сайхан оёсон юм бэ [ojsi: n]?
- Эндхийн оёдолчингууд (оёдолчид) маш сайн хийж байна [χi: ɕɛ:n]. Тэгээд бас хямды нь яана!
- Чи хэдийг төлсөн бэ?
- Ердөө л 35 доллар. Германд би ийм костюм хийлгээд зуу гаруй доллар төлж байсан юм даа [tɔldʒɛ:si:mda:].

Text

Бичвэр

1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРУУД

Үйлчилгээний газруудад үсчин, зурагчин, гутал засвар, хими цэвэрлэгээ, цагчин, нүдний шил, хувцас захиалга зэрэг хүний өдөр тутмын хэрэгцээг хангах газрууд орно. Энэ бүгд хүний сайн сайхан амьдралд тус болдог. Жишээлбэл, та үсчинд очиж үсээ сайхан засуулбал, олны дунд аятайхан харагдах болно. Зарим үед цаг тань эвдэрвэл, ажилдаа очих, хичээлдээ явах, хүнтэй уулзах гэх мэт маш олон юманд саад учирна. Тийм үед цагчин таны цагийг засаж өгдөг. Мөн паспортын болон том бага зураг хэрэгтэй болох, найз нөхөдтэйгөө хамт дурсгал болгож, зураг авхуулахад зурагчин хүн тус хүргэдэг. Ер нь үйлчилгээний газрын улс хүнд байнга тус хүргэж байдаг билээ.

2. УЛААНБААТАРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Улаанбаатарт үйлчилгээний төв олон бий. Гэднээс нэгий нь та нарт танилцуулъя. «Урт цагаан» гэдэг төв Улсын их дэлгүүрийн хойно бий. Тэнд цаг засвар, үсчин, зурагчин, гутал засвар, хувцас захиалга, хими цэвэрлэгээ гэх мэт олон төрлийн үйлчилгээний газар байдаг. Үсчнээр ороод үзье. Үсчнүүд үс засаж, сахал хусаж, үс будаж байх бөгөөд хайчаар хайчилж, самаар самнаж, цахилгаан машинаар машиндаж, үсний тос, үнэртэй ус түрхэж харагдана. Зурагчнаар орвол хүмүүс том жижиг янз бүрийн хэмжээний ерийн болон өнгөт зураг авхуулж байна. Зурагчин хүн зураг авсан хальсаа угаагаад дараа нь цаасанд буулгадаг. Цаг засварт ч гэсэн олон хүн цагийнхаа гэмтлийг үзүүлж, засуулж байна.

Хувцас захиалгын газар хүмүүс даавуу үзэж, зарим нь хэмжээгээ авхуулж, нөгөө хэсэг нь загвар өмсөж, бэлэн болсон хувцсаа авч байна. Хими цэвэрлэгээнд улс янз бүрийн хувцас өгч байна.

Гутал засварын газар улс гуталдаа зан тавиулна. Гутал засварчнууд гуталд шир тавьж эрзээн (резин) наадаг. Олон хүн гутлаа тахлуулахаар сууж байдаг.

1. Цэгийн оронд зохих үгийг тавь. Fill in suitable words.

1. Хувцас ... хаана байна вэ?
2. Та үсээ яаж ... вэ?
3. Би ... засуулъя.
4. Би үсээ уртаас нь ... байна.
5. Би үсээ нэлээд ... байна.
6. Би ... хусуулна.
7. Би ... тослуулахгүй.
8. Миний цаг ... явж байна.
9. Таны цагийн шил ... байна.
10. Таны цагийн зүүний гол нь ... байна.
11. Би пальто
12. Би ... цамц хийлгэх гэсэн юм.
13. Та костюмныхаа ... маргааш ирж өмсч үзээрэй.
14. Би ... хэмжээний зураг авхуулна.
15. Би зургаа ... авхуулсан.

2. Цэгийн оронд 'бол-, болго-' гэсэн хоёр үйл үгийн аль тохирохыг зохих хэлбэрт нь оруул.

1. Би маргааш ирэх
2. Би энэ номыг тэр хүнд дурсгал
3. Багш нэг өгүүлбэрээр жишээ
4. Бид савхин дээл захиалах
5. Би багш
6. Би Монголоос авчирсан номоо найздаа бэлэг
7. Нөгөөдөр та цагаа цагчнаас авах ... уу?
8. Үсчин үсий минь сайхан
9. Бид хоёр хамт өнгөт зураг авхуулах
10. Дулмаа гуай бага охиноо оёдолчин ...

3. Асуултад үлгэрийн дагуу хариул. Answer the questions using the model.

ҮЛГЭР А: Та үс засдаг уу?
 БИ ҮСЭЭ ЗАСУУЛМААР БАЙНА.
 (БИ ҮСЭЭ ЗАСУУЛАХ ГЭСЭН ЮМ).

1. Та зураг авдаг уу?
2. Та (бичгийн) машинаар бичдэг үү?
3. Та биеийн хэмжээ авах уу?
4. Та пальто цэвэрлэдэг үү?
5. Та сахал хусдаг уу?

6. Та гутал тахлах уу?
7. Та цүнх засдаг уу?

ҮЛГЭР Б: Та цүнх хийх үү?
БИ ЦҮНХ ХИЙЛГЭМЭЭР БАЙНА.

1. Та англи хэл заах уу?
2. Та юм угаах уу?
3. Та эрзээн (резин) наах уу?
4. Та мөнгө хураах уу?
5. Та загвар хийдэг үү?
6. Та дээл хийдэг үү?
7. Та цүнхэнд засвар хийх үү?
8. Та миний гар утсанд ялтас хийх үү?

4. Асуултад үлгэрийн дагуу хариул. Answer the questions using the model.

ҮЛГЭР А: Таны үсийг жаахан тайрчих уу?
ТЭГ, ТАЙРЧИХ.
ЮУХЭВ, ТАЙРАЛТГҮЙ.

1. Таны сахлыг хусчих уу?
2. Сахлыг тань хусах уу?
3. Хуузыг тань захалчих уу?
4. Энд таны нэрийг тавьчих уу?
5. Энэ дэвтрийг Доржид өгчих үү?
6. Танд энэ даавуугаар өмд хийчих үү?
7. Дорж оо, энийг тэнд тавьчих уу?
8. Би багшаас асуучих уу?
9. Би энэ аягатай цайг уучих уу?
10. Би тэрүүнд хэлчих үү?

ҮЛГЭР Б: Чи цагаа унагаачихаа юу? (Унагаачихсан уу?)
ТЭГСЭН, УНАГАЧИХСАН. (УНАГААЧИХСАН)
ҮГҮЙ ЭЭ, УНАГААГҮЙ. (УНАГААГААГҮЙ)

1. Чи өнөөдөр үсээ засуулчихаа юу?
2. Та захиалсан цамцаа авчихаа юу?
3. Дорж зургаа авхуулчихсан уу?
4. Батсүрэн өнөөдөр унтчихаа юу?
5. Дорж сургуульдаа явчихаа юу?
6. Чи хоолоо хийчихээ юу?
7. Чи цайгаа чаначихаа юу?
8. Та сүүгээ уучихсан уу?
9. Тэр хүүхэн явчихсан уу?

5. «Үйл үг + -ж, -ч орхи-» хэлбэрийг Replace the verb forms using the model.
«үйл үг + -чих-» хэлбэрээр соль.

ҮЛГЭР: Би бичиж орхисон. БИ БИЧЧИХСЭН.
 Би бичиж орхилоо. БИ БИЧЧИХЛЭЭ.
 Би бичиж орхино. БИ БИЧЧИХНЭ.
 Би бичиж орхиж. БИ БИЧЧИХЭЖ.
 Би бичиж орхио юу? БИ БИЧЧИХЭЭ ЮУ?

1. Нөгөө хүн чинь явж орхижээ.
2. Нөгөө хүүхэн чинь ирж орхисон байна.
3. Эмч явж орхиж.
4. Дорж маш түргэн уншиж орхив.
5. Би тэрнийг орчуулж орхино.
6. Би дасгалаа хийж орхилоо.
7. Тэр хүн бас л архи ууж орхио юу?
8. Тэд нар кинонд явж орхио юу?
9. Долгор нөгөөх шүдээ авхуулж орхисон шүү.
10. Ганбаатар аа, нар гарч орхиж, босоорой.
11. Дэлгүүр онгойж орхижээ, хоёулаа очье!
12. Тэд нар кинонд явж орхио юу?

6. «Үйл үг + -аад⁴ орхи-» хэлбэрийг Replace the verb forms using the model.
«үйл үг + -аадах⁴» хэлбэрээр соль.

ҮЛГЭР: Аль вэ, би бичээд орхиё. АЛЬ ВЭ, БИ БИЧЭЭДЭХЬЕ.
 Чи миний захиалсан цамцыг аваад орхиорой.
 ЧИ МИНИЙ ЗАХИАЛСАН ЦАМЦЫГ АВААДХААРАЙ.

1. За, би нэг гараад орхиё.
2. Аль вэ, би үзээд орхиё.
3. Энэ цаг явахгүй байна. Чи нэг үзээд орхиоч!
4. Номын сан хэдэн цагт хаахыг асуугаад орхиорой.
5. Найзад минь энийг өгөөд орхиорой.
6. Би орчуулаад орхих уу?
7. Дуламсүрэн ээ, хаалгаа хаагаад орхи.
8. Дуламсүрэн ээ, чи хаалгаа онгойлгоод орхиоч!
9. Таны утсаар нэг яриад орхих уу?
10. Чамаас нэг юм асуугаад орхих юм сан.

7. Цэгийн оронд, хаалгандхи үгийн Use a suitable word in the brackets.
аль тохирохыг хэл.

1. Доржийн дээл нь ... Багасгамаар юм. (томджээ, томсчээ)
2. Энэ малгай миний эхнэрт ... байгаа юм. Өөр томхон малгай хэрэгтэй байна. (багасаж, багадаж)

3. Энэ пиво над ... байна. Хагасы нь чи ав. (ихсэж, ихдэж)
4. Би Доржийн дээлийг ... өгнө. (томсгож, томдуулж)
5. Энэ цамцны ханцуйг ... байна. (өргөтгөмөөр, өргөсгөмөөр, өргөдүүлмээр)
6. Энэ хоол над ... байна. Та хагасы нь авахгүй юү? (ихдэж, ихтгэж, ихдүүлж)
7. Өдөрт сурдаг үг ... байна. Нэлээд олон болгомоор байна. (цөөдөж, цөөсөж)
8. Бидний нэг хичээлд сурдаг үг цөөдөж байна, ... хэрэгтэй байна. (олтгох, олон болгох, олдуулах)

8. Цэгийн оронд, хаалтандхи үгийн аль тохирохыг хэл.

Use a suitable word in the brackets.

1. Багш ... ангидаа байна уу? (чиний, чинь)
2. Доржийн эхнэр ... ирлээ. (чинь, нь, тань)
3. Би сая тасагтаа очсон ... нэг шинэ оюутан ирчихсэн байна. (чиний, чинь)
4. Дүүгээс ... захиа ирсэн үү? (чинь, чиний)
5. ... цагийг би унагачихлаа! (чинь, чиний)
6. Би цагийг ... унагачихлаа! (чинь, чиний)
7. Миний цаг буруу явдаг боллоо. Энэ муу цагийг ... өнөөдөр цагчинд тушаачихъя. (чинь, чиний)
8. (Би) шүдээ авхуулчихсан ... юм идэхэд хэцүү байна. (чиний, чинь)
9. (Би) өмсч үзэлгүй нэг цамц авчихсан ... томдоод болохгүй байна. (чинь, чиний)
10. Энэ ... чиний үзэг шив дээ? (чинь, чиний)
11. Энэ үзэг ... миний үзэг байна. (чинь, чиний)

9. Өгүүлбэрийг үлгэрийн дагуу холбож хэл (А, Б, В гурван хэсгийг харьцуулж үз).

Join the sentences using the model (compare the models A and B).

ҮЛГЭР А (Нэг үйлдэгчтэй өгүүлбэрүүдийн холбоо. – Sentences with one subject/actor.)

Миний үсийг нэг үсчин зассан. Тэр үсчин энэ байна.
МИНИЙ ҮСИЙГ ЗАССАН ҮСЧИН ЭНЭ БАЙНА.

1. Миний үсийг нэг авгай тайрсан. Тэр авгай бол үсчний сургуулийн багш.
2. Миний дээлийг нэг эмэгтэй хийсэн. Тэр эмэгтэй бас ямар ч европ хувцсыг хийж чадна.
3. Дулмаагийн үсийг нэг найз хүүхэн нь будаж өгсөн. Тэр найз хүүхэн нь одоохон манай тасагт ирнэ.
4. Бидний зургийг нэг зурагчин авна. Тэр бол жинхэнэ мэргэжлийн зурагчин юм.
5. Надад нэг хүн өчигдөр монгол дуу заасан. Тэр хүн чамд бас дуу заах гэнэ.
6. Надтай нэг зураач ирж уулзсан. Тэр зураачийг чи сайн танина.
7. Дулмаад нэг хүн интернетээр их гоё захиа бичдэг байсан. Тэр нь монгол хэл сайн мэддэг гадаадын хүн байсан.
8. Маргааш нэг багш бидэнд орчуулгын хичээл заана. Тэр багшаас энийгээ асуу.

ҮЛГЭР Б (Хоёр үйлдэгчтэй өгүүлбэрүүдийн холбоо. – Sentences with two subjects/actors.)

Би нэг багшид ном өгсөн. Тэр багш энэ байна.

МИНИЙ НОМ ӨГСӨН БАГШ ЭНЭ БАЙНА.

1. Би савхин дээл захиалсан. Тэр захиалгын газар энд бий.
2. Доржийн үсийг нэг хүн тайрсан. Тэр хүн одоо ирнэ.
3. Бидний зургийг нэг хүн авна. Тэр хүн өнөөдөр ирэхгүй.
4. Би нэг хүнээр дуу заалгасан. Тэр хүнийг чи танина.
5. Би нэг хүүхэнтэй танил байсан. Тэр хүүхэн энд байхгүй байна.
6. Бадмын цагийг нэг өндөр хүн зассан. Тэр хүн их сайн цагчин.
7. Би өчигдөр нэг хүнээр монгол дуу заалгасан. Тэр хүн чамд бас дуу заах гэнэ.
8. Би нэг зураачтай очиж уулзсан. Тэр зураачийг чи сайн танина.
9. Дулмаа нэг хүнд интернетээр их гоё захиа бичдэг байсан. Тэр нь монгол хэл сайн мэддэг гадаадын хүн байсан.
10. Бид маргааш нэг багшаар орчуулгын хичээл заалгана. Тэр багшаас энийгээ асуу.

ҮЛГЭР В (Хоёр үйлдэгчтэй, хаматуулахын нөхцөлтэй өгүүлбэрүүдийн холбоо – Sentences with two subjects / actors and possessive suffix)

Би нэг үсчнээр үсээ засуулсан. Тэр үсчин энэ байна.

МИНИЙ ҮСЭЭ ЗАСУУЛСАН ҮСЧИН ЭНЭ БАЙНА.

1. Би нэг авгайгаар үсээ тайруулсан. Тэр авгай бол үсчний сургуулийн багш.
2. Би дээлээ нэг эмэгтэйгээр хийлгэсэн. Тэр эмэгтэй бас ямар ч европ хувцсыг хийж чадна.
3. Дулмаа нэг найз хүүхнээрээ үсээ будуулсан. Тэр найз хүүхэн нь одоохон манай тасагт ирнэ.
4. Бид зургаа нэг зурагчнаар авхуулсан. Тэр бол жинхэнэ мэргэжлийн зурагчин юм.
5. Би нэг хүнээр цагаа засуулсан. Тэр хүн бол тийм сайн цагчин биш.
6. Цэнд нэг цагчинд цагаа өгсөн. Тэр цагчин Их сургуулийн дэргэд байдаг.

10. Цэгийн оронд асуух өгүүлбэр **Fill in interrogative sentences.**
бич.

1. – ...? Өнөөдөр хүн цөөн байна. Та ор ор!
2. – ...? Тэгье ээ, би үсээ засуулъяа.
3. – ...? Хувцасны өлгүүр тэр буланд байна.
4. – ...? Тийм ээ, би хоёр сар үсээ засуулаагүй байгаа юм.
5. – ...? Тайр тайр!
6. – ...? Хусалтгүй, юүхэв!
7. – ...? Хими цэвэрлэгээнд хувцас угаалгахад нэлээн үнэтэй шүү.
8. – ...? Би хувцсаа өөрөө угаадаг.
9. – ...? Миний хувцсыг эхнэр минь угааж өгдөг юмаа.

10. – ...? 4×6 –гийн хэмжээний зураг хоёрыг авчраарай.
11. – ...? Тэр хүн их сайн хүн шүү.
12. – ...? Би зураг авч чаддаггүй. Зургийн аппарат ч байхгүй.
13. – ...? Үгүй ээ, энэ цамцыг миний эхнэр хийгээгүй юм.
14. – ...? Тийм ээ, энэ цамцыг эхнэр минь эгчээрээ хийлгэж өгсөн юм.
15. – ...? Үгүй, үгүй. Та над саад болоогүй байна.
16. – ...? За, би танд энийг сайн ойлгуулж өгье.
17. – ...? Тэр бүжгийн жүжгийг би нэг үзсэн юм шиг байна.
18. – ...? Тийм ээ, тэр хүн намайг мэддэг юм шиг байна.
19. – ...? Тэгсэн. Урьдчилгаанд 1500 төгрөг тушаасан (өгсөн).
20. – ...? За тэгье. Урьдчилгаа болгож 2000 төгрөг тушаая (өгье).

11. Орчуулах.

Translation.

Үйлчилгээний газар

Батын үс засуулмаар болжээ. Тэгээд үйлчилгээний төв рүү явлаа. Хэд хоногийн өмнө бас цагаа эвдчихсэн учир цагаа ч гэсэн засуулчихъя гэж бодоод авч явлаа. Бат бас хувцас захиалгын газраар орж аятайхан хувцас захиалъя гэж нэлээд мөнгө авч гарлаа. Бат үсчингээр орж үсээ засуулж тослуулаад цагаа цагчинд өглөө. Дараа нь сайхан өнгөтэй даавуугаар костюм захиалж урьдчилгаа мөнгөө өгөөд, замдаа гэрэл зурагчнаар орж зургаа есийн зураг авхуулчихаад эргэж ирлээ. Энэ бүтэн сайн өдөр Бат их юм хийж (бүтээж) чадав.

12. Асуултад хариул.

Answer the questions.

1. Та ямар ямар үйлчилгээний газрыг мэдэх вэ?
2. Үсчин хүн юу хийдэг вэ?
3. Ямар ямар зурагчин байдаг вэ?
4. Та үсээ яаж засуулдаг вэ?
5. Хувцас захиалгын газар хаана байдаг вэ?
6. Түргэн зурагчин хаана байдаг вэ?
7. Хувцас яаж захиалдаг вэ?
8. Таны цаг яагаад эвдэрсэн бэ?
9. Зурагчин хүн зураг яаж авдаг вэ?
10. Та зургаа хаана авхуулсан бэ?
11. Ямар өнгөтэй савхиар цамц хийлгэх дуртай вэ?
12. Та үсчинд хэзээ очсон бэ?
13. Та үсчинд сард хэдэн удаа очдог вэ?
14. Та зургаа хэзээ авхуулсан бэ?
15. Та бэлэн хувцас авах уу, захиалах уу?
16. Таны цаг хуучин уу, шинэ үү?
17. Таны цаг зүгээр үү, та цагаа засуулах уу?
18. Та бэлэн гутал авах уу, захиалгаар хийлгэх үү?
19. Та гуталдаа резин наалгасан уу, шир тавиулсан уу?

- | | |
|---|---|
| 1. «Үйлчилгээний газрууд»,
«Үйлчилгээний төв» бичвэрийг
цээжээр ярь. | Learn the texts by heart. |
| 2. Яриануудыг тогтоо. | Learn the conversations by heart. |
| 3. Өөрийнхөө хотын үйлчилгээний
тухай жижиг зохиол бич. | Write a short essay about “services” in
your town. |
| 4. «Үсчин», «Гутал засвар»,
«Хувцас захиалга», «Цаг засвар»
сэдвүүдийн аль нэгээр яриа
зохиож ярь. | Prepare a conversation about the
barber’s shop, shoe repair shop and
watch repair shop. |
| 5. Орчуулах. | Translate into Mongolian: |
1. Where is the barber’s? – The barber’s is in the area of the Centre of Services.
 2. How much is a haircut? – If you have your hair trimmed a little, two hundred tugrugs, but it can also be more expensive.
 3. Would you trim my hair to the length of two fingers? – Certainly.
 4. My hair is too thick. – Would you make it a little thinner? – O.K.
 5. Will you want me to apply grease on your hair? – O.K., but I will not have perfume.
- * * *
6. The glass of my watch has broken. Would you repair it? – Let me see.
 7. Your watch must be repaired. The axle has also broken. – Can it be repaired?
 8. Oh yes (it is possible). – Then I will have it repaired.
 9. When can I come and obtain it? (You may come) any time tomorrow or the day after tomorrow.
 10. Thank you, goodbye. – Goodbye.
- * * *
11. I would like to order trousers. Do you have the material? – We do, you can choose from that material.
 12. When will the trousers be ready? – Come for a fitting in a week. Two days later the trousers will be ready.
- * * *
13. Do you make coloured pictures here? – Certainly. (Why should we not?)
 14. I want to have two photographs made of these children, size 9 × 12. – (Kindly) wait a bit. When a customer (lit.: person) leaves, you can have their pictures taken.

Хэлзүй

Grammar

1. Independent forms of the genitive

It is formed by adding the suffix *-x* to the genitive case. In this manner a new nominative arises and therefore the form can stand independently. If this form occurs in another case, the final suffix *-x* is preserved (even in the D.-L., as against the forms used in the sense 'our family' etc., see L3, Gr. 1):

<i>маргаашийн-х</i>	the one of tomorrow (Nom.)
<i>маргаашийн-х-ыг</i>	the one of tomorrow (Acc.)
<i>маргаашийн-х-ад</i>	in the one of tomorrow (D.-L.)
<i>өнөөдрийн-х-ийг</i>	the one of today (Acc.)

2. Derivation of adjectives

a) Doubling the first syllable with an added *-ө* intensifies the quality expressed by the adjective (mainly with colours):

<i>нов ногоон</i>	completely green, bright green
<i>цав цагаан</i>	completely white, snow white
<i>ув улаан</i>	completely red, scarlet red
<i>шив шинэ</i>	completely new, brand new
But: <i>тас хар, хав хар</i>	completely black, pitch black

b) The quality can also be increased by the suffix *-өтөр*⁴:

<i>дулаавтар</i>	rather warm, somewhat warm
<i>богиновтор</i>	rather short, somewhat short

3. Cases

The *instrumental* in its temporal meaning (L5, Gr. 3) can also imply an approximate period of time:

шинэ жилээр

шинэ жилийн үед (үеэр)

at the time of the New Year, around the New Year

Special form: *өглөөгүүр*

in the morning, sometimes in the forenoon

4. Temporal clause

The verbal forms in *-хлаар*⁴ (*converbum successivum* according to Poppe) have in particular a temporal meaning: 'as soon as, when'. The possessive suffixes / particles *аа*⁴ and *нь* are used with this form according to the same principles explained above (L7, Gr. 11). In purely colloquial language, however, it is possible to use the form *-хтай зэрэг*, which has the same meaning:

Хичээл завсарлахлаар уулзъя.

Хичээл завсарлахтай зэрэг уулзъя. Let's meet, when the lesson finishes.

In colloquial language the form *-хлаар*⁴ is sometimes simplified to *-хаар*⁴ (*converbum comparativum* according to Poppe), which expresses purpose. Due to this mingling, even the *converbum successivum* can be used to express purpose in colloquial language. It is perhaps not advisable to imitate this use of language, but it is necessary to understand it.

5. Nomen perfecti

Nomen perfecti in the accusative (see also L11, Gr. 7c) has the function of an object clause:

Би цас орсныг мэдээгүй.

I did not know it was snowing.

Би машин ирснийг мэдээгүй.

I did not know that the car had come.

Би Доржийг ирснийг мэдээгүй.

I did not know that Dorji had come.

Ирсний нь мэдсэн.

I knew he had come.

Өчигдөр ирснээ над хэлсэн.

He told me he had arrived yesterday.

6. Increasing the degree or the quality

In Mongolian there are two words *тусам*, *тусмаа* (written language) and *нутам* 'each', which are placed after words expressing degree or quality. The respective phrase corresponds to English 'the more... the more', etc. Sometimes the above words can also be placed after verbs and the phrases are translated by the respective verbal or noun phrases (day by day, and the like):

Өдөр ирэх тусам дулаарна.

It is getting warm day by day.

Дулаарах тусам цас хайлна.
Салхи салхилах тусмаа сайн.
Олон тусмаа сайн.

The warmer it is, the more the snow melts.
The more the wind blows, the better.
The more the better.

7. Syntactic differences of the *converbum perfecti* and *converbum imperfecti*

The difference of these two forms is more conspicuous in a sentence finished by a negative verb form. *Converbum perfecti* shares the negative meaning of the final verb, while *converbum imperfecti* preserves its positive meaning:

Заримдаа цас ороод хүйтрэхгүй
байдаг.

Sometime it is snowing and (but) it does
not get cold.

Заримдаа цас орж хүйтрэхгүй
байдаг.

Sometimes it is not snowing, neither does
it get cold.

Compare also the following:

Заримдаа цас орсон ч (гэсэн)
хүйтрэхгүй байдаг.

Sometimes it does not get cold even
though it is snowing.

Заримдаа цас ч орохгүй, хүйтрэх ч
үгүй байдаг.

Sometimes it is not snowing, neither does
it get cold.

8. a) Phrases with postponed *зарим*

This word is placed after a word in G. in a phrase appearing as an object in the sentence. In that case *зарим* takes the form of the accusative. In colloquial usage, *заримыг* is followed by *нь* (with the corresponding change in the form of the accusative suffix) (cf. Pattern No. 22 B).

Би энэ олон оюутны заримы нь
танина.

I know some (a few) of these many stu-
dents.

b) Phrases with postponed *цөм, бүгд*

These two words are placed after the main word in an object phrase and the Acc. suffix is added to each member of the phrase in the written style. In the spoken style, however, *нь* can be added after *цөмийг, бүгдийг* (with a corresponding change in the form of the accusative suffix) (cf. Pattern No. 22 Г).

Би энэ олон оюутныг цөмийг
танина.

Би энэ олон оюутныг цөмий нь
танина.

I know all of these many students.

9. Idioms and phrases

Санаа амарлаа.
Та сайн яваарай.

What a relief! (see also L11, Gr. 12)
Good-bye (Lucky journey).

Та сайн сууж байгаарай.
Сайн сайхныг хүсье.
цасаар
цаснаар
бороогоор

борооноор

Good-bye (may you sit/live [here] well).
I wish you all the best. Good luck.
through snow, by snow, with snow
at the time of snowfall
through rain, by rain (as an object, by which
s. th. is done)
at the time of rainfall (cf. L5, Gr. 3)

Vocabulary

Шинэ үг

аажимдаа	slowly, gradually
ааш	character, temperament, manners
ааштай	having a certain character; ill-tempered, ill-mannered
аж ахуй	economy
айлтга- (Э2.1)	to speak respectfully
(айлтгаж, айлтгах, айлтгана)	
амар	peace, quiet; well-being, good health; leisure
амгалан	peace; well-being
амгаланг айлтга- (Э2.1)	salute respectfully, send greetings (also through s. o.)
амрыг эр- (Э2.1)	to greet
(эрж, эрэх, эрнэ)	
амрыг айлтга- (Э2.1)	to greet
(айлтгаж, айлтгах, айлтгана)	
ашгүй	quite good, excellent
баян	rich
боловсор- (Э2.4)	to ripen
(боловсорч*, боловсрох, боловсорно)	
бороо (н)	rain
буу- (Э1) (бууж, буух, бууна)	to descend; to settle down, encamp; dismount (horse), get off (bus etc.)
бүгчим	sultriness; sultry
бэлчээр	pasture, grazing grounds
газар дэлхий	the world, earth
даар- (Э2.4)	to feel cold, shiver
(даарч*, даарах, даарна)	
дадлага	praxis
дулаар- (Э2.4)	to warm up (weather)
(дулаарч*, дулаарах, дулаарна)	
дулаац- (Э2.2)	to warm oneself (e.g. by the fire – галд)
(дулаацаж, дулаацах, дулаацна)	
дундаж	average; (middle size)
дуу (н)	thunder; (sound, noise)
зус- (Э2.5)	to pass the summer
(зусаж, зусах, зусна)	
зуслан (г)	summer camp; summer cottage
мөс (өн)	ice

навч (ин)	leaf, foliage; petal
налгар	calm, quiet; pleasant, relaxing
намар	autumn
намарж- (Э2.3)	to pass the autumn
(намаржиж, намаржих, намаржина)	
нар (ан)	sun
ногоор- (Э2.4)	to turn green, become green
(ногоорч*, ногоорох, ногоорно)	
нойрс- (Э2.5)	to sleep (honor.)
(нойрсож, нойрсох, нойрсоно)	
нутаг	homeland, domicile; pastures
нүү- (Э1)	to nomadize, migrate
(нүүж, нүүх, нүүнэ)	
нүүдэл	movement from place to place, nomadism
онгоц (он)	airplane; (vessel, boat)
онцлог	peculiarity, feature
өвөл	winter
өвөлж- (Э2.3)	to pass the winter
(өвөлжиж, өвөлжих, өвөлжинө)	
өвөлжөө (н)	winter quarters, campgrounds
өвс (өн)	grass; hey
пүүс	shop, store; firm
салхил- (Э2.4)	to blow (the wind)
(салхилж, салхилах, салхилна)	
самар	cedar nut
санаа (н)	thought, thinking; idea
сүүл	tail; end; last, final
тариа (н) 1.	grain, crop
тогт- (Э2.2)	to settle, stop; (about snow) to remain (on the ground)
(тогтож, тогтох, тогтоно)	
төл	newborn young animal
төллүүл- (Г1)	to have (let) cattle produce young
(төллүүлж, төллүүлэх, төллүүлнэ)	
тусам	each; the more ... the more
тутам	each; the more ... the more
түү- (Э1)	to collect, to pick (fruit)
(түүж, түүх, түүнэ)	
температур (халуун хүйтэн)	temperature
тэнгэр	sky, heaven; weather
улирал	season, quarter of a year
унаа (н)	saddle animal(s); means of transport
уна- 2. (Э2.1)	to ride, mount (a horse, etc.)
(унаж, унах, унана)	
урга- (Э2.1)	to grow, sprout
(ургаж, ургах, ургана)	
ургамал	plant, vegetation
ургац	crop, harvest
үдэш	evening (less frequent in colloquial)

үнэндээ	really, in fact, as a matter of fact
ҮР	seed, grain; fruit
хавар	spring
хаварж- (Э2.3)	to pass the spring
(хаваржиж, хаваржих, хаваржина)	
хаваржаа(н)	spring quarters of camp
хагал- (Э2.4)	to plough or till the land; (to break, smash)
(хагалж, хагалах, хагална)	
хадлан (г)	haymaking
хайл- (Э2.4)	to thaw, melt, dissolve
(хайлж, хайлах, хайлна)	
халууц- (Э2.4)	to feel hot, suffer from the heat (man)
(халууцаж, халууцах, халууцна)	
хасах	to reduce, diminish; subtract; minus
хашаа (н)	enclosure, court, yard
хөлд- (Э2.2)	to freeze, be frozen
(хөлдөж, хөлдөх, хөлдөнө)	
хувир- (Г2)	to change
(хувирч, хувирах, хувирна)	
хур	precipitation, rain or snow
хураа- (Э1)	to collect, harvest
(хурааж, хураах, хураана)	
хүйтэн	cold, frost, cool
хүйтэр- (Э2.4)	to cool off, become cold
(хүйтэрч*, хүйтрэх, хүйтэрнэ)	
хүнсний	food (attrib.), related to food
хэвээрээ	as usual, unchanged (in the original form)
хэм (градус)	degree (unit of measurement)
цаг агаар	weather
цас (ан)	snow
цахилгаан 1.б	lightning
цөм	all, everything
цэлмэг	clear, bright, cloudless
шарла- (Э2.1)	to become yellow
(шарлаж, шарлах, шарлана)	
шимэгд-(Э2.2)	to sublimate (about snow)
(шимэгдэж, шимэгдэх, шимэгдэнэ)	
шувуу (н)	bird, fowl
шуурга (н)	storm, blizzard
эв	harmony, agreement, friendship
эмэгтэйчүүд	women
эр- (Э2.1)	to seek, look for; to beg, request; to inquire after s.o.
(эрж, эрэх, эрнэ)	
яагаад гэвэл	because (lit.: 'if you say why')
ямай	fine, good (exclamation expressing satisfaction)

Дуудах

Pronunciation

[ü – u]	үр-ур, бүр-бур, бүс-бус, түг-туг, түс-тус, түр-тур
[ü: – u:]	үүр-уур, үүл-уул, хүүр-хуур, бүү-буу, дүү-дуу, үүсэх-уусах
[ü – ö]	үд-өд, бүс-бөс, түс-төс, түр-төр, түр-дөр, үр-өр, үс-өс
[ü: – ö:]	үүр-өөр, үүд-өөд, үүд-өөд, хүүг-хөөг, бүү-бөө
[ü – э]	үд-од, бүр-бор, түг-тог, түс-тос, түр-тор, дур-дор
[ü: – э:]	зүү-зоо, үүр-оор, зүүлэх-зоолох, үүсэл-оосор, дүүгүүрдэх-доогуурдах

Манай хааны мянган мөнгөн бөмбөлгийг
Мянган мөнгөн бөмбөлөг гэхгүй юм боп
Ямар хааны мянган мөнгөн бөмбөлгийг
Манай хааны мянган мөнгөн бөмбөлөг гэх юм бэ?

Загвар

Sentence Patterns

1. Асуулт

Өчигдөр Нөгөөдөр Өглөө Ирэх долоо хоногт Өдөр Өнгөрсөн долоо хоногт Одоо Ирэх сард Шөнө Дараагийн долоо хоногт Уржигдар Бүтэн сайн өдөр Маргааш	тэнгэр цаг агаар	ямар	байсан бэ? байна вэ? байх бол?
---	---------------------	------	--------------------------------------

Хариу

Өчигдөр Өдөр Уржигдар Шөнө Өглөө Одоо	тэнгэр цаг агаар	сайхан цэлмэг муухай эвгүй	байсан. байна.
Маргааш Нөгөөдөр Ирэх сард Дараагийн долоо хоногт Бүтэн сайн өдөр	цастай бороотой салхитай дулаарах хүйтрэх		гэнэ.

2. Асуулт

Та Дорж	хэзээ	Монголд Улаанбаатарт	энэ хотод энд	ирсэн бэ? ирэх вэ?
		тантай чамтай багштай	уулзсан бэ? уулзах вэ?	

Хариу

(Би) (Дорж)	намар зун өвөл хавар өглөө шөнө өчигдөр уржигдар өнөөдөр	(Монголд) (энэ хотод) (Улаанбаатарт) (энд)	ирсэн. ирнэ.
		тантай чамтай багштай	уулзсан. уулзана.

3. Асуулт

(Та)	ямар аль	улиралд сард өглөөд өдөрт	дуртай вэ?
------	-------------	------------------------------------	------------

Хариу

(Би)	намарт зунд хаварт долдугаар сард өвөлд дөрөвдэх өдөрт нартай өглөөд	дуртай.
------	--	---------

4. Асуулт

Цас орж Бороо орж Салхи гарч Машин ирж Такси ирж Кино гарч Бөх барилдаж Намайг ирж Доржийг ярьж Багшийг ярьж	байхад	та чи Дулмаа	хаана юу хийж	байсан бэ?
			гэртээ унтаж ном үзэж захиа бичиж	байсан уу?

Хариу А

Цас орж Бороо орж Салхи гарч Машин ирж Такси ирж Кино гарч Бөх барилдаж Намайг ирж Доржийг ярьж Багшийг ярьж	байхад	(би) (Дулмаа)	гэртээ унтаж ном үзэж захиа бичиж хоол хийж шатар тоглож	байсан.
---	--------	------------------	---	---------

Хариу Б

(Би) (Дулмаа)	цас бороо	орсныг	чиг ч	мэдээгүй.
	салхи гарсныг машин ирснийг такси ирснийг кино гарсныг таныг ирснийг Доржийг ярьсныг багшийг ярьсныг			

5. Мэдээлэл

Өнөөдөр Танайх Энэ анги Танайх Энэ өрөө	ясан ямар	хүйтэн халуун бүгчим	юм бэ!
---	--------------	----------------------------	--------

Хариу А

Нээрэн	их	хүйтэн халуун бүгчим	байна, та	даарч халууцаж	байна уу?
--------	----	----------------------------	-----------	-------------------	-----------

Хариу Б

Тэгвэл	тэнд		орох очих	уу?
	өөр	байшинд гэрт ангид өрөөнд		
гадаа гудамжинд			гарах уу?	

Хариу В

За тэгье.

6. Мэдэвэл

Өнөө орой / Үдэш Үдээс хойш Маргаш Үдхгүй	нас	орох	байх	аа! шүү!
	борлоо	хүйтрэх дунарах салхи гарах		

Харуу

Тэгэх байх	аа! шүү!
------------	-------------

7. Асуулт (Харуулаж үз)

Дорж	хаа орсон	бэ?
Батш	хайцсан	

Харуу А (Зорилго)

Target

Дорж	сүргүүлдээ кинонд хичээлдээ номын санд ажилдаа манайд дэлгүүрт	явсан. очсон.
------	--	------------------

Харуу Б (Чирлэл)

Direction

Дорж	сүргүүлдээ театр руу дэлгүүр руу манай руу номын санд руу үзэсгэлэн руу	явсан.
------	--	--------

8. Асуулт

Хоёулаа дахинд	хэзээ	хэдийгээр	уулаах	бэ?
----------------	-------	-----------	--------	-----

За, Тэгнэ ээ (Тэгэмэ).

Хариу

Баршийн Даргын Лорж гуайн	амрын амгалант	мэндийг айлгараарай.
---------------------------------	-------------------	-------------------------

10. Хүсэвт

Баярлага, (шнэ) (барын) (шнэ жилийн барын) шнэ жилийн	шнэ	оны (жилийн)
	Танд	бас
	Танд	бас
Хариу	амрын эрвэ; амгалант айлтгай;	байн сайхныг хүсвэ; баяр хүрвэ;

Хариу

Тань	байн сайхныг хүсвэ; шнэ жилийн баяр хүрвэ;
Тань	амрын эрвэ; амгалант айлтгай;
Тань	байн сайхныг хүсвэ; шнэ жилийн баяр хүрвэ;
	шнэ

9. Хүсэвт

Уульва. урильва.	шнэ жилээр патаан сараар патаан сарын үед баяр баярын үед марташ өртөө марташ өртөө шнэ жилийн үед шнэ жилийн үед ирэх өвөл өвлийн үед зүн зүн 9 пата 9 патайн үед
	(Хөёулаа дахийд)

Хариу

11. Хүсэлт

Намайг	багшийн даргын Дорж гуайн	амрыг амгаланг	эрж айлтгаж	байна гээрэй.
--------	---------------------------------	-------------------	----------------	---------------

Хариу

За, тэгнэ ээ = (тэгэмз).

12. Мэдээлэл

Дорж Дулмаа Николай	таны чиний	амрыг эрээрэй		гэсэн!
		амгаланг мэндийг	айлтгаарай	

Хариу А

Заа. (Баярлалаа).	Хариу	амры нь эрээрэй!	
		амгалангий нь мэндий нь	айлтгаарай! асуугаарай!

Хариу Б

Заа. Их баярлалаа гэж хэлээрэй.

Заа. Их баярлаж байна гэж хэлээрэй.

13. Асуулт мэндчилгээ

Та Танайх Танайхан	сайхан	зусаж намаржиж өвөлжиж хаваржиж	байна уу?
--------------------------	--------	--	-----------

Хариу

Сайхан	зусаж намаржиж өвөлжиж хаваржиж	байна аа.	Та Танайх Танайхан	сайхан	зусаж намаржиж өвөлжиж хаваржиж	байна уу?
--------	--	-----------	--------------------------	--------	--	-----------

14. Харьцуулж үз

А:

Би Тэр хүн Тэд нар	өдөр баяр	бүр тутам	багшийн сайдын даргын эмчийн ахын	амрыг амраланг	эрдэг. айлтгадаг.
--------------------------	--------------	--------------	---	-------------------	----------------------

Б:

Жил Өдөр	ирэх		тутам тусам бүр	хүйтэн дулаан	болж байна.	
Энэ Тэр	номыг хүнтэй	унших ярих уулзах		шинэ нэг сонин	юм	мэдэж байна.

15. Мэдээлэл

Би нэг илүү	тасалбар ном	авчихлаа, яах вэ!
-------------	-----------------	-------------------

Хариу

Зүгээр. Илүү	тасалбар ном	авсан	тусмаа сайн.
--------------	-----------------	-------	--------------

16. Мэдээлэл

Өдөр ирэх	тусам тутам	л	хүйтэрч байна!
-----------	----------------	---	----------------

Хариу А

Тэгэх Хүйтрэх	тусмаа	сайн.
------------------	--------	-------

Асуулт Б

Яагаад тэр билээ?

Хариу Б

Хүйтрэх тусам ус хөлдөнө. Ус хөлдвөл тэшүүрээр гулгах цаг түргэн ирнэ.
--

17. Мэдээлэл

Маргааш	тэнгэр сайхан болох цас орохгүй шуургагүй бороо орохгүй	гэнэ!
---------	--	-------

Хариу

За	яамай ашгүй	даа. дээ.
----	----------------	--------------

21. Харьууж үз

A:

Би монголоор	ярьдаг болохлоороо (ярьдаг болохоороо)	ярьдаг болохтойгоо зэрэг	чамд энит тайбарлаж өгнө. Монгол руу явна.
--------------	--	--------------------------	--

B:

Би	Думаар	Доржийг	ирэхээр нь (ирэхээр нь) ирэхтэй нь зэрэг	чам руу	тан руу	явуулна.
----	--------	---------	--	---------	---------	----------

B:

Удахгүй бороо орно.	Тэгэх(и)ээр	Бороо орохлоор	Бороо орсны дараа	ногоо сайхан урлана.
---------------------	-------------	----------------	-------------------	----------------------

Г:

Би	монгол хэл	сүрх гэж ~ сүрхаар	үүлзэх гэж ~ үүлзахаар	энд ирсэн.
----	------------	--------------------	------------------------	------------

A:

Намагт	монгол хэл	сүрххаар = (сүрхаар)	үүлзххаар = (үүлзахаар)	наттай яриарай.	чи яваарай.
--------	------------	----------------------	-------------------------	-----------------	-------------

22. Харьууж үз

A:

Бидний	Тэдний	зарим нь	унтаж чадаагүй.	өнөөдөр явна.
--------	--------	----------	-----------------	---------------

B:

Бид	Тэд	Цөм(өөрөө)	бүтл(ээрээ)	унтаж чадаагүй.	өнөөдөр явна.
-----	-----	------------	-------------	-----------------	---------------

B:

Би энэ	бүх номын	олон оюутны	их мөнгөний	заримыг	заримыг нь	уншсан.	танна.	явна.
--------	-----------	-------------	-------------	---------	------------	---------	--------	-------

Г:

Би энэ	бүх номыг	олон оюутныг	их мөнгийг	Цөмийг	Цөмийг нь	бүтлийг	бүтлийг нь	уншсан.	танна.	явна.
--------	-----------	--------------	------------	--------	-----------	---------	------------	---------	--------	-------

1-р яриа

- Монгол оронд хавар хэзээ болдог бэ?
- Гурван сараас болдог.
- Монгол орны хаврын улирлын онцлог юу вэ?
- Салхи их салхилдаг.
- Хавар болохлоор (болохтой зэрэг) газар дэлхий ямар өнгөтэй болдог вэ?
- Хавар болохлоор (болохтой зэрэг) газар дэлхий ногоорч эхэлнэ.
- Хавар цагийн гол ажил юу вэ?
- Газар хагалж, үр тариа, хүнсний ногоо тарина. Малчид хаваржаандаа нүүж, малаа төллүүлнэ.
- Монгол орны хаврын тэнгэр ямар байдаг вэ?
- Хаврын тэнгэр нэг сайхан болж, нэг муухай болж хувирч байдаг. Олон ааштай хүнийг «Хаврын тэнгэр шиг» хүн гэдэг.
- Хавар дулаан байдаг уу?
- Тийм дулаан биш. Эхлээд хүйтэн. Аажимдаа дулаарна.

2-р яриа

- Зургадугаар сараас зун болдог уу?
- Тэгнэ.
- Зун, газар дэлхий ямар өнгөтэй байдаг вэ?
- Нов ногоон байдаг.
- Зуны тэнгэр ямар вэ? Зун сайхан уу?
- Сайхан байлгүй яах вэ. Бороо их ордог. (Гэвч) тэнгэр голдуу цэлмэг байдаг. Малчин ардууд зусландаа гардаг. Улаанбаатарынхан ч зусланд гардаг. Оюутан сурагчдын зуны амралт эхэлдэг.

3-р яриа

- Сайн байна уу, Эрдэнэ ээ!
- Сайн, сайн байна уу?
- Чи ажлаа хийж байна уу, амарч байна уу?
- Би ажлаа хийгээгүй, амарч байна.
- Хаана амарч байна, амралтанд явах уу?
- Хөдөө (нутагтаа) хэд хоног амраад ирлээ. Амралтанд явахгүй.
- Хөдөөнөөс хэзээ ирэв?
- Өчигдөр орой ирлээ. Чи амралтаа авсан уу? Хэдийд амрах вэ?
- Үгүй ээ, би ажлаа хийж байна. 9-р сард амарна.
- Хаана амаръя гэж бодож байна?
- Хужиргын амралтанд очиж амарна гэж бодож байгаа.
- Сайхан амраарай.

4-р яриа

- Та цаг агааарын мэдээ соноссон уу?
- Соноссон.
- Маргаашийнхыг уу, өнөөдрийнхийг үү?
- Маргаашийнхыг ..
- Маргааш тэнгэр сайхан байвал би хөдөө явах гэсэн юм.
- Маргааш тэнгэр цэлмэг, бороо орохгүй. Жаахан салхитай байна гэсэн.
- Яамай даа. Санаа амарлаа.
- Та ямар унаагаар явах вэ?
- Онгоцоор явна.
- Очоод удах уу?
- Удахгүй, долоо хоноод ирнэ.
- Та сайн яваарай.
- За, та сайн сууж байгаарай.

5-р яриа

- Монгол оронд намар хэдийд болдог вэ?
- Есөн сард.
- Монгол орны намар ямар байдаг вэ?
- Монгол орны намар сайхан байдаг. Монголчууд намрыг налгар намар, баян намар гэж нэрлэдэг. Үр жимс боловсорно. Хүүхдүүд самар жимс түүнэ. Гэвч модны навч унана. Хүйтэн бороо орно. Ус хөлдөж эхэлдэг. Нүүдлийн шувууд буцдаг.
- Намрын гол ажил юу вэ?
- Намрын гол ажил бол ургац хураах.
- Малчин ардууд намар юу хийдэг вэ?
- Малчин ардууд хадлангаа авч, өвөлжөөгөө засдаг.

6-р яриа

- Арван хоёрдугаар сараас өвөл эхэлдэг үү?
- Тийм ээ. 12, 1, 2-р сарыг өвлийн улирал гэдэг. Гэвч үнэндээ 11-р сараас 3-р сар(ыг) дуустал цастай, хүйтэн хэвээрээ байдаг учир хүйтний улирал гэдэг юм даа.
- Өвөл их хүйтэн болдог уу?
- Заримдаа их хүйтэн болдог. (Цельсийн) хасах тавин хэм хүртэл хүйтэн болдог.
- Өвөл салхи шуурга их байдаг уу?
- Байдаг. Өвөл салхи их хэрэгтэй.
- Яагаад их хэрэгтэй байдаг юм бэ?
- Яагаад гэвэл, салхи их салхилбал бэлчээрт цас бага тогтоно. Бэлчээрт цас бага байвал малд сайн байдаг.

7-р яриа

- Гадаа ямар байна?
- Цасан шуургатай, хүйтэн байна.
- Та даарав уу?
- Их даарлаа.
- Би танд халуун цай хийж өгье.
- За, яасан сайн юм бэ!
- Та халуун цай ууж, хоол ид.
- За.
- Одоо яаж байна?
- Одоо сайхан байна. Халууцлаа. Сайхан боллоо. (Баярлалаа.)

8-р яриа

- Гадаа дулаан байна! Цас хайлж байна, ээж ээ!
- Тэгэлгүй яах вэ, хүү минь, хавар болж байна шүү дээ!
- Маргааш бас л дулаан болж цас хайлах уу?
- Тэгнэ ээ. Өдөр ирэх тусам (тутам) л дулаарна.
- Дулаарах тусам л цас хайлах уу?
- Хайлахаас илүү шимэгдэж байгаа юм. Нар салхинд шимэгдчихдэг юм.
- Цас шимэгдвэл харин сайн биз дээ?
- Сайн гэхэд хэцүү дээ, хүү минь. Цасны ус газар луу орохгүй болохоор юу нь сайн байхав дээ.
- Гадаа дулаан байна. Би орой болтол гадаа тоглох уу?
- Тэг дээ тэг.

9-р яриа

- Дашдондог гуайнх энд байдаг уу?
- Тийм ээ, одоо өөрөө байхгүй байна. Зусланд байгаа.
- Би нэг захиа өгөх гэсэн юм сан. Та ирэхлээр нь өгчихгүй юү?
- Тэгье л дээ. Яаралтай юм уу? Хэд хоног ирэхгүй бол яах вэ?
- Зүгээр. Тийм яаралтай юм биш. Дашдондог гуайг ирэхлээр л өгөөрэй.
- За. Дашдондогийг ирэхтэй нь зэрэг л би өгчихье.

10-р яриа

- Чи надад цанаар гулгахыг зааж өгнө гэсэн шүү дээ. Одоо цастай байна. Явах уу?
- Ийм цас цанаар гулгахад муу. Дахиад цас орохлоор хоёулаа явамз.

11-р яриа

- Нэг аяга халуун цай уучих.
- Ямар цай вэ, монгол цай юу?

- Тийм, давстай монгол цай.
- За, би жаахан ууя. Аажимдаа (=яваандаа) чам шиг их ууж сурах байх (=уудаг болох байх).

Бичвэр

Text

ДӨРВӨН УЛИРАЛ

Хавар, зун, хамар, өвлийг жилийн дөрвөн улирал гэдэг. Монгол орон жилийн дөрвөн улиралтай. Хавар, салхи их салхилна. Хавар болоход (болохлоор) цас мөс хайлж, цэцэг ногоо ургаж, дулаан орноос нүүдлийн шувууд ирдэг. Хавар мал төллүүлэх, үр тариа, хүнсний ногоо тарих их ажил байдаг.

Зун дуутай, цахилгаантай, салхитай бороо ордог. Зуны температур заримдаа гучаас гучин таван хэм (30-35°) хүрдэг. Зуны өдөр урт, шөнө нь богино. Зун нар их гарна. Зун болоход айлууд зусланд гардаг. Сургуулийн сурагч оюутан амардаг. Оюутны зарим нь дадлагад гарч, зарим нь пүүс, компанид очиж ажилладаг.

Намар жимс, үр тариа, хүнсний ногоо боловсорч, ургац хураах их ажил гардаг. Өвс ногоо шарлана. Намрын сүүл сард ус хөлдөж эхэлнэ.

Өвөл цас орж, уул, тал цагаан (өнгөтэй) болно. Монгол орны өвлийн дундаж хүйтэн 25-30° (хорин таваас гучин хэм / градус) байдаг. Өвөл болохтой зэрэг малчин ардууд өвөлжөөндөө буудаг.

Дасгал

Exercises

1. Цэгийн оронд зохих үг хэллэг тавь. Fill in suitable words.

Монгол орон ... улиралтай. ... болохоор дулаан орноос нүүдлийн шувуу ирдэг. Хавар газар дэлхий ... өнгөтэй болно. Хавар ... их салхилдаг. Зуны ... богино, ... урт байдаг. Зун болохоор сургуулийн сурагчид Зун, оюутны зарим нь ... явдаг. Зарим нь ... амардаг. Тав, зургаа, долдугаар ... зуны улирал гэнэ. Намар сургуулийн ... эхэлнэ. Намар болоход нүүдлийн шувууд Малчин ардууд хадлангаа ... хашаагаа Намар болохоор ... шарлаж, ... хөлддөг. ... сарыг өвлийн улирал гэнэ. Би ... улиралд их дуртай.

2. Асуултад үлгэрийн дагуу хариул. Answer the questions using the model.

ҮЛГЭР: Номын мухлаг хаана байдаг вэ? Их сургуулийн дотор байдаг уу, гадна байдаг уу?
ДОТОР НЬ (ГАДНА НЬ) БАЙДАГ.

1. Цирк хаана байдаг вэ? Их дэлгүүрийн урд байдаг уу, хойно байдаг уу?
2. Ном хаана байна вэ? Ширээн дээр байна уу, ширээн дор байна уу?

3. Бэлэг дурсгалын мухлаг хаана байдаг вэ? Зочид буудлын дотор байдаг уу, гадна байдаг уу?
4. Гуанз хаана байдаг вэ? Их сургуулийн урд байдаг уу, хойно байдаг уу?
5. Цайн газар хаана байдаг вэ? Цэцэрлэгийн дотор байдаг уу, гадна байдаг уу?
6. Хүйтэн зуушны мухлаг хаана байдаг вэ? Төв цэнгэлдэх хүрээлэнгийн дотор байдаг уу, гадна байдаг уу?
7. Зурагчин хаана байдаг вэ? Тэр байшингийн өмнө үү, хойно байдаг уу?
8. Шүүтээ хаана байна вэ? Цонхны наана байна уу, цаана байна уу?

3. Асуултад үлгэрийн дагуу хариул. Answer the questions using the model.

ҮЛГЭР: Хүүхдийн номын сан хаана байдаг юм бэ?
ХАА БАЙДГИЙ НЬ БИ МЭДЭХГҮЙ.

1. Номын сан хэдэн цагт хаадаг вэ?
2. Энэ дэлгүүр хэзээ онгойдог вэ?
3. Дорж хэзээ ирсэн бэ?
4. Дорж энэ номыг хэдийд уншсан бэ?
5. Тэднийх хаа байдаг вэ?
6. Энэ номын сан хэдэн номтой вэ?
7. Өчигдөр хэдний өдөр байсан бэ?
8. Өнөөдөр хэдний өдөр вэ?
9. Оюутнууд хаана ажиллаж байгаа вэ?
10. Бат хэзээ явах вэ?
11. Музей хэдэн цагаас ажилладаг вэ?
12. Кино хэдэн цагаас гарах вэ?

4. Хаалтандхи үйл үгийг тохирох хэлбэрт нь хэл. Use a suitable form of the verb in the brackets.

1. Өчигдөр бороо орсон. Дараа нь нар (гар-).
2. Би өглөө долоон цагт бос-. Дараа нь хоолоо (хий-).
3. Өчигдөр бороо орж (бай-). Би гадаа (гар-)гүй.
9. Did you have many credits? Did you obtain them all?
10. We had five credits. I obtained them all.

* * *

11. Did you know your questions?
12. I did not know the questions well. I answered one question rather incompletely.
13. Did the teacher ask you an additional question?
14. Yes, I knew that question well.

* * *

15. How many faculties, departments, teachers and students does your University have?
16. Our University has almost (not full) ten faculties, over fifty departments, about (approximately) a thousand teachers and over ten thousand students.

* * *

17. Are you learning new words while cooking?

18. Yes. Would you watch the dish? As soon as it starts boiling, let me know.

* * *

19. I will either go to the cinema or visit the Dorjis.

20. Either you do this work or you return home.

Хэлзүй

Grammar

1. Cases

a) The *ablative* is used in the following phrases:

эндээс хол	far from here
эндээс ойрхон	close to her (lit.: from here)
буудлаас суу-	to sit (on the bus) at the stop... (lit.: from the stop...)

b) The *sociative* is used similarly in some phrases:

энэнтэй ойрхон	close to (with) this
энэ байшинтай ойрхон	close to (with) this building

c) The *instrumental* can have a distributive meaning:

хөл ихтэй газруудаар	(moving) through busy places
----------------------	------------------------------

Approximate temporal meaning:

нэг сарын эхээр	by the beginning of January
нэг сарын сүүл(ч)ээр	by the end of January
нэг сарын дундуур	by the middle of January

d) Double case (D.-L. + Instr.):

аравдаар (арвадаар)	about the tenth (of a month)
аравдын (арвадын) орчим	about the tenth (of a month)

2. Postpositions

a) The postposition *дээр* 'on, in' often has a meaning close to that of D.-L., but implies a non-functional presence at the given place, while D.-L. implies participation in the activity of the respective institution etc. (see also L7, Gr. 2):

хийд дээр	in the monastery (as a visitor)
хийдэд	at the monastery (participation in the meeting, and the like)

хурал дээр
хуралд суу-

at the meeting (encountering s.b., talking to s.b.)
to sit at a meeting (active participation in its proceedings)

But:

буудал дээр буу-

to get off at a station

b) The postposition *хавиар* (G.) 'around, in the vicinity of, close to' has both a temporal and local meaning. The postposition *хавьд* (G.) 'around, close to' has only the local meaning (see Patterns Nos. 1-3).

3. Numerals

Mongolian occasionally makes use of older numerals for the values ten thousand and more:

<i>түм (эн)</i>	10 000	=	<i>арван мянга</i>
<i>бум</i>	100 000	=	<i>зуун мянга</i>
<i>сая</i>	1 000 000	=	<i>мянган мянга</i>
<i>живаа</i>	10 000 000	=	<i>арван сая</i>
<i>дүншүүр</i>	100 000 000	=	<i>зуун сая</i>
<i>тэрбум</i>	1 000 000 000	=	<i>мянган сая</i>

4. Optative

This is formed by the suffix *-аасай*⁴ (but: *-өөсэй*) and expressed (mostly impracticable) wishes, sometimes regret ('if only...') and the like:

<i>Бушуухан ирээсэй.</i>	I wish you came quickly
<i>Энд байгаасай.</i>	I wish he were here.

5. *Perfectum futuri*

This is formed by the particle *-сан*⁴, or *юман*, added to *nomen futuri*. It roughly corresponds to 'would like to' (see L9, Gr. 10b):

явах сан
явах юм сан (I) would like to go

хийх сэн
хийх юм сан (I) would like to do

6. Conditional

This is formed by the combination of *nomen futuri* with the past tense of the verb 'to be'.

(Би) үзүүлэх байсан. I would have shown.

(Би) хэлэхгүй байсан. I would not have said.

(Би) хэлэх байсан. I would have said.

Таныг ирсэн бол би уулзах байсан. Had you come, I would have met (you).

Би мэдсэн бол танд хэлэх байсан. Had I known it, I would have told you.

7. Verbal noun + болов уу? (colloquial бол уу?)

This phrase expresses hesitation or doubt concerning a present or future action:

Эхнэр маань намайг санаж байгаа болов уу? I wonder if my wife remembers me (misses me).

Бид ирэх болов уу? I wonder if we can come (i.e. do we have permission?).

Бид ирэх боллоо. We can come (we have permission).

Бид ирэхгүй боллоо. We cannot come (we do not have permission).

Бид уулзах болов уу? I wonder whether we will meet.

Бид уулзаж ч магадгүй, уулзахгүй ч байж магадгүй. We may meet and we may not (possibility at a non-specified time).

Note the difference:

Би ирэх үү? (ирэх ёстой юу?) Shall I come (do I have the obligation)?

Ирсэн ч болно, ирэхгүй ч байсан болно. You may come and you need not come.

8. Nomen futuri

a) *Nomen futuri* in D.-L. expresses purpose:

Зочид буудал хүрэхэд аль буудлаас суух вэ? From which station shall I go (sit), in order to reach the hotel?

Цэнгэлдэх хүрээлэн ороход ямар унаагаар явж болох вэ? Which means of transport shall I take, in order to reach the stadium?

b) *Nomen futuri* can also be used as object of the verbs *бай-* 2. 'to stop, cease' and *боль-* 'to stop doing something'. In that case it can either have the accusative suffix (the two verbs have different actors), or the possessive suffix *-aa*⁴ (the two verbs have the same actor):

... ирэхээ байсан (больсон) (he, she etc.) stopped coming

... ирэхийг байлгасан (болиулсан) (he, she etc.) stopped somebody coming

9. The word *байлгүй*

This word is placed after a verbal noun in the predicate and expresses confirmation of the statement, approximately: 'does he/she/it not?, would he/she/it not?' (in the sense: 'certainly yes').

Чамайг санаж байгаа байлгүй.

Would she not remember (miss) you? How could she not miss you? (i.e. She certainly misses you.)

10. Specification of direction, place and the cardinal points

The words designating the cardinal points are very important in Mongolian to determine position, because normally position is not determined relatively with regard to the speaking person (to the right, left), but absolutely from the point of view of the cardinal points. However, the meanings of the cardinal points seem to be derived from the words designating relative position, probably with regard to the position of the yurt (and man leaving it?). The yurt's door faces 'south' or 'the front', so the 'east' is to the 'left', the 'west' is to the 'right' and the 'north' is 'behind', 'in the back'. The words designating positions are semantically very finely differentiated with regard to the speaking person, direction of movement, relative position to other objects and the like.

a) Position in relation to the cardinal points:

<i>хойно</i>	in the north; at the back of, behind
<i>хойт</i>	northern; back, rear
<i>урд, өмнө</i>	southern; being in front
<i>баруун</i>	western; being on the right
<i>зүүн</i>	eastern; being on the left
<i>урд (өмнө) талд</i>	on the southern side; in front of
<i>хойт талд</i>	on the northern side; at the back of
<i>баруун талд</i>	on the western side; on the right
<i>зүүн талд</i>	on the eastern side; on the left

The words can also have attributive forms:

<i>ар дахь, хойтох / хойдох</i>	northern; rear
<i>урдах</i>	southern; front
<i>зүүнтэйх</i>	western; right (being on the right)
<i>баруунтайх</i>	eastern; left (being on the left)
<i>хажуу дахь</i>	at the side, being at the side

b) Movement in a direction (as if moving in a circle):

<i>энүүгээр</i>	(through) this way
<i>тэрүүгээр</i>	(through) that way
<i>цаагуур</i>	behind (e.g. when passing behind)
<i>наагуур</i>	in front of (e.g. when passing in front of)

<i>урдуур</i>	along the southern side
<i>хойгуур</i>	along the northern side
<i>зүүгээр</i>	along the eastern side
<i>баруугаар</i>	along the western side

c) Movement in a direction (moving straight):

<i>хойш, хойшоо</i>	to the north
<i>урагш, урагшаа</i>	to the south
<i>зүүнш, зүүн тийшээ</i>	to the east
<i>баруунш, баруун тийшээ</i>	to the west

If the direction is the subject's direction, the word may be followed by the possessive *аа*⁴:

<i>Хойшоо(гоо) яваарай.</i>	Go to the north (lit.: to your north)
<i>Урагшаа(гаа) яваарай.</i>	Go to the south (lit.: to your south)
<i>...хойшоогоо харсан хаалгатай хашаа</i>	...the yard (enclosure) with a gate facing north
<i>Тэндээс урагшаа(гаа) эргээд чигээрээ яв.</i>	From there you turn to (your) south and then go straight on (lit.: 'in your direction').

If the direction is unequivocally related to the person's body or in relation to the person, the possessive *аа*⁴ is used obligatorily:

<i>Чи хойшоогоо хараач!</i>	Look back (lit.: look to your back side)
<i>Жаахан хойшоогоо болоорой!</i>	Move slightly back (to your back side)
<i>Жаахан урагшаагаа болоорой!</i>	Move slightly forward (to your front side)

d) The closeness of the position is expressed by the suffix *-хан*⁴ (originally diminutive suffix, see L1, Gr. 4):

<i>хаахан</i>	where (exactly, approximately)
<i>хойхон</i>	close behind (to the north)
<i>урдхан</i>	close in front (to the south)
<i>цаахан</i>	close behind (from the speaker's point of view)
<i>наахан</i>	close in front (from the speaking person's point of view)

11. Idioms and phrases

<i>дээр үед</i>	formerly; in old times
<i>одоо үед</i>	at present
<i>аль ч хэсэг</i>	any part (= each part)
<i>энүүхэнтэй⁵ ойрхон</i>	right here, directly here, very close
<i>Төв Азийн цээжинд</i>	in the heart of Central Asia

⁵ This form appears only superficially like a sociative case, it is probably derived from *энүүхэн энд ээ > энтээ

«Туул» ресторан хүрэх зам

the way leading to the restaurant 'Tuul'

Хаанахынх вэ?

Хаанахын автобус вэ?

Which (bus line) is it?

Санаанд орохгүй байна.

Өөрөө л мэд.

I cannot remember (it does not occur to me).

It is up to you to decide (lit.: you yourself decide).

Бүү мэд | ёстой бүү мэд.

Ээ чавваас!

ягаав (<ягаад вэ)

I do not know / I really do not know.

interjection, expressing frustration or regret you know, surely (coll.: introductory phrase in the beginning of a sentence, almost always followed by *нөгөө*)

Vocabulary

Шинэ үг

автомат (нийтийн) утас

адакеми

албан газар

албагүй

албатай

аль хэдийн(ээ)

амбаар

ард (G.)

баарман

бай- 2. (Э1)

(байж, байх, байна)

байгуулга, байгууллага

бололтой

боль- (Э2.4)

(больж, болих, болино)

бурхан

бушуу(хан)

бүгд найрамдах улс

бүхэлдээ

гүүр

гэгдсэн

дагуу (G.)

далай

дампуур- (Э2.4)

(дампуурч*, дампуурах,

дампуурна)

дээш (G.)

ерөнхийлөгч

засгийн газар

захиргаа (н)

зогс- (Э2.5)

(зогсож, зогсох, зогсоно)

зөр- (Э2.4)

(зөрж, зөрөх, зөрнө)

telephone booth

Academy

office; authority (also: official building)

(it is) not necessary

(it is) necessary

long ago

storeroom

at the back side of; to the north of

barman, waiter

to stop, cease

organisation, institution

possibly, very likely

to stop doing something

1. the Buddha; 2. a statue of the Buddha; 3. a deity

(rather) quick(ly), rapid(ly)

republic

in total, completely, as a whole

bridge

the so-called

along, alongside of; according to

sea, ocean

to go bankrupt

above, higher than; up(wards)

president

government office, the seat of government

administration, management

to stop, come to a halt

to pass by, go past; to be at variance

зүлэг	lawn, green meadow
зэрэгц- (Э2.2)	to be parallel to, to be on the same level
(зэрэгцэж, зэрэгцэх, зэрэгцэнэ)	
лав	sure(ly), certain(ly)
мөрөөд- (Э2.2)	to long for, miss
(мөрөөдөж, мөрөөдөх, мөрөөднө)	
мэдээлэл	information, report
найрамд- (Э2.2)	to become friends, establish friendly relations with
(найрамдаж, найрамдах, найрамдана)	
нийслэл	capital (city)
нис- (ГЗ)	to fly; travel by air
(нисч, нисэж**, нисэх, ниснэ)	
нисэх // нисэх онгоцны буудал	the airport
нутаг нэгтэн	s.b. coming from the same country (more official style)
нүүдэлчин, нүүдэлчид	nomad(s)
орш- (Э2.3)	to be in, exist, be located
(оршиж, орших, оршино)	
өнгөр- (Э2.4.)	to pass (about time), elapse
(өнгөрч*, өнгөрөх, өнгөрнө)	
өргөж- (Э2.3)	to expand, widen, spread, increase
(өргөжиж, өргөжих, өргөжнө)	
өргөжин тэл-(Э2.4)	to spread, expand
(тэлж, тэлэх, тэлнэ)	
сайд	minister
суварга, суврага	stupa, pagoda, tomb
талбай	(public) square
тойр- (Э2.4)	to turn; to go round
(тойрч*, тойрох, тойрно)	
түлээ түлш	firewood and fuel (pair word)
Улсын Их Хурал	the national assembly, Grand Khural
урагшаа	to the south
урд	front (direction); south, in the south
усан сан, худаг	water reservoir, pool
үзэсгэлэнт(эй)	beautiful, handsome; scenic
хавь	(in the) neighbourhood; near
хандив	charity (present), donation
хийд	monastery
хоймор	the northern part of the yurt (opposite the entrance)
хойшоо	to the north
хойшоогоо	to one's back side (e.g. turn, look etc.)
хороолол	district, suburb
хотын захиргаа (н)	city administration
хөл ихтэй	busy (street)
хөндий	valley; cavity; hollow
хөшөө (н)	monument, stele
хүнсний дэлгүүр	grocery, food store

хүр- (Г2) (хүрч, хүрэх, хүрнэ)	to reach, arrive at; to amount to
хүрээ (н) хэвлэ- (Э2.1) (хэвлэж, хэвлэх, хэвлэнэ)	enclosure; yard; monastery to print, publish
хэвлэлийн газар цагдаа (г) цагдаагийн газар цахилгаан станц чиг чиглэ- (Э2.1) (чиглэж, чиглэх, чиглэнэ)	printing office policeman the police (station) electric power station direction; straight (direction) to move toward, head toward; to resolve, decide
чигээр(ээ) чиглэл чиглэлийн такси шашин шулуун, шулуухан шүт- (Э2.2) (шүтэж, шүтэх, шүтнэ)	straight on (in one's own direction) direction, orientation taxi going along a specific route religion straight, direct to worship, to believe in
эд юм шашны эд юм эзэмш- (Э2.3) (эзэмшиж, эзэмших, эзэмшинэ)	object(s), thing(s) religious objects to occupy, take possession of, possess
элчин сайд эргэ- (Э2.1) (эргэж, эргэх, эргэнэ) эрхбиш эрхэмлэ- (Э2.1) (эрхэмлэж, эрхэмлэх, эрхэмлэнэ)	ambassador to turn, to turn or move about necessarily, inevitably, must to esteem, consider important, respect
эцэс эцсийн буудал яам (ан) цаас (ан)	end, conclusion final, last stop; terminal ministry; office (e.g. элчин сайдын я. – embassy) tugrig (or any other currency; colloquial)

Pronunciation

Дуудах

- [t – d] тарга-дарга, тонших-донших, тоор-доор, төвий-дөвий, төл-дөл, төлөх-дөлөх, төр-дөр, туг-дуг, тулах-дулах, туулуулах-дулуулах, тур-дур, тэг-дэг, тэд-дэд, тэн-дэн
- [a^а – aj^(а)] сайхан-саяхан, сайт-саят, сайвар-саявтар, хайгуул-хаяг, хайх-хаях, хайлц-хаялт, тайган-таяг, дайн-даян
- [ɔ^о – ɔj^(о)] ойд-оёдол, ойгүй-оёглох, нойр-ноёрхог, нойт-ноён, гоймон-гоёмсог, ойлт-соёл, хойрго-хоёр

«Цайтай царайтай айл байна!»

Чухам	хаахан хаана	байгааг	сайн мэдэхгүй,	их дэглүүрийн төв музейн төв талбайн тэр гудамжны тэнд	л	байгаа байх.
-------	--------------	---------	----------------	--	---	--------------

Хариу

Цагдаагийн газар	Хэвлэлийн газар	Хувцас захиалга	Автомат утас	хаа(хан) чухам хаана	байна вэ?
------------------	-----------------	-----------------	--------------	----------------------	-----------

2. Асуулт

Долоон	Бсөн	Арван	Энэ	Өнгөрсөн	Ирэх	Долоо хоногийн сарын	арваагаар сүүлчээр хорьдоор дундур арван тавдаар арвадын хорьдын арван тавдын	орчим хавиар	ирсэн, буцаа, явна.
Долоо	Бсөн	Арван	Энэ	Өнгөрсөн	Ирэх				

Хариу

Чи	Та	Тардрмтэн	Тар хүн	Тэд нар	хэзээ	(манай энд) (Улаанбаатар) (хотод) (хөдөө) (нутагтаа) (Иргэд)	ирээ вэ? (ирээв?) ирээ?	буцах явах	вэ?
Чи	Та	Тардрмтэн	Тар хүн	Тэд нар					

1. Асуулт

Заргаар Sentence Patterns

Тэр ар дээрх арван таван тартан тарвагыг ар дээрх арван таван тартан тарвага гэхүй юм бол аль ар дээрх арван таван тартан тарвагыг ар дээрх арван таван тартан тарвага гэх юм бэ?

«Ар дээр арван таван тартан тарвага гэхүй юм» – Тэр юу вэ? (Хүмс)

Энэ байшингийн цаагүүр хойгүүр наагүүр баруугаар үрдүүр эүүгээр	Энүүгээр Тарүүгээр
	Энүүгээр Тарүүгээр Тойр(но). Эргэ(нэ). Вя(на).

Харуу

Энүүгээр Тарүүгээр Вяах Тойрох үү?	Энүүгээр Тарүүгээр Вяах Тойрох үү?
--	--

4. Асуулт

Энэ Тар Их сүргүүлийн	Хавьд Хавиар	ер нь тийм	Юм буудал мухлаг	байхгүй.
-----------------------------	-----------------	------------	------------------------	----------

Харуу Б

Энэ Тар	байшингийн цэцэрлэгийн гудамжны	цаана цаахан хойно хойнон баруухан зүүхэн наана наахан үрд үрдхан	(Талд) (буланд)	бий. байгаа.
------------	---------------------------------------	--	--------------------	-----------------

6)

Тар байна.

а)

Харуу А

Энэ Тар	Хавьд Хавиар	номын тамхны пивоны	мухлаг	(ойр) байна уу?
		цэг засвар автобусны буудал		

3. Асуулт

5. Асуулт

Дулмаа Тэд нар	аль чухам аль	цэцэрлэгт гудамжинд оюутны байранд хичээлийн байранд байшинд дэлгүүрт гуанзанд	байсан		бэ?
			явж сууж ажил хийж	байсан байгаа юм	

Хариу

Засгийн газрын Их сургуулийн Түүхийн музейн Тэр сүмийн Төв талбайн Усан сангийн	арын ардхи урд талын урдхи хойтхи хойт талын зүүнтэйхи зүүн талын баруунтайхи баруун талын хажуугийн хажуудхи	цэцэрлэгт гудамжинд оюутны байранд хичээлийн байранд байшинд дэлгүүрт гуанзанд	байсан.	
			явж сууж ажил хийж	байсан. байна билээ.

6. Мэдээлэл

Тэр хүн Дорж Тэднүүс	манайд ирдэг надтай уулздаг кино үздэг надад тусалдаг	байсан,	одоо саяхан энэ жил	ирэхээ уулзахаа үзэхээ туслахаа	байлаа. болилоо.
----------------------------	--	---------	---------------------------	--	---------------------

Хариу – асуулт

Хэн Ямар хүн	тэр хүний Доржийн тэднүүсийн	ирэхийг явахыг кино үзэхийг туслахыг	байлгасан болиулсан	юм бэ?
-----------------	------------------------------------	---	------------------------	--------

Хариу

Дорж Дулмаа Би	ирэхий явахы үзэхий туслахы	нь	байлгасан. болиулсан.
----------------------	--------------------------------------	----	--------------------------

7. Мэдээлэл

Би Бид Дулмаа бид хоёр	ер нь	тэр	хүнд айлд хүнтэй	хэлэхээ очихоо уулзахаа	байя! байна! больё! болино!
		(маргааш)	явахаа буцахаа тоглохоо кино үзэхээ		

Хариу

а)	Зүйтэй.
----	---------

б)	Тэгсэн Байсан Больсон	нь	дээр (байх аа).
----	-----------------------------	----	-----------------

8. Асуулт

За, хоёулаа	явах гарх орох	уу?
-------------	----------------------	-----

Хариу

Чи	явж гарч орж	бай,	би удахгүй	явна. гарна. орно.
----	--------------------	------	------------	--------------------------

9. Асуулт

Эхнэр Хүү Багш Дорж	маань минь чинь тань	намайг таныг чамайг	санаж бодож	байгаа	болов уу? (бол уу?)
------------------------------	-------------------------------	---------------------------	----------------	--------	------------------------

Хариу

Эхнэр Хүү Багш Дорж	минь чинь тань	намайг чамайг таныг	санаж бодож	байгаа	байх. байлгүй.
------------------------------	----------------------	---------------------------	----------------	--------	-------------------

10. Асуулт

Дорж гуай гэртээ байгаа болов уу (бол уу)?

Хариу

а)	Дорж гэртээ байгаа. (Одоо байгаа, би яг мэдэж байна.)
б)	Дорж гэртээ байгаа байх. (Сайн мэдэхгүй байна, байж магадгүй.)
в)	Дорж гэртээ байж байсан ... (Хэдэн минутын өмнө байсан. Одоо байна уу, үгүй юү? Мэдэхгүй.)

А:	Дарга өрөөндөө байна уу?	
Б:	(Дарга өрөөндөө)	байна. байгаа байх. байж байсан ...

А:	Дулмаа тасагтаа ирсэн үү?	
Б:	Ирсэн. Ирсэн байх. Ирсэн байсан ...	

А:	Тэр хүн англиар ярьдаг уу?	
Б:	Ярьдаг. Ярьдаг байх. Ярьдаг байсан.	

А:	Тэр хүн франц хэл мэддэг байсан уу?	
Б:	Мэддэг байсан. Мэддэг байсан байх. Мэддэг. Гүй (Үгүй).	

11. Мэдээлэл

Дорж Би Та	энэ хуралд ирэх манайд очих энүүнийг орчуулах их сургуульд орох илтгэл тавих	ёстой байсан.
------------------	--	---------------

12. Мэдээлэл

Би Дорж	бол	ингэж	хэлэхгүй хийхгүй орчуулахгүй	байсан (юм).
------------	-----	-------	------------------------------------	--------------

Таныг Чамийг Думаат	өчигдөр ирсэн натйг уулсан арт ирсэн Доржтой уулсан	бол,	би	баярлах тантай уулах	байсан.
---------------------------	--	------	----	-------------------------	---------

Б

Би	энийг мэдсэн өчигдөр ирсэн Доржтой уулсан арт ирсэн	бол,		танд хэлэх арт ирэх тантай уулах	байсан.
----	--	------	--	--	---------

А

15. Мэдэвэл

Дорж Та Чи	тэр хуралд суугаагүй тэнийд очоогүй үүнийг орчуулаагүй их сургуульд ороогүй илтгэл тавиаагүй	байна.	Би бол	суух очих орчуулах орох тавих	байсан.
------------------	--	--------	--------	---	---------

14. Мэдэвэл

Дорж Та Чи	тэр хуралд суусан тэнийд очсон энэнийг орчуулсан энийг орчуулсан их сургуульд орсон илтгэл тавьсан	байна, би бол		суухгүй орчуулахгүй очихгүй орохгүй тавихгүй	байсан.
------------------	---	---------------	--	--	---------

13. Мэдэвэл

Өгөөр л Ингэж л	хэлэх хийх орчуулах	хэлнэ хийнэ орчуулна	(даа), (дээ),	байсан (юм).	
--------------------	---------------------------	----------------------------	------------------	--------------	--

Харуу

Яаж Юу гэж	хэлэх хийх орчуулах	байсан	юм бэ? гэж?		
---------------	---------------------------	--------	----------------	--	--

Харуу – асуулт

16. Асуулт

Чи Та	энэ тэр	үзэсгэлэнг сэтгүүлийг үгийг хүүхнийг чихрээсээ цайнаасаа	надад тэрүүнд Батад	яагаад	үзүүлээгүй хэлээгүй танилцуулаагүй өгөөгүй үзүүлсэнгүй	юм бэ? вэ?
----------	------------	---	---------------------------	--------	--	---------------

Хариу

Чи Та	(өөрөө)	үзье үзүүл танилцъя танилцуул өг	гээгүй шүү дээ!	Үзье Үзүүл Танилцъя Танилцуул Өг	гэсэн бол, (би)	үзүүлэх хэлэх танилцуулах өгөх	(л)	байсан (юм).
----------	---------	--	-----------------	--	--------------------	---	-----	-----------------

17. Асуулт

Би	маргааш энд энийг		ирэх авах байх унших хийх	албатай ёстой	юу?
	энэ тэр	номыг сониныг дасгалыг	заавал	ирэх авах унших хийх	үү? уу?

Хариу А

Ирсэн Байсан Авсан Уншсан Хийсэн	ч	болно,	ирэхгүй байхгүй авахгүй уншихгүй хийхгүй	ч	байсан болно.
--	---	--------	--	---	---------------

Хариу Б

Ирнэ. Авна. Байна. Уншина. Хийнэ.	=	Ирээрэй. Аваарай. Байгаарай. Уншаарай. Хийгээрэй.	=	Ир. Ав. Бай. Унш. Хий.
---	---	---	---	------------------------------------

Хариу В

Завали	ирэх авах байх унших хийх	албаггүй,	өөрөө л мэд.
--------	---------------------------------------	-----------	--------------

18. Асуулт

Бид Тэр хүн Тэд нар	үүлзах ирэх	энийг		номыг	сонныг	дасгалыг
		унших	авах	хийх	болов уу? (бол уу?)	

Хариу

(Бид) (Тэр хүн) (Тэд нар) (Та)	үүлзах ирж	уншиж	энийг		номыг	сонныг	дасгалыг	тэр	энэ
			ирэх	унших	авч	хийж	ч	болно, магадгүй,	уншихгүй ирэхгүй авахгүй хийхгүй

19. Асуулт

Чи Та Тэд нар Дорж	юу болж байна вэ,	маргаш энд ирэх дахиад тийшээ явах Монголд явах их сургуульд орох Сүм музейг үзэх хугацаатаа сунгуулах	үү? үү?
-----------------------------	-------------------	---	------------

Хариу

Би Дорж Тэд нар	өөрөө өөрснөө	мэдэхгүй, дарга нар батш эхнэр маань (нь)	элчин сайд тэд нар	(и)	мэднэ.
-----------------------	------------------	--	-----------------------	-----	--------

Асуулт А**Хариу А**

Эхнэрээсээ Багшаасаа Дарга нараасаа Тэд нараас Элчин сайдаас Эхнэртэйгээ Багштайгаа Дарга нартайгаа Тэд нартай Элчин сайдтай	асуув уу? ятив уу?	Асуулаа. Ярилаа.
---	-----------------------	---------------------

Асуулт Б

Эхнэр Багш Дарга нар Тэд нар Элчин сайд	чинь тань нь	юу гэж байна вэ? зөвшөөрсөн үү?
---	--------------------	------------------------------------

Хариу Б (Батлах: -х болмоо | болсон)

Оч Яв Ор Үз Сунгуул	гэж байна,	тэгээд	би тэд нар Дорж	очих ирэх явах орох үзэх сунгуулах	боллоо! болсон!
Зөвшөөрсөн,					

Хариу В (Үгүйсгэх: -хгүй болмоо | болсон)

Битгий	оч яв ор үз сунгуул	гэж байна,	тэгээд	би тэд нар Дорж	очихгүй ирэхгүй явахгүй орохгүй үзэхгүй сунгуулахгүй	боллоо! болсон!
Зөвшөөрөөгүй,						

20. Асуулт

Чи Та Та нар	хэдэн цагийн хичээл			хийж зааж авч уншиж ирж явж очиж	байх	болов? болов оо? болоо вэ?
	ямар	ном сэтгүүл дасгал				
	хэдэн цагт	сургууль яаман сургууль яам	дээр руу			

Хариу

(Би) (Бид)	нэг хоёр гурван дөрвөн	цагийн хичээл			хийж зааж	байх боллоо.
	монгол англи	хэлний хэлээр	ном сэтгүүл дасгал		авч уншиж	
	найман есөн	цагт	сургууль яаман	дээр	ирж явж	
			сургууль яам	руу	очиж	

21. Мөрөөдөн хүсэх

Дулмаа Зун Өвөл Цас Тэр хүн	(бушуухан)	ирээсэй, болоосой, ороосой, гараасай, яваасай,	энийг	асуух өгөх хэлэх	юм сан. сан. сэн. сон. сөн.
			усанд сэлэх цанаар гулгах хэвтэх унтах хичээлээ давтах		

22. Мэдээлэл

Дэжид Тэр хүн Тэд нар	өрөөндөө тасагтаа их сургууль дээр	байгаа ирсэн	юм байна.	
	маргааш удахгүй 15-даар өчигдөр уржигдар	явах ирэх буцах явсан ирсэн	бололтой юм шиг	(байна).

Хариу – асуулт

Чи	яаж мэдэв (ээ)?
Та	
Яаж байна?	

- «Алтай зочид буудал» хүрээд (автобусы) аль буудлаас суух вэ?
- Боловсролын Их сургуулиас сууна.

2-р яриа

- Сайн байна уу? «Улаанбаатар» зочид буудал хаа байдаг юм бэ? Эндээс хол байна уу?
- Тийгүй, Ойрхон. Та энэ чигээрээ зүүн тийшээ яваад бай. Тэгтэл нэг хүний хөшөөтэй цэцэрлэг дайралдана. Яг хойт талд нь байгаа.
- Унаанд суултгүй юу?
- Суултгүй.

1-р яриа

Яриа Conversations

Эндээс Тар уулнаас Их сургуулиас	Манайхаас /манай гэрээс хойш(оогоо) урагш(агаа) баруун тийш(ээгээ) зүүн тийш(ээгээ)	яв- бай-
--	---	-------------

24. Газарын зүй Geographic directions

Энэ Тэр Москва Прага Ханой Петербург Токио	хот тосгон улс	нэг хоёр гурван дөрвөн олон	мянган түмэн бум сая живаа дүншүүр тэрбум	хүнтэй.
--	----------------------	---	---	---------

23. Мэдээлэл

Өрөө Тасаг Ном	нь	гэрэлтэй ангид	байна.
Марташ Удахгүй 15-даар Өчигдөр Уржигдар	явна ирнэ бүцнэ явсан ирсэн бүцсэн	гэж	Доржид Дорж Доржид Доржид Доржид
			хэлсэн хэлж байна.
			байна.

Харуу

- Ямар хаягтай автобусанд суух вэ?
- «12-р хороолол – Телевиз» гэсэн хаягтай автобусанд сууна.
- Тэгээд хаана буух вэ?
- Эцсийн буудалд нь бууна.

3-р яриа

- Энэ хаанахын автобус вэ? (Хаанахынх вэ?)
- Энэ «Зайсангийнх» байна. Та энд сууж болохгүй. Удахгүй 12-р хорооллынх ирнэ. Тэгэхлээр суугаарай.
- Такси хаанаас авч болох вэ?
- Гудамжнаас авч болно.

4-р яриа

- Таксийн төв буудал хаана байна?
- «Туул» рестораны тэнд нэг төв буудал бий.
- «Туул» ресторан хүрэх замыг өгөхгүй юү Та?
- Чигээрээ явж байтал чинь нэг хүнсний дэлгүүр дайралдана. Тэндээс урагшаага эргээд чигээрээ яв. Олохгүй бол хүнээс асуугаарай.

5-р яриа

- Цэнгэлдэх хүрээлэн ороход ямар унаагаар явж болох вэ?
- Эндээс «Зайсан», «Үйлдвэр – 7 буудал» гэсэн автобусанд сууж болно. Эсвэл чиглэлийн таксид сууж болно.
- Тэгээд хаа буух вэ?
- Гүүр гараад л бууна.

6-р яриа

- Доржийнх хаа байдаг юм бэ? Чи мэдэх үү?
- Мэднэ. Чи Гандан хийд дээр очиж үзсэн үү?
- Үзсэн.
- Тэгвэл Гандангийн баруун талд нэг усан сан харагдаж байгаа. Тэр усан сангийн урд талд хойшоогоо харсан 15 тоот хүрэн хаалгатай хашаа. Тэр Доржийнх.
- Хашаан дотор нь хэдэн гэр бий вэ?
- Хоёр гэр бий. Баруун гэр нь Доржийнх.
- Гудамжны нь нэр?
- Гудамжны нь нэр санаанд орохгүй байна.
- За яах вэ, би олох байх.
- Чи лав олох юм уу? Хоёул цуг явах уу?
- Зүгээр. Явалтгүй. Би олно.

7-р яриа

- Шинжлэх ухааны академи хүргэл хэдэн буудал бэ, эндээс?
- Эндээс лав 6 буудал бий байх. Яг мэдэхгүй юм.
- Та тэр хүрэх үү?
- Хүрнэ. Академийн буудалд зогсоход нь би танд хэлэмз.
- За тэгээрэй.

8-р яриа

- Та дараагийнх дээр буух уу?
- Буухгүй.
- Тэгвэл зөрөөдөх үү?
- За тэг.
- Та одоо буух уу?
- Бууна.

9-р яриа

- Хүүе, хүн гуай аа, Цагдаагийн газар хаахан байна (вэ)?
- Би сайн мэдэхгүй юм. Тэр цагдаагаас асуу.

10-р яриа

- Цагдаа гуай аа, цагдаагийн газар хаахан байна вэ?
- Тэр дэлгүүрийг харж байна уу?
- Харж байна.
- Тэр дэлгүүрийн чинь яг урд талд нь байгаа.
- Баярлалаа, (цагдаа гуай аа).

11-р яриа

(Хөдөөний хүн:)

- Манай нутгийнхан нэг суварга босгох санаатай. Хотод суудаг нутаг нэгтнүүдээсээ хандив цуглуулахаар явж байна (би).

(Хотын хүн:)

- Тодорхой нэрлэх хандивлагч байна уу?
- Байлгүй яахав. Яагаав нөгөө Далай гуайн хүү Мягмар «Хан-өндөр» гэдэг баян банкины эзэн болсон гэсэн.
- Тэрний банк аль хэдийнээ дампуурсан гэнэ (би)лээ.
- Ээ чааваас. Одоо тэгээд юу хийж байна тэр?
- Ханбройн наймаа хийж байгаа гэсэн.
- Ханброй гэж юу гэсэн үг юм бэ?
- Бүү мэд. Нэг пивоны нэр бололтой юм билээ.
- Ингэхэд чи чинь юу хийдэг хүн бэ?
- Би Гамбринуст баарман хийж байна.

- Юу гэнэ ээ? Дахиад хэлээрэй хүү минь.
- Гамбринус гэдэг пивоны бааранд баарман хийж байна.
- Бүгд мэдэхгүй үг байна. Үг бүрий нь тайлбарлаад өгөөрэй.
- Гамбринус гэж ямар хэлний үг юм бэ, бүү мэд. Бас л нэг пивоны нэр байх. Баар гэдэг нь пиво уудаг газар юм даа. Баарман гэдэг нь (болохоор) тэрний мухлагийн худалдагч байхгүй юу.

Text

Бичвэр

1. УЛААНБААТАР ХОТ

Улаанбаатар хот Төв Азийн цээжинд, үзэсгэлэнтэй сайхан Богд-хан уулын ард Туул голын хөндийд далайгаас дээш 1300 (нэг мянга гурван зуун) метр өндөр газар оршдог, БНМУ-ын (Бүгд Найрамдах Монгол Улсын) нийслэл юм. Энэ хотын түүх 1649 оноос эхэлдэг. Дээр үед энэ хотыг Их Хүрээ, Өргөө, Нийслэл Хүрээ, гэх мэт олон янзаар нэрлэж байжээ. 1924 онд Улаанбаатар гэж нэрлэсэн байна. Улаанбаатар бол Монгол улсын улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны төв хот. 800 000 (найман бум) орчим хүнтэй.

Хотын төвд уудам сайхан талбайтай. Талбайн голд Монголын ардын хувьсгалын удирдагч гэгдсэн Сүхбаатарын морьтой хөшөө бий. Энэ талбайг Сүхбаатарын талбай гэнэ, бас төв талбай ч гэнэ. Энэ талбайн эргэн тойрон хотын гол гол албан газрын барилгууд оршино. Хойт талд нь засгийн газрын ордон, баруун талд нь түүхийн музей, хотын захиргаа, хөрөнгийн бирж, төв шуудангийн барилга, өмнө талд нь нэг сайхан цэцэрлэг, зүүн талд нь дуурь бүжгийн академик театр, соёлын төв өргөө, дүрслэх урлагийн музей, хэвлэлийн газрын барилгууд харагдана.

Хотын гудамжууд зүлэг, ногоон модтой, өргөн, шулуухан. Гол гудамжий нь Энх тайвангийн гудамж гэнэ. Энэ гудамжны хөл ихтэй газраар олон мухлаг, дэлгүүр, нийтийн утас бий. Хотын баруун хэсэгт нь орон сууцны шинэ хорооллууд, Ламын шашны «Гандан» хийд, 3,4, 10-р хороолол, «Хархорин» гэдэг худалдааны том зах, өмнө талд нь Төв цэнгэлдэх хүрээлэн, Богд хааны ордон-музей, Хөдөө аж ахуйн их сургууль бий.

Баруун өмнө хэсэг хотын цахилгаан станцууд олон үйлдвэрийн төв юм. Мөн энэ чиглэлд Улаанбаатарын галт тэрэг, нисэх онгоцны буудал бий. Зүүн хэсэгт нь Шинжлэх ухааны академи, кино үйлдвэр, «Нарантуул» гэдэг худалдааны төв (зах) зэрэг олон албан газар байна. Хотын аль ч хэсэгт сургууль соёл, орон сууц, банк, худалдаа, үйлчилгээний пүүс компаниудын том барилга олон харагдана. Хотын эргэн тойрон, голын хөндий, ууланд хүртэл гэрийн хорооллын олон мянган гэр, хашаа байшин байна. Улаанбаатар бол Туул голын дагуу орших урт хот.

2. НҮҮДЭЛЧДИЙН ХОТ

Улаанбаатарын захаар өргөжин тэлж байгаа олон мянган хашааг харж байна уу? Хашаан дотор нэг хоёр байшин, гэрүүд байна. Хашааны дотор хойт талд (хоймор) голдуу 1-2 өрөөтэй (хашааны эзний) сууцны байшин, түүний өмнө баруунтай нь хашааны эзний (юмуу ахмад, хүндэт айлын) гэр, зүүнтэй нь тэдний хүүхэд дүү нарын гэр байна. Баруун өмнөх хэсэгт түлээ түлш, амбаар, зүүн өмнөх хэсэгт

жорлон, хогийн хайрцаг зэрэг юм байна. Хашааны болон гэр байшингийн үүдийг эрхбиш өмнө зүг чиглүүлэхийг эрхэмлэнэ. Хашаа бол эртний хааны хотын бичил загвар.

Нэг гудамжинд 10-20 хашаа зэрэгцэн оршино. 1970-аад оныг хүртэлх Улаанбаатар бол бүхэлдээ иймэрхүү хашаатны хот байсан. Эзэн хүн хүсвэл гэр, хашаа байшингаа бүгдийг ачаад нүүгээд явж болно. Нэг айл 0,7 га газар эзэмших эрхтэй. Гэвч «сэргэлэн» хүмүүс ах дүүсээрээ нийлээд нэлээд том газрын эзэн болж чадна.

Улаанбаатарын бүх гудамж (мөн түүнчлэн гэр хорооллын гудамжнууд) тусгай нэртэй, байшин хашаа бүр ноймор дугаартай. Гэвч Улаанбаатарынханд ("нүүдэлчдэд") гудамжны нэр, байшингийн дугаар чухал биш. Гэрийн хаягаар бичиг захидал хүргэх шуудангийн соёл одоо ч эхлээгүй л байна.

Дасгал

Exercises

1. Цэгийг тохирох үгээр нөх.

Fill in suitable words or phrases.

Улаанбаатар бол ... нийслэл хот. Улаанбаатарт хот ... уулын ард ... голын хөндийд оршино. Хотын төвд ... бий. Хотын хамгийн том ... Энх тайвангийн гүүр гэж нэрлэдэг. Хотын баруун хэсэгт ... байдаг. Миний нөхөр ... ажилладаг. Улаанбаатарт ... бий. Бид Монгол Улсын Их Сургуулийн ... Улаанбаатар хотод ... буудал бий. Нийслэлийг 1924 онд Улаанбаатар ... нэрлэсэн байна. Төв талбай дээр Д. Сүхбаатарын ... бий. Энэ хөшөө ... хөшөө вэ?

2. Үлгэрийн дагуу асуултад хариул.

Answer the questions using the model.

ҮЛГЭР: Цирк хаана байдаг вэ? Их дэлгүүрийн урд байдаг уу, хойно байдаг уу?
УРД НЬ БАЙДАГ.

1. Төв эмнэлэг хаана байдаг вэ? Хотын төвд байдаг уу, захад байдаг уу?
2. Улаанбаатар зочид буудал хаана байдаг вэ? Их сургуулийн өмнө байдаг уу, хойно байдаг уу?
3. Богд хааны ордон-музей хаана байдаг вэ? Туул голын наана байдаг уу, цаана байдаг уу?
4. Нисэх онгоцны буудал хаана байдаг вэ? Хотын баруун талд байдаг уу, зүүн талд байдаг уу?
5. Богд уул хаана байдаг вэ? Хотын өмнө байдаг уу, хойно байдаг уу?
6. «Тэнгис» кинотеатр хаана байдаг вэ? Их дэлгүүрийн зүүн талд байдаг уу, хойт талд байдаг уу?
7. Гуанз хаана байдаг вэ? Их сургуулийн дотор байдаг уу, гадна байдаг уу?
8. Хүүхдийн парк хаана байдаг вэ? Энх тайвангийн гүүрийн баруун талд байдаг уу, зүүн талд байдаг уу?
9. Манзуширийн хийд хаана байдаг вэ? Богд уулын цаана байдаг уу, наана байдаг уу?

10. «Баянгол» зочид буудал хаана байдаг вэ? Драмын театрын ард талд байдаг уу, урд талд байдаг уу?

**3. Өгүүлбэрийг үлгэрийн дагуу Join the sentences using the model.
холбож хэл.**

ҮЛГЭР А: Би маргааш 10 цагт энд ирнэ. Бид тэгж тохиролцлоо.
БИ МАРГААШ 10 ЦАГТ ЭНД ИРЭХ БОЛЛОО.

1. Бид удахгүй буцна. Бид тэгж тохиролцлоо.
2. Дорж өнөөдөр ирэхгүй. Бид тэгж тохиролцлоо.
3. Би тэр хүнд хэдэн төгрөг өгнө. Бид тэгж тохиролцлоо.
4. Намайг хөдөө явуулна. Тэд нар тэгж тохиролцлоо.
5. Бид сайн өдөр байгалийн түүхийн музей үзнэ. Бид ингэж тогтлоо.
6. Би Монголд дахин явна. Тэд нар тэгж тогтжээ.

ҮЛГЭР Б: Би тэр хүүхэнтэй уулздаг байсан.
Би одоо тэр хүүхэнтэй уулздаггүй болсон.
БИ ТЭР ХҮҮХЭНТЭЙ УУЛЗАХАА БАЙСАН (БОЛЬСОН).

1. Би өглөө орой босдог байсан. Би одоо өглөө эрт босдог болсон.
2. Би өдөр бүхэн хуушуур авч иддэг байсан. Би одоо хуушуур авч иддэггүй болсон.
3. Бид өглөө 9 цагаас хичээл хийдэг байсан. Бид саяхан 9 цагаас хичээл хийхгүй боллоо.
4. Манай Дорж бараг өдөр бүхэн кинонд явдаг байлаа. Өчигдрөөс эхлэн кинонд явахгүй боллоо.
5. Би энэ үгийг дандаа мартчихдаг байсан. Одоо би мартахгүй болсон.

ҮЛГЭР В: Би энд ирмээр байсан. Гэвч Дулмаа намайг ирүүлээгүй.
ДУЛМАА, НАМАЙГ ИРЭХИЙГ БАЙЛГАСАН (БОЛИУЛСАН).

1. Би нэг үг хэлмээр байсан. Гэвч багш намайг хэлүүлээгүй.
2. Дорж явах гэж байна. Гэвч би Доржийг явуулахгүй.
3. Бид хоёр их сургуулийн гуанзанд орох гэж байсан. Бид хоёрыг гуанзанд (орохыг Дулмаа зөвшөөрөөгүй) оруулаагүй.
4. Би тийшээ явмаар байлаа. Намайг тийш(ээ) явахыг манай элчин сайдын яам зөвшөөрөөгүй (явуулаагүй).
5. Дорж тэр номыг (худалдаж) авах гэсэн. Би тэр номыг авхуулаагүй.

ҮЛГЭР Г: Би санаж (мэдэж) байна. Би энэ хүнтэй уулзсан байх.
БИ ЭНЭ ХҮНТЭЙ УУЛЗСАН ЮМ ШИГ БАЙНА.

1. Би санаж байна. Би энэ киног үзсэн байх.
2. Би бодож байна. Би танд тусалж чадах байх.
3. Би санаж байна. Энэ хүн надтай театрт дайралдсан байх.

4. Би санаж байна. Би энэ номыг уншсан байх.
5. Би санаж байна. Би Дорж гуайтай нэг ярьсан байх.

ҮЛГЭР Д: Ээж минь намайг санаж байгаа байх. Тийм үү, үгүй юү?
ЭЭЖ МИНЬ НАМАЙГ САНАЖ БАЙГАА БОЛОВ УУ? (БОЛ УУ?)

1. Дулмаа одоо гэртээ байгаа байх. Тийм үү, үгүй юү?
2. Би монгол хэл сурч чадах байх. Тийм үү, үгүй юү?
3. Одоо 15 цаг болж байгаа байх. Тийм үү, үгүй юү?
4. Би энийг хийж чадах байх. Чадах уу, үгүй юү?
5. Дорж энийг хийж чадах байх. Чадах уу, үгүй юү?

ҮЛГЭР Е: Чи энэ үгийг ингэж орчуулсан байна.
Би бол ингэж орчуулахгүй.
БИ БОЛ ИНГЭЖ ОРЧУУЛАХГҮЙ БАЙСАН.

1. Та тэгж хэлсэн байсан. Би бол тэгж хэлэхгүй.
2. Та тэгж хэлээгүй байна. Би бол тэгж хэлнэ.
3. Дорж тэр лекцийг ойлгоогүй байсан. Би бол ойлгоно.
4. Дорж тэр хүүхэнтэй танилцсан байна. Би бол танилцахгүй.
5. Дулмаа энэ гутлыг авсан байсан. Би бол энэ гутлыг авахгүй.
6. Дулмаа энэ цамцыг аваагүй байна. Би бол авна.
7. Чи тэр хүүхнээр үсээ засуулсан байна. Би бол засуулахгүй.

4. Цэгийг тохирох үгээр нөх. Use the suitable verb forms in brackets.

ҮЛГЭР: Би маргааш заавал ... үү? (ИРЭХГҮЙ, ИРЭХ, ИРЖ)
БИ МАРГААШ ЗААВАЛ ИРЭХ ҮҮ?

1. Би нөгөөдөр ... албатай юу? (ИРДЭГ, ИРЭХ, ИРНЭ)
2. Би тэр хүнтэй танил ... (БОЛОХ, БОЛЛОО)
3. Энэ хотын хамгийн том гүүрийг Энх тайвангийн гүүр ... (ТЭГЖ, ГЭЖ, ИНГЭЖ) нэрлэдэг.
4. Би энэ сэтгүүлийг захиалаагүй юм. Энэ их сайхан сэтгүүл байна. Би энэ сэтгүүлийг ... (ЗАХИАЛДАГ, ЗАХИАЛНА)
5. Дулмаа өчигдөр орой энд ирсэн юм. Одоо бас ... (ИРЭЭСЭЙ, ИРЭХ ЮМСАН).
6. Сайд одоо өрөөндөө ... (БАЙЖ, БАЙГАА, БАЙДАГ) байх.
7. Дулмаа гэрийн даалгавраа өчигдөр ... (ХИЙЖ БАЙСАН, ХИЙЖ БАЙГАА, ХИЙЖ БАЙХ) байх.
8. Би маргааш өглөө таныг ирэхэд ... (УНТАЖ БАЙДАГ, УНТАЖ БАЙХ, УНТАЖ БАЙГАА) байх шүү.
9. Тэд нар маргааш явах ... (БОЛСОН, БАЙСАН).
10. Тэд нар маргааш явахаа ... (БАЙСАН, БОЛСОН)
11. Тэд нар маргааш явах ... (БАЙВ УУ?, БОЛОВ УУ?)
12. Хоёулаа шуудан дээр очъё. Надад захиа ирсэн ... (БАЙЖ, БОЛЖ БАЙСАН) магадгүй.

13. Багш хичээл заахаа ... (БОЛЬСОН, БОЛСОН) байсан.

5. Цэгийг нөхцөлөөр нөх.

Fill in suitable verb forms.

1. Дулмаа 9 цагт энд ирэх ёстой бай... . Одоо 10 цаг болж байна. Дулмаа ирэхээ бай... юм шиг байна.
2. Та миний яриаг одоо ойлгож байгаа бай... гэж би бодож байна.
3. Энд одоо өдөр болж байна, манай нутагт шөнө бол... байгаа бай... .
4. Дорж яг 10 цагт Дулмаагийн дунд байж байна гэсэн. Одоо 10 цаг хагас болж байна. Дорж одоо Дулмаагийн дунд байж бай... байх.
5. Багш намайг монголоор сайн ярьдаг бол... гэсэнд би их баяртай байна.
6. Эмч намайг тамхи татаж болох... гэсэн.
7. Би таныг манай улст явах бол... гэж дуулсан. Үнэн үү?
8. Монголын нийслэлийг 1924 онд Улаанбаатар гэж нэрлэдэг бол... билүү?
9. Нина залуудаа сайхан хүүхэн бай... билээ. Одоо ч нэг хөгшин авгай л бол...

6. Хоёр өгүүлбэрийг үлгэрийн дагуу Join the sentences using the model.
холбож хэл.

ҮЛГЭР: Чи үзэсгэлэн үзсэн. Би тэр үзэсгэлэнг үзсэн.
БИ ЧИНИЙ ҮЗСЭНИЙГ ҮЗСЭН.

1. Батбаяр нэг үг хэлсэн. Би тэр үгийг ойлгосон.
2. Тэр хүн нэг бичиг бичсэн. Би тэр бичгийг уншсан.
3. Чи асуулт асуусан. Тэр асуултыг багш сонсоогүй.
4. Чи нэг ном авсан. Тэр номыг тэр хүн авсан.
5. Дорж нэг газар байсан. Тэр газар би байсан.
6. Та нэг ном уншсан. Тэр номыг би уншиж чадна.
7. Тэр хүүхэд жимс түүсэн. Тэр жимснээс би идсэн.
8. Хүн үг хэлдэг. Тэр үгийг би чамд хэлнэ.
9. Хүн юм сурдаг. Тэр юмыг би сурна.

7. Давхар өгүүлбэрийг үлгэрийн дагуу задал.

Split the complex sentences and explain them using the model.

ҮЛГЭР А: Би чиний ирснийг мэдсэнгүй.
ЧИ ИРСЭН ЮМ БАЙНА. ИРСЭН ГЭЖ БИ МЭДСЭНГҮЙ. (ИРСНИЙГ ЧИНЬ БИ МЭДСЭНГҮЙ)

1. Батбаярын хэлснийг би мэдсэнгүй.
2. Чиний үзсэнийг бид бас үзсэн.
3. Багшийн ярьсныг би ойлгоогүй.
4. Тэр хүний бичсэнийг Дулмаа уншиж чадаагүй.
5. Доржийн эхнэр авсаныг Дулмаа над хэлсэн.
6. Ахын чинь ярьдгийг одоо л ойлгож байна.

ҮЛГЭР Б: Би чамайг ирснийг мэдсэнгүй.
ЧИ ИРСЭН ЮМ БАЙНА. ИРСЭН ХҮН НЬ ЧИ ЮМ БАЙНА, ЧАМАЙГ
ГЭЖ БИ МЭДСЭНГҮЙ.

1. Батбаярыг хэлснийг би мэдсэнгүй.
2. Чамайг музей үзсэнийг бид дуулсан.
3. Энэ хүн, багшийг ярьсныг ойлгоогүй.
4. Тэр хүнийг бичсэнийг Дулмаа мэдсэн.
5. Доржийг эхнэр авсныг би мэдээгүй байсан.
6. Намайг ирснийг Доржид битгий хэлээрэй.
7. Ахыг чинь Улаанбаатар явсныг би өчигдөр л мэдлээ.
8. Танай энд үнэг байдгийг одоо л мэдлээ.
9. Энэ амьтан үнэг байсныг би мэдээгүй юм.

8. Өгүүлбэрийг үлгэрийн дагуу *Change the sentences using the model.*
өөрчил.

ҮЛГЭР: Дулмааг ирвэл би юм асуумаар байна.
ДУЛМАА ИРЭЭСЭЙ. БИ ЮМ АСУУХ ЮМ САН.

1. Аавыг зөвшөөрвөл би ирмээр байна.
2. Доржийг ном өгвөл би уншмаар байна.
3. Цэрмааг явбал би амармаар байна.
4. Багшийг байвал би юм асуумаар байна.
5. Ээжийг хоолоо хийвэл би идмээр байна.
6. Ахыг хөдөөнөөс ирвэл би уулзмаар байна.
7. Дэлгүүр бушуухан онгойвол сүү авмаар байна.
8. Автобус бушуухан ирвэл харимаар байна.
9. Гуталчин онгойвол гутлаа тахлуулмаар байна.
10. Батыг сүү авчирвал би цай хиймээр байна.

9. Өгүүлбэрийг үлгэрийн дагуу *Change the sentences using the model.*
өөрчил.

ҮЛГЭР: Дулмаа ирээгүй. Би юм асууж чадаагүй.
ДУЛМААГ ИРСЭН БОЛ БИ ЮМ АСУУХ БАЙСАН.

1. Аав зөвшөөрөөгүй. Би ирж чадаагүй.
2. Дорж ном өгөөгүй. Би уншиж чадаагүй.
3. Цэрмаа яваагүй. Би амарч чадаагүй.
4. Багш байгаагүй. Би юм асууж чадаагүй.
5. Ээж хоолоо хийгээгүй. Би идэж чадаагүй.
6. Ах хөдөөнөөс ирээгүй. Би уулзаж чадаагүй.
7. Дэлгүүр онгойгоогүй. Би сүү авч чадаагүй.
8. Автобус ирээгүй. Би харьж чадаагүй.
9. Гуталчин онгойгоогүй. Би гутлаа тахлуулж чадаагүй.

10. Бат сүү авчраагүй. Би цай хийж чадаагүй.

10. Орчуулах.

Translation.

1. УЛААНБААТАР

Улаанбаатар бол Монгол Улсын нийслэл хот. Улаанбаатар хот Богд уулын ард, Туул голын үзэсгэлэнт сайхан хөндийд оршдог. Хотын төвд Сүхбаатарын талбай, талбайн төвд Сүхбаатарын хөшөө, хөшөөний хойно засгийн газрын ордон бий. Хотын төв гудамжийг «Энх тайвангийн гудамж» гэдэг. Улаанбаатар хотод төрөл бүрийн сургууль, эмнэлэг, үйлчилгээний төв, банк, дэлгүүр, мухлаг, үйлдвэр, соёлын ордон, цэнгэлдэх хүрээлэн, кино театр, гуанз, ресторан, зочид буудал бий. Мөн гадаадын олон улсын элчин сайдын яам байдаг.

2. ШАШИН

Монголд одоо олон шашны салбарууд байна. Гол нь бурхны шашин буюу ламын шашин. Манай ээж Еэсүс бурхан шүтдэг. Би энэ жижиг бурхныг Гандангийн тэндхи шашны эд юмны дэлгүүрээс авсан. Монголын казахууд мусулман (лалын) шашин шүтдэг юм шиг байна лээ.

11. Цэгийг асуух өгүүлбэрээр нөх.

Fill in interrogative sentences.

1. ...? – 1300 метрийн өндөр газар байдаг.
2. ...? – 1649 оноос.
3. ...? – 1924 онд.
4. ...? – Улаанбаатарт өөр олон талбай бий.
5. ...? – Хотын захаар гэрийн (гэр) хороолол бий.
6. ...? – Засгийн газрын баруун талд байгаа.
7. ...? – Хотын захиргаа ч бас тэнд байгаа.
8. ...? – Улаанбаатарын гудамжинд зүлэг, ногоон мод жаахан бий.
9. ...? – Энэ гудамж, орой өглөө л хөл ихтэй байдаг.
10. ...? – Жимсийн усны мухлаг, тэр байшингийн зүүнтэй бий.
11. ...? – Манай хичээлийн байранд чиг автомат утас бий.
12. ...? – Чиглэлийн таксид суухад нэг зуун төгрөг байдаг.
13. ...? – Автобусанд бас л зуун цаас (= төгрөг).
14. ...? – Тийм ээ, таны явсан гудамж бол хотын хамгийн урт гудамж.
15. ...? – Үгүй, Дамдин хашаа байшинтай.
16. ...? – Гайгүй, бороо орохгүй байх.
17. ...? – Энэ, Зайсангийн автобус.
18. ...? – Та баруун гар тийш эргэ.
19. ...? – За тэгсэн, нэг хөшөө дайралдсан.
20. ...? – Олсон. Би амархан олсон шүү.
21. ...? – Тэр цагдаагаас асуу. Лав мэдэж байх ёстой.
22. ...? – Би энэ сарын сүүл(ч)ээр буцах санаатай.
23. ...? – Чамайг авъя гэсэн бол өгөх л байсан.

12. Асуултад хариул.

Answer the questions.

1. Монгол Улсын нийслэлийн нэрийг юу гэдэг вэ?
2. Монголын нийслэлийг 1924 оноос өмнө юу юу нэрлэж байсан бэ?
3. Энэ хот хаана оршдог вэ?
4. Улаанбаатар аль зэрэг өндөр газар оршдог вэ?
5. Хотын төв хэсэгт нь ямар барилга байшин байдаг вэ?
6. Энэ хотод сургууль соёлын ямар газар бий вэ?
7. Нисэх онгоцны буудал нь хаа байдаг вэ?
8. Улаанбаатарт хэдэн хүн суудаг вэ?
9. Улаанбаатарын гол унаа нь юу вэ?
10. Энэ хотод трамвай, троллейбус бий юү?
11. Хотын төв гудамж ямар нэртэй вэ?
12. Энэ хотод ямар ямар музей байдаг вэ?
13. Их сургууль, төв талбайтай ойрхон байна уу?
14. Танай нийслэлд ямар ямар унаа үйлчилдэг вэ?
15. Улаанбаатар хуучин хот уу, шинэ хот уу?
16. Улаанбаатар чамд гоё байна уу?
17. Улаанбаатарын сонин хачин юм нь юу вэ?
18. Энэ хотын гайхмаар юм юу вэ?

Даалгавар

Homework

1. Яриаг тогтоон ярьж сур. Learn the conversations by heart.
2. Улаанбаатарыг ярь. Talk about Ulaanbaatar.
3. Улаанбаатарын тухай жижиг бичвэр зохио. Write a short text about Ulaanbaatar.
4. Улаанбаатарыг харилцан ярь. Talk about Ulaanbaatar with your colleague.
5. Өөрийнхөө хотыг ярь. Talk about your own town.
6. Орчуулах. Translate into Mongolian:
 1. Ulaanbaatar is the capital of the Mongolian Republic located in the heart of Central Asia.
 2. This city is the political, economic, cultural and scientific centre of the Mongolian Republic.
 3. In the middle of the city there is a great square. This square is called the Square of Suhebaatar.
 4. Ulaanbaatar lies 1300 m above sea level.

5. Around the Square of Suhebaatar there are various office buildings.
6. To the north of the square there is the government palace.
7. In the government palace the President, the State Assembly, its president, and the Prime Minister work.
8. Ulaanbaatar is a busy city. At present it has about 800,000 people.

* * *

9. What is there in the northern part of the city?
10. In the northern part of the city there are mostly residential areas (districts with enclosures and houses).
11. What buildings are there in the western part of the city?
12. In the western part there is the Trade Unions' Central Palace of Culture.
13. In the southern part there is the Agricultural University in the broad valley of the Bogd Mountain.
14. Our family purchases all food from the 'Dalai Edge' market. The victuals there are very fresh and of good quality.
15. Mongols call the great (Buddha) statue Megzed Janraisag. It is in fact a Tibetan name of the Bodhisattva Avalokiteshwara.
16. There is no office there, there are (always) only the kiosks of market traders.
17. Formerly there was the Cultural Palace of Workers in the Building Industry. What is there now?
18. It seems that now there is the "Chingis" beer factory.